



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
2024 ОНЫ НАМРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАН

2025 ОНЫ 01 ДҮГЭЭР САРЫН 09-НИЙ ӨДӨР, ПҮРЭВ ГАРАГ

ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ
НЭГДСЭН ХУРАЛДААН

ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ ХЭЛТЭС

НЭГДСЭН ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА
 2025 оны 01 дүгээр сарын 09-ний өдөр, Пүрэв гараг

Хуралдааны тэмдэглэлийн агуулга	1
Хуралдааны товч тэмдэглэл:	2-17
Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:	18-114

1.Цөмийн энергийн тухай хуульд заасны дагуу хөрөнгө оруулагчтай байгуулах хөрөнгө оруулалтын гэрээг зөвшилцөх дэгийн тухай хуулийн төсөл	18-25
2.“Стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордын төрийн эзэмшлийн хувь, хэмжээг орлуулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл /Засгийн газар 2024.12.25-ны өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/	25-50
3.Элчин сайдыг томилох саналыг зөвшилцөх тухай асуудал /Монгол Улсын Ерөнхийлөгч 2024.12.26-ны өдөр өргөн мэдүүлсэн, зөвшилцөх/	50-64
4.“Тогтоолын хавсралтад нэмэлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл /Засгийн газар 2024.12.25-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/	64-68
5.“Жамсрангийн Самбуугийн алдар гавьяаг мөнхжүүлэх, түүний мэндэлсний 130 жилийн ойг тэмдэглэн өнгөрүүлэх талаар авах зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл /Улсын Их Хурлын гишүүн С.Эрдэнэболд нарын 101 гишүүн 2024.12.13-ны өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/	68-72
6.“Батлан хамгаалахын техник, тоног төхөөрөмж болон технологи шилжүүлэх тухай Монгол Улсын Засгийн газар, Япон Улсын Засгийн газар хоорондын хэлэлцээр”-ийг соёрхон батлах тухай хуулийн төсөл /2024.12.27-ны өдөр өргөн мэдүүлсэн, соёрхон батлах/	72-82
7.“Стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордын төрийн эзэмшлийн хувь, хэмжээг орлуулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл /Засгийн газар 2024.12.25-ны өдөр өргөн мэдүүлсэн, эцсийн хэлэлцүүлэг/	82-95
8.Үндэсний баялгийн сангийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн Ашигт малтмалын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүд /Засгийн газар 2024.12.25-ны өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/	95-114

**Монгол Улсын Их Хурлын 2024 оны намрын ээлжит чуулганы
2025 оны 01 дүгээр сарын 09-ний өдөр /Пүрэв гараг/-ийн
нэгдсэн хуралдааны товч тэмдэглэл**

Улсын Их Хурлын дарга Д.Амарбаясгалан ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 126 гишүүнээс 76 гишүүн хүрэлцэн ирж, 60.3 хувийн ирцтэйгээр хуралдаан 10 цаг 02 минутад Төрийн ордны “Их хуралдай” танхимд эхлэв.

Томилолттой: С.Амарсайхан, Ж.Баясгалан, Ш.Бямбасүрэн, Х.Жангабыл, Д.Жаргалсайхан, Л.Мөнхбаясгалан, Т.Мөнхсайхан, Ж.Энхбаяр;

Чөлөөтэй: Д.Батбаяр, Х.Баттулга, П.Батчимэг, Ж.Ганбаатар, Ц.Мөнхбат, Б.Мөнхсоёл, П.Мөнхтулга, Б.Найдалаа, М.Нарантуяа-Нара, Л.Оюун-Эрдэнэ, Б.Тулга, О.Цогтгээрэл;

Эмнэлгийн чөлөөтэй: Ж.Алдаржавхлан, Ж.Баярмаа, Х.Болормаа, Л.Гантөмөр, Х.Ганхуяг, С.Лүндэг, М.Мандхай, З.Мэндсайхан, Б.Түвшин, Д.Цогтбаатар, Ө.Шижир, Б.Энхбаяр;

Хоцорсон: Н.Алтанхуяг-04 минут, Ц.Баатархүү-02 минут, Б.Батбаатар-02 минут, Б.Батцэцэг-45 минут, Э.Батшугар-04 минут, Б.Бейсен-25 минут, Д.Ганбат-14 минут, Б.Дэлгэрсайхан-43 минут, Б.Жаргалан-04 минут, Б.Заяабал-17 минут, Л.Мөнхбаатар-02 минут, Ц.Мөнхтуяа-45 минут, Н.Номтойбаяр-02 минут, С.Одонтуяа-21 минут, Ц.Туваан-15 минут, Г.Тэмүүлэн-11 минут, Н.Учрал-17 минут, Д.Энхтуяа-08 минут.

Улсын Их Хурлын дарга Д.Амарбаясгалан Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1-д “Улсын Их Хурлын дарга хууль санаачлагчаас Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн төслийг хэлэлцүүлэгт бэлтгэх Байнгын хороог, хэрэв төсөл хэд хэдэн Байнгын хорооны эрхлэх асуудлын хүрээнд хамаарахаар бол Зөвлөлтэй зөвшилцөн холбогдох болон бусад Байнгын хороог тогтоож, нэгдсэн хуралдаанд мэдээлнэ.” гэж заасны дагуу Эрүүгийн хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг Улсын Их Хурлын гишүүн Ч.Лодойсамбуу нарын 19 гишүүн 2024 оны 12 дугаар сарын 27-ны өдөр өргөн мэдүүлснийг, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон уг хуулийн төсөлтэй холбогдуулан боловсруулсан Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг Засгийн газраас 2024 оны 12 дугаар сарын 27-ны өдөр өргөн мэдүүлснийг Хууль зүйн байнгын хороонд, Батлан хамгаалахын техник, тоног төхөөрөмж болон технологи шилжүүлэх тухай Монгол Улсын Засгийн газар, Япон Улсын Засгийн газар хоорондын хэлэлцээрийг соёрхон батлах тухай хуулийн төслийг Засгийн газраас 2024 оны 12 дугаар сарын 27-ны өдөр өргөн мэдүүлснийг Аюулгүй

байдал, гадаад бодлогын байнгын хороонд тус тус хуваарилсныг мэдээлэв./10:07/

Нэг.Цөмийн энергийн тухай хуульд заасны дагуу хөрөнгө оруулагчтай байгуулах хөрөнгө оруулалтын гэрээг зөвшилцөх дэгийн тухай хуулийн төсөл

Хуралдаанд Улсын Их Хурлын Ерөнхий нарийн бичгийн дарга Б.Баасандорж, Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга Ч.Ариунхур, Хуулийн газрын дарга Ч.Дондогмаа, мөн газрын Зөвлөх үйлчилгээний хэлтсийн зөвлөх П.Хулан, Байнгын хороодын ажлын албаны Ёс зүй, дэгийн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Д.Наранцэцэг нар байлцав.

Төслийг хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх Ёс зүй, дэгийн байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Б.Баярбаатар танилцуулав.

Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн П.Сайнзориг, С.Ганбаатар, Л.Соронзонболд нарын тавьсан асуултад Ёс зүй, дэгийн байнгын хорооны дарга Б.Баярбаатар хариулж, тайлбар хийв.

Цөмийн энергийн тухай хуульд заасны дагуу хөрөнгө оруулагчтай байгуулах хөрөнгө оруулалтын гэрээг зөвшилцөх дэгийн тухай хуулийн төслийг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 44 дүгээр зүйлийн 44.2-т заасны дагуу эцэслэн батлах санал хураалт явуулав.

Д.Амарбаясгалан: Байнгын хорооны саналаар Цөмийн энергийн тухай хуульд заасны дагуу хөрөнгө оруулагчтай байгуулах хөрөнгө оруулалтын гэрээг зөвшилцөх дэгийн тухай хуулийн төслийг эцэслэн батлах санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 58

Татгалзсан: 28

Бүгд: 86

67.4 хувь буюу нийт гишүүдийн олонхын саналаар дэмжигдсэнгүй.

Улсын Их Хурлын гишүүн Х.Баасанжаргал, Ж.Батсуурь, Б.Бат-Эрдэнэ, Д.Бум-Очир, Б.Жавхлан, Да.Цогтбаатар, Г.Хосбаяр, Б.Хэрлэн, Л.Энх-Амгалан нар саналаа дэмжсэнээр хуралдааны тэмдэглэлд тэмдэглүүлэх санал гаргав.

Улсын Их Хурлын гишүүн А.Ариунзаяа саналаа өгч амжаагүй тул дээрх санал хураалтыг хүчингүй болгож, дахин санал хураалт явуулах горимын санал гаргав.

Д.Амарбаясгалан: Улсын Их Хурлын гишүүн А.Ариунзаяагийн гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 67

Татгалзсан: 21
Бүгд: 88
76.1 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

Д.Амарбаясгалан: Байнгын хорооны саналаар Цөмийн энергийн тухай хуульд заасны дагуу хөрөнгө оруулагчтай байгуулах хөрөнгө оруулалтын гэрээг зөвшилцөх дэгийн тухай хуулийн төслийг эцэслэн батлах санал хураалтыг дахин явуулъя.

Зөвшөөрсөн: 73
Татгалзсан: 13
Бүгд: 86
84.9 хувь буюу нийт гишүүдийн олонхын саналаар хууль батлагдлаа.

Ёс зүй, дэгийн байнгын хорооны дарга Б.Баярбаатар үг хэлж, хуулийн төслийг эцэслэн баталсан тул эцсийн найруулгыг сонсьё гэсэн санал гаргав.

Улсын Их Хурлын дарга Д.Амарбаясгалан Цөмийн энергийн тухай хуульд заасны дагуу хөрөнгө оруулагчтай байгуулах хөрөнгө оруулалтын гэрээг зөвшилцөх дэгийн тухай хуулийн эцсийн найруулгыг танилцуулав. Улсын Их Хурлын гишүүн П.Сайнзориг эцсийн найруулгатай холбогдуулан санал хэлэв. Улсын Их Хурлын гишүүд хуулийн эцсийн найруулгатай танилцлаа./10:23/

Уг асуудлыг 10 цаг 24 минутад хэлэлцэж дуусав.

Хоёр.“Стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордын төрийн эзэмшлийн хувь, хэмжээг орлуулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл /Засгийн газар 2024.12.25-ны өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Н.Учрал, Улсын Их Хурлын гишүүн, Агаар орчны бохирдлыг бууруулах үндэсний хорооны дарга, Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сайд С.Одонтуяа, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дэд дарга Д.Цолмон, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын зөвлөх Б.Хулан, А.Мандуул, Хууль зүй, дотоод хэргийн яамны Хууль зүйн бодлогын газрын дарга Н.Жамъянхүү, Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Нэгдсэн бодлого, төлөвлөлтийн газрын дарга Б.Алимаа, Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны Эрдэс баялгийн бодлогын газрын дарга Г.Намчинсүрэн, мөн яамны Хуулийн хэлтсийн дарга Т.Ганбаатар, Геологи, уул уурхайн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын ахлах шинжээч Ц.Өнөрнасан, Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яамны Байгалийн нөөцийн бодлогын хэрэгжилтийн газрын дарга Ц.Уранчимэг, Эдийн засаг, хөгжлийн яамны Макро эдийн засгийн бодлогын газрын дарга Л.Энх-Амгалан, Сангийн яамны Татварын бодлогын газрын дарга Б.Тэлмүүн, Татварын ерөнхий газрын дарга Ч.Чимидсүрэн, “Эрдэнэс Монгол” ХХК-ийн гүйцэтгэх захирал С.Наранцогт, мөн компанийн Геологи, үйлдвэрийн бодлогын газрын дарга Ц.Төгсбаян, Дотоод хяналт, эрсдэлийн удирдлагын газрын дарга Л.Наранчимэг, Хууль, эрх зүйн зөвлөлийн дарга Б.Гэрлээ, Хамтын ажиллагааны хэлтсийн менежер Т.Төрбадрах, Ашигт

малтмал, газрын тосны газрын Төрийн захиргааны удирдлагын газрын дарга Ш.Ганхуяг, Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг, Усны газрын дарга З.Батбаяр, Цөмийн энергийн комиссын Ажлын албаны дарга Г.Манлайжав, мөн албаны Цөмийн технологийн бодлогын газрын дарга М.Чадраабал, Цөмийн аюулгүй байдлын бодлогын газрын дарга Э.Нямдаваа, “Мон Атом” ХХК-ийн гүйцэтгэх захирал Д.Далайжаргал, мөн компанийн Захиргааны албаны дарга Д.Сугарсүрэн, ахлах геологич А.Алтанхундага, мэргэжлийн шинжээч, Монголын Мал эмнэлгүүдийн дундын хоршооны зөвлөх, Монгол Улсын шинжлэх ухааны гавьяат зүтгэлтэн, академич, профессор Я.Ганболд, Физикийн ухааны доктор Н.Тэгшбаяр, Дотоодын хуулийн зөвлөх, Г.Мөнхболд, Б.Батмандах, З.Шагдарсүрэн, С.Батхүлэг нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга Ч.Ариунхур, Хуулийн газрын дарга Ч.Дондогмаа, мөн газрын Зөвлөх үйлчилгээний хэлтсийн зөвлөх П.Хулан, мөн хэлтсийн ахлах мэргэжилтэн Б.Агиймаа, Байнгын хороодын ажлын албаны Эдийн засгийн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Д.Мягмарцэрэн нар байлцав.

Төслийг анхны хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх Эдийн засгийн байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Б.Пүрэвдорж танилцуулав.

Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Ц.Идэрбат, О.Батнайрамдал, Б.Уянга, А.Ундраа, Б.Батбаатар, Б.Жаргалан нарын тавьсан асуултад Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Н.Учрал, ажлын хэсгийн ахлагч, Улсын Их Хурлын гишүүн Б.Пүрэвдорж, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын зөвлөх Б.Хулан, Хууль зүй, дотоод хэргийн яамны Хууль зүйн бодлогын газрын дарга Н.Жамъянхүү нар хариулж, тайлбар хийв.

“Стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордын төрийн эзэмшлийн хувь, хэмжээг орлуулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн талаар Эдийн засгийн байнгын хорооноос гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулав.

Нэг.Эдийн засгийн байнгын хорооны дэмжсэн санал:

Д.Амарбаясгалан: 1.Улсын Их Хурлын гишүүн Б.Пүрэвдорж, Б.Баярбаатар, Г.Тэмүүлэн, А.Ариунзаяа, Б.Батбаатар, О.Батнайрамдал, Ж.Баярмаа, Ш.Бямбасүрэн, Г.Ганбаатар, Х.Ганхуяг, Б.Найдалаа, У.Отгонбаяр, Д.Пүрэвдаваа, П.Сайнзориг, Х.Тэмүүжин, Б.Уянга, Г.Уянгахишиг, Да.Цогтбаатар, С.Цэнгүүн, Ө.Шижир, Б.Энхбаяр, С.Эрдэнэбат/цаашид “Ажлын хэсэг” гэх/ нарын гаргасан, Төслийн 1 дэх заалтын “MV-018915 дугаартай “Дулаан-Уул” гэснийг “MV-018916 дугаартай “Дулаан-Уул” гэж, “MV-018916 дугаартай “Зөөвч-Овоо” гэснийг “MV-018915 дугаартай “Зөөвч-Овоо” гэж тус тус өөрчлөх гэсэн Эдийн засгийн байнгын хорооны дэмжсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Татгалзсан: 35
Бүгд: 93
62.4 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Улсын Их Хурлын гишүүн Г.Уянгахишигийн гаргасан, Төсөлд доор дурдсан агуулгатай 2 дахь заалт нэмэх:

“2.Энэ тогтоолын 1 дэх заалтад заасны дагуу энгийн хувьцааг давуу эрхийн хувьцаанд хөрвүүлэхэд дараах зарчмыг баримтална:

1/төрийн эзэмшлийн 10 хувийн давуу эрхийн хувьцаа нь тухайн компанийн хувь нийлүүлсэн хөрөнгийн 10 хувьтай тэнцүү байх;

2/нийт гаргасан энгийн болон давуу эрхийн хувьцаанд эзлэх төрийн эзэмшлийн хувь хэмжээг 10 хувиас бууруулахгүй байх.” гэсэн Эдийн засгийн байнгын хорооны дэмжсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 63
Татгалзсан: 30
Бүгд: 93
67.7 хувийн саналаар дэмжигдлээ.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн С.Бямбацогт, Ж.Батжаргал нар үг хэлэв.

3.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 3 дахь заалтыг “Энэ тогтоолыг 2025 оны 01 дүгээр сарын 10-ны өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.” гэж өөрчлөх гэсэн Эдийн засгийн байнгын хорооны дэмжсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 62
Татгалзсан: 31
Бүгд: 93
66.7 хувийн саналаар дэмжигдлээ.

Улсын Их Хурлын гишүүн Г.Уянгахишиг, Б.Хэрлэн нарыг дэмжсэнээр тооцож, 68.8 хувийн саналаар дэмжигдлээ.

НАЙРУУЛГЫН САНАЛ

Д.Амарбаясгалан: 1.Улсын Их Хурлын гишүүн Г.Уянгахишигийн гаргасан, Төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томъёолол дэмжигдсэнтэй холбогдуулан төслийн бүтэц, нэр томъёо, хэл найруулга, дэс дараалал, заалтын дугаарыг нийцүүлж өөрчлөх гэсэн Эдийн засгийн байнгын хорооны дэмжсэн

саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 66
Татгалзсан: 27
Бүгд: 93
71.0 хувийн саналаар дэмжигдлээ.

Хоёр.Эдийн засгийн байнгын хорооны дэмжээгүй санал:

Д.Амарбаясгалан: 1.Улсын Их Хурлын гишүүн Г.Уянгахишигийн гаргасан, Төслийн 1 дэх заалтын “төрийн эзэмшлийн 34 хувийн” гэсний дараа “энгийн” гэж нэмж, мөн заалтын “10 хувийн” гэснийг хасах гэсэн Эдийн засгийн байнгын хорооны дэмжээгүй саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 56
Татгалзсан: 37
Бүгд: 93
60.2 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Улсын Их Хурлын гишүүн М.Бадамсүрэнгийн гаргасан, Төсөлд доор дурдсан агуулгатай 3 дахь заалт нэмэх:

“3.Стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордын ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийн 30-аас доошгүй хувийг олборлолтын сөрөг нөлөөлөлд өртөж буй аймаг, сумдын орон нутгийн хөгжлийн санд хуваарилах эрх зүйн үндсийг бий болгох чиглэлээр холбогдох арга хэмжээ авахыг Монгол Улсын Засгийн газар /Л.Оюун-Эрдэнэ/-т даалгасугай.” гэсэн Эдийн засгийн байнгын хорооны дэмжээгүй саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 43
Татгалзсан: 50
Бүгд: 93
46.2 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

3.Улсын Их Хурлын гишүүн Л.Соронзонболдын гаргасан, Төслийн хавсралтын “40-50 хүртэл 0.5%” гэснийг “40-өөс дээш 5%” гэж өөрчилж, “50-иас дээш 5%” гэсэн мөрийг хасах гэсэн Эдийн засгийн байнгын хорооны дэмжээгүй саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 48
Татгалзсан: 45
Бүгд: 93
51.6 хувийн саналаар дэмжигдлээ.

Зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хурааж дууслаа.

“Стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордын төрийн эзэмшлийн хувь, хэмжээг орлуулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг

эцсийн хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Эдийн засгийн байнгын хороонд шилжүүлэв.

Уг асуудлыг 11 цаг 53 минутад хэлэлцэж дуусав

Гурав.Элчин сайдыг томилох саналыг зөвшилцөх тухай асуудал
/Монгол Улсын Ерөнхийлөгч 2024.12.26-ны өдөр өргөн мэдүүлсэн, зөвшилцөх/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Гадаад харилцааны сайд Б.Батцэцэг, Монгол Улсын Ерөнхийлөгчийн Хот, хөдөөгийн бодлого хариуцсан зөвлөх Г.Ганболд, Гадаад харилцааны яамны Төрийн захиргаа, хүний нөөцийн удирдлага, зохион байгуулалтын газрын захирал Д.Булган, мөн яамны Консулын газрын дэд захирал Т.Бат-Орших, Бодлогын газрын дэд захирал Д.Бямбадорж, Гэрээ, эрх зүйн газрын захирлын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Ж.Соёлмаа, Монгол Улсаас Бүгд Найрамдах Польш Улсад суух Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайдад нэр дэвшигч Н.Оюундарь нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга Ч.Ариунхур, Хуулийн газрын дарга Ч.Дондогмаа, мөн газрын Байнгын хороодын ажлын албаны Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Ш.Хишигсүрэн нар байлцав.

Монгол Улсын Ерөнхийлөгчийн Монгол Улсаас Бүгд Найрамдах Польш Улсад суух Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайдыг томилох саналыг Монгол Улсын Ерөнхийлөгчийн Хот, хөдөөгийн бодлого хариуцсан зөвлөх Г.Ганболд танилцуулав.

Монгол Улсын Ерөнхийлөгчийн саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн А.Ариунзаяа, Б.Пүрэвдорж, С.Ганбаатар, С.Бямбацогт, Д.Үүрийнтуяа, Ж.Батсуурь, С.Эрдэнэболд, Ж.Золжаргал, Ц.Сандаг-Очир, А.Ганбаатар нарын тавьсан асуултад Гадаад харилцааны сайд Б.Батцэцэг, Монгол Улсын Ерөнхийлөгчийн Хот, хөдөөгийн бодлогын зөвлөх Г.Ганболд, Монгол Улсаас Бүгд Найрамдах Польш Улсад суух Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайдад нэр дэвшигч Н.Оюундарь нар хариулж, тайлбар хийв.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.12-т “Хуралдаан даргалагч тухайн асуудлаар санал хураалт явуулах цагийг тухай бүрд нь урьдчилан зарлаж болно” гэж заасны дагуу санал хураалтыг үдээс хойш явуулахаар зарлав./12:42/

Дөрөв. “Тогтоолын хавсралтад нэмэлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл /Засгийн газар 2024.12.25-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Зам, тээврийн сайд Б.Дэлгэрсайхан, Зам, тээврийн яамны Төмөр зам, далайн тээврийн бодлого, зохицуулалтын газрын дарга Х.Итгэлт, мөн яамны Төмөр замын тээврийн хэлтсийн дарга Д.Мөнхбат, Далай ашиглалт, усан замын хэлтсийн дарга Д.Жавхлан, Хуулийн хэлтсийн дарга С.Мяндасмаа, мөн хэлтсийн

ахлах шинжээч Б.Цэнд нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга Ч.Ариунхур, Хуулийн газрын дарга Ч.Дондогмаа, мөн газрын Зөвлөх үйлчилгээний хэлтсийн зөвлөх Ц.Баянмөнх, Байнгын хороодын ажлын албаны Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Ш.Хишигсүрэн, мөн албаны Төрийн байгуулалтын байнгын хорооны ажлын албаны референт Э.Баттогтох нар байлцав.

Төслийн үзэл баримтлалын талаарх илтгэлийг Зам, тээврийн сайд Б.Дэлгэрсайхан, хуулийн төслийг хэлэлцэх эсэх талаарх Төрийн байгуулалтын байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн С.Бямбацогт нар танилцуулав.

Илтгэл болон Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Д.Пүрэвдаваагийн тавьсан асуултад Зам, тээврийн сайд Б.Дэлгэрсайхан хариулж, тайлбар хийв.

Д.Амарбаясгалан: Байнгын хорооны саналаар “Тогтоолын хавсралтад нэмэлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэх нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 59
Татгалзсан: 34
Бүгд: 93
63.4 хувийн саналаар Байнгын хорооны санал дэмжигдлээ.

Уг асуудлыг 12 цаг 58 минутад хэлэлцэж дуусав.

Монгол Улсаас Бүгд Найрамдах Польш Улсад суух Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайдаар томилох асуудлаар санал хураалт явуулав.

Д.Амарбаясгалан: Монгол Улсаас Бүгд Найрамдах Польш Улсад суух Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайдаар Наваан-Юндэнгийн Оюундарийг томилох тухай саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 63
Татгалзсан: 30
Бүгд: 93
67.7 хувийн саналаар дэмжигдлээ.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 109 дүгээр зүйлийн 109.3-т заасны дагуу санал хураалтын дүнг Монгол Улсын Ерөнхийлөгчид бичгээр мэдэгдэхээр тогтов./12:58/

Уг асуудлыг 12 цаг 58 минутад хэлэлцэж дуусав.

Үдээс өмнөх хуралдаан 2 цаг 57 минут үргэлжилж, 12 цаг 59 минутад завсарлав.

Үдээс хойших хуралдаан 14 цаг 03 минутад эхэлж, Улсын Их Хурлын дэд дарга Х.Булгантуяа даргалав.

Тав. “Жамсрангийн Самбуугийн алдар гавьяаг мөнхжүүлэх, түүний мэндэлсний 130 жилийн ойг тэмдэглэн өнгөрүүлэх талаар авах зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл /Улсын Их Хурлын гишүүн С.Эрдэнэболд нарын 101 гишүүн 2024.12.13-ны өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хуулийн газрын Зөвлөх үйлчилгээний хэлтсийн зөвлөх Д.Нямбаяр, Байнгын хороодын ажлын албаны Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Ш.Хишигсүрэн, мөн албаны Төрийн байгуулалтын байнгын хорооны ажлын албаны референт Э.Баттогтох нар байлцав.

Төслийг анхны хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх Төрийн байгуулалтын байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Б.Баярбаатар танилцуулав.

Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн А.Ариунзаяа, С.Ганбаатар нар үг хэлэв.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.12-т “Хуралдаан даргалагч тухайн асуудлаар санал хураалт явуулах цагийг тухай бүрд нь урьдчилан зарлаж болно” гэж заасны дагуу санал хураалтыг хойшлуулав./14:42/

Зургаа. “Батлан хамгаалахын техник, тоног төхөөрөмж болон технологи шилжүүлэх тухай Монгол Улсын Засгийн газар, Япон Улсын Засгийн газар хоорондын хэлэлцээр”-ийг соёрхон батлах тухай хуулийн төсөл /2024.12.27-ны өдөр өргөн мэдүүлсэн, соёрхон батлах/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Н.Учрал, Улсын Их Хурлын гишүүн, Батлан хамгаалахын сайд С.Бямбацогт, Батлан хамгаалах яамны Төрийн нарийн бичгийн дарга Д.Ганхуяг, мөн яамны Гадаад хамтын ажиллагааны газрын дарга Т.Наранхүү, Төрийн захиргааны удирдлагын газрын Хуулийн хэлтсийн дарга Г.Энхболд, мөн газрын Олон улсын гэрээ, эрх зүй, ёслолын ажил хариуцсан ахлах мэргэжилтэн Ц.Сэргэлэнбаатар нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга Ч.Ариунхур, Хуулийн газрын дарга Ч.Дондогмаа, Байнгын хороодын ажлын албаны Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Ш.Хишигсүрэн нар байлцав.

Төслийн үзэл баримтлалын талаарх илтгэлийг Батлан хамгаалахын сайд С.Бямбацогт, хуулийн төслийг хэлэлцэх эсэх талаарх Аюулгүй байдал, гадаад

бодлогын байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Д.Энхтүвшин нар танилцуулав.

Илтгэл болон Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн С.Ганбаатар, Д.Рэгдэл, П.Сайнзориг, Б.Бейсен, Х.Булгантуяа нарын тавьсан асуултад Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Н.Учрал, Батлан хамгаалахын сайд С.Бямбацогт, Батлан хамгаалах яамны Төрийн нарийн бичгийн дарга Д.Ганхуяг нар хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын дарга Д.Амарбаясгалан 14 цаг 48 минутаас хуралдааныг даргалав.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.12-т “Хуралдаан даргалагч тухайн асуудлаар санал хураалт явуулах цагийг тухай бүрд нь урьдчилан зарлаж болно” гэж заасны дагуу санал хураалтыг хойшлуулав./14:49/

Долоо. “Стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордын төрийн эзэмшлийн хувь, хэмжээг орлуулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл /Засгийн газар 2024.12.25-ны өдөр өргөн мэдүүлсэн, эцсийн хэлэлцүүлэг/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Н.Учрал, Улсын Их Хурлын гишүүн, Сангийн сайд Б.Жавхлан, Улсын Их Хурлын гишүүн, Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайд Ц.Туваан, Улсын Их Хурлын гишүүн, Агаар орчны бохирдлыг бууруулах үндэсний хорооны дарга, Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сайд С.Одонтуяа, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дэд дарга Д.Цолмон, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын зөвлөх Б.Хулан, А.Мандуул, Хууль зүй, дотоод хэргийн яамны Хууль зүйн бодлогын газрын дарга Н.Жамъянхүү, Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Нэгдсэн бодлого, төлөвлөлтийн газрын дарга Б.Алимаа, Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны Эрдэс баялгийн бодлогын газрын дарга Г.Намчинсүрэн, мөн яамны Хуулийн хэлтсийн дарга Т.Ганбаатар, Геологи, уул уурхайн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын ахлах шинжээч Ц.Өнөрнасан, Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яамны Байгалийн нөөцийн бодлогын хэрэгжилтийн газрын дарга Ц.Уранчимэг, Эдийн засаг, хөгжлийн яамны Макро эдийн засгийн бодлогын газрын дарга Л.Энх-Амгалан, Сангийн яамны Татварын бодлогын газрын дарга Б.Тэлмүүн, Татварын ерөнхий газрын дарга Ч.Чимидсүрэн, “Эрдэнэс Монгол” ХХК-ийн гүйцэтгэх захирал С.Наранцогт, мөн компанийн Геологи, үйлдвэрийн бодлогын газрын дарга Ц.Төгсбаян, Дотоод хяналт, эрсдэлийн удирдлагын газрын дарга Л.Наранчимэг, Хууль, эрх зүйн зөвлөлийн дарга Б.Гэрлээ, Хамтын ажиллагааны хэлтсийн менежер Т.Төрбадрах, Ашигт малтмал, газрын тосны газрын Төрийн захиргааны удирдлагын дарга Ш.Ганхуяг, Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг, Усны газрын дарга З.Батбаяр, Цөмийн энергийн комиссын Ажлын албаны дарга Г.Манлайжав, мөн албаны Цөмийн технологийн бодлогын газрын дарга М.Чадраабал, Цөмийн аюулгүй байдлын бодлогын газрын дарга Э.Нямдаваа, “Мон Атом” ХХК-ийн захирал

Д.Далайжаргал, мөн компанийн Захиргааны албаны дарга Д.Сугарсүрэн, ахлах геологич А.Алтанхундага, мэргэжлийн шинжээч, Монголын Мал эмнэлгүүдийн дундын хоршооны зөвлөх, Монгол Улсын шинжлэх ухааны гавьяат зүтгэлтэн, академич, профессор Я.Ганболд, физикийн ухааны доктор Н.Тэгшбаяр, Дотоодын хуулийн зөвлөх, Г.Мөнхболд, Б.Батмандах, З.Шагдарсүрэн, С.Батхүлэг нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга Ч.Ариунхур, Хуулийн газрын дарга Ч.Дондогмаа, мөн газрын Зөвлөх үйлчилгээний хэлтсийн зөвлөх П.Хулан, мөн хэлтсийн ахлах мэргэжилтэн Б.Агиймаа, Байнгын хороодын ажлын албаны Эдийн засгийн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Д.Мягмарцэрэн нар байлцав.

Төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх Эдийн засгийн байнгын хорооноос гаргасан танилцуулгыг Улсын Их Хурлын гишүүн Б.Пүрэвдорж танилцуулав.

Байнгын хорооны танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Н.Наранбаатар, А.Ганбаатар, М.Бадамсүрэн, А.Ундраа, Б.Батбаатар нарын тавьсан асуултад Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Н.Учрал, Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайд Ц.Туваан, Сангийн сайд Б.Жавхлан, ажлын хэсгийн ахлагч, Улсын Их Хурлын гишүүн Б.Пүрэвдорж, Улсын Их Хурлын Тамгын газрын Хуулийн газрын дарга Ч.Дондогмаа нар хариулж, тайлбар хийв.

“Стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордын төрийн эзэмшлийн хувь, хэмжээг орлуулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн талаар Эдийн засгийн байнгын хорооноос гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулав.

Эдийн засгийн байнгын хорооны дэмжсэн санал:

Д.Амарбаясгалан: Төслийн 3 дахь заалтыг хасах гэсэн Эдийн засгийн байнгын хорооны дэмжсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 61
Татгалзсан: 33
Бүгд: 94
64.9 хувийн саналаар дэмжигдлээ.

Зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулж дууслаа.

Д.Амарбаясгалан: Байнгын хорооны саналаар “Стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордын төрийн эзэмшлийн хувь, хэмжээг орлуулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг батлах санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 64
Татгалзсан: 30
Бүгд: 94
68.1 хувийн саналаар Монгол Улсын Их Хурлын тогтоол батлагдлаа.

Эдийн засгийн байнгын хорооны дарга Р.Сэддорж үг хэлж, тогтоолын төслийг баталсан тул эцсийн найруулгыг сонсъё гэсэн санал гаргав.

Улсын Их Хурлын дарга Д.Амарбаясгалан “Стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордын төрийн эзэмшлийн хувь, хэмжээг орлуулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын эцсийн найруулгыг танилцуулав. Улсын Их Хурлын гишүүдээс эцсийн найруулгатай холбогдуулан асуулт, санал гараагүй болно. Улсын Их Хурлын гишүүд тогтоолын эцсийн найруулгатай танилцлаа./15:25/

Уг асуудлыг 15 цаг 26 минутад хэлэлцэж дуусав.

Тав дахь асуудал буюу “Жамсрангийн Самбуугийн алдар гавьяаг мөнхжүүлэх, түүний мэндэлсний 130 жилийн ойг тэмдэглэн өнгөрүүлэх талаар авах зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн талаарх Төрийн байгуулалтын байнгын хорооноос гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулав.

Төрийн байгуулалтын байнгын хорооны дэмжсэн санал

Д.Амарбаясгалан: 1.Улсын Их Хурлын гишүүн С.Эрдэнэболдын гаргасан, Төслийн гарчгийн “Жамсрангийн Самбуугийн алдар гавьяаг мөнхжүүлэх, түүний мэндэлсний 130 жилийн ойг тэмдэглэн өнгөрүүлэх талаар авах зарим арга хэмжээний тухай” гэснийг “Засгийн газарт чиглэл өгөх тухай” гэж өөрчлөх гэсэн Төрийн байгуулалтын байнгын хорооны дэмжсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 65
Татгалзсан: 29
Бүгд: 94
69.1 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Улсын Их Хурлын гишүүн С.Эрдэнэболдын гаргасан, Төслийн тэмдэглэх хэсгийн “БНМАУ-ын Ардын Их Хурлын тэргүүлэгчдийн дарга асан, Бүрэн эрхт Элчин сайд, XX зууны төр, нийгмийн нэрт зүтгэлтэн Жамсрангийн Самбуугийн мэндэлсний 130 жилийн ой тохиож байгаатай холбогдуулан түүний алдар гавьяаг мөнхжүүлэх зорилгоор” гэснийг хасах гэсэн Төрийн байгуулалтын байнгын хорооны дэмжсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 67
Татгалзсан: 27
Бүгд: 94
71.3 хувийн саналаар дэмжигдлээ.

3.Улсын Их Хурлын гишүүн С.Эрдэнэболдын гаргасан, Төслийн 1 дүгээр заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“1.БНМАУ-ын Ардын Их Хурлын тэргүүлэгчдийн дарга асан, хөдөлмөрийн баатар, Онц бөгөөд Бүрэн эрхт элчин сайд, төр, нийгмийн нэрт зүтгэлтэн Жамсрангийн Самбуугийн мэндэлсний 130 жилийн ой 2025 онд тохиож байгаатай холбогдуулан түүний алдар гавьяаг мөнхжүүлэх зорилгоор дараах арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг Монгол Улсын Засгийн газар /Л.Оюун-Эрдэнэ/-т даалгасугай:

1/Нийтээр тэмдэглэх баярын болон тэмдэглэлт өдрүүдийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.2-т заасны дагуу Жамсрангийн Самбуугийн мэндэлсний 130 жилийн ойг тэмдэглэх өдрийн товыг тогтоож, ойг тэмдэглэн өнгөрүүлэх бэлтгэл ажлын төлөвлөгөө, үйл ажиллагааны хөтөлбөр баталж, зохион байгуулах үүрэг бүхий ажлын хэсэг байгуулан ажиллуулах;

2/Жамсрангийн Самбуугийн Монгол Улсын нийгэм, эдийн засгийг хөгжүүлэх, олон улсын харилцааг бэхжүүлэх, энх тайвныг сахин хамгаалах, төрийн албыг төлөвшүүлэхэд гүйцэтгэсэн үүрэг, түүний амьдрал, үйл ажиллагааг олон нийтэд сурталчлан таниулах ажлыг зохион байгуулах;

3/ойг тэмдэглэн өнгөрүүлэх арга хэмжээнд шаардагдах зардлыг санхүүжүүлэх арга хэмжээг хууль тогтоомжид заасан эрх хэмжээний хүрээнд шийдвэрлэх.” гэсэн Төрийн байгуулалтын байнгын хорооны дэмжсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 64
Татгалзсан: 30
Бүгд: 94
68.1 хувийн саналаар дэмжигдлээ.

Д.Амарбаясгалан: 4.Улсын Их Хурлын гишүүн С.Эрдэнэболдын гаргасан, Төслийн 2 дугаар заалтын “үүрэг болгосугай” гэснийг “даалгасугай” гэж өөрчлөх гэсэн Төрийн байгуулалтын байнгын хорооны дэмжсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 67
Татгалзсан: 27
Бүгд: 94
71.3 хувийн саналаар дэмжигдлээ.

Зарчмын зөрүүтэй саналын томьёоллоор санал хураалт явуулж дууслаа.

“Жамсрангийн Самбуугийн алдар гавьяаг мөнхжүүлэх, түүний мэндэлсний 130 жилийн ойг тэмдэглэн өнгөрүүлэх талаар авах зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Төрийн байгуулалтын байнгын хороонд шилжүүлэв.

Уг асуудлыг 15 цаг 30 минутад хэлэлцэж дуусав.

*Зургаа дахь асуудал буюу “Батлан хамгаалахын техник, тоног төхөөрөмж болон технологи шилжүүлэх тухай Монгол Улсын Засгийн газар, Япон Улсын Засгийн газар хоорондын хэлэлцээр”-ийг соёрхон батлах тухай хуулийн төслийг **Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 44 дүгээр зүйлийн 44.2-т заасны дагуу эцэслэн батлах санал хураалт явуулав.***

Д.Амарбаясгалан: Байнгын хорооны саналаар “Батлан хамгаалахын техник, тоног төхөөрөмж болон технологи шилжүүлэх тухай Монгол Улсын Засгийн газар, Япон Улсын Засгийн газар хоорондын хэлэлцээр”-ийг соёрхон батлах тухай хуулийн төслийг эцэслэн батлах санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 71

Татгалзсан: 23

Бүгд: 94

75.5 хувь буюу нийт гишүүдийн олонхын саналаар хууль батлагдлаа.

Уг асуудлыг 15 цаг 32 минутад хэлэлцэж дуусав.

Найм.Үндэсний баялгийн сангийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн Ашигт малтмалын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүд /Засгийн газар 2024.12.25-ны өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Н.Учрал, мөн газрын дэд дарга Д.Цолмон, Хууль зүй, дотоод хэргийн яамны Хууль зүйн бодлогын газрын дарга Н.Жамъянхүү, Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны Эрдэс баялгийн бодлогын газрын дарга Г.Намчинсүрэн, мөн яамны Хуулийн хэлтсийн дарга Т.Ганбаатар, Эдийн засаг, хөгжлийн яамны Макро эдийн засгийн бодлогын газрын дарга Л.Энх-Амгалан, Сангийн яамны Татварын бодлогын газрын дарга Б.Тэлмүүн, Татварын ерөнхий газрын дарга Ч.Чимидсүрэн, “Эрдэнэс Монгол” ХХК-ийн гүйцэтгэх захирал С.Наранцогт, мөн компанийн Хууль, эрх зүйн зөвлөлийн дарга Б.Гэрлээ нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга Ч.Ариунхур, Хуулийн газрын дарга Ч.Дондогмаа, мөн газрын Зөвлөх үйлчилгээний хэлтсийн зөвлөх П.Хулан, мөн хэлтсийн ахлах мэргэжилтэн Б.Агиймаа, Байнгын хороодын ажлын албаны Эдийн засгийн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Д.Мягмарцэрэн, референт Б.Уулганцэцэг нар байлцав.

Төслийг анхны хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх Эдийн засгийн байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Б.Пүрэвдорж танилцуулав.

Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн А.Ариунзаяа, О.Батнайрамдал, А.Ганбаатар, Х.Булгантуяа, М.Бадамсүрэн, Б.Пунсалмаа, А.Ундраа, Б.Батбаатар, Ц.Мөнхтуяа нарын

тавьсан асуултад Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Н.Учрал, Сангийн яамны Татварын бодлогын газрын дарга Б.Тэлмүүн, “Эрдэнэс Монгол” ХХК-ийн гүйцэтгэх захирал С.Наранцогт нар хариулж, тайлбар хийв.

Үндэсний баялгийн сангийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн Ашигт малтмалын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаарх Эдийн засгийн байнгын хорооноос гаргасан зарчмын зөрүүтэй саналын томьёоллоор санал хураалт явуулав.

Эдийн засгийн байнгын хорооны дэмжсэн санал:

Д.Амарбаясгалан: 1.Улсын Их Хурлын гишүүн Г.Уянгахишигийн гаргасан, Төслийн 1, 2, 3 дугаар зүйлийг нэгтгэн доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“1 дүгээр зүйл.Ашигт малтмалын тухай хуулийн 47² дугаар зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

“47² дугаар зүйл.Стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордын ашигт малтмалын нөөц ашигласны тусгай төлбөр

47².1.Энэ хуулийн 5.3, 5.4, 5.5-д заасан төрийн эзэмшлийн хувь, хэмжээг стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордын ашигт малтмалын нөөц ашигласны тусгай төлбөрөөр орлуулах тохиолдолд тусгай зөвшөөрөл эзэмшигч хуулийн этгээд нь тусгай төлбөрийг энэ хуулийн 47².2-т заасан хувь хэмжээгээр тооцож төлнө.

47².2.Энэ хуулийн 47².1-д заасан стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордын ашигт малтмалын нөөц ашигласны тусгай төлбөрийн хувь, хэмжээг тухайн ордын онцлогоос хамаарч Засгийн газрын өргөн мэдүүлснээр Улсын Их Хурал тогтооно.” гэсэн Эдийн засгийн байнгын хорооны дэмжсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн:	65
Татгалзсан:	29
Бүгд:	94

69.1 хувийн саналаар дэмжигдлээ.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн С.Бямбацогт үг хэлэв.

Зарчмын зөрүүтэй саналын томьёоллоор санал хураалт явуулж дууслаа.

Үндэсний баялгийн сангийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн Ашигт малтмалын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Эдийн засгийн байнгын хороонд шилжүүлэв.

Уг асуудлыг 16 цаг 37 минутад хэлэлцэж дуусав.

Чуулганы нэгдсэн хуралдаанаар 8 асуудал хэлэлцэв.

Чуулганы нэгдсэн хуралдааны зохион байгуулалтыг Улсын Их Хурлын Тамгын газрын Хуулийн газрын Хуралдаан зохион байгуулах хэлтсийн дарга Н.Наранцогт, шинжээч Ш.Мөнхцоож, С.Энхзаяа, ахлах мэргэжилтэн С.Золжаргал нар хариуцан ажиллав.

Хуралдаан 5 цаг 32 минут үргэлжилж, 126 гишүүнээс 94 гишүүн хүрэлцэн ирж, 74.6 хувийн ирцтэйгээр 16 цаг 38 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:

ЕРӨНХИЙ НАРИЙН
БИЧГИЙН ДАРГА

Б.БААСАНДОРЖ

Тэмдэглэл хөтөлсөн:

ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ
ХЭЛТСИЙН ШИНЖЭЭЧ

П.МЯДАГМАА

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2025 оны 01 дүгээр сарын 09-ний өдөр,
Пүрэв гараг Төрийн ордон “Их хуралдай” танхим 10 цаг 02 минут.

НЭГДСЭН ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

Д.Амарбаясгалан: Улсын Их Хурлын гишүүдийн энэ өглөөний амгаланг айлтгая. Чуулганы нэгдсэн хуралдааны ирц хүрсэн тул 2025 оны 1 дүгээр сарын 9-ний өдрийн нэгдсэн хуралдаан нээснийг мэдэгдье ээ.

Чуулганы нэгдсэн хуралдаанаар өнөөдөр 8 асуудлыг хэлэлцэнэ.

Хэлэлцэх асуудлыг танилцуулъя.

Нэгдүгээрт, Цөмийн энергийн тухай хуульд заасны дагуу хөрөнгө оруулагчтай байгуулах хөрөнгө оруулалтын гэрээг зөвшилцөх дэгийн тухай хуулийн төслийг хэлэлцэнэ.

Хоёрдугаарт, “Стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордын эзэмшлийн хувь хэмжээг орлуулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн анхны хэлэлцүүлгийг явуулна.

Гуравдугаарт, Элчин сайдыг томилох саналыг зөвшилцөх тухай асуудлыг хэлэлцэнэ.

Дөрөвдүгээрт, “Тогтоолын хавсралтад нэмэлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн хэлэлцэх эсэх хэлэлцүүлгийг явуулна.

Тавдугаарт, “Жамсрангийн Самбуугийн алдар гавьяаг мөнхжүүлж түүний мэндэлсний 130 жилийн ойг тэмдэглэн өнгөрүүлэх талаар авах зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн анхны хэлэлцүүлгийг явуулна.

Зургаадугаарт, Батлан хамгаалахын техник тоног төхөөрөмж болон технологи шилжүүлэх тухай Монгол Улсын Засгийн газар Япон Улсын Засгийн газар хоорондын хэлэлцээрийг соёрхон батлах тухай хуулийн төслийг хэлэлцэнэ.

Долоодугаарт, “Стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордын эзэмшлийн хувь хэмжээг орлуулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн эцсийн хэлэлцүүлгийг явуулна”

Наймдугаарт, Үндэсний баялгийн сангийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг явуулна.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 29.1-д Улсын Их Хурлын дарга хууль санаачлагчаас Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн төслийг хэлэлцүүлэгт бэлтгэх Байнгын хороог хэрэв тухайн төсөл хэд хэдэн

Байнгын хорооны эрхлэх асуудлын хүрээнд хамаарахаар бол зөвлөлтэй зөвшилцөн холбогдох болон бусад Байнгын хороог тогтоож, нэгдсэн хуралдаанд мэдээлнэ гэж заасан байгаа.

Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг холбогдох Байнгын хороонд хуваарилсан талаар танилцуулъя.

1.Эрүүгийн хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг Улсын Их Хурлын гишүүн Чулуунбилигийн Лодойсамбуу нарын 19 гишүүн 2024 оны 12 дугаар сарын 27-ны өдөр өргөн мэдүүлснийг ХЗБХ-нд,

2.Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон уг хуулийн төсөлтэй холбогдуулан боловсруулсан Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг Засгийн газраас 2024 оны 12 дугаар сарын 27-ны өдөр өргөн мэдүүлснийг ХЗБХ-нд.

3.Батлан хамгаалахын техник тоног төхөөрөмж болон технологи шилжүүлэх тухай Монгол Улсын Засгийн газар, Япон Улсын Засгийн газар хоорондын хэлэлцээрийг соёрхон батлах тухай хуулийн төслийг Засгийн газраас 2024 оны 12 дугаар сарын 27-ны өдөр өргөн мэдүүлснийг Аюулгүй байдал гадаад бодлогын байнгын хороонд тус тус хуваарилсан.

Хэлэлцэх асуудалдаа оръё. Цөмийн энергийн тухай хуульд заасны дагуу хөрөнгө оруулагчтай байгуулах хөрөнгө оруулалтын гэрээг зөвшилцөх дэгийн тухай хуулийн төслийг хэлэлцэнэ.

Төслийн талаарх Ёс зүй, дэгийн байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Ёс зүй, дэгийн байнгын хорооны дарга Баярмагнай Баярбаатар танилцуулна аа. Индэрт урьж байна.

Б.Баярбаатар: Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Их Хурал 2024 оны 11 дүгээр сарын 21-ний өдөр Цөмийн энергийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулж цөмийн энергийг ашиглах хөрөнгө оруулалтын гэрээний эрх зүйн орчныг бүрдүүлсэн. Цөмийн энергийн тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.3 дахь хэсэгт энэ хуулийн 30.1-д заасан гэрээг хөрөнгө оруулагчтай Засгийн газар байгуулахдаа Улсын Их Хурлын аюулгүй байдлын асуудал эрхэлсэн Байнгын хороотой зөвшилцөнө гэж заасныг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас 2025 оны 1 дүгээр сарын 8-ны өдөр Бадрах Энержи ХХК, Хөрөнгө оруулагч Орона Майнинг Си Эй Си компанитай байгуулах Хөрөнгө оруулалтын гэрээний төслийг зөвшилцөхөөр ирүүлсэн байна аа.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 10 дугаар бүлгээр олон талт олон улсын гэрээ байгуулах санал гэрээний төслийг Байнгын хороо болон нэгдсэн хуралдаанаар хэлэлцэх асуудлыг тусгайлан зохицуулдаг боловч Цөмийн энергийн тухай хуульд заасан хөрөнгө оруулагчтай байгуулах хөрөнгө оруулалтын гэрээний төслийг зөвшилцөх асуудлыг хуульчлаагүй байна аа.

Иймд Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1 дэх хэсэгт тухайн асуудлыг хэлэлцэх хуралдааны дэгийг энэ хуулиар зохицуулаагүй бол уг асуудлыг хэлэлцэх дэгийг Ёс зүй, дэгийн Байнгын хороо хэлэлцэж саналаа нэгдсэн хуралдаанд оруулна гэж заасны дагуу Цөмийн энергийн тухай хуульд заасны дагуу хөрөнгө оруулагчтай байгуулах хөрөнгө оруулалтын гэрээг зөвшилцөх дэгийн тухай хуулийн төслийг Улсын Их Хурлын Ёс зүй, дэгийн байнгын хороо 2025 оны 1 дүгээр сарын 8-ны өдрийн хуралдаанаараа хэлэлцлээ.

Хуулийн төсөл нь 12 зүйлтэй бөгөөд гэрээний төслийг БОХХАА-н төсвийн болон Эдийн засгийн байнгын хороо тус тусдаа урьдчилан хэлэлцэхээс гадна нам эвслийн бүлэг хэлэлцсэн санал, дүгнэлтээ Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороонд хүргүүлж нэгтгэн хэлэлцэх. Тус байнгын хороогоор төслийг хэлэлцэхэд Монгол Улсын Ерөнхий сайд эсвэл тухайн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн хуралдаанд танилцуулах, гэрээний төсөлтэй холбогдуулан гишүүд асуулт асууж, үг хэлэхээр төсөлд тусгалаа.

Гэрээний төслийн агуулга ач холбогдлыг нь харгалзан Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороо гишүүдийн олонхын саналаар гэрээний төслийг нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэн зөвшилцөхөөр шийдвэрлэж болох ба хуралдаанд оролцсон гишүүдийн олонх Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны санал, дүгнэлтийг дэмжсэн бол оруулсан Улсын Их Хурлын тогтоол баталсанд тооцохоор түүнчлэн уг хуулийг баталсан өдрөөс эхлэн Засгийн газраас Цөмийн энергийн тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.3-д заасны дагуу Хөрөнгө оруулалтын гэрээг зөвшилцөл дуустал хугацаанд дагаж мөрдөхөөр тус тус тусгалаа.

Байнгын хорооны хуралдаанаар хуулийн төслийг хэлэлцэх үед Улсын Их Хурлын гишүүн Д.Рэгдэл төслийн 11 дүгээр зүйлд заасан хуралдаанд оролцсон гишүүдийн олонхын талаар тодруулга асуулт асуусан бөгөөд Байнгын хорооны гишүүдээс үг хэлж, санал гаргаагүй болно.

Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Цөмийн энергийн тухай хуульд заасны дагуу хөрөнгө оруулагчтай байгуулах хөрөнгө оруулалтын гэрээг зөвшилцөх дэгийн тухай хуулийн төслийг хэлэлцсэн талаарх Ёс зүй, дэгийн байнгын хорооны санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг та бүхнээс хүсье ээ.

Д.Амарбаясгалан: Баярлалаа. Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан асуулт асууж, үг хэлэх Улсын Их Хурлын гишүүд нэрээ өгье.

Гурван гишүүнээр тасаллаа. Пүрэвжавын Сайнзориг гишүүн.

П.Сайнзориг: Гишүүддээ бас энэ өглөөний мэндийг хүргэе ээ. Тэгээд оруулж ирж байгаа дэгтэй холбоотой зүгээр 2, 3 редакцын зүйлүүд дээр анхаарч өгөөч л гэж хүсэлтэй байгаа. Ер нь бол зарчмын хувьд дэгийн төслийг дэмжиж байна. Хуулийн төслийн 7 дугаар зүйл дээр байгаа юм аа. Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороо гэрээний төслийн талаар ил санал хураалт явуулж хуралдаанд оролцсон гишүүдийн олонхын саналаар дараах санал дүгнэлтийн аль нэгийг гаргана гээд байж байгаа. Энэ дээрээ нэг зүйл байгаа.

Гэрээний төслийг дэмжээгүй бол шалтгааныг тайлбарласан санал, дүгнэлтийг Засгийн газарт хүргүүлэх гэгчихсэн байгаа. Гэрээний төслийг зүгээр шалтгааныг гэдэг зүйл их тийм ойлгомжгүй л болчихоод байгаа юм. Ер нь зүгээр үндэслэл бүхий л хариу өгөх ёстой. Яагаад энэ гэрээний төслийг дэмжээгүй вэ гэдэг талаар үндэслэл бүхий тийм тайлбар гэдэг юм уу тэр зүйлийг шийдвэрээ хүргүүлэх тэр асуудлаа дурдмаар байгаа юм. Тэгэхээр шалтгааныг тайлбарласан санал, дүгнэлт биш уг нь үндэслэл бүхий хариу гэж өгмөөр байна.

Улсын Их Хурал нэг их тайлбарлаад байх шаардлага байна уу үгүй юу Засгийн газарт, Дэмжсэн дэмжээгүй гэдэг үндэслэл бүхий шийдвэрээ л хүргүүлэх ёстой байгаа. Яах вэ зүгээр энэ дэг дээр дэмжээгүй гэдэг юм уу тодорхой зүйлүүдийг Засгийн газарт хугацаатай чиглэл өгөөд тэрийгээ хөрөнгө оруулагч талтайгаа хэлэлцээд ороод ирвэл богино хугацаанд буцаахгүйгээр хэлэлцээд явах тийм процедурын асуудлыг хөндөж ярилцаж үзээгүй юу гэдэг зүйлийг ийм 2 асуулт байна аа. Тэгээд товчхон хариулт өгөхийг хүсье ээ.

Д.Амарбаясгалан: Байнгын хорооны дарга Баярбаатар дарга хариулт өгье.

Б.Баярбаатар: Сайнзориг гишүүний саналыг дэмжиж байна. Энэ редакцын саналыг авах нь зөв байх. Шалтгаан гэдгийг үндэслэл гэдгээр редакцын засвар хийе. Ер нь бол энэ дэг 12 зүйл бүхий дэг байгаа юм. Тэгээд энэ дээр бид нар Тамгын газартайгаа ярилцаж зөвшилцөөд бүх л боломжийг нь дэгээр олгоод өгчихсөн байгаа. Буцаагдах, шаардлагатай бол Улсын Их Хурал руу татаж оруулж ирж хэлэлцэх эд нар гэсэн бүх зүйлүүдийг нь энэ гэрээний төслийн ач холбогдлыг нь харгалзаад оруулж өгсөн байгаа. Зүгээр яг таны хэлсний дагуу хугацаатай тийм зүйл өгөхийг заавал дэгд оруулаад байх шаардлагагүй. Хэрвээ шаардлагатай бол тэр үедээ хурлын завсарлагын үеэр ч юм уу тодорхой хугацаанд хурлыг завсарлуулаад асуудлыг дахиж шийдвэрлэх боломж нь байгаа болов уу гэж харагдаж байна.

Д.Амарбаясгалан: Сайнхүүгийн Ганбаатар гишүүн асуулт асууя.

С.Ганбаатар: Байнгын хороогоор хэлэлцэхдээ би энэ танилцуулга дээр байна. Төслийн хугацаанд хувь нийлүүлсэн зээлийг хязгаарлаж зээл авах зайлшгүй онцгой шаардлага үүссэн тохиолдолд хувьцаа эзэмшигчдийн хурлын 100 хувийн шийдвэрээр шийдвэрлэхээр тохирлоо гэж байна. Энэ хувьцаа эзэмшигчдийн дотор Монголын талын хэдэн хүн байгаа вэ? Энэ 100 хувийн шийдвэрээр гэдэг дотор Монголчуудын оролцож байгаа тэр хүмүүсийн оролцоо, хувь бяр тэнхээ, шийдвэрт оролцох нөхцөл байгаа юу? Оюу Толгой бол одоо ТУЗ-өөрөө зээл авсаар байгаад 17.6 тэрбум долларын зээлтэй. Оюу Толгойн төсөл дампуурчихсан гэсэн үг. Бид нар яагаад ноогдол ашиг авдаггүй вэ гэвэл тэдний зээлийг төлөх гэж ядарч байгаа гэсэн үг. Ийм байдал руу оруулахгүйн тулд энэ 100 хувийн энэ асуудал дээр Монголчуудын оролцоо, Монголчуудын бяр тэнхээ байгаа юу? 1 дүгээр асуулт.

Би энэ танилцуулгатай холбогдуулж асууж байна шүү.

Хоёрдугаар асуулт. Засгийн газрын бүтээгдэхүүний 10 хүртэл хувийг хөрөнгө оруулагчтай ижил нөхцөл болзлын дагуу худалдан авахаар гэрээний төсөлд тусгалаа гэж байна. Шар нунтаг уранаасаа бид нэг 10 хувийг авах юм байна. Уг нь 34 байсан одоо бид сайн дураараа сайхан сэтгэл гаргаж татгалзаад 10 хувийг нь

авна. Бидний энэ 10 хувиар бага оврын реактораар бид ногоон хямд эрчим хүч үйлдвэрлэх нэг нартай сайхан өдөр ирэхэд энэ 10 хувь хангалттай юу? Энэ талаар Байнгын хороогоор ярихдаа тооцоо, судалгаа, үндэслэлийг нь гаргасан уу? 10 хувь хүрэхгүй эсвэл 10 хувь хангалттай хүрнэ гэсэн ийм асуулт байна.

Гуравдугаар асуулт. Энгийн болон аюултай хог хаягдлын менежментийг хэрэгжүүлэхдээ Хог хаягдлын хуульд заасны дагуу ангилан ялгаж дахин боловсруулах болон бусад шаардлагатай арга хэмжээг авч хэрэгжүүлэх бусад шаардлагатай гэдэг энэ бөөрөнхий үгэн дотор аюултай хог хаягдлаа боловсруулах булшлах үйлдвэр баригдахаар нарийвчилж ТЭЗҮ дээр туссан уу гэдгийг асууж байна. Ийм 3 асуулт дээр би хариулт авъя.

Д.Амарбаясгалан: Ганбаатар гишүүн гэрээний агуулгатай холбоотой асуудал асууж байна. Ёс зүй, дэгийн байнгын хороо Дэгийн хуулийн зохицуулалт оруулж ирж байгаа учраас хариулах боломжгүй.

Нацагдоржийн Батсүмбэрэл гишүүн асуулт асууя.

Н.Батсүмбэрэл: Оруулж ирсэн асуудлыг дэмжиж байна. Тэгээд асуулт байна.

Нэгдүгээрт энэ 6 дугаар зүйл дээр байгаа гэрээний төсөлтэй холбогдуулан гишүүд асуулт асууж, үг хэлж болно гэхихсэн байгаа. Болно гэдэг нь яг юу гэсэн үг вэ? Тэгээд энэ чинь нөгөө тодорхой тоо зааж үг хэлнэ гэсэн үг үү? Нийт гишүүд үг хэлнэ гэсэн үг үү? Энийг хоёрдмол биш нэг болгох нь зөв байна. Өөрөөр хэлэх юм бол энэ чухал асуудал учраас төсөвтэй ижил бүх Их Хурлын гишүүд үг хэлэх нь зүйтэй байх гэсэн ийм саналтай байна. Энэ дээр тодруулж асууя.

Хоёр дахь нь энэ 7 дугаар зүйл дээр ил санал хураалтаас гадна энэ Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороо хаалттай хуралдах бололцоог нээж өгөх шаардлагатай. Зарим асуудлыг хаалттай ярих шаардлага үүсэж болзошгүй байх. Энэ асуудлыг тусгаж өгвөл ямар байдаг юм болоо?

Гурав дахь асуулт нь энэ 12 дугаар зүйл байна. 12 дугаар зүйл уншихаар яг одоо явж байгаа гэрээнд зориулсан маягтай болчхоод байдаг. Энийг тодотгож хариулж өгөөч гэж асууж байна аа.

Д.Амарбаясгалан: Байнгын хороон дарга Баярбаатар хариулт өгье.

Б.Баярбаатар: Батсүмбэрэл гишүүний асуултад хариулъя.

Ойлголт нь бол бүх гишүүд асуулт асууж, үг хэлж, хариулт авах ийм нээлттэй байдлаар оруулж ирж байгаа тэгээд болно гэдэг нь яг энэ агуулгаа илэрхийлээд явж байгаа гэдгийг Дэгийн хуульдаа тусгаж өгсөн. Хаалттай хуралдаанаар хэлэлцэх асуудал угаасаа өнөөдрийн дэгд Байнгын хороо асуудлыг хаалттай хэлэлцэх асуудлын дэг нь өөрөө байж байгаа учраас заавал энэ дэг дээрээ оруулаад байх шаардлагагүй болов уу гэж Байнгын хорооны зүгээс үзсэн.

Д.Амарбаясгалан: Нацагдоржийн Батсүмбэрэл гишүүн тодруулж асууя.

Н.Батсүмбэрэл: Тэгэхлээр тэр юуг ойлголоо. 6 дугаар зүйл дээр байгаа томъёоллыг жоохон нарийвчлах нь байна. Тэгээд Их Хурлын гишүүд бүгд асуулт асууж, үг хэлэх эрх нээгдэх нь гэж ойлголоо. Тэгээд хаалттай болон нээлттэй хуралдах асуудал дэгээрээ явах нь байна. Тэр 12 дугаар зүйл одоо мявж байгаа энэ Орона болон Бадрах Энержи дээр яаж нөлөөлөх юм бэ? Энийгээ нэг тодорхой хариулт л хэрэгтэй байгаад байдаг. Энэ дээр Дэгийн байнгын хороо дээр нь нөгөө Засгийн газраас субъект байхгүй байгаад тэгээд эсвэл ажлын хэсгийнхэн ч юм уу хариулбал яадаг юм бол.

Д.Амарбаясгалан: Баярмагнайн Баярбаатар гишүүн хариулт өгье.

Б.Баярбаатар: Сая Байнгын хорооны дүгнэлт дээр тодорхой туссан байгаа. Өнөөдрийн манай мөрдөгдөж байгаа дэгээр бол олон талт гэрээ болон 2 талт гэрээний асуудлыг хэлэлцэх дэг нь байдаг. Өнөөдрийн энэ бид нарын батлах дэгээр бол 2 ААН-ийн хоорондох хөрөнгө оруулалтын гэрээг байгуулахыг Засгийн газарт зөвшөөрөл олгох ийм асуудал байгаа. Одоо энэ гэрээний асуудал нь энэ дэгийн хууль батлагдсаны дараагаар ингээд Улсын Их Хурлын гишүүдэд тараагдана. Ингээд тэрний дараагаар тэр саяын дэгд туссан 3 Байнгын хороо, нам эвслийн бүлгүүд нэгд хуралдаж дүгнэлтээ Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороонд хүргүүлж тэндээсээ ямар шийдвэр гарах вэ тэндээ асуудлаа шийдвэрлээд хагалаад явах уу эс үгүй бол Улсын Их Хурлын нэгдсэн чуулганд оруулж ирж дахин хэлэлцүүлгийг өргөн хэлбэрээр явуулах уу гэдэг шийдвэрийг Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороо саналаараа гаргах ёстой ийм дэгтэй байж байгаа.

Д.Амарбаясгалан: Улсын Их Хурлын гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа.

Одоо Байнгын хорооны саналаар Цөмийн энергийн тухай хуульд заасны дагуу хөрөнгө оруулагчтай байгуулах хөрөнгө оруулалтын гэрээг зөвшилцөх дэгийн тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулна аа.

Санал хураалт.

67.4 хувиар санал дэмжигдлээ.

Чуулганы хуралдаанд оролцсон гишүүдийн олонхоор дэмжсэнээр Даваагийн Цогтбаатар, Хосбаяр, Батсуурь, Жавхлан, Б.Бат-Эрдэнэ, Л.Энх-Амгалан, Х.Баасанжаргал, Хэрлэн гэсэн гишүүд, Бум-Очир гишүүн.

Д.Амарбаясгалан: Баярбаатар дарга горимын санал гаргая.

Б.Баярбаатар: Ёс зүй, дэгийн байнгын хорооноос асуудлаа хэлэлцүүлсэн учраас эцсийн найруулгыг сонсох горимын саналыг гаргачихъя.

Д.Амарбаясгалан: Энэ хууль эцэслэн баталж байгаа учраас 64-өөс дээш гишүүдээр батлагдах ёстой юм байна. Аюушийн Ариунзаяа гишүүн горимын санал гаргая.

А.Ариунзаяа: Хурлын дарга би сая бичиг баримт авах гэж гарч байгаад хоцорчихлоо, уучлаарай. Тэгээд уг нь дэмжиж байгаа манай Байнгын хорооноос

асуудал оруулж байгаа учраас. Хүчингүй болгоод дахиад санал хураах боломж байдаг юм болов уу?

Д.Амарбаясгалан: Ариунзаяа гишүүний гаргасан горимын саналаар санал хураалтыг хүчингүй болгоё. Гишүүд суудалдаа суугаад анхааралтай санал өгөхийг хүсэж байна.

Горимын саналаар санал хураалт явуулъя.

67 гишүүн дэмжиж санал хүчингүй боллоо.

Байнгын хорооны саналаар Цөмийн энергийн тухай хуульд заасны дагуу хөрөнгө оруулагчтай байгуулах хөрөнгө оруулалтын гэрээг зөвшилцөх дэгийн тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя аа.

Санал хураалт.

73 гишүүн буюу 83 хувиар санал дэмжигдлээ. Хуулийн төсөл батлагдлаа.

Улсын Их Хурлын гишүүдэд талархал дэвшүүлье.

Баярбаатар гишүүн сая Байнгын хороон дарга санал гаргасан. Дахиад саналаа илэрхийлье. Микрофон өгье.

Б.Баярбаатар: Хууль эцэслэн батлагдсан учраас эцсийн найруулгыг сонсох санал гаргуулж байна.

Д.Амарбаясгалан: Байнгын хорооны саналаар Ёс зүй, дэгийн байнгын хорооноос гаргасан саналын дагуу батлагдсан хуулийн эцсийн найруулгыг сонсоно.

1.Цөмийн энергийн тухай хуульд заасны дагуу хөрөнгө оруулагчтай байгуулах хөрөнгө оруулалтын гэрээг зөвшилцөх дэгийн тухай хуулийн эцсийн найруулга дээр саналтай гишүүд байна уу?

Пүрэвжавын Сайнзориг гишүүн.

П.Сайнзориг: Түрүүн Баярбаатар дарга саналыг авч болно гэж хэлсэн. Сая бас Улсын Их Хурлын Тамгын газрын алба хаагчидтай ярилцахад боломжтой гэж үзэж байна. Тийм гэсэн. Тийм учраас баталж байгаа хуулийн 7.3-ын гэрээний төслийг дэмжээгүй бол үндэслэл бүхий санал, дүгнэлтийг гэж редакц хийж эцсийн найруулгыг уншиж өгөхийг хүсье ээ. Баярлалаа.

Байнгын хороо эцсийн найруулга дээр хэлсэн гишүүний саналыг тусгая.

Ингээд эцсийн найруулгыг сонссонд тооцлоо.

10.23 цагт

Дараагийн асуудалд оръё. “Стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордын төрийн эзэмшлийн хувь хэмжээг орлуулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн анхны хэлэлцүүлгийг явуулна.

Төслийн анхны хэлэлцүүлгийг явуулсан талаарх Эдийн засгийн байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Улсын Их Хурлын дэд дарга Бөхчулууны Пүрэвдорж танилцуулна аа. Индэрт урьж байна.

Б.Пүрэвдорж: Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газраас 2024 оны 12 дугаар сарын 25-ны өдөр Улсын Их Хуралд яаралтай хэлэлцүүлэхээр өргөн мэдүүлсэн Стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордын төрийн эзэмшлийн хувь хэмжээг орлуулах тухай Монгол Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцэх эсэх асуудлыг Улсын Их Хурлын чуулганы 2024 оны 12 дугаар сарын 26-ны өдрийн нэгдсэн хуралдаанаар хэлэлцэж шийдвэрлэж төслийг анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Эдийн засгийн байнгын хороо болон холбогдох бусад Байнгын хороонд шилжүүлсэн.

Монгол Улсын Их Хурлын 2024 оны 338 дугаар захирамжаар тогтоолын төслийг Байнгын хорооны болон чуулганы нэгдсэн хуралдааны хэлэлцүүлэгт бэлтгэх, санал, дүгнэлтийн төсөл боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгийг байгуулж ажлын хэсгийн ахлагчаар Улсын Их Хурлын гишүүн, Улсын Их Хурлын дэд дарга Б.Пүрэвдорж, бүрэлдэхүүнд Улсын Их Хурлын гишүүн Б.Баярбаатар, Г.Тэмүүлэн, Ариунзаяа, Б.Батбаатар, О.Батнайрамдал, Ж.Баярмаа, Ш.Бямбасүрэн, Г.Ганбаатар, Х.Ганхуяг, Б.Найдлаа, У.Отгонбаяр, Д.Пүрэвдаваа, П.Сайнзориг, Х.Тэмүжин, Б.Уянга, Г.Уянгахишиг, Да.Цогтбаатар, С.Цэнгүүн, Ө.Шижир, Б.Энхбаяр, С.Эрдэнэбат нар ажиллалаа.

Эдийн засгийн байнгын хороо 2025 оны 1 дүгээр сарын 27-ны өдрийн хуралдаанаараа дээрх тогтоолын төслийн анхны хэлэлцүүлгийг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39 дүгээр зүйлд заасныг баримтлан явуулж дараах санал, дүгнэлтийг гарган та бүхэнд танилцуулж байна аа.

Байнгын хорооны хуралдаанаар тогтоолын төслийн анхны хэлэлцүүлгийг явуулах үед Улсын Их Хурлын гишүүн М.Бадамсүрэн, Н.Батсүмбэрэл, Л.Соронзонболд, Г.Уянгахишиг, Р.Сэддорж нар төсөлтэй холбогдуулан асуулт асууж хариулт авсан болно. Тогтоолын төслийг Байнгын хорооны болон чуулганы нэгдсэн хуралдааны хэлэлцүүлэгт бэлтгэх үүрэг бүхий ажлын хэсгийн зүгээс төслийн нэг дэх заалтад тусгагдсан ашигт малтмалын тусгай зөвшөөрлүүдийн дугаар солигдсоныг өөрчлөх, тогтоолыг дагаж мөрдөх огноог тодорхой болгох талаар зарчмын зөрүүтэй саналын томьёоллууд бэлтгэсэн бөгөөд Улсын Их Хурлын гишүүн Г.Уянгахишиг тогтоолын төсөлд төрийн эзэмшлийн хувь хэмжээг орлуулахад баримтлах зарчмыг тодорхой болгох талаар дэд заалт нэмэх зарчмын зөрүүтэй саналын томьёолол гаргаж, төслийн бүтэц, нэр, томьёолол, хэл найруулга, дэс дараалал, заалтын дугаарыг нийцүүлж өөрчлөх тухай найруулгын санал гаргасныг Монгол Улсын Их Хурлын чуулганы дэгийн тухай хуулийн 39 дүгээр зүйлийг баримтлан саналын томьёолол бүрээр санал хураалт явуулахад хуралдаанд оролцсон гишүүдийн олонх эдгээр саналуудыг дэмжлээ, Улсын Их Хурлын гишүүн Г.Уянгахишиг төслийн нэг дэх заалтын төрийн эзэмшлийн 34 хувийн гэсний дараа энгийн гэж нэмэх мөн заалтын 10 хувь гэснийг хасах, Улсын Их Хурлын гишүүн М.Бадамсүрэн стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордын

АМНАТ-ийн 30-аас доошгүй хувийг олборлолтын сөрөг нөлөөлөлд өртөж буй аймаг сумдын орон нутгийн тө хөгжлийн санд хуваарилах эрх зүйн үндсийг бий болгох чиглэлээр холбогдох арга хэмжээ авахыг Монгол Улсын Засгийн газарт даалгах. Улсын Их Хурлын гишүүн Л.Соронзонболд төслийн хавсралтын 40-өөс 50 хүртэл 0.5 гэснийг 40-өөс дээш 5 хувь гэж өөрчилж, 50-иас дээш 5 хувь гэснийг мөрийг хасах зэрэг зарчмын зөрүүтэй саналын томьёолол гаргасныг хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжээгүй байна.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордын төрийн эзэмшлийн хувь хэмжээг орлуулах тухай Улсын Их Хурлын тогтоолын төсөлтэй холбогдуулан ажлын хэсэгт болон Улсын Их Хурлын гишүүдийн зүгээс гаргасан зарчмын зөрүүтэй саналын томьёоллуудыг олонхын дэмжлэг авсан аваагүйгээр нь бүлэглэн томьёолж зарчмын зөрүүтэй саналуудын томьёоллуудыг санал, дүгнэлтийн хамт та бүхэнд хүргүүлсэн болно.

Тогтоолын төслийн анхны хэлэлцүүлгийг явуулсан талаарх Эдийн засгийн байнгын хорооны санал дүгнэлт, зарчмын зөрүүтэй саналын томьёоллыг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг та бүхнээс хүсье ээ.

Анхаарал тавьсанд баярлалаа.

Д.Амарбаясгалан: Ажлын хэсгийн гишүүдийг танилцуулъя.

Ням-Осорын Учрал Монгол Улсын сайд ЗГХЭГ-ын дарга, Дорждэрэмийн Цолмон ЗГХЭГ-ын дэд дарга, Санжаагийн Наранцогт Эрдэнэс Монгол компанийн гүйцэтгэх захирал, Бат-Эрдэнийн Хулан Монгол Улсын сайд ЗГХЭГ-ын даргын зөвлөх, Алтангэрэлийн Мандуул Монгол Улсын сайд ЗГХЭГ-ын даргын зөвлөх, Лхагвабаярын Энх-Амгалан Эдийн засаг, хөгжлийн яамны Макро эдийн засгийн бодлогын газрын дарга, Бямбарагчаагийн Тэлмүүн Сангийн яам, Татварын бодлогын газрын дарга, Нармандахын Жамъянхүү ХЗДХЯ-ны Хууль зүйн бодлогын газрын дарга, Гүнчинсүрэнгийн Намчинсүрэн Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны Эрдэс баялгийн бодлогын газрын дарга, Цэрэндоржийн Уранчимэг Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яамны Байгалийн нөөцийн бодлогын хэрэгжилтийн газрын дарга, Шаравдоржийн Ганхуяг АМГТГ-ын дарга, Чойгүнсэнгийн Чимэдсүрэн Татварын ерөнхий газрын дарга, Зэнээмядарын Батбаяр Усны газрын дарга, Гунаажавын Манлайжав Цөмийн энергийн комиссын ажлын албаны дарга Мавагийн Чадраабал Цөмийн энергийн комиссын Ажлын албаны Цөмийн технологийн бодлогын газрын дарга, Энхгэрэлийн Нямдаваа Цөмийн энергийн комиссын ажлын албаны Цөмийн аюулгүй байдлын бодлогын газрын дарга, Лхагвасүрэнгийн Жаргалсайхан ШУА-ийн Хими, хими технологийн хүрээлэнгийн захирал, Цагааны Өнөрнасан Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны Геологи, уул уурхайн БХЗГ-ын ахлах шинжээч, Балжиннямын Гэрлээ Эрдэнэс Монгол Компанийн Хууль эрх зүйн зөвлөлийн дарга, Лувсаншаравын Наранчимэг Эрдэнэс Монгол компанийн Дотоод хяналт, эрсдэлийн удирдлагын газрын дарга, Цэдэнбалжирын Төгсбуйан Эрдэнэс Монгол компанийн Үйлдвэрлэлийн бодлогын газрын дарга, Түмэнжаргалын Төрбадрах Эрдэнэс Монгол компанийн хамтын ажиллагааны хэлтсийн дарга, Доржбалын Далайжаргал Мон-Атом компанийн захирал, Дашдаваагийн Сугарсүрэн Мон-Атом компанийн Захиргааны албаны дарга, Амарсанаагийн Алтанхундага Мон-Атом компанийн ахлах геологич, Дашдоржийн Баярхүү Олон улсын

харилцааны судлаач профессор, Яндагийн Ганболд Монголын мал эмнэлгүүдийн дундын хоршооны зөвлөх, Монгол Улсын шинжлэх ухааны гавьяат зүтгэлтэн, академич, профессор, Норовын Тэгшбаяр Физик ухааны доктор, Ганбатын Мөнхболд Дотоодын хуулийн зөвлөх, Баярбатын Батмандах Дотоодын хуулийн зөвлөх, Зуунайн Шагдарсүрэн Дотоодын хуулийн зөвлөх, Сүхдоржийн Батхүлэг Дотоодын хуулийн зөвлөх.

Ингээд Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан намын бүлэг болон бүлэгт харьяалагдаагүй гишүүдээс урьдчилан ирүүлсэн нэрсийн дагуу асуулт асууна аа. Цагаанхүүгийн Идэрбат гишүүн асуулт асууя.

Ц.Идэрбат: Та бүхэнд өглөөний мэнд хүргэе. Шинэ он гараад удаагүй байна. Шинэ оны анхны Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаан хуралдаж байна. Тэгээд ер нь бол одоо ингээд нөгөө Монголын төр бодлогогүй юм шиг, Монгол Улсад нөгөө бүх юм болохоо больчихсон юм шиг, энэ төр засаг, Их Хурал Засгийн газар, ард түмнээ ойлгохгүй байгаа юм шиг амьдралыг нь мэдрэхгүй байгаа юм шиг олон зүйлүүд сүүлийн үед их яригдаад байгаа юм.

Тийм учраас би нэг он цагийн дараалалтай нэг хэдэн зүйл хэлээд асуулт асууя гэж ингэж бодсон юм байгаа юм. Монгол Улс төрийн бодлого аль нэг нам гарснаараа биш, аль нэг даргын үзэмжээр биш эрдэмтдийнхээ батлагдсан алсын хараа гэдэг энэ 2050 гэдэг энэ бодлогын бичиг баримт 2018 оноос эхэлж боловсруулагдаж эхлээд өнөөдрийг хүртэл Монгол төрийн бүх байгууллагууд хэрэгжээд ингээд явж байгаа. 2019 онд Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтөөр байгалийн баялагтаа Монголчууд эзэн болно оо, баялгаасаа хувь хүртэнэ гэсэн энэ агуулгыг баялгийн сантай байна гэдэг энэ том өөрчлөлтийг 2019 оны Үндсэн хуулиараа хийж чадсан. 2021 оны шинэ сэргэлтийн бодлого гэж өнөөдрийн бидний ярьж байгаа энэ эрчим хүч энэ боомтын сэргэлтийг хийхгүйгээр Монгол Улс цаашаа хөгжихгүй юм байна гэдэг том бодлогыг гаргаж ирсэн. 2023 онд Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтөөр 76 биш 126 болж сонгуулийн систем юмаа өөрчилсөн. 2024 онд нэг маш том чухал хууль гарсан нь энэ Үндэсний баялгийн сан гэдэг энэ хууль гарч 2019 оны Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийг амилуулах энэ бололцоог бүрдүүлж өнөөдөр Монголын ард түмэн байгалийн баялгаасаа хувь хүртэх бүрэн дүүрэн бололцоотой болж эхэлсэн. Бүсчилсэн хөгжлийн асуудал яригдсан. 2024 онд хамтарсан Засгийн газар байгуулагдсан. Ингээд хамтарсан Засгийн газар эхний ээлжид Монгол Улсын эдийн засгийг тэлэх ард түмний амьдралыг өөд нь дээш нь татах 14 мега том төслийг хэрэгжүүлэх ийм том зорилт тавиад ингээд явж байгаа. Тэгээд энэ болгоныг би дурдаад байгаагийн шалтгаан бол Монголын төр байгаа. Монголын төрийн бодлого залгамж халаагаар дэс дараагаар бодлогоо хэрэгжүүлээд явж байгаа.

Эхний үр дүнгүүд нь гараад үнэхээр бид нар байгалийн баялагтаа эзэн болох бололцоо бодит байдал бий болж эхэлсэн гэдгийг би энд нэг оны эхэнд хэлчихье гэж ингэж бодож байгаа юм. Гэхдээ яах вэ бүх зүйл амьдрал сайхан болчихоод байгаа юм биш. Гэхдээ нөгөө холын зорилго байхгүй бол ойрын зовлон салахгүй гэж нэг том үг байдаг нэг үг байдаг. Тэгэхээр Монгол Улсын төрийн бодлого бол энэ холын зорилгоо зөв тодорхойлоод улс төрийн намууд нь хамтраад ингээд хичээгээд явж байгаа гэдгийг бас хэлэх гэж байгаа юм.

Хэлэлцэх гэж байгаа асуудалтай холбогдуулаад нэг асуух зүйлүүд байгаа. Энэ дээр юу вэ гэхээр энэ стратегийн 2007 оны Улсын Их Хурлын 27 шиг санаж

байна. Тогтоолоор стратегийн ордуудыг 1. 2 дугаар хавсралтаар баталсан. Үүнээс 15 стратегийн ордыг 1 дүгээр хавсралтаараа баталсан байгаа. Эндээс энэ баялгийн сан руу 34 хувиа авах энэ хэлэлцээр ер нь ямархуу шатанд явж байгаа вэ? Нөгөө талдаа би нэг зүйлийг тодруулж асууя гэж байгаа нь Монгол Улсын Их Хурлын 2007 оны 27 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтаар 39 ордыг стратегийн ордод бас 2 дугаар хавсралтаараа оруулсан байдаг юм билээ. Тэгэхээр энэ 15 энэ 39 гэсэн энэ ордууд маань энэ баялгийн сангийн хуулийн хэрэгжилтийг хангах энэ үйл явц ямархуу байдлаар явж байгаа вэ? Хэрвээ өнөөдөр бид нар тав, зургаахан ордын ашгаар Үндэсний баялгийн сандаа хуримтлал үүсгэж эхэлсэнтэй адил энэ 30, 40 ААН энэ ордуудаа бид эргэлтэд оруулбал энэ байтугай боломж Монголын ард түмэнд гарах юм байна гэж ингэж харж байгаа учраас.

Д.Амарбаясгалан: Хариулт өгье ЗГХЭГ-ын дарга Ням-Осорын Учрал гишүүн.

Н.Учрал: Идэрбат гишүүнд баярлалаа. Үндэсний баялгийн сангийн хууль өнгөрсөн парламентад батлагдсан нь бол энэ Үндсэн хуулийн 6.2 гэдэг заалтыг амилуулах ийм арга замыг тодорхой болгосон. Тэгэхээр бид сая энэ хөрөнгө оруулалтын гэрээг хийхдээ нэг ийм жанжин шугамтай байсан. Тэр юу вэ гэвэл газрын хэвлийн баялгийн 50 дээр нэмэх 1-ийг ард түмэн эзэмшинэ гэж. Энэ жанжин шугамыг давж болохгүй. Нэг ёсондоо хэмжүүр тавьчихсан. Ингээд баялгийн сан хуримтлал бүрдүүлээд иргэд түүнийг хадгаламж хэлбэрээр хараад түүнийгээ эрүүл мэнд, орон сууц, боловсролдоо зарцуулж болох юм байна гэдгийг сая оны н өмнө нь харуулсан. Уул уурхайн тавхан ТӨК хуримтлал бүрдүүлэхэд 480 орчим тэрбум төгрөг хуримтлагдана гэдэг энэ үр дүн. Тэгэхээр цаашдаа ТӨК-ууд, уул уурхайн компаниуд ашигтай ажиллах юм бол хуримтлалын сан дээр нь хуримтлал нь нэмэгдээд түүнийгээ иргэд, эрүүл мэнд, боловсрол орон сууцдаа зарцуулж болдог, өнөөгийн иргэд. Ийм боломжийг л бид нар эрэлхийлэх ёстой.

Энэ утгаараа Засгийн газрын зүгээс Үндэсний баялгийн сангийн хуулийн хүрээнд энэ төрийн эзэмшлийн 34 хувийг хэрхэн тохиролцох вэ гэдэг стратегийн ордуудыг эзэмшиж байгаа хувийн компаниудтай хэрхэн хэлэлцээр хийгээд 34 хувиа авч иргэд түүнийгээ эрүүл мэнд, боловсрол орон сууцдаа хэрхэн зарцуулах вэ гэдэг чиглэлээр хэлэлцээр хийх ажлын хэсэг байгуулсан. Өчигдөр Засгийн газрын зүгээс жишээ нь Эрдэнэтийн үүсмэл орд Ачит эхтэй холбоотой 34 хэлэлцээрийг хийх ажлыг эхлүүлсэн. Бид нар санхүүгийн шинжээч нар авна, хуулийн баг авна. Ингээд хувьдаа ч ашигтай, төрдөө ч ашигтай, иргэддээ ч ашигтай хэлэлцээрийг хийнэ. Үүнийг Их Хурал Үндэсний баялгийн сангийн хуулиар амилуулж өгч байгаа.

Хэрвээ Их Хурал энэ 7 хоногт Үндэсний баялгийн сангийн хуулийг дагалдуулсан. Хэрвээ төрийн эзэмшлийн 34-ийг АМНАТ-аар орлуулсан тохиолдолд тэр АМНАТ-аар орлуулсан хэсэг нь иргэний хуримтлалын данс руу шилждэг зохицуулалтыг хийж чадах юм бол бид төрийн эзэмшлийн 34 хувийг зүгээр аваад ирээдүйд нөгөө өр үүсгээд санхүүгийн хариуцлага хүлээгээд хөрөнгө оруулах хариуцлага хүлээгээд хувийн компаниудын менежмент рүү ороод байх биш байгалийн баялагтаа иргэд эзэн болоход тэр 34 хувийн тодорхой хэсгийг нь тусгай АМНАТ-аар орлуулаад нөгөөдхийг нь хуримтлалын сан руу хийдэг. Тэгээд тодорхой хувийг нь энэ давуу эрхийн хувьцаа болгодог. Энэ Ураны хөрөнгө оруулалтын гэрээний жишгийг бусад стратегийн ордууд дээр нэвтрүүлснээрээ хувьдаа ч ашигтай, төрдөө ч, иргэддээ ч ашигтай ийм хэлэлцээрүүд хийгээд ирэх оны 12 сар гэхэд иргэд хуримтлалын дансаа аль компани надад ямар хэмжээний хуримтлал

бүрдүүлэв гэдгийг хардаг иргэд үүнийгээ хүр хүртдэг ийм л нөхцөлийг бүрдүүлэх болно.

Цагаанхүүгийн Идэрбат гишүүн тодруулж асууя.

Ц.Идэрбат: Тийм баялгийн сангийн хуулиар ийм том боломж гарсан. Ер нь Монголчууд бол яах вэ энэ чинь 2 ч юмнаас бид нар хувь хүртээд эхэллээ шүү дээ. Нөгөө нүүрсний хулгай цэгцэрснээс авхуулаад Тавантолгойн нүүрсний ордоос 350 мянган төгрөг, өнгөрсөн жил энэ чинь 100 гаран мянган төгрөг байсан ингээд нэмэгдэж байгаа. Үндэсний баялгийн сангаараа 130 хэдэн мянган төгрөг ингээд аваад эхэлж байгаа. Энэ бол дөрөв, тавхан ордоос бид нар ашиг хүртэж байгаа. Харин Улсын Их Хурлаар тэр 2007 оны 27 дугаар тэр хавсралт 2.39-ийг бас энэ Үндэсний Баялгийн сантай холбох асуудлаа яаравчлах хэрэгтэй байх гэж ингэж бодож байгаа юм. Нөгөө талдаа би өнгөрсөн парламентын үед Сандаг-Очир гишүүнээр ахлуулаад энэ уул уурхайн асуудлаар хяналт шалгалтын түр хороо гараад Улсын Их Хурлын 62 дахь тогтоол гарсан байгаа.

Тэгэхдээ энэ одоо яг Их Хурлын сонгуулийн ердөө өмнөхөн. Тэгэхээр энэ 62 дугаар тогтоолын хэрэгжилтийг хангах тал дээр Засгийн газар бас ямар арга хэмжээ авч байгаа вэ?

Д.Амарбаясгалан: Учрал сайд нэмж хариулт өгье.

Н.Учрал: Идэрбат гишүүний асуултад хариулъя.

Энэ тогтоолын хэрэгжилтийг хангуулахаар ер нь бол ажлын хэсэг гарсан. Тэгэхээр Их Хурлаас Засгийн газарт өгсөн үүрэг чиглэлүүдийг, энэ тогтоолуудыг хэрэгжүүлэх нь бидний үүрэг. Энэ утгаараа тогтоол бүр дээр ажлын хэсгүүд гарч ажиллаж байгаа. Тэгээд энэ ажлын хэсгийн тайлан мэдээг танд бас эргээд бид бол илүү тодорхой мэдээлэл өгнө өө. Тэгээд түрүүн хэлсэн тэр стратегийн ордууд дээр ч гэсэн, өчигдөр энэ 34 хувийн хэлэлцээг хийх ажлын хэсэг байгуулагдсантай холбогдуулаад эхлээд 2 хувийн хэвшил буюу стратегийн орд эзэмшиж байгаа компаниудаас хүсэлт ирүүлсний дагуу эхний 2 компанитай хэлэлцээ хийх ажил ирэх 7 хоногоос эхлэх болно.

Д.Амарбаясгалан: Отгоншарын Батнайрамдал гишүүн асуулт асууя.

О.Батнайрамдал: Баярлалаа. Өглөөний мэнд. Сая Ганбаатар гишүүн нэг мэдэгдэл хийчих шиг боллоо л доо. Тэрнээс эхэлье гэж бодлоо. Оюу Толгой төслийг дампуурчихсан гээд хэлчхэв. Жишээ нь юу сонсчхов. Оюу Толгой төсөл чинь одоо таны үгээр бол дампуурчихсан, өнгөрсөн цаг дээр болж таарлаа шүү дээ. Ингээд бодоод байсан чинь яг тэрийг юу санагдуулж байна гэсэн чинь нэг хэдэн жилийн өмнө нэг улс төрч бас яг энэ ордны энэ чуулганы танхим дээрээс нэг мэдэгдэл хийж байсан. Эрдэнэт үйлдвэрийг эмчилгээ сувилгаанд нь орох болчихсон хаалтаа хийх цаг нь болчихсон гээд, хийж байсан мэдэгдэлтэй яг адилхан сонсогдож байна. Тэгж дураараа дампуурчих төсөл биш л дээ энэ чинь. Монгол Улсын гадаадаас орж ирж байгаа хөрөнгө оруулалтын 40 хувийг дангаараа хариуцаж оруулж ирж байгаа дэлхийн хэмжээний төсөл. Тийм таны үгээр дампуурчихгүй байх. Тэгэхээр та энэ дээр яг албан ёсоор дампуурчихсан шалтгаанаа яг албан ёсоор мэдэгдэх ёстой гэж бодож байна. Чуулганы индэр дээрээс бид нар хариуцлагатай үг хэлэх ёстой. Ораногийн гэрээ дагалдаж ирсэн уншсан. Ер нь Ораногийн хөрөнгө оруулалтын

гэрээ сайн гэрээ болсон байна лээ. Бид нар хамгийн гол нь л Үндсэн хуулийнхаа зарчмыг хэрхэн хэрэгжүүлэх. Стратегийн ач холбогдол бүхий орд ашиглаж байгаа нөхцөлд өгөөжийнх нь дийлэнх нь Монголын талд хэрхэн ноогдох вэ? Ерөөсөө энийг л хангасан зохицуулалттай гэрээ орж ирсэн нь сайшаалтай. Тэгээд энэ гэрээний дараа 2 томоохон нарийвчилсан гэрээнүүд байгуулагдана. Хувь нийлүүлэгчдийн гэрээ болон орд ашиглалтын гэрээ. Тэгэхээр Учрал сайдаас 2 асуулт асуумаар байна.

Тэгэхээр энэ 2 нарийвчилсан зохицуулалтаа гэрээ орж ирэх ч гэсэн бас бид нар анхаарах ёстой байх гэж бодож байгаа юм. Энэний энэ гэрээний нэг гол оруулж ирсэн хэсэг нь болохоороо үндэсний ханган нийлүүлэгчээ дэмжих. Ер нь Оюу Толгой төслийг бид нар аваад үзэх юм бол Оюу Толгой төсөл чинь яг үндсэн ажилтнаараа л нэг 4, 5 мянга. Гэхдээ ханган нийлүүлэгчээрээ бараг энэ чинь 15-аас 17 мянган хүний ажлын байр ирж байгаа юм л даа. Энийгээ дагасан дэд ач холбогдлыг нь аваад үзэх юм бол тэрнээс илүү болсон.

Тэгэхээр энэ гэрээний 11.3.с-ийн 2 дээр жилийн худалдан авалтын үнийн дүнгийн 40-өөс доошгүй хувийг нь Монгол Улсад бүртгэлтэй татвар төлөгч хуулийн этгээд байна гэж заасан байгаа юм. Гэхдээ энэ уурхай маань цаашдаа 2060 он хүртэл явах урт хугацаандаа явах уурхай. Тэгэхээр энэ 40 хувийг нь цаашаагаа бид нар 10 жилийн дараа 2030 он гэхэд, 2040, 2050 гээд 2060 он гэхэд Монгол Улсын үндэсний ханган нийлүүлэгч 40, 50, 60, 70, 80 гээд 2060 он гэхэд дор хаяж 80 хувьд хүрэхээр үе шаттайгаар өгч чадах юм аль аль талдаа харилцан ашигтай болов уу гэж бодож байгаа юм. Мөн засаглалын хэлбэр дээр байгаа юм. Ямар ч байсан бид нар давуу эрхийн хувьцаа 10 хувийн давуу эрхийн хувьцаа хамгийн гол нь яг алтан хувьцааны хамгийн үндсэн зарчимд хориг тавих эрхийг авч байгаа нь үнэхээр сайшаалтай.

Тэгэхээр яг энэ гэрээн дээрээ бол хамгийн гол нь яг бид нарт стратегийн ач холбогдол бүхий зайлшгүй оролцох ёстой хувь хэмжээ өөрчлөгдөх юм бол тусгай зөвшөөрлийг шилжүүлэх, барьцаалах, баталгаа гаргах, нэмэлт, өөрчлөлт оруулахад хориг тавих эрх байна гэдэг бол яг бороотой өдөр бид нарт цув болох, шүхэр болох гол заалт энэ дээр давхар орж ирж байгаа. Тэгээд мэдээж 10 ТУЗ-ийн гишүүнтэй байна гэж байгаа юм. Тэгэхээр мэдээж тэрний о ойролцоогоор 3-ны 1 нь бие даасан ТУЗ-ийн гишүүн байх байх. Тэгэхээр болж өгвөл тэр бие даасан ТУЗ-ийн гишүүний 1 юм уу 2 нь уг нь Монгол Улсын иргэн байвал аль аль талдаа бас хэрэгтэй. Тэгэхээр энийг бас дараа дараагийн гэрээ байгуулахдаа бие даасан иргэнийг Монгол Улсын иргэн нөгөө талаас Франц байх байх л даа. Тэгэхээр хольж оруулбал аль аль талдаа ашигтай.

Д.Амарбаясгалан: Ням-Осорын Учрал сайд хариулт өгье.

Н.Учрал: Энэ хөрөнгө оруулалтын гэрээний нэг онцлог бол энэ орон нутгийг дэмжих чиглэл рүү дээрээс нь хүний нөөцийг бүрдүүлэхдээ Монгол хүнийг ажилд авах. Дээрээс нь тухайн сум орон нутгийн иргэдийг илүү тэргүүн ээлжид ажилд авах нөхцөлийг бид нар бүрдүүлж хөрөнгө оруулалтын гэрээнд тодорхой тусгасан.

Дээрээс нь нөгөө цалин хөлсний урамшууллыг хүртэл шударга байдал буюу нөгөө хүний нөөцийн шударга байдал гэж нэг ойлголт бий л дээ. Тэгээд түүний дагуу авахгүй бол нөгөө гаднаас ирсэн хүмүүс өндөр цалинтай дотоодынх нь бага цалинтай гэдэг ийм 1 тэгш бус байдал үйлчлээд байдаг. Энэ утгаараа бид нар энэ

төслийн хугацаанд бол 1600 хүнээс 17 хүн л гаднын ажилчид байна гэсэн ийм тооцоололтой юм байна лээ.

Дээрээс нь төслийн хугацаанд бол нэг 1.7 тэрбум долларын худалдан авалтыг ханган нийлүүлэлтээс нь авах ийм тооцоолол гарсан. Мэдээж орон нутагт төслийн нийт хугацаанд бол татвар, хураамж, ус болон газрын төлбөр орон нутгийн дэмжлэг хэлбэрээр гэхээр 44 сая доллар, нийт 1 тэрбум ам.долларын мөнгөн урсгал орохоор бидний хийсэн санхүүгийн загвар дээр туссан байгаа. Тэгээд энэ хөрөнгө оруулалтууд энэ орон нутгийг дэмжиж байгаа энэ бодитой ажлууд бол мэдээж нутаг орон нутагтаа бусад төрлийн эдийн засгийг нэмэгдүүлэхэд нэлээд тодорхой дэмжлэг болно. Тэгээд бид дундаж цалингаа энэ хэлэлцээний явцад 7-оос 12 сая төгрөг байна гэдгийг ерөнхийдөө өнөөдрийн зах зээлийн ханшаар нь ингэж ярилцсан.

Тэгэхээр мэдээж энэ бол орон нутагт маш том дэмжлэгүүд үүний дараа бий болно гэдгийг хэлье.

Д.Амарбаясгалан: Бөхчулууны Пүрэвдорж гишүүн ажлын хэсгийн дарга нэмж хариулъя.

Б.Пүрэвдорж: Мэдээж Оюу Толгой дээр манайх манай талаас 3 ТУЗ-ийн гишүүн байдаг. Гэвч одоо яг бүрэн дүүрэн яг Монгол Улсаа бүрэн дүүрэн төлөөлж чадаж байгаа юу гэдэг дээр асуудал гарч байгаа. Хэдийгээр 10 хувийн давуу эрхийн хувьцаа энэ Бадрах Энержигийн төсөл дээр авч байгаа боловч бид нар хамгийн гол нь хориг тавих олон олон асуудал дээр хориг тавих эрхээ энэ давуу эрхийн хувьцааны дагуу авч байгаа. Яг энэ таны гаргасан Монголчуудыг ТУЗ-ийн гишүүнд илүү оруулах талаар мэдээж энэ дээр хэлцлийн явцад тусгаж өгнө. Хамгийн гол нь орж байгаа тэр хүмүүс нь яг тэр Монгол Улсынхаа эрх ашгийг хангаж ажиллаж чадаж байна уу? Олон олон.

Д.Амарбаясгалан: Отгоншарын Батнайрамдал гишүүн тодруулж асууя.

О.Батнайрамдал: Пүрэвдорж гишүүн тантай яг санал нэг байгаа юм. Яах вэ нөгөө бие даасан гишүүд нэг 3-аас 4 байх болов уу тиймээ? 10 гишүүнтэй гэдэг чинь? Тэгэхээр тэрэн дээр Монголын талаас, Францын талаас байх юм бол яг Монголоо ч ойлгодог, Монголын эдийн засгаа ч ойлгодог. Ач холбогдлыг нь ч ойлгодог тэгээд аль аль талдаа харилцан ашигтай байж болох хувилбар байгаа юм л даа. Тэгэхээр энийгээ бас цаашдаа энэ хувь нийлүүлэгчдийн гэрээн дээрээ бас 2 талтай тохиролцож чадах юм бол энэ харилцан ашигтай хувилбар байх болов уу л гэж бодож байгаа юм. Баярлалаа.

Д.Амарбаясгалан: Сайнхүүгийн Ганбаатар гишүүн асуулт асууя.

С.Ганбаатар: Батнайрамдал гишүүний асуултад товчхон хариулъя аа. Зарим гишүүд маань асуудлаа юмаа уншвал их сайн байгаа юм. Оюу Толгой дампуурчихсан албан ёсоор хэлье. Та нар Оюу Толгойн хувьцаа манайх 34 хувь гэж байгаа. Яг үнэ цэн нь хэд гэж бодож байна? Өчигдөр би нууцын баримтаас Оюу Толгойн тайланг санхүүгийн тайланг авлаа. Нууцад байдаг юм шүү дээ. Гишүүд минь та нар авч үзээрэй уншаарай. Яагаад нууцад ордог юм бүү мэд. Тэгээд үзсэн 34 хувийг 426 сая доллароор үнэлж байгаа. Нийт манай Оюу Толгойн 100 хувь хувьцаа гэж тооцоход чинь 1.3 тэрбум доллар байгаа. Тэгэхэд өөрөө энэ компани

өөрөө 17.6 тэрбум долларын өр тавьчихсан байгаа. Та нар Дубайн гэрээгээр гэхэд л 5.4 тэрбум долларын өрийг 15 банканд Монголын газар нутгийг тавьчихсан байгаа шүү дээ. Би хариуцлагатайгаар ярьж байна шүү дээ. Өөрийн компанийнх нь үнэ цэнээс 9 дахин өндөр зээл авчихсан байгаа тэр компанийг би дампуураагүй гэж хэлэх юм бол харин ямар ч бизнесийн сонгодог ойлголт байхгүй хүн болж хувирна. Би хариулт өглөө тоо баримтаа харж яриарай. Миний хайран цагаас авчих юм даа. Одоо тэгээд ярина.

1 дүгээр асуулт. Энэ танилцуулга дээр орж ирж байна. Ораногийн гэрээн дээр энэ ТЭЗҮ батлагдсан уу? ТЭЗҮ эцэслэн батлагдсан уу? Яг энэ дээр надад хариулт өгөөрэй. ТЭЗҮ батлагдсан тохиолдолд ТЭЗҮ-ээ яг дагана биз. Нарийн ярья Оюу Толгой ТЭЗҮ батлагдаагүйгээр хууль баталсан. ТЭЗҮ-гүй батлагдсан. Засвартайгаар батлагдсан. Дараа нь ТЭЗҮ-ээ ерөөсөө мөрддөггүй. Энэ миний асуултад хариулна уу? Төслийн ТЭЗҮ эцэслэн батлагдсан уу?

Хоёрдугаарт энэ танилцуулга дээр орж ирж байна. Үгүй ер нь найзууд аа, энэ ямар диктатуртай бүр ингээд дарамтлуулчихсан орон биш. Чуулган дээр ураны талаар өөр оронтой хэлэлцээр хийж байхад гишүүд нь юм ярьж протокол тусгана гэдэг хэлэлцээрт орох гэж байгаа хүмүүст үгүй мөн нэмэртэй юм байгаа юм даа. Тэгэхгүй тэгээд алга ташсаар байгаад л өнгөрвөл наад Францууд чинь бөөн баяр хүлээж авна даа. Нэг 1 минут 36 секунд үлдлээ. Төслийн хугацаанд хувь нийлүүлсэн зээлийг хязгаарлаж зээл авах зайлшгүй онцгой шаардлага үүссэн тохиолдолд хувьцаа эзэмшигчдийн хурлын 100 хувийн шийдвэрээр шийдвэрлэхэд тохирлоо гэж байгаа юм. Оюу Толгой дээр зүгээр дураараа зээл авдаг, бид ноогдол ашиг улам алсардаг л гэдгийг би уг нь ярих гэж ярьсан. Тэгээд энэ дээр ийм асуудал танилцуулга дээр орж ирж байна. 100 хувь шийдвэрээр гэж байгаа. Энэ шийдвэрт Монголын талын хувьцаа эзэмшигчдэд орж байгаа 2 төлөөлөл гэж би ойлгосон. Хэдэн хүн байгаа юм? Тэрийг нь тодруулаад эд нар нөлөөтэй юу? Энэ 100 хувийн шийдвэрт хэр нөлөө байгаа вэ? Ядаж Монголчуудын нэг саналыг авч байж зээл авна нэмж зээл авна гэдэг ийм хариулт авах боломж байна уу? Энийг тодруулж хэлж өгөөч, 2 дугаар асуулт.

Шууд гол юм руугаа оръё.

Д.Амарбаясгалан: Минут нэмчихье. Энгийн болон аюултай хог хаягдлын менежментийг хэрэгжүүлэхдээ Хог хаягдлын тухай хуульд заасны дагуу ангилан ялгаж дахин боловсруулах болон бусад шаардлагатай арга хэмжээг авч хэрэгжүүлэх гээд ийм бөөрөнхий хаячихсан шаардлагатай. Зүгээр л нэн хортой, аюултай хог хаягдал нь 150 тонн байгаа. Хог хаягдал 750 тонн жилд гарна гэж байгаа. Та нарын танилцуулга дээр. Энэ аюултай хог хаягдлыг боловсруулах булшлагтай үйлдвэр барих уу? ТЭЗҮ дээр хэдэн төгрөг тусгасан бэ? Францын тал үйлдвэрээ хэдий хугацаанд хэдэн төгрөгөөр барих вэ? ТЭЗҮ дээр туссан зүйлүүд байгаа юу? 3 дугаар асуулт.

Энэ дээр маш сайн заалт орсон. Энэ олон хүний хөдөлмөр байгаа. Би та нар муу ажилласан гэж хэлээгүй шүү дээ. Үгүй магтуулах юманд дуртай юм аа. Энэ дотроос чинь Француудтайгаа хатуухан шиг ярих юм байгаа шүү. Та нар маань яриарай. Чуулганы протокол дээр ингэж заасан гэж хэлэхэд үгүй мөн нэмэртэй дээ л гэж ярьж байгаа.

11.3.6-д сайн заалт орсон. Монгол Улс дотооддоо элементийн хүхэр үйлдвэрлэж боломжит үнээр боловсруулсан тохиолдолд төсөл хэрэгжүүлэгч компани нь тэргүүн ээлжид дотоодын зах зээлээс худалдан авна гэж байгаа. Энэн дээр одоо Уулын уурхайн яамнаас асуучихъя.

Нөгөө монголчууд нь элементийн хүхрээ үйлдвэрлэх боломжуудыг нь үүд хаалгыг нь бэлэн болгож байгаа юу? Боломжит үнэ гэдгээ яг юу гэж ярьж байгаа вэ? Энэ хүхрийн хүчлийг үйлдвэрээ Францын тал яг барих уу ТЭЗҮ дээр хэдэн төгрөг туссан бэ? Хэдий хугацаанд барих вэ?

Д.Амарбаясгалан: Ажлын хэсгийн дарга Бөхчулууны Пүрэвдорж гишүүн хариулт өгье.

Б.Пүрэвдорж: С.Ганбаатар гишүүнтэй би ярилцаж байхад бол энэ стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордын эзэмшлийн хувь хэмжээг орлуулах өөрөөр хэлбэл 10 хувь аваад дээрээс нь бусад татвараар АМНАТ-аар 51 хувиас дээш баялгийг хүртэх энэ боломжийг хангах тухай асуудлыг дэмждэг. Тэгэхээр өнөөдөр бид нар яг энэ орлуулах тухай асуудлыг ярьж байгаа. АМНАТ-аар болон хувь хэмжээгээр орлуулах тухай, татвараар орлуулах тухай. Тэгэхээр энэ асуудлаа хэлэлцээд шийдчих юм бол ТЭЗҮ энэний дагуу шийдэгдээд явах юм. Өөрөөр хэлбэл бид нар энэнд дэмжигдэхгүй 34 хувиа эзэмших тухай асуудал ярих юм бол бид тэр ТЭЗҮ чинь өөр болох байхгүй юу даа. Өөрөөр хэлбэл манай Монгол Улс 34 хувьдаа тодорхой хөрөнгө оруулалт хийнэ.

Дээрээс нь АМНАТ-ын хувь хэмжээ бас хуучнаараа тавхан хувь дээрээ үлдэнэ. Ийм байдлаар ингээд явах юм бол тэр ТЭЗҮ чинь өөрчлөгдөх юм. Тийм учраас өнөөдөр бид нар энэ тогтоолоо гар хэлэлцээд гаргачих юм бол бид нар маш хурдтайгаар энэ ТЭЗҮ-ийг оруулаад эцэслэн батлаад явна гэсэн үг.

Би Ганбаатар гишүүний 2 дахь асуудал буюу хүхрийн хүчлийн асуудал яригдаж байгаа. Тэгэхээр энэ дээр энэ Хүхрийн хүчлийн үйлдвэрийг байгуулах таны санал дээр би маш бүрэн дүүрэн дэмжиж байгаа. Энийг бүр бүрэн протоколд оруулах хэрэгтэй. Энийг дэмжих ёстой. Яагаад гэвэл бид нар хүхрийн хүчлээ үйлдвэрлээд нийлүүлчих юм бол 1 дүгээрт бүтээгдэхүүнийхээ өртгийг зардлыг хянах боломжтой болох юм. Тэгээд бүтээгдэхүүнээ хянах боломжтой болох ийм 2 том ач холбогдолтой учраас дээрээс нь бид нар бас өөрсдөө дотооддоо үйлдвэрлэлийг байгуулж нэмүү өртөг шингээж байгаа учраас энэ маш чухал зүйл байгаа юм аа.

Тийм учраас яг энэ орд ашиглах энэ хөрөнгө оруулалтын хэлэлцээрийг дагаад орд ашиглах болон хувь нийлүүлэгчдийн гэрээнүүд дахин батлагдах ёстой, шинэчлэгдэх ёстой. Тэгэхээр энэ дээр бол тодорхой энэ хүхрийн хүчлийн үйлдвэрийг заавал байгуулах талаар оруулах ёстой гэж таны саналыг уламжлахыг хүсэж байна аа. Баярлалаа.

Нэмэлт хариулт өгье. Ням-Осорын Учрал сайд хариулт өгье.

Н.Учрал: Энэ хөрөнгө оруулалтын гэрээний 3.1 төслийн хугацаанд хувьцаа эзэмшигчдээс аливаа зээл авахыг зөвшөөрөхгүй. Хэрэв урьдчилсан тооцоогүй нөхцөл байдалд энэ төрлийн санхүүжилт шаардлагатай бол заавал хувьцаа

эзэмшигчдийн 100 хувийн саналаар шийдвэрлэнэ гээд хатуу тусгасан. Энэ бол ер нь энэ хөрөнгө оруулалтын гэрээний нэг чухал заалт.

Дээрээс нь ТУЗ-д нэг хүн Монголыг төлөөлнө. Гэхдээ тэр нэг хүн тэр бето эрхтэй хориг тавих эрхтэй нэг хүн. Одоо өнөөдөр Оюу Толгойн ТУЗ-ийн 3 хүн хориг тавих эрхгүй байхгүй юу. Гурвуулаа байна уу, хоёулаа байна уу хориг тавих эрхгүй. Тэр шийдвэрт хориг тавих эрхтэй нэг ТУЗ-ийн гишүүн гэдэг асар чухал. Тийм учраас энэ асуудлыг зөвшөөрүүлж чадсан. Дээрээс нь ТЭЗҮ дээр хог хаягдлын менежментэд 400 мянган доллар гээд тусгасан байгаа. Хүхрийн хүчлийн үйлдвэрт мөн ТЭЗҮ дээр.

Д.Амарбаясгалан: Учрал сайдад нэмэлт минут өгье.

Н.Учрал: хүхрийн хүчлийн үйлдвэрт 96.5 сая долларыг 2028 оноос байгуулж эхлэхээр төлөвлөгөөнд тусгаад явж байгаа. ТЭЗҮ бол төсөл хэрэгжүүлэгч компани төрийн байгууллагадаа заавал хүргүүлж байхыг хөрөнгө оруулалтын гэрээнд тусгасан. Их Хурлын энэ стратегийн ордын 34 хувийг АМНАТ-аар орлуулах тогтоол хэрвээ батлагдвал Эрдэс баялгийн зөвлөл дээр ТЭЗҮ-ийг эзлэх бэлтгэл ажил бүрэн хангагдсан хэд хэд танилцуулагдаад ингээд ерөнхийдөө ТЭЗҮ батлагдахад бэлэн байна. Гэхдээ энэ Их Хурлын тогтоолоор АМНАТ-аар орлуулаад шийдвэрээ гарсны дараа эцсийн байдлаар албажна. ТЭЗҮ байхгүйгээр хөрөнгө оруулалтын гэрээ хийнэ гэж угаасаа байхгүй шүү дээ.

Тийм учраас энэ асуудлыг хатуу тусгасан гэдгийг хэлье.

Д.Амарбаясгалан: Ажлын хэсгийн 15 дугаар микрофон өгье.

Б.Хулан: Ганбаатар гишүүний асуултад хог хаягдлын асуудлаар нэмж тайлбар хэлье. ТЭЗҮ-д урьдчилсан байдлаар тооцоолсноор үйлдвэрийн үйл ажиллагааны үед жил бүр 1400 гаруй тонн хог хаягдал үүсэхээс бага цацрагт идэвх хаягдал 250 тонн, аюултай хог хаягдал 125-аас 200 тонн, ахуйн хог хаягдал бол 800-аас 900 тонн хог хаягдал гарахаар ийм урьдчилсан тооцоо тусгасан байгаа. Тэгээд сая сайд үнийн дүнг нь хэлчихлээ. Тэгэхээр аль болох хог хаягдлын менежментийн хөтөлбөрөөрөө дахин боловсруулах, дахин ашиглах, мөн дахин эргүүлэн ашиглах гэдэг ийм бодлогыг барина. Мэдээж олон улсын болон Монгол Улсын стандарт норм дүрэмд шаардлага хангасан аюултай хог хаягдлын Засгийн газраар баталсан дүрэм журмыг биелүүлэхийг хатуу энэ гэрээнд тусгаж өгсөн байгаа.

Энэ дээр нэмж хэлэхэд аюултай хог хаягдлыг үйлдвэр барих уу гэж байгаа. Тэгэхээр аюултай хог хаягдлын үйлдвэрийг ангиллаар нь дахин боловсруулах бүх асуудал.

Д.Амарбаясгалан: Гүйцээж хариулъя.

Б.Хулан: Яг энэ дээр үүсэж байгаа аюултай хог хаягдлын зарим асуудлыг бол тухайн төсөл хэрэгжүүлэгч тусгай зөвшөөрөл авч аюултай хог хаягдлын үйлдвэрийн үйл ажиллагааг эрхэлнэ ээ.

Д.Амарбаясгалан: Болдын Уянга гишүүн асуулт асууя.

Д.Амарбаясгалан: Гишүүддээ мөн ажлын хэсгийнхэнд энэ өдрийн мэндийг хүргэе ээ. Өнөөдөр бүгдээрээ ашигт малтмалын нөөц ашигласны тусгай төлбөрийг Улсын Их Хурлын тогтоолоор батлах энэ эхний хэлэлцүүлгийг хийж байна аа. Тэгэхээр Улсын Их Хурлын тогтоолоор тусгай төлбөрийн хэмжээг тогтооно. Хуульд албан ёсоор оруулахгүй байна гэдэг бол Улсын Их Хурлаар тусгай төлбөрийн хувийг өөрчлөөд байх боломжтой тийм тогтвортой бус юм шиг ийм ойлголттой байгаад байх юм. Тэгэхээр энэн дээр манай Цөмийн энергийн тухай хууль дээр эсвэл яг доод таазыг нь, дээд таазыг нь аль нэгэн байдлаар оруулах ёстой байж уу? Ер нь хувийн хэвшил талдаа яг энэ төсөл хэрэгжүүлэгч талдаа нэг эрсдэл нь болоод ороод ирэх вий. Энэн дээр ямар хариултыг өгөх вэ? Мөн Бадрах Энержи Хязгаарлагдмал ХК-ийн төрийн эзэмшлийн давуу эрхийн 10 хувийн ийм хувьцаатай бол бид нар болох нь ээ. Тэгэхээр энэ дээр түрүүхэн Мон-Атом ХК-ийн талаар Соронзонболд гишүүнтэй ярьж байсан юм л даа.

Ер нь Мон-Атом Бадрах Энержигийн 10 хувийг нь төр эзэмшиж байна аа. Тэгэхээр Мон-Атом компанийн ер нь өөрийнх нь эдийн засгийн байдал нь ямар байгаа юм? Энд яг ямар байдлаар оролцох юм. Эрдэнэс Оюу Толгой шиг байх юм уу? Ашигтай ажиллах юм уу? Үйл ажиллагааг нь ер нь ямар байдлаар харж байгаа вэ? Энэ дээр хариулт авъя аа.

Гуравдугаарх нь болохоор уул уурхайн ашиглалтын үе шатад төсөл хэрэгжүүлэгч компанийн нийт ажилчдын 90 хувь нь Монгол байна. 10 хувь нь гадаад байж болно оо гээд ингээд гэрээнд гэрээний төсөлд заагдаж орж ирсэнд талархаж хүлээж авч байгаа. Гэхдээ өнөөдөр бүгдээрээ ажилчдынхаа тоогоор биш магадгүй цалингийн сангийнх нь 90 хувь нь Монгол ажилчдад 10 хувь нь гадаад ажилчид ноогдох байдлаар ашиглалтын үед явна гээд оруулж өгөх шаардлагатай байж уу? Тэгээд яах вэ зүгээр Эрдэнэс Монгол компанийн захирал байгаа учраас дараа дараагийн иймэрхүү төрлийн хөрөнгө оруулалтын гэрээн дээр яг энэ цалингийн сангийнх нь хуваарилалт байдлаар нь ярьдаг бол яасан юм бэ гэсэн ийм саналтай байна.

Сүүлийн нэг асуулт бол энэ хөрөнгө оруулалтын гэрээний хавсралтад бүтээн байгуулалтын үе шат буюу 4 жилийн хугацаанд хийх ажлынхаа нарийвчилсан төлөвлөгөөг хавсарч оруулж өгөхгүй байсан уу? Яг Монгол орчуулга дээрээ бол 4 жил бүтээн байгуулалтаа хийхийг эрмэлзэнэ гээд орчихсон байгаа юм. Тэгэхээр яг энийгээ магадгүй яг эцэслэн зөвшилцөөд батлахдаа 4 жил багтааж явуулна тэгээд хавсралтаар энэ нь ажлаа хийнэ гэж оруулж өгөх ёстой байсан уу? Энэ саналуудыг гаргасан байгаа юм аа. Тэгээд албан ёсоор Учрал сайдад хаяглаад хүргүүлсэн байгаа. Та хэд маань зөвшилцлийнхөө шатанд хэрэглэх зүйлүүдээ авч ашиглахыг хүсье ээ.

Д.Амарбаясгалан: Эрдэнэс Монголын захирал Наранцогт хариулт өгье.

Х.Наранцогт: Уянга гишүүний асуултад хариулъя аа. Тусгай АМНАТ-ын таазыг Үндэсний баялгийн сангийн хууль хэлэлцэх үеэр бид нар Ашигт малтмалын хуулиас авсан. Энэ удаа бол цөмийн энергид яг энэ агуулгаар хийгдэж байгаа юм. Тэгэхээр аливаа төсөл бол уг төслийнхөө ялангуяа уул уурхайн төслүүд бол яг геологи, уулын нөхцөл, тухайн төслийн, ингээд технологийн онцлог гээд олон зүйлээс хамаардаг та сайн мэдэж байгаа.

Тийм учраас ямар нэгэн байдлаар хязгаарлалт хийж өгөх нь өөрөө их хязгаарлагдмал байдлыг хийж байгаа. Тийм учраас тухайн төсөл болгон дээр аль нь эдийн засгийн хувьд илүү үр өгөөжтэй, аль нь бид нар бүтээгдэхүүн хуваах байна уу, тусгай АМНАТ-аар солих байна уу? Энэ зүйлүүдээс хамаараад эдийн засгийн тооцоогоо хийж ингээд Засгийн газар өөрөө тооцоогоо хийж үзээд Их Хурал дээр авч ирж шийдүүлэхээр ингэж хуульчлагдаж оруулж ирж байгаа.

Тэгэхээр энэний хувьд бол таазгүй байх нь Монгол Улсын хувьд илүү ач холбогдолтой юм гэж ингэж бид нар үзсэн. Тэр цалингийн хувьд бүтээн байгуулалтын хувьд монгол ажилтнууд 60 хувь үйл ажиллагаа эхлээд Монгол Ажилтнууд 90 хувь байна гээд ингээд гэрээнд их тодорхой заачихсан. Дээр нь нэмээд ажил ижил ажил үүрэг гүйцэтгэж байгаа хүмүүс ижил цалин авна гээд ингээд заасан. Өөрөөр хэлэх юм бол Гадаад Монгол гэж цалингийн ялгавартай байдлыг тогтоохгүй ээ. Яг адилхан ажил хийвэл, адилхан цалин авна л гэсэн үг.

Тийм учраас сая цалингийн мэдээллийг Учрал сайд тодорхой хэлсэн. Тэгэхээр энэ дээр аль болох бид нар Монголчууд цалингийн 90 хувийг авах ийм бололцоотой байна гэж ингэж үзэж байгаа.

Мон-Атомын эзэмшлийн хувьд ярилаа. Энийг энэ нөгөө эзэмшлийн хувьд энэ хэлэлцүүлгийн үеэр маш олон ярьсан учраас би нэмж ярихгүй. Зүгээр ТӨК-ийн тухай хууль сая Засгийн газраар ингээд хэлэлцэгдээд Их Хуралд өргөн баригдах гэж байна. Энэнтэй холбоотой төрийн өмчийн компаниудын талаар авах ийм тогтоолын төслийг Засгийн газар дээр хэлэлцэж байгаа. Энэ тогтоолын төслөөр бол бид нар энэ ашиггүй ажиллаж байгаа болоод энэ хувь эзэмшилтэй холбоотой энэ компаниудынхаа асуудлыг нэг мөр Засгийн газар шийдвэрлэхээр ингэж ажиллаж байна. Энэ хүрээнд манай Эрдэнэс Монголын нэгдлийн харьяанд ч ажиллаж байгаа компаниудын асуудал ер нь нэг мөр шийдэгдэнэ.

Засгийн газраас барьж байгаа бодлогын хувьд бол ер нь үр ашигтай яг бизнесийн утгаараа ажиллаж байгаа компаниудаа ТӨК гэж нэрлээд аваад явъя гэдэг ийм зүйл ярьж байгаа. Тэгэхээр хувь нийлүүлэгчийн гэрээний үеэр бол бид нар энэ хувь эзэмшлийнхээ асуудал энэ компанийнхаа үйл ажиллагааг хэрхэн авч явах талаар нэлээн тодруулж ярина гэж ингэж бодож байгаа. Яг одоогоор бол нэгэнтээ давуу эрхийн 10 хувийн хувьцаатай явж байгаа учраас энүүгээрээ явна гэж ингэж ойлгож байна аа. Бүтээн байгуулалтын талаар та асуусан. Бүтээн байгуулалтын хувьд бол.

Д.Амарбаясгалан: Гүйцээж хариулъя.

Х.Наранцогт: Бүтээн байгуулалтын хувьд бол ТЭЗҮ дээр энэ эхний үйлдвэр барих юу юу баригдах вэ гэдэг зардал мөнгө бүгдээрээ нарийвчлан тусчихсан байгаа. Хугацааны хувьд бол бид нар яг хатуу 4 жил дотроо барина гэдгийг нэлээн хэлэлцээний үеэр шахсан юм аа. Тэгэхээр хөрөнгө оруулагч маань юу гэж энэ дээр үзээд байгаа вэ гэхээр энэ цар тахлын ийм гашуун туршлага байгаа учраас иймэрхүү асуудлууд энэ тэр ингээд гарч ирэх янз бүрийн байдлаар эрсдэл байгаа учраас ер нь 4 жилдээ гүйцээхийг эрмэлзэнэ гэдэг энэ зүйлээрээ оруулчихъя гэдгээр ингээд оруулчихсан байгаа.

Зүгээр одоо бид хавсралт дээр аль нэг хувь нийлүүлэгчийн гэрээ байна уу? Энэ дээр энэ хавсралтаар оруулах шаардлагатай талаар яриад үзье. Одоо ингээд

нөгөө Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороотой зөвшилцөөд сүүлийн бас бид нар хяналтын уншлага юмаа хийж гэрээ байгуулахаас өмнө гэрээ үзэглэхээс өмнө бүх гэрээг нарийвчилж эцэслэнэ.

Тэгэхээр энэ үеэр таны гаргаж байгаа саналыг бид нар ТЭЗҮ-ээсээ ялгаж аваад.

Д.Амарбаясгалан: Тодорхой хариулт авлаа. Амгаланбаатарын Ганбаатар гишүүн асуулт асууя.

А.Ганбаатар: Тогтоолын төслийг бүхэлд нь дэмжиж байна. Гэхдээ асуух зүйлс байна аа. Тогтоолын төсөл батлагдсанаар Зөөвч овоо, Дулаан уулын ураны ордын хөрөнгө оруулалтын гэрээ байгуулагдаад Монгол Францын хамтарсан ураны төсөл үр дүнтэй цаашид ажиллана гэсэн итгэл байна. Гэхдээ энэ төслийн хүрээнд 34 хувийн энгийн хувьцааг 10 хувийн давуу эрхийн хувьцааг 5 хувийн ашигт малтмалын нөөц ашигласны тусгай төлбөрөөр орлуулаад 9 хувийн өсөн нэмэгдэх АМНАТ гээд. Эд нараа цуглуулсан тохиолдолд нийт улс болон орон нутгийн төсөвт 5.1 тэрбум доллар төвлөрөх боломжтой гэж байгаа юм. Энэ бол АМНАТ-аар орлуулсны одоо төвлөрөл орлого гэх юм уу. Бид нарын нөгөө мэдэж заншсанаар Оюу Толгойн гэрээ засаг Монголд 34 хувь эзэмшдэг гээд энэ нийтийн ойлголт байж байна. Иргэдийн хувьд хэрвээ 34 хувиа эзэмших юм бол 5.6 тэрбум доллар төвлөрнө гэхийсэн байж байгаа. Тэгэхээр энэ гэрээг энэ уламжлалт аргаасаа гэдэг юм уу өмнө нь хийж байсан гэрээнээсээ өвөрмөц аргаар гэдэг юм уу арай өөр хувилбараар хийсний давуу тал юу вэ?

Нийт иргэд, жирийн иргэд энийг ялгааг нь ойлгохгүй байна. Шууд харахад ингээд 5.6? 5.1 хоёрыг харьцуулахаар 34 хувийн гэрээгээ хийгээд хүлээсэн нь дээр юм шиг харагдаад байгаа байхгүй юу. Тэгэхээр маргаашийн өөхнөөс өнөөдрийн уушги гэдэг зарчмаар ажиллаж байгаа бол Учрал сайд мэргэжлийн хүмүүс маань олон нийтэд энэ мэдээллээ өгөхдөө ийм ийм учраас цаг хожсон учраас ийм ийм ашигтай байгаа юм. Ашгаа эхэлж хүртэж байгаа юм, тэр хуримтлалын сандаа төвлөрсөн юмнаасаа орон сууцын зээл боломжууд, боловсрол, эрүүл мэндийн асуудлуудаа ингэж шийдэх юм гэдэг энэ гарцаа маш сайн хэлж өгөхгүй бол зөвхөн тоон үзүүлэлтээр харахаар 5.6 тэрбумаа хүлээгээд арай илүү ашиг авсан нь зүгээр юм биш үү гэдэг ийм үзэл санаатай бодолтой хүмүүс байгаа.

Энийг Учрал сайдад хэлье ээ. Энийг яаж нийтэд тайлбарлах вэ гээд.

Хоёрт нь энэ татварын тогтворжуулалт хийх юм бол экспортод гарч байгаа бүтээгдэхүүнүүд дээр НӨАТ байхгүй болно оо. Тэгэхээр Засгийн газар энэ шар нунтгаа эцсийн бүтээгдэхүүн мөн эсэхийг зарлана гэдэг юм уу тогтоомоор байгаа юм л даа. Тэгээд энэ цаашаа явах байх.

Гуравт нь нөгөө мэргэжлийн улсуудаар энэ төслөө цаашаа удирдуулахын тулд хуучин байсан цөмийн хэргийн агентлагаа байгуулахгүй юм уу? Улс төрчид сайд, дарга нар удирдахаар асуудал цаашаа гарна шүү дээ. Тэгэхээр мэргэжлийн хүмүүсийгээ гарт нь үлдээх үүднээс цаашаа авч явах төслөө амжилттай байлгах үүднээс энэ агентлагаа бага болгох уу гэж дээр асууж байсан. Энийгээ дахиж асууя. Гэрээг яах вэ дараа нь ярих байх. Гэхдээ гэрээн дээр нэг хэдэн зүйл ажиглагдаж байгаа нь маркетингийн төлбөр 2 хувь ноу хау төлбөр 1.2 хувийг Орано төлөх юм

байна гэж заасан байна лээ. Энэ төлбөрийн ашгаас авах юм уу эсвэл нийт орлогыг тооцон авч төлөхөөр байгаа юм уу гэсэн нэг ийм асуулт байна.

Гэрээг дахиад харахад энэ байгаль орчны нөхөн сэргээлтийн асуудлууд маш бүдэг туссан. Тэгээд энэ байгаль орчны нөхөн сэргээлтийнхээ зардалд ахиад энэ орлого олж байгаа 5.6 тэрбум доллар эд нар гээд тэр хүртэлх зардал гарчих юм биш биз дээ гэсэн ийм болгоомжлол байна.

Эцэст нь хэлэхэд энэ гэрээ цуцлах терминэйшн дээр Монголын тал сул харагдаад байгаа юм л даа. Тэгээд гэрээ байгуулахаас илүү цуцлах нь маш чухал байдаг.

Тэгэхээр энэ дээр мэргэжлийн хуульчид олон улсын хуульчидтай хэрхэн хамтарч ажиллаж байгаа вэ? Гэрээ цуцлах тал дээр энэ гэрээ яригдахад яригдах байх. Гэхдээ энийгээ өөрчилж харж байна уу гэсэн ийм хэдэн асуулт байна аа. Учрал сайд.

Д.Амарбаясгалан: Учрал сайдад хариулт өгье.

Н.Учрал: Засгийн газрын хувьд үр өгөөжийг авахдаа найдвартай, эрсдэл багатай, уян хатан байх буюу энэ бүтээгдэхүүний үнэ зах зээл дээр хэр өсөж байгаагаас шалтгаалж тэр үр өгөөжөө хүртдэг байх зарчмыг барья л гэж аягүй хичээсэн. Яагаад гэхээр нөгөө ураны эрэлт ингээд нэмэгдээд байдаг тэгэхээр үнэ өсөх жил ирэх тусам ингээд үнэ нь өсөх ийм хандлагатай учраас 1 дүгээрт бид нар өсөн нэмэгдэх АМНАТ-ыг тооцох асуудлыг оруулж ирсэн.

Хоёрт, ямар тохиолдолд эрсдэл багатай байх юм бэ гэдэг асуудал бол хамгийн их чухал байсан. Тийм учраас Засгийн газар 10 хувийн давуу эрхийн хувьцаагаа авахдаа санхүүгийн ямар ч хариуцлага хүлээхгүй шүү гэдгээ хатуу тохирсон. Зээл авлаа ч байсан тэрэн дээр 10 хувь хариуцлага хүлээхгүй, хөрөнгө оруулалт хийлээ ч 10 хувь хүлээхгүй. Ирээдүйд ямар нэгэн санхүүгийн хариуцлага хүлээхгүй гэж. Ингээд АМНАТ-аар орлуулснаар эрсдэлгүй орлогын хувийг одоо тэр таны ярьж байгаа 5.6 тэрбум долларыг хэрвээ 34 хувиар аваад тэр хүмүүс цаг хугацаандаа ноогдол ашгаа өгөх тэр зардлыг тооцоод үзэхээр нөгөө эрсдэлтэй нь 18 хувь байсныг одоо АМНАТ-аар орлуулснаараа 45 хувь хүртэл эрсдэлийг бууруулсан гэсэн үг. Тэгэхээр эрсдэлгүй. Тэгээд нөгөө компани ашигтай ашиггүй ажиллахаас үл хамаараад борлуулалтаас нь АМНАТ авах нь өөрөө эрсдэлгүй. Орлогын түвшнийг 45 хувь бууруулж байгаа гэдэг ийм санхүүгийн схем гарсан.

Хоёрт бол Монголчууд өөрсдөө бас нэг олон улсын нэг ийм гэрээ хийдэг шүү. Хөрөнгө оруулалтын гэрээ хийдэг шүү. Бид нар нэг чаддаг шүү. Дандаа бас нэг чадуулаад байдаггүй шүү гэдгээ харуулах зорилгоор энэ санхүүгийн багуудыг аваад өөрсдөө санхүүгийн схемээ гаргаад. Тэгээд өөрсдөө хөрөнгө оруулалтын гэрээний драфтаа боловсруулаад тэдэнтэй хэлэлцээ хийсэн. Тэгэхээр нөгөө нэг фунт одоо ураны үнэ 80 доллар байхад хэд байх юм. 100 доллар хэд байхад хэд байх юм, 90 доллар хэд байх юм бэ гэдгийг санхүүгийн модель дээрээ гаргаж тавьж байгаа. Бид нар харж чадаж байгаа. Одоо энэ тооцоолол 80 доллар дээр явж байна. 80 доллар дээр явахад 51 хүрэхгүй буюу нөгөө өгөөжийн тохируулга хийж, түүнийг гүйцээх 51-д нь хүргэх энэ зарчмыг гэрээнд тусгасан. Өсөн нэмэгдэх АМНАТ бол 51 дотор орохгүй байгаа. Тэгэхээр өсөн нэмэгдэх АМНАТ буюу тэр 0-9 хүртэлх хувь чинь

нэмэгдээд ороод ирнэ гэсэн үг. Тэгэхээр нөгөө Үндсэн хуулийн суурь зарчим хангагдана.

Тэгээд өгөөжийн тохируулга бол энэ гэрээний эрсдэлийг бууруулж байгаа хамгийн том зорилт. Үндсэн хуулийн суурь зарчмыг хангуулж байгаа зорилт. Тэгээд Оюу Толгойн төсөл дээр жишээ нь хэрвээ өгөөжийн тохируулгыг хийсэн байсан бол 2010-2023 онд Засгийн газар нэмэлтээр жилд 350 сая ам.долларын өгөөжийн төлбөр авах байсан юм байна лээ. Жилд нийтдээ өнгөрсөн хугацаанд 7.2 тэрбум долларыг авах ёстой байсан гэдэг ийм тооцоолол гарсан.

Тэгэхээр энэ бол энэ хөрөнгө оруулалтын гэрээний том давуу тал. Энэ иргэддээ шууд хүртэнэ гэж.

Д.Амарбаясгалан: Нэмж хариулъя.

Н.Учрал: Тэгэхээр энэ төрийн эзэмшлийн тэр 34 хувийг тусгай АМНАТ-аар орлуулаад ирэхэд иргэдийн зүгээс ч бай, нийгмийн зүгээс ч бай ямар саналуудыг хэлсэн юм бэ гэхээр тусгай АМНАТ-аар орлуулж байгаа хэсгээ иргэний нөгөө хуримтлалын данс руу авдаг болгооч. Төсөв рүү битгий хураагаач ээ. Ингээд өнөөдрийн Үндэсний баялгийн сангийн хуулийг бид хэлэлцэж байгаа хуулийн дагуу тусгай АМНАТ-аар орлуулж байгаа хувь нь иргэний хуримтлалын данс руу шилжихээр нөгөө И Монгол дээр харагдаад байгаа өнөөдөр бага 138 мянган төгрөг харагдаад байгаа тэгээд мөнгөн дүн өсөж эхэлнэ.

2028 оноос, ноогдол ашиг 2031 оноос, 28 оноос бүтээн байгуулалт эхлээд ингээд АМНАТ аваад эхлэхээр энэ гар утсан дээр шууд ураны төсөл хэрэгжсэнээр танд ийм мөнгө орж байна гэдгийг хардаг ийм л шударга ил тод олборлох салбарын хариуцлагыг нэмэгдүүлье л гэж зорьж байгаа.

Д.Амарбаясгалан: Ажлын хэсгээс нэмж хариулт өгье.

Хууль зүй, дотоод хэргийн яам ажлын хэсгийн 21 дүгээр микрофон.

Н.Жамъянхүү: Хууль зүй, дотоод хэргийн яам Жамъянхүү. Гэрээний төсөл дээр гэрээний төслийн 14 дүгээр заалт дээр бол энэ гэрээ цуцлахтай холбоотой мэдэгдэл хүргүүлэх, гэрээ цуцалснаас үүсэх үр дагавар ямар нөхцөлүүдэд гэрээ цуцлах талаар нарийвчлаад ингээд оруулж өгсөн. Ингээд нарийвчилж оруулахдаа бол ялангуяа гэрээ цуцлахад бол хөрөнгө оруулагч талын санал байна. Нөгөө талдаа бол Монгол Улсын Засгийн газрын саналаар бол гэрээ цуцлах тодорхой нөхцөлүүдийг бол 2 тусдаа байдлаар ялгаж оруулж өгсөн байгаа. Тухайлбал 14.2-т Засгийн газар гэрээг цуцлах эрх бол Засгийн газрын дараах тохиолдолд гэрээг цуцална гээд энэ дээр бол нийтдээ 7 нөхцөлүүд болсон.

Тухайлбал төслийг хэрэгжүүлээгүй тохиолдолд бас гэрээг цуцлах гэсэн ийм нөхцөлүүд. Мөн гэрээ цуцлах нөхцөлүүдээс гадна энэ гэрээ цуцалснаас үүсэх үр дагаврын талаар бол нэлээн энэ гэрээний төсөл дээр.

Д.Амарбаясгалан: Гүйцээж хариулъя. Ажлын хэсгийн 21 дүгээр микрофон.

Гэрээ цуцлах үр дагавар бол энэ гэрээний хувьд бол ер нь их онцгой ач холбогдолтой. Ялангуяа гэрээ цуцалснаас үүссэн биелэгдээгүй үүргийг аль тал нь

хариуцаж гүйцэтгэх ёстой юм бэ? Тухайлбал байгаль орчны нөхөн сэргээлтийн үүргээ хэн хариуцаж гүйцэтгэх ёстой юм бэ гэдгээ бол Монгол Улсын хууль тогтоомж болон олон улсын гэрээ, олон улсын эрх зүйн хэм хэмжээний зарчим эд нарыг баримтлаад дандаа хөрөнгө оруулалт төсөл хэрэгжүүлж байгаа тал нь дандаа энэ үүргүүдийг хүлээсэн байгаад байгаа юм. Ийм үр дагаврууд болон үүргээс үүссэн гэрээ цуцалснаас үүссэн нөхөн төлбөрийн асуудлыг энэ гэрээний үр дагавар дээр ялангуяа нарийвчлаад тодорхой зохицуулаад тусгаад өгчихсөн байгаа 2 талаас.

Д.Амарбаясгалан: Амгаланбаатарын Ганбаатар гишүүн тодруулж асууя.

А.Ганбаатар: Тэр нөгөө шар нунтгаа эцсийн бүтээгдэхүүн гэж шийдэх тийм шийдвэрээ гаргах юм уу Засгийн газраас.

Хоёрт нь нөгөө энэ мэргэжлийн агентлаг гэж би зүгээр томьёолоод байгаа юм. Цөмийн энергийн агентлаг байсан хуучин. Тэр агентлагаа байгуулаад мэргэжлийн хүмүүс өөрөө энэ төслөө цаашаа хянуулж авахгүй юу гэсэн энэ 2 дээр хариултаа авъя.

Д.Амарбаясгалан: ЗГХЭГ-ын дарга Ням-Осорын Учрал сайд хариулт өгье.

Н.Учрал: Хөрөнгө оруулалтын гэрээн дээр НӨАТ төлөх үүргийн хувьд бусад уурхай нэгжүүдээс үл ялгаварлах нөхцөлөөр хангагдана гэдэг зарчмыг барья гээд Хөрөнгө оруулалтын гэрээнд тусгачихсан. Үүний цаана юу байна вэ гэхээр манай улс бол нүүрсийг угаагаад угаасан нүүрсийг л эцсийн бүтээгдэхүүн гэж үздэг улс. Гэтэл дэлхийн тавхан орон шар нунтгийг дараагийн шатад гаргадаг. Гэтэл та нар угаасан нүүрсээ эцсийн бүтээгдэхүүн гэж үзчихээд шар нунтгийг эцсийн бүтээгдэхүүн гэж үзэхгүй байгаа гэж ойлгохгүй байна аа. Үл ялгаварла цогцоор нь энэ бүтээгдэхүүнийг эцсийн бүтээгдэхүүн биш гээд үзвэл НӨАТ-аа төлөөд явна гэсэн. Тэгээд бид нар Засгийн газрын зүгээс ийм шийдвэр гаргаж болно. Үүн дээр Их Хурлын гишүүд нийгэмд нөгөө сошиалаар янз бүрийн юм бичдэг нөхдүүд тайван байх хэрэгтэй. Үүний цаана энэ шийдвэрийг гаргана. Энэ дээр харин хатуу хамгаалаарай л гэж гишүүдээс хүсье.

Д.Амарбаясгалан: Хариулт авч дууслаа.

Агваанлуvsангийн Ундраа гишүүн асуулт асууя.

А.Ундраа: Та бүхнийхээ энэ өдрийн амгаланг айлтгая.

Бид бол ингээд Улсын Их Хурлаараа нэг уул уурхайн төслийн гэрээ хэлцэл хэрхэн хийгдэх вэ гэдэг талаар ингээд гэрээний нөхцөлүүдийг яриад сууж байна л даа. Тэгээд яах вэ дэндүү олон удаа уул уурхайн төслүүдийг ингэж детальчилж ярих нь бол ер нь Улсын Их Хурлын хэлэлцэх асуудлын хүрээг дандаа ингэж доошлуулаад баймааргүй байгаа юм. Цар хүрээг. Энэ хүрээнд ЗГХЭГ-ын даргаас асуух асуулт бол Учрал сайд яах вэ ингээд гэрээний хэлцлийн нөхцөл байдлын талаар тэгээд татварыг ямар нөхцөлөөр авах вэ хэр зэрэг орлогоо нэмэгдүүлэх вэ? Энийг хангалттай хариулаад байна гэж харагдаж байна.

Цацрагийн хяналтын талаар бол маш олон асуултууд гарч байна. Тэгээд цацрагийн хяналт гэж асууж байна гэдэг нь ер нь цацрагаас айх айдас байгаатай уялдаатай. Тэгээд цацрагаас айх айдас юун дээр үндэслэж гарах вэ гэвэл энэ

цацрагийг хянах асуудлаа тэрийг залах асуудлаа мэдэхгүй шинжлэх ухаанч бус байдлаас тодорхой хэмжээнд үүдэлтэй гэж хэлж болно. Тэгэхээр бидний хувьд бол энэ бодлогоор шинжлэх ухаанд хөрөнгө оруулалт хийх тэрэн дээр шийдвэр гаргах илүү нарийн мэргэжлийн хүмүүсээ бэлдэх шаардлага байгаатай энэ тодорхойгүй нөхцөл байдал энэ тодорхой хэмжээний болгоомжлол энэ дээрээс үндэслэж гараад байна.

Тэгэхээр Засгийн газрын хувьд Цөмийн энергийн газрыг нээх асуудлаар ямар байр суурьтай байна? Сая гишүүн асуулаа. Та энэ талаар яг тодорхой хариулт өгсөнгүй. Цөмийн энергийн газар бол байсан тэгээд нэг цаг үеийн байдлаар эмоцид автсан байдлаар энийг хаасан. Энэ нь бол манай Монгол Улсын хөгжилд ухралт болсон гэж би хардаг. Цацрагийг хэрвээ хянаад мэдээж залж чадах юм бол тэндээс ХАА-н салбарт, анагаах ухааны салбарт гээд маш олон байдлаар хэрэглэж болно. Тэгээд ингэж хэрэглэх хэрэгцээгээ шинжлэх ухаанч байдлаар шийдэх, улсаа хөгжүүлэх боломжоо хаагаад өөрсдийнхөө хөгжлөө ингээд хумиад байх нь бид нарт ер нь бодлогын хувьд яагаад ч зохимжтой байж таарахгүй.

Тэгэхээр Засгийн газрын хувьд энэ Цөмийн энергийн газрыг нээх асуудлаар ямар байр суурьтай байна? Нээх бол хэзээ нээх вэ?

Хоёрдугаарт, Монгол Францын Засгийн газар хоорондын хэлэлцээр 2010 оны 10 дугаар сард хийгдсэн. Энэ Оронагийн гэрээтэй холбоотой ерөнхий энэ амбрелла гэж хэлж болохуйц хэлэлцээрүүдийг талаар эмхэтгэж оруулахдаа энэ Засгийн газар хоорондын хэлэлцээрийг тусгаагүй байна лээ. Тэгэхээр хамгийн чухал юмаа яагаад орхигдуулсан юм бэ? Энэ эрчим хүчнийхээ салбарын 80 орчим хувийг цөмийн эрчим хүчнээс гаргаж авдаг. Цөмийн гүрэн Франц улстай байгуулсан Монгол улсын Засгийн газар хоорондын хэлэлцээрийг яагаад 15 жилийн өмнө байгуулсан бэлээхэн хэлэлцээр байгаад байхад энийг явцууруулсаар байгаад зөвхөн нэг ордын асуудал болгоод ингэж өөрсдийнхөө боломжийг хумьж оруулж ирж байгаа юм бэ гэдэг асуудлыг тодруулмаар байна.

Тэгэхээр энд хэлэлцээрийнхээ хүрээнд тэнд тусгагдсан илүү өргөн хүрээний хамтын ажиллагаа, илүү шинжлэх ухаан технологийн хамтын ажиллагаануудыг энэ яриа хэлэлцээртээ тусгаж байнга тэр асуудлыг бодолцож ажиллах ёстой байх аа. Тэрнээс зөвхөн нэг ордыг ийм байдлаар олборлоно. Ингээд нэг уул уурхайн компанийн ашиглалтын уулын ажлын горим баталж байгаа юм шиг эсвэл санхүүгийн хэлтэс нь дараа жилийнхээ орлогоо юм уу хэдэн жилийнхээ орлогынхоо төлөвлөлтийг гаргаж байгаа юм шиг ингээд хэлэлцээд суух нь тун учир дутагдалтай байна л гэж харагдаж байна л даа. Учрал сайдаас тодруулна дараа нь.

Д.Амарбаясгалан: Ням-Осорын Учрал сайд хариулт өгье.

Н.Учрал: Ундраа гишүүн их зөв асуудлыг хөндөж байна. Тэгээд Ундраа гишүүн бол өөрөө эрдэмтэн хүн. Тийм учраас би энэ мэргэжлийн асуудлаар бол Ундраа гишүүнд хариулна ч гэж юу байх вэ. Тэгээд ер нь манай улсад нэг ийм бүгдийг мэддэг гэж өөрийгөө боддог гэх хүмүүс олон болсон. Бүгдийг мэддэг ч юм шиг, мэддэггүй ч юм шиг нэг ийм хүмүүс их олон болсноос болоод төрийн шийдвэр гаргалт байгаа онохгүй болсноос болоод л энэ цөмийн физикийн агентлаг татан буугдсан л даа.

Тэгээд Франц улс Монгол Улс 2 цаашдаа стратегийн түншлэлтэй больё гэдэг асуудлаар Монгол Улсын Ерөнхийлөгч Ухнаагийн Хүрэлсүх Францад айлчлахдаа албан ёсны санал тавиад энэ асуудал нэлээн өндөр түвшинд яригдаж байгаа юм. Стратегийн түншлэлтэй болно. Энэ хүрээнд 4 салбарт ажиллая гэсэн. Энэ ураны гэрээг явуулъя. Онцгой байдлын салбарт ажиллая тэгээд үндэсний хиймэл дагуулын төслийг хамт хэрэгжүүлбэ гээд ингээд ярилцсан.

Тэгээд Ерөнхийлөгчийн айлчлалын үеэр санамжийн бичгүүд зурагдсан. Тэгээд одоо нөгөө их мэдэгч нар оролцсоноос болоод нөгөө хиймэл дагуул хойшилсон. Нэг ёсондоо ярьсан хэлснээсээ буцдаг, хэлсэн ярьснаасаа буцдаг, за гэгчхээд хойшоо хараад өөр юм ярьдаг ийм улстай бид цаашдаа яаж ярих вэ л гэдэг хөрөнгө оруулагч нар ч гэсэн та нар чадах уу гэдэг асуултыг үргэлж асуудаг болсон. Энэ 2 орны найрамдал хамтын ажиллагаа. Цаашдаа бид нар Франц гэдэг энэ Европын Холбооны энэ том улстай энэ Аюулгүйн зөвлөлийн орон гишүүн оронтой стратегийн түншлэлтэй болох зорилтыг дэвшүүлнэ ээ.

Тийм учраас Ундраа гишүүний хэлсэн энэ одоо бид нар энэ гэрээн дээр энэ геополитикийн асуудлыг олон улсын харилцааны асуудлыг тухайлан үндэслэлүүд дээр нь оруулж өгөх дээр анхааръя. Тэгээд ер нь бол цаашдаа энэ гэрээ бол зөвхөн санхүүгийн үр өгөөжөөр хэмжигдэх биш, энэ бол гуравдагч хөршдөө хийж байгаа хөрөнгө оруулалтын гэрээ учраас хөрөнгө оруулалтын орчныг сайжруулах, олон улсын харилцааны түвшинд бол биднийг шинэ түвшинд гаргахад цаашдаа хөрөнгө оруулагч нар Монгол руу зорих урсгалыг нэмэгдүүлэхэд мөнгөн дүнгээсээ илүү хэмжиж болохгүй, олон томоохон агуулга зорилтыг энд хангуулж байгаа.

Тийм учраас бол энэ хөрөнгө оруулалтын гэрээ олон замыг бид нарт цаашдаа нээнэ. Ирэх хаврын чуулганаас өмнө энэ гэрээ батлагдсаны дараа Цөмийн энергийн агентлагийг шинээр байгуулъя. Тэгээд оруулж ирээд цаашдаа энэ төслийг хэрэгжүүлэх ч гол байгууллага нь энэ мэргэжлийн агентлаг нь болоод яваасай гэж ингэж хүсэж байгаа.

Тэгээд та бүхнийг дэмжихийг хүсэж байна аа.

Д.Амарбаясгалан: Агваанлувсангийн Ундраа гишүүн тодруулж асууя.

А.Ундраа: Цөмийн энергийн газар байгуулах чиглэлээр бэлтгэл ажил хийж байгааг сонсоход баяртай байна. Төмөр замын газар байгуулах чиглэлээр Засгийн газар тогтоолын төсөл өргөн барьсан байна лээ ингээд удахгүй хэлэлцэх гэж байна. Тэгэхээр яг энэ стратегийн чухал гэж байгаа салбаруудаа хөгжүүлэхийн тулд харьяалах хамаарах агентлагийг нь байгуулах, тэрийг чадавхжуулах, тогтвортой ажиллуулах энэ төрийн бодлогын залгамж халаанд маш чухал байгаа.

Тэгэхээр 2010 онд Занданшатар дарга гадаад харилцааны сайд байх үед байгуулсан тэр Засгийн газар хоорондын хэлэлцээрийг бас ахиад нэг анхааралтай танилцаад тэгээд энэ зөвхөн нэг төслийн хүрээнд биш илүү өргөн хүрээтэй ажиллах боломж бололцоо юу байдгийг анхааралтай үзэж хараасай гэж хүсэж байна аа. Баярлалаа.

Д.Амарбаясгалан: Ням-Осорын Учрал сайд нэмж хариулъя.

Н.Учрал: Тийм Ундраа гишүүний саналыг ойлголоо. 2010 онд тэр цөмийн эрчим хүчний салбар дахь хамтын ажиллагааны гэрээ байгуулсан. Энэ бол том эхлэл тавигдсан. Дээрээс нь 2 орон бүр хоорондоо хөрөнгө оруулагч нарыг харилцан дэмжиж хамгаалах тухай гэрээ 1993 онд хүчин төгөлдөр болсон ийм гэрээтэй. Ингээд бид бол стратегийн түншлэлтэй орон болохоор мэдээж хамтын ажиллагааны түншлэлээ бол үүрэгжүүлэхээр ярилцаж байна. Тэгээд энэ бол маш чухал асуудал учраас бид цаашдаа үүнд онцгойлон анхаарч ажиллах болно гэдгээ хэлье ээ.

Д.Амарбаясгалан: Батын Батбаатар гишүүн асуулт асууя алга байна. Батбаярын Жаргалан гишүүн асуулт асууя.

Б.Жаргалан: Сайн байцгаана уу? Та бүхэнд энэ өдрийн мэндийг хүргэе. тэгэхээр ирэх 7 хоногийн даваа гарагт буюу 1 дүгээр сарын 13-нд Монголчууд бид ардчилсан Үндсэн хуулиа баталсны 33 жилийн ойн баяраа тэмдэглэж өнгөрүүлнэ.

Тэгэхээр энэ 33 жилийн хугацаанд бид нар бол улс төрийн эрх чөлөөгөө хэрхэн яаж баталгаажуулах мөн эдийн засгийн эрх чөлөөгөө хэрхэн яаж олж авах буюу энэ байгалийн баялагтаа хэрхэн эзэн байх тухай асуудлыг л олон талаас нь хэлэлцээд л алдаж ч үзлээ онож ч үзлээ. Тэгээд энэ 33 жилийн түүх бол ердөө ийм. Тэгээд манай улсын хувьд бол уул уурхайн салбар бол яах аргагүй маш тийм том байр суурь эзэлж байгаа.

2000-аад оны эхэн үеэс эхэлсэн дэлхийн зах зээл дээрх уур уурхайн түүхий эдийн үнийн супер циклийн үед бид бол бид Оюу Толгой хэмээх одоо дэлхийд томоохонд тооцогдох эзсийн орд газраа ямар ч байсан эхлүүлээд авсан. Дэлхий даяар бол Оюу Толгой гэдэг энэ орд газрын талаар мэддэг болсон. Тухайн үед бол 2006 онд Монгол Улс анхны Баялгийн сан болох Монгол Улсыг хөгжүүлэх сангийн тухай хуулийг батлаад Монгол Улсын хөгжүүлэх санд тодорхой хөрөнгө хуримтлуулаад түүнээсээ хүүхдийн мөнгийг олгож ирсэн. Тэгэхээр өнгөрсөн хугацаанд бол бид нар энэ жижиг нээлттэй эдийн засгийн хувьд уул уурхайн томоохон төслүүд бол манай эдийн засагт үлэмж хувь нэмэр оруулаад ирж байгаа.

Тэгэхээр энэнээс бол яаж ард иргэддээ байгалийн баялгаасаа хувиа хүртээх вэ гэдэг асуудал дээр бол янз бүрээр л толгойгоо ажиллуулсан. Тэгэхээр энэ утгаараа бол стратегийн орд газруудад 34 хувь төр эзэмших тухай асуудал бол бас л энэ одоо бодлогын нэг хэсэг байсан. Байгалийн баялгаас аль болох илүү өндөр өгөөжийг эх орондоо дотоодын зах зээлд шингээх явдалд бол тухайн төсөл тодорхой хувь эзэмших эсвэл АМНАТ буюу роялтигаа нэмэгдүүлэх аль эсвэл бүтээгдэхүүн хуваах эсвэл юу гэдэг юм тодорхой ажиллах хүчинд тавигдах шаардлага, эсвэл дотоодын ААН-үүдээс аливаа худалдан авалтыг хийх зэрэг янз бүрийн аргаар аливаа улс орнууд энэ тухайн төслөөс аль болох илүү өндөр өгөөжийг дотооддоо байршуулахыг эрмэлздэг ээ.

Тэгэхээр сүүлийн үед энэ Зөөвч овоо төсөлтэй холбоотой асуудал дээр 34 хувь эзэмших асуудал бол ерөөсөө маш буруу зүйл байсан юм. Оюу Толгой дээр бид нар энэ дээр маш том алдаа гаргасан юм гэдэг ийм ийм яриа маш их ихээр давамгайлаад байгаад дурамжхан байгаад байгаа. Яагаад гэхлээр тухайн үед Оюу Толгойн гэрээ байгуулж байхад Улсын Их Хурлын 57 дугаар тогтоол гарч байсан. Тэр үед бол Улсын Их Хурал Засгийн газарт маш тодорхой зааврыг өгсөн гэж

ойлгоод байгаа юм. 34 хувийг бол эзэмших ёстой. Гэхдээ энэ нь өр зээл байх ёстой гэсэн зүйл яригдаагүй.

Тэгэхээр тухайн үед бол Засгийн газар Улсын Их Хурлын тэр даалгаврыг биелүүлэлгүйгээр 34 хувьтай нөгөө гэрээ байгуулахдаа өр зээл авчихсан учраас асуудал үүсчихсэн. Тэгээд улмаар өмнөх Засгийн газар бол яг энэ асуудал дээр маш том гавьяа байгуулсан шүү дээ. Энэ 34 хувьд ноогдох Монголын талын Монголын төрийн эзэмших өр зээлийн асуудлыг тэглэсэн явдал, тиймээ.

Тэгэхээр дараа дараачийн төслүүд дээр магадгүй тухайн төслийн онцлогтой холбоотойгоор зарим төслүүд дээр 34 хувиа эзэмшээд явдаг санж уу. Зарим төслүүд дээр энэ АМНАТ-аар орлуулдаг санж уу. Зарим төслүүд дээр бүтээгдэхүүн хуваах гэрээ байгуулдаг санж уу. Яг ингээд ийм нэг тийшээгээ битгий савлаасай л гэж хүсэж байгаа юм. Энийг бол яг ингээд тодорхой хариуцлагатайгаар хэлэхийг хүсэж байгаа юм.

Тэгэхээр яг энэ төсөл.

Д.Амарбаясгалан: Нэмэлт нэг минут өгье Жаргалан гишүүнд.

Б.Жаргалан: Тэгэхээр яг энэ Зөөвч овоо төсөлтэй холбоотойгоор энэ нөгөө 34 хувийг тусгай АМНАТ-ийн тусгай төлбөрөөр нэмэгдүүлэх асуудал орж ирж байна. Тэгэхээр энэ дээр болохоор 50 доллароос дээш нэг фунт ураны үнэ 50 доллароос дээш болох нөхцөлд 5 хувийн тусгай төлбөр авна гээд орхичихсон байж байгаа. Тэгэхээр ганц нэг зах зээлийн таамаглалуудыг харахаар ирэх жил гэхэд ураны үнэ магадгүй 100 доллароос давж магадгүй гэсэн энэ тэр таамгууд явж л байгаа юм л даа.

Тэгэхээр энэ сайт талдаа бол бид нар ерөнхийдөө бол нөгөө 5 хувь дээр өөрсдийнхөө орлогыг хаачхаж байгаа юм? Тэгэхээр аливаа нэг ийм уул уурхайн түүхий эдийн үнэ ялангуяа нөгөө зах зээлийн хомсдоллоос болоод маш ийм өндөр хувиар өсөхөд уул нь эндээс л бид нар өндөр өгөөж хүртэх ёстой байгаад байгаа юм л даа. Тэгэхээр энэ э тал дээр тэр аплайд тал дээрээ та нар ямар яг тооцоо.

Д.Амарбаясгалан: Ажлын хэсгийн дарга Бөхчулууны Пүрэвдорж гишүүн хариулт өгье.

Б.Пүрэвдорж: Мэдээж Оюу Толгойн гэрээ бол тийм муу гэрээ биш шүү дээ. Энэ эдийн засагт маш том үүрэг гүйцэтгээд явж байгаа. Тэгэхээр энэ 34 хувиа эзэмшсэнээр бид нар хэзээ яг цэвэр ашгаа авч эхлэх нь одоо хүртэл тодорхой биш байгаа.

Тийм учраас яг энэ Үндсэн хуулийн 6.2-ын газрын доорх баялгийн ашгийн дийлэнхийг нь ард түмэнд эзэмшихээр энэ заасны дагуу яг энэ өнөөдрийн хэлэлцээрээр 34 хувь эзэмших юм бол 5 тэрбум 600 сая доллар болох юм. Хэрвээ энэ АМНАТ-аар орлуулаад бусад татвараараа аваад явах юм нэг ойролцоогоор 5.2 тэрбум доллар болох юм. Хэдийгээр ашиггүй хүн мэт харагдаж байгаа боловч бид нар ямарваа нэгэн санхүүгийн эрсдэл хүлээхгүйгээр энэ төслөөс шууд олборлолт гарангуут нь үр ашгаа хүртээд явах ийм боломжийг бүрдүүлж байгаа. Тэгэхээр өнөөдрийн энэ 5.6, 5.2 бол 80 доллар дор суурилагдаж хийгдсэн. Тэгэхээр яг 2028

онд энэ үйлдвэр ашиглалтад ороход ураны үнэ бол ойролцоогоор 110 доллар дээр очно гэсэн ийм одоо төсөөлөлтэй байгаа.

Тэгэхээр энд 110 доллар болох юм бол ойролцоогоор нэг 56 хувийн ашигтай болж, Монголын талдаа ашигтай болж хувирахаар ийм тооцоолол байгаа. Ер нь бол цаашдаа ураны 1 сая кг нүүрс түлэх үү, 1 кг ураны түлш түлэх үү гэдэгт хамгийн гол асуудал байгаад байгаа юм л даа. Энэ нь байгаль орчинд ээлтэй гэж цаашдаа тооцогддог болсон.

Тийм учраас энэ ураны хэрэглээ маш их нэмэгдэх ийм нөхцөл байдал харагдаж байгаа. Францын талын төсөөлж байгаагаар бол 2035 онд ойролцоогоор 250 орчим доллар дээр 1 кг уран очно гэсэн ийм төсөөлөлтэй байгаа. ОХУ-ын төсөөллөөр бол нэг ойролцоогоор 300 орчим доллар дээр очно гэсэн үг. Энэ нь юунаас шалтгаалж байна вэ гэвэл маш их эрчим хүчний шаардлага ирээдүйд гарах учраас энэ ураны үнэ улам өснө гэдэг ийм л хандлага гарчхаж байгаа. Тэгэхээр энэ тохиолдолд бол ер нь 57 хувь орчимд л манай Монголын ашиг 57 хувь дээр л байнгын байна л гэсэн ийм л төсөөлөлтэй байхад болно гэж хэлмээр байна.

Нэмэлт хариултыг Учрал сайд хариулъя.

Д.Амарбаясгалан: Учрал сайд нэмж хариулъя. Санал хураалт болно. Гишүүдийг танхимд урьж байна.

Н.Учрал: Ураны үнийн өсөлт ингээд харахаар нээрээ 100 болох юм шиг ер болох юм шиг цаашдаа ер нь өсөх эрэлт ихтэй. Тийм учраас бид нар энэ өсөн нэмэгдэх АМНАТ гэдэг ойлголтыг Цөмийн энергийн хуульд оруулсан. Үнийн өсөлтөөс хамаарч байгаа АМНАТ бол тусгай АМНАТ огт биш. Тэгэхээр мэдээж үнэ өсөөд явах юм бол 2 талын орлого нэмэгдээд явна. Хэрвээ 51 хувьдаа өгөхгүй бол өгөөжийн тохируулга хийнэ л гэдэг ийм заалт байгаа.

Тэгэхээр мэдээж энэ өгөөжийн асуудлыг ярьж байгаа бол АМНАТ ч бай, ноогдол ашиг ч бай нэмэлт төлбөр ч бай энийг салгаж ярих бололцоогүй. Сая Жаргалан гишүүний хэлж байгаа Үндэсний баялгийн сангийн хуульд хэрвээ нэмэлт, өөрчлөлт батлагдвал энэ тусгай АМНАТ-аас олох энэ төслийн хугацаанд олох 2.5 их наяд төгрөг хуримтлалын сан руу орно. Өсөн нэмэгдэх АМНАТ, суурь АМНАТ-ын 65 хувь нь ирээдүйн өв сан руу 65 хувь нь ороод үлдсэн нь орон нутаг руу тогтворжуулах.

Д.Амарбаясгалан: Учрал сайд гүйцээж хариулъя.

Н.Учрал: Энэ тусгай АМНАТ-аас төслийн хугацаанд бид нар 2.5 их наядыг олно. Энэ 2.5 их наяд бол иргэдийн хуримтлалын данс руу орно. Одоо нөгөө И Монгол дээр харагдаж байгаа хуримтлалын данс руу. Өсөн нэмэгдэх АМНАТ буюу сая Жаргалан гишүүний хэлж байгаа үнэ нь өсөөд явбал нөгөө прогрессив роялти Цөмийн энергийн хууль дээр жагсаасан. Яг үүнтэй үүний дагуу өсөн нэмэгдэх АМНАТ ч бай, суурь АМНАТ ч бай 65 хувь нь Ирээдүйн өв сан руу ороод, үлдсэн орон нутгийн сан руу, тогтворжуулалтын сан руу хуваагдаад орно гэсэн ийм л зохицуулалт хийсэн.

Д.Амарбаясгалан: Гишүүд асуулт асууж хариулт авч дууслаа.

Байнгын хорооноос гаргасан зарчмын зөрүүтэй саналын томьёоллоор санал хураалт явуулна. Зарчмын зөрүүтэй 7 санал байгаа.

Зарчмын зөрүүтэй саналыг тайлбарлаж түүнийг дэмжсэн, эсрэг байр суурьтай намын бүлгийг төлөөлж мөн аль нэг нам эвслийн бүлэгт харьяалагдаагүй тус бүр 2 хүртэл гишүүн үг хэлж, болохоор Дэгийн хуульд заасан байгаа.

Зарчмын зөрүүтэй саналын томьёоллыг танилцуулъя.

Стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордын төрийн эзэмшлийн хувь хэмжээг орлуулах тухай Монгол Улсын Их Хурлын тогтоолын төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томьёолол.

Нэг.Эдийн засгийн байнгын хороо дэмжсэн санал

Д.Амарбаясгалан: 1.Төслийн 1 дэх заалтын “MV-018915 дугаартай “Дулаан-Уул”” гэснийг “MV-018916 дугаартай “Дулаан-Уул” гэж, “MV-018916 дугаартай “Зөөвч-Овоо”” гэснийг “MV-018915 дугаартай “Зөөвч-Овоо”” гэж тус тус өөрчлөх гэсэн. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Пүрэвдорж, Баярбаатар, Тэмүүлэн Ариунзаяа, Батбаатар, Батнайрамдал, Баярмаа, Бямбасүрэн, Ганбаатар, Гомбын Ганбаатар, Ганхуяг, Найдалаа, Отгонбаяр, Пүрэвдаваа, Сайнзориг, Тэмүүжин, Уянгахишиг, Давааагийн Цогтбаатар, Цэнгүүн Шижир, Баттөмөрийн Энхбаяр, С.Эрдэнэбат цаашид ажлын хэсэг гэх. Санал гаргасан ажлын хэсгийг төлөөлж Бөхчулууны Пүрэвдорж гишүүн тайлбар хэлье.

Б.Пүрэвдорж: Энэ тогтоолын төсөл дээр анхнаасаа орж ирэхдээ Засгийн газраас орж ирсэн тогтоолын төсөл дээр орж ирэхдээ урд талынхаа дугаарлалтыг гэрчилгээнийхээ дугаарлалтыг сольчихсон юм байна лээ шүү дээ. Өөр ямарваа нэгэн асуудал байхгүй.

Д.Амарбаясгалан: Санал хураалт 58 гишүүн буюу 62.4 хувиар санал дэмжигдлээ.

2.Төсөлд доор дурдсан агуулгатай 2 дахь заалт нэмэх:

“2.Энэ тогтоолын 1 дэх заалтад заасны дагуу энгийн хувьцааг давуу эрхийн хувьцаанд хөрвүүлэхэд дараах зарчмыг баримтална:

1/төрийн эзэмшлийн 10 хувийн давуу эрхийн хувьцаа нь тухайн компанийн хувь нийлүүлсэн хөрөнгийн 10 хувьтай тэнцүү байх;

2/нийт гаргасан энгийн болон давуу эрхийн хувьцаанд эзлэх төрийн эзэмшлийн хувь хэмжээг 10 хувиас бууруулахгүй байх.” Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Гончигдоржийн Уянгахишиг. Эдийн засгийн байнгын хорооны дэмжсэн санал байгаа.

Энэ дээр Батлан хамгаалахын сайд, Улсын Их Хурлын гишүүн С.Бямбацогт.

С.Бямбацогт: Энэ заалтыг дэмжиж байгаа. Ер нь ингээд тодорхой байх ёстой. Оюу Толгой дээр бидний алдсан алдаа 34 хувиа эзэмшинэ гэсэн. Гэтэл 34 хувийг эзэмшихдээ өрийг нь дагуулаад тийм үү зээл Монгол дээр бичээд явахаар ийм алдаа л гарчихсан шүү дээ. Уг нь байгалийн баялгийн эзэн байж байж бид ямар ч төлбөр авахгүйгээр зээл авахгүйгээр эзэмших л ёстой байсан. Одоо бид нар ингээд энэ Орано дээр тэгээд л хийж байгаа. Тийм болохоор иймэрхүү юман дээр нэлээн сайн анхаарч байхгүй бол бид ингээд Улсын Их Хурлаас тогтоол гаргаж өгдөг, хууль гаргаж өгдөг. Хэрэгжүүлэхдээ Засгийн газар болон холбогдох албан тушаалтнууд гуйвуулаад мушгиад ингээд хэрэгжүүлчихдэг. Үүнээсээ болж эцэст нь ийм сөрөг үр дагавартай байдаг. Бид нар Оюу Толгойн туршлагаас харсан.

Дахиад нөгөө асуудал бол зардлын менежментийн төлбөр гэж 6 хувь, удирдлагын зардал. Тэр менежмент хийж байгаа хүмүүс нь ерөөсөө аль болох их зардалтай ажиллана. Түүнээс нь 6 хувийн төлбөр урамшуулал олгож авах учраас хөлс авах учраас аль болох өндөр зардалтай гаргаж ажилласан. Үүнээсээ болж Монгол Улс өрөнд орсон. Уг нь зүй нь яах ёстой байсан гэрээ хийхдээ ашгийнхаа 6 хувийг ав. Чи аль аль болох хувьцаа эзэмшигчдээ хөрөнгө оруулагч нартаа илүү ашиг өгнө, түүнээсээ 6 хувиа өгсөн бол тэр менежментийн баг илүү ашигтай ажиллуулахын тулд анхаараад 6 хувиа ахиу авахын тулд ажиллах байсан. Ийм л алдаанууд гарсан.

Тийм болохоор ийм алдаануудыг бид нар давтахгүй байх ёстой. Энийг нэлээн гайгүй сайн болж орж ирж байгаа болов уу гэж найдаж байгаа. Цааш цаашдаа бидэнд анхаарах дахиад асуудал бол яг энэ жишгээр энэ олон маргаантай ордууд байж байна. Мардай гээд ураны орд байж байна. Тэр юу гэдэг юм Газрын ховор элемент гэх юм бол тэр Луугийн голынх, тэр Могойн голынх өшөө юу билээ? Ховд, Мушгиа худаг, тэр Ховдын Халзан бүргэдэй гээд энэ ордууд ингээд маргаад байгаад байх юм уу? 34 хувь төр эзэмших юм уу, эзэмшихгүй юм уу, эс үгүй бол ийм байдлаар 34 хооронд яах юм уу, хөдөлгөмөөр байна. Хөдөлгөмөөр байна.

Одоо тэр Цагаан суварга. Бас л ингээд л маргаад байж байгаа. Одоо тэр Эрдэнэт, тэр Ачит эх ингээд л маргаад байж байгаа. Тийм болохоор тодорхой хэмжээгээр юу гэдэг юм 34 хувь эзэмших газар зөв. 34 хувь эзэмшье өмнөх алдааг давтахгүй. Гарцаа байхгүй 34 хувь давуу эрхийн хувьцаа, дээрээс нь ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр авахаар энэ ийм жишгээр аваад явъя. Ийм байдлаар ингээд тал талдаа энэ хөрөнгө оруулагч ард иргэд хооронд тулчихсан маргачихсан хэрсэн бух шиг ингээд зогсчихсон. Төр тэн дунд нь яаж ч чаддаггүй ийм байдалтай баймааргүй байна. Энэ нэгэнтээ сайн жишгийг бид нар бий болгомоор байна. Ялангуяа одоо энэ үндэсний компаниудын энэ хөрөнгө оруулагчдын явуулах гээд байгаа төслүүдийг энэ гаднын хөрөнгө оруулалтыг дэмжиж байгаатай адилхан бид нар анхаарах ёстой шүү. Дэмжих ёстой шүү. Тэр Цагаан суварга дээр, тэр Ачит эх дээр, өшөө тэр Ховдын тэр Халзан бүргэдэй дээр гэдэг юм уу иймэрхүү төслүүд дээр бид нар бас 34 хувиа эзэмшээд. Үндэсний баялгийн сан ард иргэддээ өгөх өгөөжөө л нэмэгдүүлье л дээ.

Зөвхөн стратегийн арван тавхан ордоор хязгаарлагдах биш стратеги 15 ордоос үндсэндээ хэдхэн л үр өгөөжөө өгч байгаа шүү дээ. Тэгвэл бүх стратегийн ордууд, цаашлаад томоохон ордууд. Энэ рүү үр өгөөжөө хүртэх бололцоог нэмэгдүүлэхийн тулд энэ гацааг бид нар гаргахын тулд бас Засгийн газар Улсын Их Хурлаас яг энэ жишгээр цаашдаа анхаарч ажилламаар байгаа шүү л гэдгийг хэлье ээ.

Д.Амарбаясгалан: Бямбацогт гишүүн дэмжиж үг хэллээ.

Батжаргал гишүүн Жигжидийн Батжаргал гишүүн үг хэллээ.

Ж.Батжаргал: Баярлалаа. Тэгэхээр стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордын төрийн эзэмшлийн хувийг орлуулж болох эрх зүйн зохицуулалтыг бид нар хийчихсэн юм. Цөмийн энергийн тухай хуулиараа хийчихсэн. Өнөөдөр бол бид нар тэр 34 хувийг орлуулахдаа 10 хувийг нь давуу эрхийн хувьцаагаараа орлуулъя. Үлдэж буй 24 хувийг нь АМНАТ-өөр гэхдээ бүүр их тодорхой зааж байгаа 5 хувиар орлуулахаар ингэж орж ирж байгаа. Манай ажлын хэсгийн гол анхаарал төвлөрөөд яваад байгаа юм нь Үндсэн хуулийн 6.2 буюу ашигт малтмалын үр өгөөжийн дийлэнх хэсэг ард түмэнд үлдэх тухай энэ үзэл санааг бодитой болгох гэж нэлээн сайн ажиллаж байгаа юм билээ. Энэ бол их сайн гэрээ. Гэрээ яг Их Хурал дээр ороод ирэхээр бол ярих зүйлүүд олон бий. Өнөөдөр гэрээ байгуулахад 10 хувийн давуу эрхээр тэр цаад 24-ийг нь АМНАТ-ийн 5 хувиар орлуул гэдэг ийм эрхийг Засгийн газартаа өгөөд тэр дагуу гэрээний үндэслэл болж хийгдэх ёстой.

Гэтэл тооцооллынх нь харахаар бас тэр цаад 5 хувиар орлуулаад байгаа зүйл дээр эргэлзээ үүсээд болж өгөхгүй байгаа. Нийт АМНАТ тооцох бүтээгдэхүүний борлуулалтын орлогыг 15 орчим тэрбум доллар байхаар төсөөлөл харагдаад байгаа. 5 хувиар тооцох юм бол 750 сая долларын тухай л асуудал байгаа. Томсгосон тооцоогоор нь татварын дараах буюу ноогдол ашиг хуваарилах ашгийг би нэг бараг 7 орчим тэрбум долларын юм байх гээд байгаа юм уу гэж хараад байгаа. Энийг хэрвээ 24 хувиар тооцох юм бол наадах чинь 1.5 тэрбум долларын тухай асуудал яригдах гээд байх шиг байгаа юм аа. Тэгэхээр энэ 2 хоорондоо дүйх тухай асуудал байгаа. 51 хувиа дэндүү их том бодоцгоогоод тусгайлсан эрх зүйн зохицуулалтаар гаргаад өгчихсөн зохицуулалтаа хангахгүйгээр асуудал хийчих юм бол энэ гэрээ өөрөө эрх зүйн зөрчилтэй гэрээ болж хувирч харагдах гээд байгаа юм аа. Тийм учраас тэр Цөмийн энергийн тухай хууль, Ашигт малтмалын тухай хуулиудад заагдсан ашигт малтмалын нөөц ашигласны тусгай төлбөрөөр төрийн эзэмшлийн хувиа орлуулж болох тэр зохицуулалтаа харж энэ хувь нь өөрөө тогтогдох ёстой зүйл ээ.

Тэгэхээр би энийг одоо өнөөдөр Их Хурал Засгийн газартаа гэдэг юм уу гэрээ байгуулах үндсэн суурь чиглэлээ болгож өгөхдөө их зөв тогтоож өгөхгүй бол энэ эргэлзээ үүсгэнэ шүү. Энийг би зориуд энэ өнөөдрийн чуулганы хуралдааны протоколд тэмдэглүүлэхээр зориуд энийг хэлж байгаа юм. Энэ тал дээр Дэгийн хуулиар тайлбар өгөх боломжгүй юу? Тэрнээс энэ ажлын хэсэг энэ дээрээ нэг тайлбар өгч их тодорхой болгох ёстой. Энэ чинь тусгайлсан хуулиар зохицуулчхаад байгаа харилцааг бид ярьж байгаа зүйл шүү. Тэрнээс биш нийт 51-ийн тухай яриагүй зүйл шүү. Энийг их тодорхой бодож бид шийдлээ гаргах ёстой гэж ингэж хэлмээр байна.

Д.Амарбаясгалан: Үг хэллээ. Тайлбар хийх боломж дэгээрээ байхгүй учраас Батжаргал гишүүний байр суурийг протоколд тэмдэглэлээ.

Ингээд зарчмын зөрүүтэй 2 дахь саналын Эдийн засгийн байнгын хорооны дэмжсэн саналыг дэмжье гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя аа.

Санал хураалт.

63 гишүүн буюу 67.7 хувиар санал дэмжигдлээ.

Монгол Улсын ардчилсан Үндсэн хуулийн 33 жилийн ойн хүрээнд Улсын Их Хурлын Тамгын газраас хүний эрх, эрх чөлөө, шударга ёс сэдвийн хүрээнд мөн үндэсний эв нэгдэл, төрт ёс, түүх соёлын уламжлал сэдвийн хүрээнд эссэ бичлэгийн уралдааныг оюутан залуучуудын дунд зохион байгуулсан байгаа. Нийт 140 гаруй оюутан оролцсоноос эхний 10 байр эзэлсэн оюутан залуучууд манай чуулганы хуралдааны танхимд орж ирсэн байна аа.

Тэгээд та бүхэндээ баяр хүргэж, амжилт хүсье ээ.

3.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 3 дахь заалтыг “Энэ тогтоолыг 2025 оны 01 дүгээр сарын 10-ны өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.” гэж өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг.

Эдийн засгийн байнгын хорооны дэмжсэн саналыг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя.

Санал хураалт.

62 гишүүн буюу 66.7 хувиар санал дэмжигдлээ.

Найруулгын санал.

Бадарчийн Хэрлэн гишүүн дэмжсэнээр протоколд уу? Бадарчийн Хэрлэн гишүүнийг дэмжсэнээр протоколд, Гончигдоржийн Уянгахишиг гишүүнийг дэмжсэнээр протоколд оруулъя. Өөрийнх нь гаргасан санал.

НАЙРУУЛГЫН САНАЛ

1.Төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томьёолол дэмжигдсэнтэй холбогдуулан төслийн бүтэц, нэр томьёо, хэл найруулга, дэс дараалал, заалтын дугаарыг нийцүүлж өөрчлөх.

Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Гончигдоржийн Уянгахишиг. Эдийн засгийн байнгын хорооны дэмжсэн саналыг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя.

Санал хураалт.

66 гишүүн буюу 71 хувиар санал дэмжигдлээ.

Хоёр.Эдийн засгийн байнгын хороо дэмжээгүй санал:

1.Төслийн 1 дэх заалтын “төрийн эзэмшлийн 34 хувийн” гэсний дараа “энгийн” гэж нэмж, мөн заалтын “10 хувийн” гэснийг хасах.

Санал гаргасан Гончигдоржийн Уянгахишиг гишүүн. Эдийн засгийн байнгын

хорооны дэмжээгүй саналыг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт.

56 гишүүн буюу 60.2 хувиар санал дэмжигдлээ.

Эдийн засгийн байнгын хорооны дэмжээгүй санал дэмжигдлээ.

2.Төсөлд доор дурдсан агуулгатай 3 дахь заалт нэмэх:

“3.Стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордын ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийн 30-аас доошгүй хувийг олборлолтын сөрөг нөлөөлөлд өртөж буй аймаг, сумдын орон нутгийн хөгжлийн санд хуваарилах эрх зүйн үндсийг бий болгох чиглэлээр холбогдох арга хэмжээ авахыг Монгол Улсын Засгийн газар /Л.Оюун-Эрдэнэ/-т даалгасугай.”

Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Мягмарсүрэнгийн Бадамсүрэн.

Эдийн засгийн байнгын хорооны дэмжээгүй саналыг дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя.

Санал хураалт.

46 гишүүн буюу 46.2 хувиар Эдийн засгийн байнгын хорооны дэмжээгүй санал дэмжигдсэнгүй.

3.Төслийн хавсралтын “40-50 хүртэл 0.5%” гэснийг “40-өөс дээш 5%” гэж өөрчилж, “50-иас дээш 5%” гэсэн мөрийг хасах.

Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Соронзонболд. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүнд микрофон өгье.

Л.Соронзонболд: Яах вэ манай хөрөнгө оруулагч компани маань өөрөө яг энэ ураны зах зээл дээрээ бүх өртгийн сүлжээндээ оролцдог ийм том тоглогч байгаад байгаа байхгүй юу. Тэгээд бид нар АМНАТ-аа 40 доллар хүртэл 0 болгочхож байгаа. Тэгээд 40-өөс 50 доллар дээр 0.5 гээд 50-иас дээш дээр тэр 5 гэж байгаа нь би буруу байна гэж үзэж байгаа юм. Монгол Улсынхаа эрх ашгийг бодох юм бол бид нар 40-өөс 50 доллар дээр ч гэсэн 5 хувь байх ёстой. Тийм учраас 40 доллараас дээш 5 хувь гэж байгаа саналыг гаргасан юм аа. Тэгэхээр гишүүд үүнийг дэмжиж өгөхийг хүсье ээ.

Д.Амарбаясгалан: Эдийн засгийн байнгын хорооны дэмжээгүй саналыг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя.

Санал хураалт.

48 гишүүн буюу 51.6 хувиар Эдийн засгийн байнгын хорооны дэмжээгүй санал дэмжигдлээ.

Зарчмын зөрүүтэй саналын томьёоллоор санал хурааж дууслаа.

“Стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордын төрийн эзэмшлийн хувь, хэмжээг орлуулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Эдийн засгийн байнгын хороонд шилжүүллээ.

Эдийн засгийн байнгын хороо 12 цагаас хуралдана. 12 цагаас хуралдахаар байгаа.

11.53 цагт

Дараагийн асуудалд оръё. Элчин сайдыг томилох саналыг зөвшилцөх тухай асуудлыг хэлэлцэнэ.

Монгол Улсын Ерөнхийлөгчийн саналыг Монгол Улсын Ерөнхийлөгчийн Хот, хөдөөгийн бодлого хариуцсан зөвлөх Гочоогийн Ганболд зөвлөх танилцуулна аа. Индэрт урьж байна.

Г.Ганболд: Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Үндсэн хуулийн 33 дугаар зүйлийн нэг дэх хэсгийн 5 дахь заалт, Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 3, Засгийн газрын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 4, Дипломат албаны тухай хуулийн 16 дугаар зүйлийн нэг дэх заалтыг тус тус үндэслэн Монгол Улсаас БНПУ-д суух Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайдаар Наваан-Юндэнгийн Оюундарийг шинээр томилох саналыг танилцуулж байна аа.

Наваан-Юндэнгийн Оюундарийг БНПУ-д суух суух Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайдаар томилох асуудлыг 2024 оны 12 дугаар сарын 25-ны өдөр Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлж, Засгийн газрын гишүүд дэмжиж, 2025 оны 1 дүгээр сарын 8-ны өдөр Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороо дэмжсэн болно оо.

Элчин сайд нь Монгол Улсын олон улсын гэрээ, холбогдох хууль тогтоомжоор олгогдсон бүрэн эрх, хүлээсэн чиг үүргийнхээ хүрээнд суугаа болон авсан суугаа улс ОУБ-даа Монгол Улсыг төлөөлөн ажиллаж ашиг сонирхол болон эрхийг нь хамгаалах, харилцаа, хамтын ажиллагааг хөгжүүлэх, Монгол Улсын хөгжлийн зорилтыг шийдвэрлэхэд шаардагдах судалгааг хийж, төр засгийн байгууллагыг мэдээллээр хангах, гаргасан шийдвэрийг хэрэгжүүлэх, 2 болон олон талын харилцааны асуудлаар яриа, хэлэлцээр хийх, гэрээ, хэлэлцээр байгуулах, Монгол Улсын иргэн, хуулийн этгээдийн хууль ёсны эрх ашиг сонирхлыг олон улсын эрх зүй, суугаа орны хууль тогтоомжийн дагуу хамгаалж ажилладгаас гадна тэргүүлж буй ЭСЯ-ныхаа үйл ажиллагааг нэгдсэн удирдлагаар хангах чиг үүрэгтэй байдаг аа.

Элчин сайдаар томилон ажиллуулахаар нэр дэвшүүлж буй Н.Оюундарь нь төрийн алба, дипломат албанд, олон жил ажилласан, дипломат албанд ажилласан туршлагатай мэргэжлийн өндөр ур чадвартай, удирдах ажлын дадлага туршлагатай, Англи, Орос, Герман, Хятад хэлний мэдлэгтэй, төрийн болон дипломат албаны хууль тогтоомжийн шалгуурыг хангасан төрийн тусгай албанд ажиллах бүрэн боломжтой албан хаагч болно.

Иймд Монгол Улсаас БНПУ-д суух Элчин сайдыг шинээр томилох Монгол Улсын Ерөнхийлөгч Ухнаагийн Хүрэлсүхийн саналыг зөвшилцөн шийдвэрлэж өгөхийг хүсье ээ.

Анхаарал тавьсанд баярлалаа.

Д.Амарбаясгалан: Баярлалаа.

Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Батбаярын Жаргалан гишүүн танилцуулна аа. Индэрт урьж байна.

Б.Жаргалан: Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Үндсэн хуулийн 33 дугаар зүйлийн нэг дэх хэсгийн 5 дахь заалт, Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 3 дахь хэсэг, Дипломат албаны тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1 дэх хэсэгт заасныг үндэслэн Монгол Улсын Ерөнхийлөгчөөс Монгол Улсаас БНПУ-д суух Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайдаар Наваан-Юндэнгийн Оюундарийг томилох саналыг 2024 оны 12 дугаар сарын 26-ны өдөр Улсын Их Хуралтай зөв зөвшилцөхөөр өргөн мэдүүлснийг Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороо 2025 оны 1 дүгээр сарын 8-ны өдрийн хуралдаанаараа хэлэлцлээ.

Байнгын хорооны хуралдаанаар дээрх асуудлыг хэлэлцэх үед Улсын Их Хурлын гишүүн Д.Энхтүвшин БНПУ болон Европын улс орнуудтай экспорт, импорт, хөрөнгө оруулалт, эдийн засгийн хамтын ажиллагааг өргөжүүлэхэд анхаарч ажиллах, ГХЯ мэргэшсэн албан хаагчийг дипломат албанд томилох, улс төрийн томилгоо хийх асуудал дээр ямар байр суурьтай ажиллаж байгаа талаар, Улсын Их Хурлын гишүүн Ж.Энхбаяр нэр дэвшигчийг дэмжиж байгаагаа илэрхийлээд БНПУ-ын ХАА-н салбарыг өөрийн улстай холбох мөн боомтын асуудалд анхаарах, уламжлалт анагаах ухаан, эрүүл мэндийн салбарын хамтын ажиллагаа, аюулгүй байдал, гадаад орчны асуудалд анхаарах, Улсын Их Хурлын гишүүн Д.Ганбат нэр дэвшигчийг дэмжиж байгаа бөгөөд цаашид ийм мэргэжлийн хүнээр ЭСЯ-ны тэргүүнийг томилох нь зүйтэй талаар, манай улсын иргэд гадаадын хэдэн улсад визгүй зорчиж байгаа тухай, мөн цаашид энэ тоо нэмэгдүүлэхэд хэрхэн анхаарч байгаа талаар нэр дэвшигч болон ГХЯ-аас асуулт асууж хариулт авсан.

Түүнчлэн Улсын Их Хурлын гишүүн Г.Тэмүүлэн мэргэжлийн болон төрийн албаны дадлага туршлагатай, хэлний өндөр мэдлэгтэй, дипломат албан шаардлагыг хангасан энэ хүнийг энэ албанд томилоход анхаарч ажиллах талаар үг хэлсэн.

Монгол Улсын Ерөнхийлөгчөөс Улсын Их Хуралд зөвшилцөхөөр өргөн мэдүүлсэн Наваан-Юндэнгийн Оюундарийг Монгол Улсаас БНПУ-д суух Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайдаар томилох саналыг Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Ерөнхийлөгчөөс Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Элчин сайдыг томилох асуудлаар зөвшилцөх тухай саналыг хэлэлцсэн талаарх Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг та бүхнээс хүсье ээ. Баярлалаа.

Д.Амарбаясгалан: Ажлын хэсгийн гишүүдийг танилцуулъя.

Батмөнхийн Батцэцэг гадаад харилцааны сайд, Гочоогийн Ганболд Монгол Улсын Ерөнхийлөгчийн зөвлөх, Дансрангийн Булган Төрийн захиргаа, хүний нөөцийн удирдлага зохион байгуулалтын газрын захирал, Гадаад яамны Донжчимбуугийн Бямбадорж мөн яамны Бодлогын газрын дэд захирал, Төмөрбаатарын Бат-Орших мөн яамны Консулын газрын дэд захирал, Жамбалдоржийн Соёлмаа Гэрээ, эрх зүйн газрын захирлын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч, Монгол Улсаас гадаад улсад суух Элчин сайдаар томилогдох албан тушаалтныг танилцуулъя. Наваан-Юндэнгийн Оюундарь Монгол Улсаас БНПУ-д суух Онц Бөгөөд Бүрэн эрхэт Элчин сайдад нэр дэвшигч.

Ингээд Байнгын хорооны санал, дүгнэлттэй Монгол Улсын Ерөнхийлөгчийн санал болон Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан түүнчлэн нэр дэвшигчээс асуулт асууж, үг хэлэх гишүүд нэрээ өгье.

13 гишүүнээр тасаллаа. Аюушийн Ариунзаяа гишүүн асуулт асууя.

А.Ариунзаяа: Монгол Улсын Ерөнхийлөгчөөс зөвшилцөхөөр оруулж ирж байгаа нэр дэвшигчийг бүрэн дүүрэн дэмжиж байна аа. Яах вэ бид нар нэг юман дээр анхаармаар байгаа юм. Сошиал дээр урьдчилаад ямар нэгэн байдлаар тэр тийшээ томилогдох гэнэ ээ гэдэг ийм сэвээнүүд яваад байдаг. Тэгэхээр энэ мэдээлэл нь хаана алдагдаад, хаанаас гараад яагаад ингээд нийгмийг үймүүлээд байдаг юм бэ гэдэг дээр нэн тэргүүнд ГХЯ дотроо анхаарч энэ Элчин сайдуудын томилгоон дээр явагдаж байгаа төлөвлөгөөгөө дотроо энэ албаны нууц гэдгээрээ авч үлддэг юм уу яадаг юм. Энэ нэг мэдээлэл алдагдаад байгаа тал дээр бид нар анхаарах шаардлагатай байна гэдгийг энэ ташрамд зайлшгүй сануулж хэлэх гэсэн юм аа.

Цаашид 22 элчин сайдын асуудал орж ирнэ гэсэн ийм мэдээллийг л дахиад л нөгөө сошиалаас авсан. Тэгэхээр ямар нэгэн байдлаар хэн нэгэн хүнийг сорчилж аваад энэ сошиалаар яваад байдаг нь бол өөрөө буруу юм гэдгийг энэ талдаа хэлмээр байна. Улс төрч хүн өөрөө Элчин сайдаар томилогдож болохгүй гэдэг заалт байхгүй. Харин ч эсрэгээрээ яг Оюундарь нэр дэвшигчийн хувьд бол улс төрд байсан нь эсрэгээрээ давуу тал болж ирж байна гэдгийг онцлон хэлмээр байна.

Улсын Их Хурлын гишүүнээр ажиллаж байхдаа Европын холбоо Монгол парламентын бүлгэмийн даргаар ажиллаж байсан. Орос, Англи, Герман, Хятад хэлтэй. Бээжин дэх Улаанбаатар хотын төлөөлөгчөөр 4 жил ажиллаж байсан ийм туршлагатай Гадаад харилцааны дэд сайд байсан. Ер нь улс төрд ажиллаж байсан хүн Элчин сайдаар томилогдох нь өөрөө маш олон давуу талуудыг бий болгодог. Элчин сайдуудтай харилцдаг, төр нийгмийнхээ өөрийнхөө энэ тогтолцооныхоо асуудлыг маш сайн мэддэг. Гадаадад байгаа Монголчуудынхаа эрх ашгийг хамгаалах тал дээр бол хаана, хэнтэй, яаж харилцах вэ, ямар бодлогыг явуулах вэ гэдэг нь эсрэгээрээ давуу тал болдог юм аа. Ийм учраас Оюундарь гишүүн асныг дэмжиж байгаагаа илэрхийлмээр байна аа.

Европын Холбоо та одоо Европт Нидерландад байх аа мастераа хамгаалж байсан. Европын холбооны дэмжлэгээр. Тэгээд одоо энэ Польш улс хавсран сууж байгаа 2 Европын Холбооны улстай, 3 Европын Холбооны улсыг хавсран суух ийм Элчин сайдаар томилогдож байгаа. Тэгээд яг та мэргэжлийн хүний хувьд энэ улс төрийнхөө туршлагынхаа хувьд энэ ирэх 4 жилдээ хэрэвзээ томилогдох юм бол

ямар нийгэм эдийн засгийн өөрчлөлтийг хийх вэ гэдгийг асууж саналыг нь сонсьё гэсэн ийм хүсэлт байна.

Д.Амарбаясгалан: Нэр дэвшигч Наваан-Юндэнгийн Оюундарь хариулт өгье.

Н.Оюундарь: Польш БНПУ-д өөрөө Европын Холбооны гишүүн улс, НАТО-ийн гишүүн, дээрээс нь Польшид суугаа Варшавт суугаа Монгол Улсын ЭСЯ-аас 3 улсыг хавсран суудаг юм. Украйнд Литви, Латвыг хавсран сууж байгаа. Литви, Латви маань өөрөө Европын Холбооны улсууд. Тэгэхээр Европын Холбоотой харилцах геополитикийн маш их чухал асуудлууд тэнд байж байгаа. Ерөнхийдөө бол угаасаа тэнд амьдарч байгаа Монгол Улс дипломат төлөөлөгчийн газар өөрөө Монгол Улсаас тэнд оршин сууж байгаа иргэдийн асуудал, улс хоорондын харилцааны асуудал, улс төрийн асуудал, нийгэм, эдийн засгийн асуудал гээд олон асуудлын цар хүрээтэй ажилладаг. Тэр дотроо бол соёлын харилцаа маш их өндөр ач холбогдолтой байдаг. Яагаад вэ гэхлээр энэ маань өөрөө зөөлөн хүчний бодлогоор бид нар бас Монголыг таниулах Монгол улсад олноор хөрөнгө оруулалтыг татах эдийн засгийн олон үр өгөөжүүдийг бий болгох ийм ач холбогдолтой болж байгаа юм аа. Ерөнхийдөө түүнээс гадна ийм орон нутгийн харилцааг нэлээд их хөхүүлэн дэмжиж ажиллах шаардлага байгаа.

Тухайлбал яг Польштой бол манай Төв аймаг, Дархан-Уул аймаг, Дорнод аймаг, Налайх дүүрэг гэх мэтийн газрууд бол хамтын ажиллагаатай ажилладаг. Энэ маань өөрөө бол хүн хоорондын харилцаа бий болж байж улс төрийн харилцаа улам их нарийн нандин, илүү цар хүрээтэй ийм болох боломжууд нь илүү болдог оо. Ерөнхийдөө бол цаашид 2 улсын хамтын ажиллагааны гол чиглэл болох эдийн засаг, худалдаа хамтын ажиллагааг бэхжүүлэхийн тулд нэлээд олон төсөл хөтөлбөрүүдийг давхар хэрэгжүүлэх хэрэгтэй. Ялангуяа шинжлэх ухаан, боловсрол, геологи, уул уурхайн тал дээр. Тэр дотроо бол нийгэм эдийн засгийн асуудал дээр нэлээд анхаарах хэрэгтэй.

Эрхэм гишүүн Ариунзаяагийн ажиллаж байсан Хөдөлмөр нийгэм, хамгааллын шугамаар ч гэсэн нэлээд олон асуудлууд энэ 3 оронтой Польш Европын холбооны 3 оронтой байдаг юм байна лээ. Тухайлбал гэхэд тэтгэврийн шинэчлэл, хөгжлийн бэрхшээлтэй ард иргэдэд ард иргэдийн асуудал гэх мэтийн асуудал дээр бол нэлээд түлхэцтэй, нэлээд үйл ажиллагааг нь сайжруулахаар зорин ажиллана аа.

Д.Амарбаясгалан: Бөхчулууны Пүрэвдорж гишүүн асуулт асууя.

Б.Пүрэвдорж: Тэгэхээр Оюундарь гишүүнтэй яг энэ түрүүчийн парламентад ажиллаж байхдаа бас хэд хэдэн хууль дээр, ялангуяа гадаад харилцаа, боловсрол, нийгмийн асуудлаар хэд хэдэн хууль дээр ажлын хэсэгт ажиллаж байсан. Тэгэхээр ер нь бол ажил хэрэгч, мэдлэг, боловсролтой асуудалд шуурхай ханддаг ийм эмэгтэй. Тийм учраас Япон Польш Улсад Элчин сайдаар томилж байгааг нь дэмжиж байна. Мэдээж гадаад харилцааны чиглэлээр нэлээн олон газар ажилласан дэд сайдаар ажиллаж байсан хүний хувьд бол энэ гадаад харилцааг илүү өндөр түвшинд болгох, ялангуяа эдийн засгийн харилцааг Монгол Польшийн хооронд түүнчлэн хавсарч суугаа орнуудтай илүү сайн хөгжүүлэх тэр асуудлуудыг илүү сайн хийнэ. Ялангуяа Европын холбооны улстай тодорхой хэмжээгээр харилцаа хамтын ажиллагааг илүү сайн түвшинд хүргэнэ гэдэгт эргэлзэхгүй байна. Мөн түүнчлэн энэ жил Монгол Улсын Ерөнхийлөгч Польш Улсад айлчлахаар төлөвтэй байгаа. Тэгэх

дээр энэ айлчлалын бэлтгэл ажлыг хангах мөн түүнчлэн яг энүүгээр энэ үеэр ялангуяа бизнесүүдийн хамтын ажиллагааг үйлдвэрлэлийн болон хөрөнгө оруулалтын хувьд бол энэ том том мега төсөл явах үеэр бол гадаадын хөрөнгө оруулалт хийх, илт нэмэгдэх ийм боломж нээгдэнэ гэж харж байгаа.

Оюу Толгой төсөл хэрэгжсэнээр Монголд хөрөнгө оруулалтын бүүм бий болсон. Саяхан цөмийн энергийн хууль батлагдангуут Францаас жишээ нь 3 томоохон сан ирж, Монголын компаниудтай уулзаж, тэдний үйл ажиллагааг дэмжих хөрөнгө оруулалт хийх энэ санхүүгийн дэмжлэг өгөх, энэ асуудлаар маш амжилттай уулзалтуудыг хийгээд явж байгаа. Тэгэхээр энэ Ораногийн төсөл явсантай холбоотойгоор тодорхой хэмжээний хөрөнгө оруулалтууд нэмэгдэх ийм чиг хандлага харагдаж байна. Энэ дээр одоо Европын Холбоо болон Польш улсын хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх талаар илүү идэвхтэй ажиллаарай гэж хэлмээр байна аа.

Тэгээд амжилт хүсье.

Хоёрт нь Батцэцэг сайдад хандаж үг хэлмээр байна. Дандаа МАН-ын хүн оруулж ирэхгүй шүү. Хамтарсан засаг шүү. Өөрөөр хэлбэл бид нар хамтарсан засаг учраас тодорхой хэмжээний томилгоог бид нар хамтарч хийх ёстой. Өөрөөр хэлбэл энэ Засгийн газрын бодлого, парламент энэ хамтарч үйл ажиллагаа явуулж байгаа учраас гадаад бодлого ч гэсэн хамтдаа байх ёстой. Тийм учраас энэ АН-ын.

Д.Амарбаясгалан: Пүрэвдорж гишүүнд нэг минут нэмж өгье.

Б.Пүрэвдорж: АН-ын гадаад харилцаагаар мэргэшсэн маш их олон сайн дипломатууд мэргэжилтнүүд байгаа. Тэднээс заавал оруулж ирэх талаар анхаарахгүй бол бид нар 42 кноптой хүмүүс байдаг шүү. Тийм учраас энэ гадаад бодлого дор хамтын ажиллагаа харилцан ярилцаж байж энэ томилгоонуудаа хийх ёстой шүү гэж зөвлөмөөр байна.

Д.Амарбаясгалан: Дэмжиж үг хэллээ. Сайнхүүгийн Ганбаатар гишүүн асуулт асууж, үг хэлье.

С.Ганбаатар: Монголын парламентын индэр дээрээс Польшид амьдарч байгаа, ажиллаж байгаа Монголчууддаа, ялангуяа уламжлалт эмнэлгийн анагаахын салбарт амжилт гаргаад ажиллаж байгаа Монголчууддаа талархаж байгаагаа илэрхийлье. Тэгээд миний асуулт бол Польшид Элчин сайдаар ингээд явах гэж байгаа Оюундарь элчин сайдын болох гэж байгаа хүний хувьд бол энэ Монголчуудаас анх удаа оюуны оюуны өвөг дээдсийн энэ суу бүтээлийг экспортолж чадсан маш том энэ жишээг төрөөс яаж дэмжих вэ? Яаж төрийн бодлогоор энийг яаж тэлэлт хийх вэ? Өөр орнуудад энийг уламжлал болгож тэлэлт хийхэд ямар бодлого барих вэ? Энэ бол одоо нүдний цөцгий мэт хайрлах ёстой зүйл шүү дээ. Польшийн Монголын уламжлалт эмнэлэг гэдэг бол бүр үнэхээр гайхалтай бахархмаар. Тэгээд энийг яаж хайрлаж, хамгаалж бас бодлогоор бид дэмжих ёстой вэ?

Хоёрдугаар зүйл Монголын бизнес эрхлэгчдийг Польшийн зах зээл дээр гарах тал дээр мэдээж та судалгаа хийгээд орж ирсэн байх. Энэ салбарын л амжилттай яваа Монголын мэдээж дипломат салбарт таны амжилт гаргасан туршлага байгаа.

Дээр нь нэмээд Монголын олон олон бизнес эрхлэгчид, олон олон ажлын байр бий болгож олон хүнийг тэжээдэг л том бизнесийн төлөөллийн хувьд танаас асуухад Монголын бизнес эрхлэгчдийг яаж Польшийн зах зээл дээр гаргах вэ, ямар хэлэлцээр хийх вэ? Ямар арга зам байгаа вэ? Юу бодож байгаа вэ? Энэ чинь одоо бусад орны төрийн томчуул бусад оронд айлчлахлаараа яаж Беларусь трактороо шахах вэ л гэж ирж байгаа юм шүү дээ. Яаж Германы тоног төхөөрөмж технологийг яаж бусад улс орнуудад үнэ цэнтэй болгох вэ л гэж. Үндсэн бодлого нь. Тэгэхээр энэ дээр манай компаниудын тэлэлтийг яаж Польшийн зах зээл дээр хийх вэ?

Гуравдугаар асуулт Польшийн технологи, Польшийн ололт амжилт маш их. Олон том орнуудаар хүрээлэгдсэн Польш орноос сурах юм их бий. Польшийн технологийн ололт амжилтуудыг яаж Монголд импортолж оруулж ирэх вэ? Энэ дээр яг бодсон зүйлүүд байгаа юу? МАА, ХАА дээр Польш Европын л урдаа барьдаг орны нэг. Миний 3 дугаар асуулт энэ байна.

Ингээд Оюундарийг би дэмжиж байна. Учир нь гэвэл одоо өнөөдөр энэ гадаад бодлогыг яаж эдийн засагжуулах вэ гэдэг л Монголын хамгийн том толгойны өвчин болчихсон шүү дээ. Очоод л нэг улс төрийн амралтад очиж байгаа юм шиг тэгээд л яхийгаад л хэвтчихдэг нөхдүүд зөндөө. Тэгэхэд бол бизнесийн төлөөлөл, бизнесийн яг зовлон жаргал мэддэг хүн ингэж явна гэдэг тэгээд л амжилттай яваа. Хүн явна гэдэг бол олон бизнесменүүдэд нар гаргана гэж би итгэж байгаа. Анх удаа энэ элчин сайдуудад би санал бодлоо хуваалцаж асуулт асууж байна.

Д.Амарбаясгалан: Нэр дэвшигч Наваа-Юндэнгийн Оюундарь хариулт өгье.

Н.Оюундарь: Эрхэм гишүүн Ганбаатарын асуултад хариулъя аа. Юуны түрүүнд Монгол Улс БНПУ 2 өөрөө эрт дээр үеэс ийм харилцаа холбоотой улсууд. Монголчуудын өвөг дээдэс болох Хүннүгийн удам угсаатнууд 4 дүгээр зуун, 5 дугаар зууны үед Польшийн нутаг дэвсгэр дээр байлдан дагуулалт хийж байсан. Ийм түүхэн баримтууд байгаа. Липизийн тулаан гэж дэлхийд нэлээд нэртэй тийм нэг тулаан байдаг. Тэнд нэлээд олон Монголчууд Монгол угсаатнууд амьдардаг. Өөрөө Марко Пологийн үед 50 орчим жилийн Ромын Папын Жованы Карбинитэй Монгол Улсад энэ Польшийн Бенедикт Полакт гэж хүн ирж байсан юм байна лээ. Тэр үедээ өөрөө Хархорин хотод үндсэндээ бол Гүег хаанд бараалхаж очиж байсан. Тийм болохоор бид нарыг хооронд нь бол ийм соёлын түүхийн маш их олон зүйлүүдийн хамаатай зүйлүүд нэлээд их байдаг аа. Дөнгөж саяхан Номин сайдтай энэ соёлын харилцааны талаар бид нар ярилцаж байсан. Нэлээд олон хэмжээний соёлын арга хэмжээнүүдийг бид нар зохион байгуулахаар хэрвээ Элчин сайд болох юм бол зохион байлгуулахаар төлөвлөж байгаа. Үндсэндээ бол соёлоор дамжиж ард иргэдийнхээ оюун санаанд, ард иргэдийнх нь оюун санаанд нь дэм оруулах тийм асуудал дээр нэлээд түлхүү ажиллана гэж бодож байгаа.

Хоёр дахь асуудал нь бол Эдийн засгийн харилцааг хэрхэн гадаад бодлогын хамгийн нэг том асуудлын нэг нь бол өөрөө эдийн засгийг эрчимжүүлэх гадаад худалдааны эргэлтийг нэмэгдүүлэх асуудал байдаг. Энэ маань цаашид 2 улсын хамтын ажиллагааны хамгийн гол чиглэл болох эдийн засаг, худалдаа, хөрөнгө оруулалтыг бэхжүүлэхийн тулд нэлээд их ажлуудыг хийж зохион байгуулах хэрэгтэй болно. Тэнд ажиллаж амьдарч байгаад мянгаад Монгол иргэд байгаа. Тэд нарынхаа дэмжлэг туслалцаа болон бас Монголыг дэмждэг Польшийн бизнесийн бүлэглэлүүд нэлээд хэмжээгээр ажилладаг юм байна лээ. Урьд өмнө нь ажиллаж байсан Элчин

сайднууд бас их эрчимтэй сайн ажил хийж байсны улмаас бас ингэж харилцаа холбоогоо түвшин түвшиндээ нэлээн сайн бэхжүүлж ажилласан байгаа.

Тухайлбал гэхэд парламентын хоорондын харилцаа маш их идэвхтэй явагддаг, бизнесийн харилцаа нэлээд идэвхтэй явагддаг. Давхар улс төрийн харилцаа мэдээж идэвхтэй явагддаг байж байгаа. Тэгэхээр энүүн дээр Польшоос Монгол руу орох хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх эдийн засгийн агуулгыг нь өөрчлөх. Манайхаас худалдааны эргэлт өнөөдөр бол сүүлийн 3 жилд 2 дахин нэмэгдсэн байж байгаа. Зуугаад сая орчим доллар болсон байж байгаа. Энийг хэрхэн яаж нэмэгдүүлэх вэ гэдгийг бизнесийн хувийн хэвшлийнхэнтэй нийлээд хамтарч ажиллана гэж бодож байгаа.

Гурав дахь асуудалд хариулъя. МАА, ХАА-н чиглэлээр Монгол Улс, БНПУ 2 хоорондоо их ойролцоодуу явж байгаа. Ерөнхийдөө бол гарааны нэг нөхцөлөөс эхэлж байсан учраас бид нарт түүхтэй социализмыг хамтдаа ингэж туулсан. Зах зээлийн эдийн засагт хамтдаа яг нэг гараанаас эхэлж гарч байсан. Тэр дотроо бол МАА, эрчимжсэн МАА газар тариалан дээр нэлээд хамтын ажиллагаа эрчимжүүлж явуулдаг юм байна лээ. Тэгэхээр энийг бол Монголд давхар бид нар Польшоос суралцах туршлага солилцох ийм ажлуудыг орон нутгийн түвшинд болон улсын түвшинд нэлээд хийх шаардлагатай болов уу гэж ойлгож байна аа. Баярлалаа.

Д.Амарбаясгалан: Хариулт өглөө. Сандагийн Бямбацогт сайд асуулт асууя, үг хэлье.

Оюундарь нэр дэвшигчийг сайн мэднэ танина аа. Тэгээд гадаад харилцааны салбарт ажиллаж байсан туршлагатай, ОУБ-д ажиллаж байсан туршлагатай бас Монголд төр түшилцэж, Их Хурлын гишүүнээр ажиллаж байсан туршлагатай. Ийм болоод төрийн болоод, гадаад харилцааны туршлагатай томилогонуудыг дэмжинэ, дэмжиж байгаа. Сая Пүрэвдорж гишүүн хэллээ. АН, Ардын намтай хамтарсан байгаа АН боловсон хүчин сайтай. Тийм болохоор Элчин сайдаар томилохдоо гадаадад хүмүүс томилохдоо АН-ын боловсон хүчнийг томилох ёстой шүү хамтарч байгаа юм чинь сандал ширээгээ хуваана гэж хэлж байна. Бид нар ажлаа хувааж хийх гэж хариуцлагаа хувааж үүрэх гэж хамтарсан. Олон том гацсан төслүүдээ гацаанаас гаргах гэж аль болох талцаж хуваагдаж улс төржихгүй, улс орныхоо хөгжлийн төлөө хамтарч ажиллах гэж хамтарсан. Энэ бодлого бүх шатдаа явах ёстой зөвхөн сандал ширээ хуваах гэж биш. Энэ бодлогуудаа явуулах гэж хамтарч байгаа. Зөвхөн дээрээ дээд түвшинд Улсын Их Хурлын түвшинд, Элчин сайд нарын түвшинд гэдэг юм уу, агентлаг, даргын түвшинд сандал ширээ хуваах асуудал яригдахгүй ээ. Бүх түвшиндээ хамтарсан бол хамтарсан байх хэрэгтэй. Одоо орон нутагт ингээд ялагдчихсан. Ардчилсан нам ялчихсан гээд төрийн жинхэнэ албан хаагчдыг хоморголж халж байна. Хоморголж. Тэр чинь нам бус хүмүүс. Ардын намын нэр хаягтай гэж нэр нааж байгаад л хоморголж халж байгаа. Төрийн жинхэнэ албан хаагч нар. Тэд нарыг хэн хамгаалах юм, хэн өмгөөлөх юм. Тэр ТАЗ ажлаа хийж байна уу, хийхгүй байна уу. Ховд аймгийн ЗДТГ-аар үүрэг гүйцэтгэгчийн үүрэг гүйцэтгэгчээр хүн томилогдоод ажиллаж байна шүү дээ. Ингэж болдог юм уу?

Хууль зөрчиж байгаа бол хулгай хийсэн бол тэр төрд ажиллаж байгаа хүмүүсийг хариуцлагыг нь хүлээлгэж халах халах ёстой. Ажлаа сайн хийж чадаж байгаа, хууль зөрчихгүй байгаа албан хаагч нар ажлаа хийх ёстой төрийн албандаа. Тэр оронд нь тавих гэж байгаа хүмүүс байдаг юм бол тэр нь төрийн албаны хууль, бусад холбогдох хуулийн шалгуур шаардлага хангасан байх ёстой.

Гэтэл одоо үүрэг гүйцэтгэгчийн үүрэг гүйцэтгэгч гэж ямар албан тушаал байдаг юм. Сумынхаа иргэдээс, багийнхаа иргэдээс олонхын санал аваад багийн даргад нэр дэвшээд гараад ирчихсэн ялчихсан багийн дарга нарыг батламжлахгүй өчнөөн гацааж байна шүү дээ бас. Одоо Ховд аймгийн Цэцэг сумд иймэрхүү байдлаар хамтрахгүй бас. Тийм хамтарч байгаа бол доод түвшиндээ ч анхан шатандаа ч хамтраад ажлаа, хариуцлагаа хуваах ёстой. Тэгээд энэ дээр анхаарах ёстой шүү. Тэгээд ийм байдлаар юу гэдэг юм дээрээ хамтарч байгаа гээд л, дээрээ бүх юмаа хуваана гэж ярьдаг. Ажлаа ч хуваах ёстой, эрхээ ч хуваах ёстой, үүргээ ч хуваах ёстой, хариуцлагаа ч хуваах ёстой бүх шатдаа.

Энийг тал талдаа анхаарах ёстой л гэдгийг хэлье.

Д.Амарбаясгалан: Дэмжиж үг хэллээ. Доржсүрэнгийн Үүрийнтуяа гишүүн асуулт асууж, үг хэлье.

Д.Үүрийнтуяа: Монгол Улсаас Польш улсад суух Элчин сайдад мэргэжлийн төрийн албаны болоод дипломат албаны арвин туршлагатай гадаад хэлний өндөр мэдлэгтэй ийм түлхүүр боловсон хүчнийг нэр дэвшүүлж оруулж ирж байгаад Монгол Улсын Ерөнхийлөгчид болон Батцэцэг сайдад талархлаа илэрхийлмээр байна.

Монгол улсын гадаад бодлого нэг цонхны бодлогоор нэг цонхоор явах ёстой явж ч байгаа гэж харж байгаа. Тэгэхээр бид нар энэ Элчин сайд нарыг томилоход улс төрийн аливаа өнцгөөс харахаас илүүтэй тухайн Элчин сайдаар томилогдож байгаа хүний ур чадвар, дадлага туршлага, мэдлэг боловсрол, дипломат албанд хамгийн гол нь ажилласан энэ цаг хугацааны үр дүнгээр шалгуур болгодог ийм жишиг тогтож орж ирж байна гэж ингэж харж байгаа. Тэгээд санал байна надад Оюундарь нэр дэвшигчид хандаж хэлэх.

Польш улсын хувьд бол металлурги, химийн үйлдвэрлэлийн чиглэлээр, ялангуяа зэсийн баяжмал хайлах, боловсруулах үйлдвэрийн чиглэлээр бол дэлхийд том тоглогч орон. Каги Эйч Эм гээд дэлхийн томоохон металлургийн том компани 2 ч хайлах үйлдвэртэй. Тэгэхээр Монгол Улсын Засгийн газрын мөрийн хөтөлбөрт тусгагдаад явж байгаа энэ томоохон 14 мега төслийг хэрэгжүүлэхэд ялангуяа зэсийн баяжмал хайлах, боловсруулах үйлдвэр, түүнийг түшиглэсэн үйлдвэр технологийн паркийг түшиглэсэн энэ металлург химийн үйлдвэрийг хөгжүүлэхэд энэ Польш улстай хийх хамтын ажиллагаа бол их чухал гэж харж байгаа. Цаашдаа энэ хайлах үйлдвэрийг дагасан металлургийн үйлдвэрүүд дээр томоохон ийм хамтын ажиллагаануудыг эхлэх боломжууд энэ 2 улсын хооронд хийхэд их том боломжууд бидэнд нээгдэх юм гэж харж байгаа.

Тэгэхээр энэ тал дээр таныг илүү санаачилгатай 2 улсын хамтын ажиллагаанд ялангуяа Монгол Улсын металлургийн салбарын хөгжилд Польш улстай хамтын ажиллагаагаа өргөжүүлж энэ чиглэлээр боловсон хүчнээ сургах, дадлагажуулах, мэргэшүүлэх, технологийн чиглэлээр олон асуудлууд дээр туршилт судалгаа хийж хамтрах энэ боломжуудыг нээхэд чухал үүрэг гүйцэтгэж ажиллах байх гэж итгэж байна. Үүнд анхаарч ажиллаасай гэж хүсэж байна.

Ингээд танд амжилт хүсье. Баярлалаа. Дэмжиж үг хэллээ.

Д.Амарбаясгалан: Жамбын Батсуурь сайд асуулт асууж, үг хэлье.

Ж.Батсуурь: Бүгдэд нь өдрийн мэнд хүргэе. Тэгээд Польш улсад элчин сайдын нэр дэвшиж орж ирж байгаа Оюундарь гишүүнд амжилт хүсье. Баруун Европын Европын үүд хаалга болсон Польш улсад Элчин сайдаар очно гэдэг маш том хариуцлага. Монгол орны бүтээн байгуулалт мега төслүүд, хойшдын үйл ажиллагаанд нэлээд нэмэртэй ийм томилгоо болно гэж ингэж үзэж байгаа юм. Миний хувьд бас Польш Монголын эдийн засгийн хамтын ажиллагаа буюу Засгийн газрын комиссыг тэргүүлдэг. Тийм учраас танд би зүгээр санал хэлж таныг дэмжиж үг хэлж байгаа юм. Асуух асуулт алга.

Монгол, Польшийн эдийн засгийн хамтын ажиллагаа буюу Засгийн газрын комисс 2022 оны 3 сард хамгийн сүүлд хуралдсан байна. Тэр үед бол ковид гээд дэлхий нийтээрээ хаалттай байсан болохлоор цахимаар хуралдсан ийм байдаг. Тийм учраас та Элчин сайд болоод 2 орны Засгийн газрын хамтын ажиллагааг идэвхжүүлэхийн тулд хамгийн түрүүнд хоёулаа нийлж Монгол Польшийн эдийн засгийн хамтын ажиллагаа буюу Засгийн газар хоорондын комиссыг яаралтай хуралдуулж ирэх он жилүүдэд хийх Монгол Улсын мега төслүүд болон хөгжилд дэм болох асуудлуудаа тэргүүлэх чиглэл болон дунд хугацааны ойрын хугацааны хөтөлбөрөө ярилцана гэдэгт итгэлтэй байна. Тэгээд таны улс төрийн туршлага энэ хүмүүсийн хэлж байгаа манлайлалд би үнэхээр итгэж илүү талархалтай байгаагаа хэлье.

Монгол Польшийн хамтын ажиллагаа, зээлийн хэлэлцээрийн юунд бол хөдөөгийн аймгуудын цэвэрлэх байгууламж явдаг. Баруун 5 аймаг, ингээд ер нь цаашдаа дэд бүтцийн асуудал дээр ер нь бидний хүүхэд байхын л Польшоос барилгын материал орж ирж байна. Польшид ажилчид сурч байна. Тэндээс өнөөгийн Солонгосоос өмнө бид нар чинь Польш руу явж ганзагын наймаа хийж байсан. Польшид ажилчин илгээж байсан ийм туршлагатай байгаа юм.

Тийм учраас энэ зөвхөн баруун 5 аймаг гэхгүйгээр энэ төслийн үйл ажиллагааг хэмжээг томсгож, хөдөөгийн хотжилт, барилга, орон сууцын салбарыг нийслэлийг бид нар Засгийн газрын түвшинд бүх чиглэлээр дэмжиж байна. Тэгтэл Монгол Улс бол нийслэл бөгөөд хөдөөгийн 21 аймаг гэж ингэж байгаа гэж байгаа.

Тийм учраас хөдөөгийн аймгуудаа дэд бүтцээр хангах цэвэрлэх байгууламжийн энэ төслийг бүх үлдсэн бүх аймгуудад бий болгох энэ асуудал дээр хоёулаа идэвхтэй хамтран ажиллая.

Дээр нь барилга, барилгын материалын салбар, орон сууцын салбар, хот байгуулалтын салбарт та тэнд Монголыг мэдэхгүй зүйлүүдэд нь мэдүүлэх мөн Монголыг сонирхож байгаа хүмүүсийг бид нартай холбож өгөх энэ асуудал дээр би таныг идэвхтэй үйл ажиллагаа явуулна гэж ингэж бодож байна.

Д.Амарбаясгалан: Дэмжиж үг хэллээ. Жамбын Батсуурь сайдад нэг минут нэмж өгье.

Ж.Батсуурь: Тэгээд таны улс төрийн бөгөөд энэ туршлагыг ашиглаж энэ Монгол Польшийн хоорондын хамтын ажиллагааг өндөр түвшинд гаргая. Эдийн засгийн хамтын ажиллагааг одоо бодитоор тоон илэрхийллээр хоёулаа нэг 4 жилийн дараа таныг байх хугацаанд намайг бас байх хугацаанд бүүр тоон

илэрхийллээр бүүр дахин өссөн гэсэн ийм ажлуудыг хамтарч ажиллая аа. Тэгээд танд ажлын амжилт хүсье. Сайн сайхныг хүсье.

Баярлалаа.

Д.Амарбаясгалан: Дэмжиж үг хэллээ. Сүхбаатарын Эрдэнэболд гишүүн асуулт асууж, үг хэлье.

С.Эрдэнэболд: Манай төвийн бүс Сэлэнгэ аймгаас Монгол Улсын Их Хуралд сонгогдож байсан, иргэд олон нийтийнхээ итгэл дэмжлэгийг хүлээж байсан туршлагатай улс төрч. Мөн гадаад харилцааны салбарт өөрийн гэсэн түүхийг бүтээж яваа ийм хүн байгаа. Насан-Очирын Наваан-Юндэн гэж Монголын төрийн түүхэнд том үүрэг гүйцэтгэсэн хүн. Тэгээд энэ хүнээр овоглодгийн хувьд бас улс төрчийнхөө хувьд гэхээсээ гадна Монгол төрийн алтан аргамжийг олон улстай холбох ийм чухал хариуцлагатай албанд томилогдож байгаад нь амжилт хүсэж байна. Өмнө нь хэд хэдэн гишүүдийн үгэн дээр асуулт дээр давтагдсан нэг зүйл бол гадаад харилцааг эдийн засагжуулах гэдэг яриа байгаа. Монгол Улс эдийн засгийн олон тулгуурт бодлого үүнийгээ хэрэгжүүлэх шинэ томоохон төсөл хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэх гээд тэгэхээр Польш улстай сая Байнгын хорооны хурал дээр танилцуулга хийхдээ Монгол Улс Польш Улс 2-ын хоорондын худалдааны эргэлтийн тоон үзүүлэлтийн талаар өөрөө дурдаж байсан. Тэгээд ер нь Элчин сайдаар томилогдож ажиллах хугацаанд энэ тоон үзүүлэлтийг яг одоо хэд байгаа бөгөөд цаашлаад яаж ахиулах тийм боломжтой байна вэ? Бас энэ өнөөдөр бас энэ таны томилгоог иргэд олон нийт харж байгаа. Тэр утгаараа бас Польш улсад ажиллаж амьдардаг мөн Польш Монголын хооронд бизнес эрхлэгчид бизнес хийдэг хүмүүс харж байгаа.

Энэ таатай боломжийг яаж нэмэгдүүлэх вэ? Хэрвээ танд боломжтой бол одоогийн байгаа худалдааны эргэлтийн тоо хэчнээн хувиар таны Элчин сайдаар ажиллах хугацаа нэмэгдэх боломжтой вэ? Энэ чиглэлээр яг судалгааны тоог та хэлж өгөөч? Амжилт хүсье ээ.

Д.Амарбаясгалан: Дэмжиж үг хэллээ. Асуултад хариулъя. Наваан-Юндэнгийн Оюундарь нэр дэвшигч.

Н.Оюундарь: Монгол Улсаас БНПУ руу ерөнхийдөө худалдааны эргэлт зуугаад сая ам.доллар-ын хэмжээтэй байгаа. Энийг бол бодитоор нэмэгдүүлэх боломжууд нэлээд байгаа. Тухайлбал гэхэд бид нар импортоор авдаг, бид нар импортоор ХАА-н бүтээгдэхүүн, хүнсний бүтээгдэхүүн, барилгын материал, химийн бүтээгдэхүүнийг авдаг юм байна лээ. Экспортоор архи, нэхмэл, ноос ноолуур, мал малын гаралтай бүтээгдэхүүнийг экспортолдог юм байгаа юм. Тэгэхдээ сая Үүрийнтуяа гишүүн ч гэсэн бас өөрийнхөө үгэн дээрээ хэлж байна лээ. Нэлээд том төслүүдийг энэ мега төслүүдийг хэрхэн яаж нэмэгдүүлэх вэ? Өөр бусад гишүүд ч гэсэн ерөнхийдөө бол эдийн засгийн агуулгыг илүү эрчимжүүлэх тал дээр анхаараарай гэдгийг нь бүрнээ хүлээн зөвшөөрч байна. Энэ талаар бид бүгдээрээ хамтраад нэлээд ажиллая. Сая Засгийн газар хоорондын комиссын Монгол талын дарга Батсуурь сайд ч гэсэн хамтарч ажиллаж Засгийн газар хоорондынхоо комиссыг хуралдуулах асуудлыгаа яаравчилж түргэвчилж бодит эдийн засгийн төр хувийн хэвшлийн хамтын ажиллагааг нэлээд эт эрчимжүүлэх тал дээр үг хэллээ. Энүүн дээр тантай маш их санал нийлж байна.

Ерөнхийдөө бол Польшийн тэр КГХМ гэдэг компани өөрөө дэлхийд 6-д ордог тэр дотроо бол зэс боловсруулах үйлдвэрээр хамгийн их тэргүүлдэг ач холбогдолтой ийм үйлдвэр байдаг юм байна лээ. Байгалийн хий, газрын тосны ПГНГ түлш шатахууны Орлеон зэрэг компаниуд бол нэлээд дэлхийд томоохонд ордог ийм компаниуд байдаг. Эдгээр компаниудаас Монгол Улсад хөрөнгө оруулалт оруулж бид нарын том мега төслүүдийг хэрхэн яаж дэмжих боломж бололцоо байна вэ гэдэг талаар хамтарч ажиллахаар нэлээдгүй ажлыг хийж зохион байгуулах шаардлагатай байх гэж бодож байна. Түүнчлэн бас зөвхөн том мега төслүүдийн хажуугаар ийм жижиг ялангуяа ЖДҮ-лэлийг эрхэлж байгаа ААН-үүдэд тэр дотроо МАА, ХАА-н чиглэлээр ажиллаж байгаа газруудад нэлээдгүй хамтын ажиллагаа хийх хэрэгтэй байх гэж бодож байгаа.

Худалдааны эргэлтийг бид нар айлын талаас бараа бүтээгдэхүүн аваад зогсохгүй Монголдоо хөрөнгө оруулалтыг татан ирүүлэхийг хөхүүлэн дэмжих, дээрээс нь бид нар Монголоос гарч байгаа бараа бүтээгдэхүүнийг хэрхэн яаж энэ тоо толгойг нь нэмэгдүүлэх вэ гэдэг тал дээр бид нар нэлээдгүй хамтарч ажиллах шаардлагатай болно гэж бодож байна аа.

Д.Амарбаясгалан: Хариулт өгч дууслаа. Жаргалсайханы Золжаргал гишүүн асуулт асууя.

Ж.Золжаргал: Польш Улс эдийн засгийн өсөлт нь ч сүүлийн 30 жил ер нь тийм тогтвортой өсөж ирсэн. Тэгээд улс төрийн хувьд, стратегийн хувьд төв Европын нэлээн том байр суурьтай болж байгаа ийм улс. Түүхэндээ ч Монголдоо орчин үеийн түүх нь ч тэр эртнээсээ хойш харилцаа идэвхтэй байсан. Тэгэхээр би Оюундарь нэр дэвшигчийг маш их ийм нөгөө нөөц боломж байгаа. Ашиглагдаагүй ашиглаж болохуйц харилцаанд идэвхтэй ажиллах маш их нөөц боломж байна аа. Тэгээд таны өмнө бол энэ нөөц боломжийг эргэлтэд оруулах ийм их том даалгавар ноогдож байгаа юм байна гэж харж байна аа. Тэгээд мэргэжлийн хувьд туршлагын хувьд нэр дэвшигчийг дэмжиж байгаа.

Монгол Польшийн парламентын бүлгэм байгуулагдсан. Тэгээд миний бие даргын үүргийг гүйцэтгэж байгаагүйн хувьд нөгөө талтайгаа холбоо бариад ингээд 2 улсын парламентын, найрамдлын бүлгэмүүд уламжлалт харилцаагаа үргэлжлүүлээд явж байгаа. Энэ талаараа бид таныг бүх талаар дэмжиж хамтарч ажиллана гэдгээ илэрхийлмээр байна.

Тэгээд мэдээж энэ эдийн засгийн чиглэлээр батлан хамгаалахын чиглэлээр уламжлалт ийм хамтын ажиллагаа боловсролын чиглэлээр маш сайн тогтчихсон байдаг. Тэгээд эдгээрээс гадна шинээр түрүүн бас 2, 3 гишүүд яриад байгаа энэ уламжлалт анагаахын чиглэлээр яагаад ч юм тэнд ингээд маш сайн ийм суурь бүрдчихсэн. Гэхдээ нөгөөхийг ийм сонгодог анагаахын юунд хүлээн зөвшөөрдөггүй, ийм асуудлууд байдаг, аль түвшинд, ямар түвшинд ямар байдлаар хүлээн зөвшөөрүүлж албажуулж болох вэ гээд. Магадгүй энэ бол Монголын үндэсний оюуны экспортын нэг тийм том суурь алсдаа болох тэгээд гарц нь тэндээс эхэлж болзошгүй юм гэж.

Хоёрдугаарт нь энэ аюулгүй байдалдаа их анхаардаг, тэгээд цахим хөгжил кибер аюулгүй байдал дээр их урагшаагаа явчихсан ийм улс байгаа. Энэ талаар хамтарч ажиллах маш өргөн боломжууд байдаг юм байна лээ. Нэмээд хэлэхэд тэр уул уурхай нөгөө мянга хэдэн зуун метрийн гүний уурхайнууд ажилладаг. Нүүрсний

далд уурхай, хамгийн том уурхайнууд байдаг. Маш их ийм нөөц боломжтой чадвартай ийм улс байгаа юм. Археологи, палеонтологиор их хамтарч ажилладаг.

Тэгэхээр энэ бүх чиглэлээр идэвхтэй хамтарч ажиллахыг л танаас хүсье дээ. Тэгээд амжилт хүсье. Баярлалаа.

Д.Амарбаясгалан: Дэмжиж үг хэллээ. Цэндийн Сандаг-Очир гишүүн асуулт асууж, үг хэлье. Баярлалаа.

Ц.Сандаг-Очир: Нэр дэвшигчээс асуугаад байх зүйл алга. Би Гадаад харилцааны сайдаас зарчмын асуулт асууя аа. Бид нар энэ дипломат Элчин сайдуудыг Их Хуралд зөвшилцөж ингэж тогтоолоор баталж явуулдаг. Энэ өнгөрсөн хугацаанд томилогдсон Элчин сайдууд ер нь ажлаа хэнд хаана тайлагнадаг юм бэ? Гадаад харилцааны сайдад юм уу, Ерөнхийлөгчид юм уу? Томилуулах болохоор Их Хуралтай зөвшилцөж, чуулганаар орж ирж томилогдоод явдаг, дэмжигдээд явдаг. Ажлын тайланг нь сонсож байсан удаа би ерөөсөө харсангүй, үзсэнгүй. Энэ томилогдсон, урьд өмнө нь хой томилогдсон Элчин сайдууд чинь ер нь ажлаа ер нь хэр сайн хийж байгаа юм? Сайн хийж байгаа нэг нь байгаа байх. Урьд өмнө янз бүрийн асуудал гаргаад л Элчин сайдууд архины, тамхины бизнес хийж байсан асуудлууд гарч байсан тийм түүх байдаг юм байна лээ шүү дээ.

Тийм учраас энэ Элчин сайдаар томилогдсон нөхдүүд маань ингээд л томилогдоод л тэгээд л дуугүй болоод л ингээд л юу хийж байгаа нь мэдэгдэхгүй. Ямар улс төрийн гэрээ хэлцэл, ямар хөрөнгө оруулалтын гэрээ хэлцлүүдийг хийж улс орондоо ашигтай хөрөнгө оруулалтыг татаж, бараа бүтээгдэхүүн, худалдаа наймааны асуудал дээр ямар ахиц өөрчлөлт гарч байна гэдгийг хэн дүгнэдэг юм. Ажлыг нь хэрхэн зүгээр л томилоод л тэгээд л болоод 4 жил нүд аниад хэрхэн яаж ажиллах нь хамаагүй ингээд явчихдаг юм уу, Энэ томилгоон дээр ер нь шалгуур шаардлагаа ер нь хэр барьж ажиллаж байна аа? Мэдээж дипломат албаны шалгуур шаардлагыг хангасан байх ёстой. Улс төржсөн томилгоо хийх гээд урьд өмнө л Солонгосын ЭСЯ-ан дээр манайхаас санал болгосон хүнийг цаад улс орон хүлээж авахгүй хугацаа алдаж байсан тохиолдол биш шүү дээ. Энэ бол шалгуур шаардлага хангахгүй улсуудыг санал болгочхоод ингэж байсан асуудал гарч байсан.

Тийм учраас одоо бид бүхэн яаж ямар шалгуураар ингэж энэ улсуудыг хангаж тавьж байна. Тавьсан улсууд чинь яаж шалгуур шаардлага хангаж ажиллаж байна. Зөвхөн Элчин сайд гэлтгүй доор нь 1, 2 дугаар нарийн бичиг, консул тэгээд энэ улсуудыг ер нь яаж томилдог юм. Энэ улсууд ер нь яг юу хийдэг юм? Ямар эрх ямба эдэлдэг юм. Ингээд албан тушаалын зүгээр шагнал болоод явчихдаг юм уу. Ийм нэг зарчмын асуудлууд дээр та нэг хариулт өгөөч ээ.

Д.Амарбаясгалан: Гадаад харилцааны сайд Батмөнхийн Батцэцэг сайд хариулт өгье.

Б.Батцэцэг: Гишүүний асуултад хариулъя. Элчин сайд нар Гадаад харилцааны сайдтай гэрээ байгуулдаг. ГХЯ-ны ажилтан гэж явдаг учраас ГХЯ-ны жилийн ажлын төлөвлөгөөг хийж хэрэгжүүлдэг ийм албан тушаал байгаа юм аа. Элчин сайд нарын томилгооны хувьд бол одоо 80 хувь нь гадаад харилцааны салбарын мэргэжилтэн буюу мэргэжлийн дипломатууд байгаа. 20, 22 хувь нь бусад салбараас томилогдсон ийм хүмүүс байгаа. Бид нар өнгөрсөн 30 жилийн хугацаанд Элчин сайд нарын томилгоо дээр алдаа оноонууд гарч байсан. Янз бүрийн оронд

алдаа дутагдал гаргаж асуудалд холбогдож байсан Элчин сайд нар байсан. Элчин сайдаас дооших элчин зөвлөх, зөвлөх, 3 дугаар нарийн бичгийн дарга, 2 дугаар нарийн бичгийн дарга, 1 дүгээр нарийн бичгийн дарга, атташе гэдэг дипломат албан тушаалтай хүмүүсийг бүгдийг нь ГХЯ-ны мэргэжлийн дипломатууд томилогдож ажиллах ёстой. Зарим тусгай үүрэг гүйцэтгэдэг ТЕГ, Сангийн яам, Эдийн засаг, хөгжлийн яам, Боловсролын яам, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны төлөөллүүд тодорхой газруудад томилогдож ажилладаг ийм журамтай. Энэ Элчин сайд болон дипломат ажилтнууд бүгд Дипломат албаны тухай хуулийн хүрээнд ажиллаж үйл ажиллагаагаа явуулдаг. Ямар нэгэн байдлаар эзэнгүй, хянах хүнгүй, ажлаа тайлагнахгүй тийм асуудал огт байхгүй ээ. Их нарийн дүрэм журамтай ажилладаг аа. Ажлын тайланг бид нар хагас жилээр нь байнга авдаг. Дотоод аудиттай төлөвлөсөн ажлыг сар сараар нь холбогдох газрууд нь хариуцаад явдаг. Жишээлбэл Европын орон гэхэд хариуцаж байгаа орон болгондоо Элчин сайд нарынхаа ажлын өдөр тутмын ажлыг удирддаг. Элчин сайд нар төвөөсөө буюу ГХЯ-ны удирдлагаас байнга чиглэлийг авсны дагуу үйл ажиллагаагаа явуулдаг аа. Баярлалаа.

Д.Амарбаясгалан: Амгаланбаатарын Ганбаатар гишүүн асуулт асууя.

А.Ганбаатар: Наваан Юндэнгийн юун дээр нэр дэвшигчээс асуух зүйл алга, санал байна. Европын анхны ардчилсан манлайлал үзүүлсэн ардчиллын баян бүрд болсон орон бол Польш. Валенсия гээд л бид нар мэднэ. Монголд ирж байсан. Одоо бол Ерөнхий сайд хийж байгаа Дональд Туск Европын холбооны Ерөнхийлөгч хийж байсан. Монголд бас ирж байсан. Ийм ардчиллын том лидерүүдтэй ийм орон. Тэгэхээр Монгол бол ардчиллаа хамгаалах ардчиллаа бэхжүүлэх ардчиллын тулгуур ойлголтуудыг Польшоос сурах зүйл их байна. Тэгэхээр энэ тал дээр та улс төрийн болон дипломат шугамаараа олон янзын сургалтуудыг бас Монголд хийгээрэй. Польшид хүмүүс явуулаарай гээд.

Хоёрт нь нөгөө дан дипломат хүн, улс төрч хүн элчин сайд хийж байгаад карьерынхаа оргилыг бол 2 улсын Ерөнхийлөгчийн харилцан айлчлуулахад байдаг гэж ярьдаг л даа. Би тэгж сонсож байсан. Дипломат хүмүүсээс та бол өөрөө бас бизнесийн мэдлэгтэй хүн учраас миний хувьд бол Элчин сайдын 2 жигүүрийн нэг нь бол дипломат ёсноос гадна бизнесийн үйл ажиллагаа. Энэ бизнесийн харилцан юу гэдэг юм эдийн засгийн эргэлтийг нэмэгдүүлэх гэж ойлгоод байгаа. Тэгээд та энэ дээр бас том дэмжлэг үзүүлээрэй. Миний мэдэхээр би бол нимгэн мэдлэгтэй учраас мэдэхгүй байна. Польштой холбоотой эдийн засгийн асуудал худалдаа наймаа хийхээр манай нөгөө урбанек гээд санаанд ороод байна. Тэгэхээр Урбанек төдийгүй эдийн засгийн тэлэлтийг хийгээрэй гэж хүсье.

Таны хамрах газруудад бас чухал газрууд байж байгаа юм байна. Манай энэ инновац цахим хөгжлийн чиглэлээр туршлага судалчих ийм олон орон байгаа юм байна. Би бас энэ Байнгын хорооны гишүүн. Азаар бас бүлгийн дарга нь манай энэ Байнгын хорооны дарга байж байна Золжаргал. Бид нар энэ чиглэлд бас Польшоос сурах, таны хамрах хүрээний орнуудаас суралцах зүйл их байна. Энэ тал дээр бас дэмжиж ажиллаарай гэж хүсье. Амжилт хүсье.

Д.Амарбаясгалан: Нэр дэвшигч Наваан-Юндэнгийн Оюундарь хариулт өгье.

Н.Оюундарь: Варшавд өөрөө бас ардчилсан орнуудын хамтын нийгэмлэг гээд Коммунисти оф демокрастик буюу Варшав төвтэй ийм байгууллага байдаг. Тэр

маань өөрөө яахын аргагүй Ганбаатар гишүүний хэлснээр ардчиллын хараацай болсон ийм улс орон. Тэр дотроо бол зүүн Европоос барууны чиглэл рүү шилжих, бид нар 1990 онд яг ижилхэн гараагаа эхэлж байсан. Тэгэхээр энэ ардчилсан орнуудын хамтын нийгэмлэгээс бид нар бас хамтарч ажиллана. Зөвхөн 2 улсын хоорондын харилцаа гэлтгүйгээр энэ олон улсын хамтын ажиллагаагаа нэлээд өргөжүүлж хэрэгжүүлнэ гэж бодож байна аа.

Д.Амарбаясгалан: Амгаланбаатарын Ганбаатар гишүүн тодруулж асууя.

А.Ганбаатар: Энэ нөгөө Польшид суралцаж төгссөн хүмүүсийн холбооноос нэг ийм асуулт хүсэлт тавиарай гэсэн юм. Польшийн ЭСЯ виз олгохгүй байгаа юм байна лээ. Хятадаас олгоод байгаа гэнэ үү? Хуучин Польшийн ЭСЯ чинь өргөн харилцаатай ийм яам байсан. Одоо харин ямархуу түвшинд байгаа юм бол? Би буруу мэдээлэл аваагүй бол Монголын Польш явах иргэдийн визийг Польшийн ЭСЯ-аас олгохгүй өөр газраас олгоод байгаа юм байна лээ. Энийг та нэг анхаарч өгөөрэй.

Д.Амарбаясгалан: Нэр дэвшигч Наваан-Юндэнгийн Оюундарь хариулт өгье.

Н.Оюундарь: Польшийн визийг дотоодын өөрсдөө БНПУ-ын дотоодын зохион байгуулалтын улмаас Бээжин дэх Польшийн ЭСЯ-аас олгож байгаа. Гэхдээ Польш өөрөө Шенгений улс учраас Герман, Франц, Унгар зэрэг улсуудаас ингээд виз авах боломжтой. Дипломат албан паспорт 90 хоног визгүй зорчих ийм боломж бололцоо бол байгаа.

Д.Амарбаясгалан: Гишүүд асуулт асууж, үг хэлж, хариулт авч дууслаа.

12.43 цагт

Дараагийн асуудалд орно. 2 асуудлын санал хураалтыг 13 цагт хамтад нь явуулна аа.

Тогтоолын хавсралтад нэмэлт оруулах тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцэх эсэх хэлэлцүүлгийг явуулна.

Хууль санаачлагчийн илтгэлийг Засгийн газрын гишүүн Зам, тээврийн сайд Борхүүгийн Дэлгэрсайхан танилцуулна. Индэрт урьж байна.

Б.Дэлгэрсайхан: Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Их Хурлын чуулганы 2023 оны 7 дугаар сарын 7-ны өдрийн нэгдсэн хуралдаанаар Төмөр замын тээврийн тухай хуулийн шинэчилсэн найруулгыг баталсан бөгөөд тус хуулийн 10 дугаар зүйл мөн Улсын Их Хурлын 2023 оны 72 дугаар тогтоолын хавсралтаар баталсан Төрийн захиргааны байгууллагын тогтолцоо бүтцийн ерөнхий бүдүүвчид зам тээврийн сайдын эрхлэх асуудлын хүрээний Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг төмөр замын газар байна гэж тус тус хуульчилсан. Гэвч Улсын Их Хурлын 2024 оны 13 дугаар тогтоолын хавсралтаар төрийн захиргааны байгууллагын тогтолцоо бүтцийн ерөнхий бүдүүвчийг шинэчлэн батлахдаа Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг, төмөр замын газар орхигдсон байна. ОХУ, БНХАУ болон Төмөр замын чиглэлээр идэвхтэй харилцдаг бусад улс орнуудад төмөр замын тээврийн үйл ажиллагаанд хяналт тавьж зохицуулалтыг

хэрэгжүүлэх чиг үүрэг бүхий Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг буюу Төмөр замын газартай байдаг.

Өнөөгийн байдлаар Монгол Улс хөрш орнуудтайгаа ижил түвшний байгууллага байхгүйгээс тус үүргийг УБТЗ-ын хувь нийлүүлсэн нийгэмлэг гүйцэтгэсээр ирлээ. Мөн хууль батлагдаж байх үед буюу 2007 онд төмөр замаар тээвэрлэх ачааны хэмжээ 14.8 сая тонн байсан бол 2024 оны байдлаар 45.9 сая тонн болж 3 дахин нэмэгдсэн.

Салбарт нийт 15 мянган орчим хүн 1115 км замыг хариуцан ажиллаж байсан бол ойрын үед хэрэгжихээр шийдвэр гарсан төмөр замуудтай нийлээд төмөр замын сүлжээний нийт урт 4200км болж 3.7 дахин өссөн. Энэ хэрээр ажиллах хүч 50 мянга орчимд хүрч, 3.3 дахин тус тус нэмэгдсэн болно.

Засгийн газарт хэрэгжүүлэгч агентлаг Төмөр замын газрыг байгуулахдаа Монгол Улсын 2025 оны төсвийн хуулиар батлагдсан Зам, тээврийн сайдын төсөвт багтаан байгуулна аа. Тухайлбал Галт тэрэгний хөдөлгөөний зохицуулалтын нэгдсэн төв УТҮГ-ыг татан буулгах ба мөн ЗТЯ-ны тодорхой тооны орон тоог шилжүүлэх замаар улсын төсөвт аливаа дарамт үзүүлэхгүйгээр байгуулахаар төлөвлөсөн болно.

Иймд Улсын Их Хурлын 2024 оны 13 дугаар тогтоолд нэмэлт оруулах тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг боловсруулан танилцуулж байна аа. Хэлэлцэн шийдвэрлэж өгнө үү.

Анхаарал тавьсанд баярлалаа. баярлалаа.

Д.Амарбаясгалан: Төслийн талаарх ТББХ-ны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Сандагийн Бямбацогт танилцуулна. Индэрт урьж байна.

С.Бямбацогт: Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газар 2024 оны 12 дугаар сарын 20 Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн “Тогтоолын хавсралт нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн хэлэлцэх эсэх асуудлыг Төрийн байгуулалтын байнгын хороо 2025 оны 1 дүгээр сарын 7-ны өдрийн хуралдаанаараа хэлэлцлээ.

Улсын Их Хурлаас 2023 оны 7 дугаар сарын 7-ны өдөр баталсан Төмөр замын тээврийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын 10 дугаар зүйлд Төмөр замын тээврийн үйл ажиллагаатай холбоотой хяналт зохицуулалтыг хэрэгжүүлэх чиг үүрэг бүхий төмөр замын тээврийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага буюу Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлагтай байхаар зохицуулсан. Хууль санаачлагч Зам, тээврийн яам болон Галт тэрэгний хөдөлгөөн зохицуулалтын нэгдсэн төвийн орон тоо болон нөөцийг ашиглан төсөвт дарамт учруулахгүйгээр Төмөр замын тээврийн тухай хуулийн шинэчилсэн найруулгад тусгагдсан. Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг төмөр замын газрыг байгуулан үйл ажиллагааг явуулах бүрэн боломжтой гэж үзэж тогтоолын төслийг боловсруулсан байна.

Улсын Их Хурлын тогтоолын төслийг D_parliament.mn цахим хаягт байршуулж иргэд олон нийтийн саналыг авч байгаа болно.

Байнгын хорооны хуралдаанаар тогтоолын төслийг хэлэлцэх үед Улсын Их Хурлын гишүүн Пүрэвдорж Төмөр замын тээврийн үйл ажиллагааны талаар ЗТЯ-ны баримталж буй бодлого шийдвэрийн талаар, Улсын Их Хурлын гишүүн Сандаг-Очир Төмөр замын газрын хэрэгжүүлэх чиг үүрэг, бүтэц орон тоо, төсөвт үзүүлэх ачааллыг тооцсон эсэх талаар асуулт асууж хариулт авсан болно.

Мөн Улсын Их Хурлын гишүүн Сайнзориг Төмөр замын газрыг байгуулахдаа бүтэц орон тоог нэмэгдүүлэхгүй оновчтой зохион байгуулахад анхаарч Төрөөс төмөр замын тээврийн талаар баримтлах бодлого батлах тухай Улсын Их Хурлын 2010 оны 32 дугаар тогтоолын хэрэгжилтийг эргэн харж Хөгжлийн бодлого төлөвлөлт түүний удирдлагын тухай хууль тогтоомж болон Улсын Их Хурлаас баталсан хөгжлийн бодлого төлөвлөлтийн баримт бичигтэй нийцүүлэх нь зүйтэй талаар, Улсын Их Хурлын гишүүн Зулпхар тогтоолын төслийг дэмжиж байгаа бөгөөд агентлагийг байгуулахдаа татан буугдаж буй Галт тэрэгний хөдөлгөөн зохицуулалтын нэгдсэн төвийн албан хаагчдын төрийн албаны ангилал зэрэглэл эрх зүйн байдлыг дордуулахгүй байхад анхаарах талаар, Улсын Их Хурлын гишүүн Бямбацогт сүүлийн 10 гаруй жилийн хугацаанд төмөр замын тээврийн салбарт өмчийн олон хэлбэр бүхий хуулийн этгээд бий болж өсөн нэмэгдсээр байгаад тээврийн хэрэгцээг хангах салбарын хүний нөөцийг мэргэшүүлэх төмөр замын суурь бүтэц хөдлөх бүрэлдэхүүний паркийг шинэчлэх, тээврийн сүлжээг өргөжүүлэх зэрэг үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд мэдлэг чадвартай хүний нөөц бүхий төмөр замын тээврийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага байгуулах нь зүй ёсны шаардлага үүссэн тул тогтоолын төслийг дэмжиж байгаа талаар тус тус саналаа илэрхийлсэн болно.

“Тогтоолын хавсралтад нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг Байнгын хороонд оролцсон гишүүдийн олонх буюу 68.8 хувь нь үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжиж чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх нь зүйтэй гэж үзсэн болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

“Тогтоолын хавсралтад нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцэх эсэх талаарх Төрийн байгуулалтын байнгын хорооны санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг та бүхнээс хүсье ээ.

Анхаарал тавьсанд баярлалаа.

Д.Амарбаясгалан: Баярлалаа.

Ажлын хэсгийг танилцуулъя.

Хүчитбаатарын Итгэл ЗТЯ-ны Төмөр, зам далайн тээврийн бодлого зохицуулалтын газрын дарга, Түвшинжаргалын Жавхлан ЗТЯ-ны Зам тээвэр, төмөр зам далайн тээврийн бодлого зохицуулалтын газрын дарга, Данзан-Ерэмпилийн Мөнхбат ЗТЯ-ны Төмөр зам, далайн тээврийн бодлого зохицуулалтын газрын Төмөр замын тээврийн хэлтсийн дарга, Сүхээгийн Мяндасмаа ЗТЯ-ны Хуулийн хэлтсийн дарга, Баасанхүүгийн Цэнд ЗТЯ-ны Хуулийн хэлтсийн ахлах шинжээч.

Улсын Их Хурлын гишүүд хууль санаачлагчийн илтгэл болон Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан намын бүлэг болон бүлэгт

харьяалагдаагүй гишүүдээс урьдчилан ирүүлсэн нэрсийн дагуу асуулт асууна аа. Асуулт асууж, хариулт авна.

Даваахүүгийн Пүрэвдаваа гишүүн асуултаа асууя.

Д.Пүрэвдаваа: Энэ өдрийн мэндийг хүргэе ээ.

Нэгдүгээрт энэ 2025 оны төсвийн тухай хуульд суулгаж амжаагүй тэгээд энэ бүтцийг араас нь оруулж ирж байна гэж байгаа юм. Тэгэхээр танай яамнаас Сангийн яаманд энийгээ ингээд цаг тухайд нь саналаа хүргүүлээгүй гэж ойлгож байна аа. Тэгэхээр энэнд нь хариуцлага хүлээж байгаа албан тушаалтан байгаа юу гэж нэг асууя.

Хоёрдугаарт нөгөө хэмнэлтийн хуультайгаа уялдуулаад төр данхайхгүй байх ёстой. Шинээр бүтэц байгуулахгүй байх ёстой гэдэг асуудал яригдсан. Ялангуяа төсөв өргөн баригдахад бол эхлээд нөгөө энэ орон тоог бол цөөлөх. Та бүхэн санаж байгаа бол цагдаагийн байгууллагын орон тоог цөөлөх асуудал маш маргаантай байдал үүсгэсэн. Дараа нь нөгөө төсвөө Ерөнхийлөгч хориг тавиад төсөвт хязгаарлалт хийж байхад бол энэ асуудал нэлээн өндөр түвшинд яригдсан.

Тэгэхээр орон тоог нэмэхгүй байх асуудал энэ 2025 оны төсөв батлагдахад анхаарал татсан учраас танайх энэ асуудлаа хэдэн хүнээр орон тоо нэмэгдэж байгаа юм. Цалингийн шатлал нь яаж явагдаж байгаа юм? Энэ талаар дэлгэрэнгүй мэдээллийг өгөөч гэж хүсэх байна. Тэгээд эцэс сүүлд нь бол энэ байгууллага түр байгууллага юм уу, эсвэл яваандаа ингээд энэ нөгөө хэвийн байдалд ортол одоо энэ нэгж чинь байж байгаад дараа нь татан буугдах юм уу эсвэл ингээд урт хугацаанд байгууллага юм уу энэ тооцоо судалгаа нь ямар байгаа юм бэ гэж асуумаар байна.

Д.Амарбаясгалан: Зам, тээврийн сайд Борхүүгийн Дэлгэрсайхан сайд хариулт өгье.

Б.Дэлгэрсайхан: Пүрэвдаваа гишүүний асуултад хариулъя аа.

2025 оны бүтцэд ингээд орж ирсэн. ЗТЯ бол журмын дагуу бүтцээ оруулж ирсэн. Тэгээд энэ ЗГХЭГ дээр бас энэ техникийн алдаанаас болж ингээд үлдсэн байдаг юм аа. Энийг бас бид эргэж лавлаж тэгээд энэ асуудлыг тухайн үед төсөв дагуулан өргөн барьсан боловч хууль зөрчсөн учраас дараа нь ингээд тусад нь оруулж ирж байгаа гэдгийг энэ дашрамд хэлье.

Энэ төрд анхаарахгүй байх дахиж төрийн байгууллага нэмж байгуулахгүйг ТӨК нэмж байгуулахгүй гэдэгтэй би тантай санал нийлж байгаа. Гэхдээ өнөөдөр энэ зам тээврийн агентлаг нь өөрөө зайлшгүй энэ зам тээврийн шинээр батлагдсан 2023 оны 7 дугаар сарын 7-нд батлагдсан хуульд төмөр замын агентлагтай байна гэдэг ийм заалт байгаа. Энэ 1 дүгээрт хууль хэрэгжүүлэхээр орж ирж байгаа.

Хоёрдугаарт ийм агентлаг байхгүйгээс болж Монгол Улс өмнө нь ганцхан Орос, Монгол хамтарсан төмөр замтай байсан учраас энэ үүргийг УБТЗ-ын ХНН давхар хэрэгжүүлж явсан юм аа. Өнөөдөр бол Монгол Улс өөрөө үндэсний төмөр замтай болсны хажуугаар түрүүн Бямбацогт сайдын хэлснээр олон хэвшлийн төр хувийн хэвшлийн олон төмөр замтай болсонтой холбогдуулаад энэ төмөр замуудын

төрөөс энэ төмөр замуудыг удирдах хөдөлгөөнийг нь удирдах зохион байгуулах ийм ажлыг бол зайлшгүй хийх шаардлагатай. Бусад оронд ч яг ингэж явдаг.

Тийм учраас өнөөдөр энэ олон суурь бүтэц дээгүүр 4 төрлийн суурь бүтэц байна. Өөрөөр хэлбэл энэн дээгүүр нийтдээ 253 компанийн хөдлөх бүрэлдэхүүн явж байна. Цаашдаа энэ тоо нэмэгдэх хандлагатай байгаа. Төмөр зам ч гэсэн нэмэгдэж баригдах ийм хөгжлөө дагаад зайлшгүй шаардлага байгаа.

Гуравдугаарт бол олон төмөр замууд хил холбогдож байгаа. Энэ бүгдийг зохицуулах төрийн байгууллагын зайлшгүй ийм агентлаг байх ёстой юм аа. Бусад улс оронд яг ийм байдаг. Тийм учраас бид бусад улс оронтойгоо харьцах үүднээс тэгш харилцаатай байх үүднээс энэ агентлагийг зайлшгүй байгуулах шаардлагатай. Тэгээд энийг байгуулснаараа одоо төрд ямар нэгэн дарамт ийм төрийн бүтцэд данхайх ямар нэгэн юм байхгүй. Энийг өмнө нь орлож байсан Галт тэрэгний хөдөлгөөн зохицуулалтын төв гэж байсан дээр суурилж байгуулагдаж байгаа. Өнөөдөр Галт тэрэгний хөдөлгөөн зохицуулалтын төв.

Д.Амарбаясгалан: Бадамсүрэн гишүүн алга байна. Батын Батбаатар гишүүн алга байна. Гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа.

Төслийн талаар байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг дэмжсэн эсрэг байр суурьтай намын бүлгийг төлөөлж болон бүлэгт харьяалагдаагүй гишүүдээс урьдчилан ирүүлсэн нэрсийн дагуу гишүүд дэмжсэн, дэмжээгүй байр сууриа илэрхийлж үг хэлнэ ээ.

Даваахүүгийн Пүрэвдаваа гишүүн үг хэлье.

Пүрэвдаваа гишүүн индрээс үг хэлье. Аан за асуултаар үндсэндээ санаагаа илэрхийлээд болчихсон гэж үзэж байна. Ингээд гишүүд үг хэлж дууслаа. Санал хураалт эхэлнэ.

Эдийн засгийн байнгын хорооны хурал дууссан байна. Гишүүд танхимдаа орж ирж суудлаа эзлэхийг хүсэж байна. Ирц бүртгэлийн санал хураалт явуулаадахъя. Ирц бүртгэлийн санал хураалт. 41 гишүүн бүртгэгдэж байна. Саналаа өгч чадаагүй гишүүн байна уу? Амжаагүй байна. 52 гишүүн болж байгаа юм байна тиймээ?

Байнгын хорооны саналаар “Тогтоолын хавсралтад нэмэлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжих эсэх талаар санал хураалтыг явуулна аа.

Санал хураалт.

Тогтоолын үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явагдсан. Нийтэд тогтоолын үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явагдсан.

59 гишүүн буюу 63.4 хувиар санал дэмжигдлээ.

“Тогтоолын хавсралтад нэмэлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг гишүүдийн олонх дэмжсэн тул төслийг анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр ТББХ-нд шилжүүллээ.

Өмнөх асуудлын санал хураалтыг явуулъя.

Байнгын хорооны саналаар Элчин сайдыг томилох саналыг дэмжих эсэх талаар санал хураалт явуулна.

1.Монгол Улсаас БНПУ-д суух Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайдаар Наваан-Юндэнгийн Оюундарийг томилох тухай саналыг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулна аа.

Санал хураалт.

63 гишүүн буюу 67.7 хувиар санал дэмжигдлээ.

Чуулганы нэгдсэн хуралдаан дээр явагдсан санал хураалтын дүнг Монгол Улсын Ерөнхийлөгчид албан бичгээр хүргүүлнэ ээ. Нэр дэвшигчид амжилт хүсье ээ. Ингээд үдээс өмнөх чуулганы хуралдаан өндөрлөлөө.

14 цагаас үдээс хойших чуулганы хуралдаан үргэлжилнэ.

ЗАВСАРЛАГА

Х.Булгантуяа: Улсын Их Хурлын чуулганы үдээс хойших чуулган эхэлж байна.

Дараагийн хэлэлцэх асуудалд оръё. “Жамсрангийн Самбуугийн алдар гавьяаг мөнхжүүлэх түүний мэндэлсний 130 жилийн ойг тэмдэглэн өнгөрүүлэх талаар авах зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцэж эхэлье.

Улсын Их Хурлын тогтоолын төслийн анхны хэлэлцүүлгийн төслийн анхны хэлэлцүүлгийг явуулсан талаарх ТББХ-ны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Ёс зүй, дэгийн байнгын хорооны дарга Баярмагнайн Баярбаатар танилцуулна.

Б.Баярбаатар: Улсын Их Хурлын дарга эрхэм гишүүд ээ,

Улсын Их Хурлын гишүүн С.Эрдэнэболд нарын 101 гишүүнээс 2024 оны 12 дугаар сарын 13-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдрүүлсэн “Жамсрангийн Самбуугийн алдар гавьяаг мөнхжүүлэх түүний мэндэлсний 130 жилийн ойг тэмдэглэн өнгөрүүлэх талаар авах зарим ар арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн хэлэлцэх эсэх асуудлыг Монгол Улсын Их Хурал 2024 оны 12 дугаар сарын 26-ны өдрийн нэгдсэн хуралдаанаараа хэлэлцсэн.

Анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр ТББХ-нд шилжүүлсэн. Төрийн байгуулалтын байнгын хороо 2025 оны 1 дүгээр сарын 7-ны өдрийн хуралдаанаараа тогтоолын төслийн анхны хэлэлцүүлгийг явуулахдаа Монгол Улсын Их Хурлын

чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39 дүгээр зүйлд заасны дагуу тогтоолын төслийг хэлэлцсэн болно.

Байнгын хорооны хуралдаанаар тогтоолын төслийн анхны хэлэлцүүлгийг явуулах үед Улсын Их Хурлын гишүүн С.Эрдэнэболд Нийтээр тэмдэглэх баярын болон тэмдэглэлт өдрүүдийн тухай хуульд нийцүүлж тогтоолын төслийн гарчгийг Засгийн газарт чиглэх тухай гэж өөрчлөх, мөн тогтоолын төслийг боловсронгуй болгох чиглэлээр нийт 4 зарчмын зөрүүтэй санал гаргасныг хуралдаанд оролцсон гишүүд олонх дэмжсэн болно.

ТББХ Улсын Их Хурлын гишүүнээс гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёоллын нэг бүрчлэн хэлэлцсэн бөгөөд зарчмын зөрүүтэй саналын томъёолол болон тогтоолын төслийн анхны хэлэлцүүлгийг явуулах талаар Байнгын хорооны санал, дүгнэлтийг та бүхэнд хүргүүлсэн болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ, “Жамсрангийн Самбуугийн алдар гавьяаг мөнхжүүлэх түүний мэндчилсний 130 жилийн ойг тэмдэглэн өнгөрүүлэх талаар авах зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн анхны хэлэлцүүлгийг явуулсан талаарх ТББХ-ны санал дүгнэлт, зарчмын зөрүүтэй саналын томъёоллыг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг та бүхнээс хүсье ээ.

Анхаарал хандуулсанд баярлалаа.

Х.Булгантуяа: Байнгын хорооны санал дүгнэлттэй холбогдуулан намын бүлэг болон бүлэгт харьяалагдаагүй гишүүдээс урьдчилсан ирүүлсэн нэрсийн дагуу асуулт асуухаар байгаа. Нийтдээ 3 гишүүн нэрээ ирүүлсэн байна. Аюушийн Ариунзаяа гишүүн.

А.Ариунзаяа: Монгол Улсад нийтээр тэмдэглэх баярын болон тэмдэглэлт өдрүүдийг өдрүүдийн тухай хууль байдаг. Тэгэхээр энэ хуулийнхаа дагуу хуулийн 5.2 дээр энэ асуудлыг тогтоох эрх мэдэл нь бол Засгийн газарт байгаа. Засгийн газар журмаараа энэхүү асуудлыг тогтоодог байгаа. Тэгээд энэхүү журмынхаа дагуу төр бол нийгмийн зүтгэлтэн болон гавьяат үйлстнийг алдаршуулах, дурсгалыг нь хүндэтгэх ойг буюу энэ түүхэн хүмүүсийг мэндэлсний 100 болон түүнээс дээших 50 жилийн давтамжтай ойг нь тэмдэглэнэ гэж заасан байдаг.

Би бол Эрдэнэболд гишүүнд юунд нь баярлаж талархаж байгаа вэ гэхээр яг энэ түүхэн хүмүүсийн дурсгалыг буюу яагаад ер нь тэмдэглэх гээд байдаг юм гэхлээр өнөө цагийн хүмүүстээ ийм хүмүүс байсан юм шүү ийм үйлийг хийж байсан юм шүү гэдгийг 1 дүгээрт таниулаад өнөөдөртөө өөрсдийгөө үлгэр жишээ авч цэгнээд маргааш ч гэсэн хүүхдүүд маань ийм хүн болоосой эх оронч хүмүүс чинь ийм байдаг юм шүү ийм үйл бүтээдэг юм шүү гэдгийг бол таниулах ийм арга хэмжээ болдог. 50 жил гэдэг 100 болоод түүний дараагийн 50 жил гэдэг хоорондоо асар хол хугацаа юм аа. Энэ хугацаанд түүхэн гэрчүүд нь тэнгэрт дэвшдэг. Эргээд үр хүүхдүүдээс ч гэсэн байсан уу, байхгүй юу гэдгээс хамаараад тухайн хүнийг дурсах олон нийтэд таниулах хүмүүс нь улам хомс болдог учраас энийг ойртуулж 130 жилийг тэмдэглэн өнгөрүүлбэ гэдэг энэ санаачилгыг дэмжиж 101 хүн гарын үсэг зурсан гишүүдийн нэг нь би өөрөө.

Тэгэхээр энэн дээр бол Засгийн газрын журмаа шинэчлэх энэн дээр анхаарах хэрэгцээ шаардлага байна гэдгийг онцолж хэлэх гэсэн юм аа. Тэгэхээр энэн дээрээ

бид нар бол өнөөдөр тэмдэглэнэ гэдэг тогтоол гаргахгүй. Харин Засгийн газарт яг энэ асуудлыг шийдвэрлэх эрх нь байгаа учраас чиглэл өгөх ийм тогтоолыг батлах гэж байна. Нөгөө талдаа Засгийн газар маань энэхүү журмаа бариад өө уучлаарай 100 болон 50 жилээр түүнээс хойших 50 жилээр л тэмдэглэх журамтай юм гээд буцаачих вий. Ийм учраас Засгийн газар маань энэнд анхаараад журмаа 1 дүгээрт шинэчлээд 2 дугаарт бол яг энэ түүхэн энэ тэмдэглэлт ойг хэрхэн яаж тэмдэглэх вэ гэдгийг ч гэсэн шинэчилж өгөх юм бол бид нар өнөөдөр зүгээр нэг эрдэм шинжилгээний хурал эс үгүй бол зургийн үзэсгэлэн эс үгүй бол юу байдаг юм тэмцээн уралдаан зохион байгуулахаас илүүтэй тухайн байгууллага бүр гэдэг юм уу сургууль дээр тийм түүхийн хичээл дээр гэдэг юм уу багш нь хүүхдүүдтэй ярилцаж тухайн хүнийг бас бүх нийтээрээ дурсаж ярих ийм боломжийг бүрдүүлж өгөөсэй гэж бодож байна аа.

Тэгэхээр энэ бол асуулт биш. Нэг талдаа бас дэмжиж байгаагаа илэрхийлээд 2 дахь нь болохлоор бид нар энэ манай чиглэл маань өөрөө хуулийнхаа дагуу явах ёстой учраас Засгийн газар журмаа шинэчлээсэй гэдгийг анхааруулж хэлэх гэсэн юм аа. Баярлалаа.

Х.Булгантуяа: Ариунзаяа гишүүн санал хэллээ. Сайнхүүгийн Ганбаатар гишүүн.

С.Ганбаатар: Өнөөдрийн энэ Эрдэнэболд гишүүн болон 101 гишүүн санал оруулж ирсэн. Энэ асуудлыг дэмжиж байгаа. Тэгээд яах вэ Монголчууд бид Чингис хааныхаа ойг тэмдэглээд л өвөг дээдсээрээ бахархаад л цээжээ дэлдээд л давхиад байдаг. Бид энэ өвөг дээдсийн төрт ёсны уламжлал, ёс заншлыг хадгалах томоохон уламжлалын үйл ажиллагаа бол энэ төрийн өвөг дээдсийн маань төрд оруулсан хувь нэмэр ёстой нөгөө дундартал, чөмгөө дундартал зүтгэсэн тэр өвгөдийн төрд яг юуг оруулж ирсэн юм бэ гэдгийг л ярьж, тунхаглаж, санаж, хэрэгжүүлэх явдал бол энэхүү ойн хамгийн чухал асуудал. Самбуу гуай бол уламжлалт МАА-гаа битгий хаяарай. Энэ дээр онцгой анхаараарай гэдгийг л насан туршдаа бидэнд захиж, сануулж, үлгэрлэж, энэ асуудлаар олон бүтээл хийж байсан. Өнөөдөр чинь ер нь бид бол тэгээд л нэг хэдэн газрын хөрсөн доор нүүрс ороод, хийгээд, бүтээгээд гаргаад ирчихсэн юм шиг л баясаад гүйгээд байгаа шүү дээ. Өвөг дээдсийн үлдээсэн юмыг л ухаж л байгаа улсууд. Тэгээд энэ нөхөгддөг энэ баялгаа дандаа энүүгээрээ додомдож тордоорой гэдгийг л Самбуу гуай бидэнд үлдээсэн өв байгаа. Ойд төөрсөн сармагчин шиг бид бол нэг ингээд нэг ямар ч өв уламжлалгүй улсууд шиг байж болохгүй. Ингээд Самбуу гуайн энэ асуудал дээр Улсын Их Хурлын 126 гишүүд юуг анхаарах вэ, Юунд анхаарах вэ? Тэр хүн шуналгүй байсан гэдгээрээ бидний бахархал. Одоо чинь ер нь тэгээд шунал ер нь хэрээс хэтэрсэн. Тэр хүн уул уурхай, газар нь шороо гэхээсээ илүү уламжлалт МАА-г л байнга ярьдаг байсан.

Дээр нь гадаад харилцааг эдийн засагжуулах тал дээр гайхалтай том бүтээлүүд сургаалуудыг бидэнд хэлсэн байдаг аа. Ингээд үргэлж үрждэг баялгийн төлөө хийж байсан тэр олон ололт амжилтуудыг ялангуяа коминтерн социализмын тэр хэцүү хүнд цаг дор уламжлалаа хамгаалах Монгол төрөө хамгаалах тал дээр хийж байсан нарийн арга заль. Энэ болгоныг нь энэ зүйл дээр зүгээр нэг бөх барилдуулаад нэг баясаад өнгөрөх биш. Энэ өв уламжлалын тал дээр онцгойлон анхаарч хоорондоо шүүж, тунгааж ярилцах ёстой гэдэг ийм байр суурийг би хэлж байна. Тэгээд Эрдэнэболд гишүүн болон бусад гишүүдэд энэ санаачилж орж ирсэн гишүүдэд талархалтай байна энийгээ дэмжиж байгаагаа илэрхийлье ээ.

Х.Булгантуяа: Улсын Их Хурлын гишүүн Батын Батбаатар асуулт асууж, санал ирэхээр нэрээ өгсөн байна. Байхгүй байна. Ингээд тогтоолын төсөлтэй холбогдуулан Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан намын бүлэг, бүлэгт харьяалагдаагүй гишүүдээс асуулт асууж, санал хэлж дууслаа. Зарчмын зөрүүтэй санал хураалтууд байгаа. Санал хураалтыг нэгдсэн журмаар өмнөх хэлэлцсэн асуудлуудтай хамтатган зохион байгуулъя.

Дараагийн хэлэлцэх асуудалдаа оръё.

14.12 цагт

Хэлэлцэх асуудал 6. “Батлан хамгаалахын техник тоног төхөөрөмж болон технологи шилжүүлэх тухай Монгол Улсын Засгийн газар, Япон Улсын Засгийн газар хоорондын хэлэлцээрийг соёрхон батлах тухай” хуулийн төсөл Засгийн газраас өргөн барьсан.

Хууль санаачлагчийн илтгэлийг Засгийн газрын гишүүн, Батлан хамгаалахын сайд Сандагийн Бямбацогт гишүүн танилцуулна аа. Сайдыг индэрт урьж байна

С.Бямбацогт: Улсын Их Хурлын дэд дарга, эрхэм гишүүд ээ,

Батлан хамгаалахын техник, тоног төхөөрөмж болон технологи шилжүүлэх тухай Монгол Улсын Засгийн газар, Япон Улсын Засгийн газар хоорондын хэлэлцээрийг соёрхон батлах тухай хуулийн төслийг танилцуулж байна аа. Энэхүү Засгийн газар хоорондын хэлэлцээр байгуулах асуудал Монгол Улсын Ерөнхийлөгч Хүрэлсүхийн 2022 онд Япон улсад хийсэн төрийн айлчлалын үеэр байгуулсан Монгол Улс, Япон Улсын Энх тайван хөгжил цэцэглэлтийн төлөөх тусгай стратегийн түншлэлийн үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдаж түүнийг хэрэгжүүлэх зорилгоор 2 талаас томилогдсон ажлын хэсэг хэлэлцээрийн төслийг эцэслэн тохиролцсон.

Хэлэлцээр байгуулах асуудлыг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэн дэмжигдэж, Улсын Их Хурлын Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороотой зөвшилцсөнөөр хэлэлцээрт 2024 оны 12 дугаар сарын 11-ний өдөр Улаанбаатар хотноо гарын үсэг зурсан.

Энэхүү хэлэлцээр нь олон улсын гэрээний тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.6, 8.2-т заасны дагуу Улсын Их Хурлаар заавал соёрхон батлуулах олон улсын хэлэлцээрт хамаарна аа.

Иймд холбогдох хууль тогтоомжийн хүрээнд хэлэлцээр соёрхон батлах тухай хуулийн төслийг боловсруулан хуулийн төслийн үзэл баримтлалыг Гадаад харилцааны сайд болон Хууль зүй, дотоод хэргийн сайдтай хамтран баталсан. Хэлэлцээр соёрхон батлах тухай хуулийн төслийг Засгийн газрын 2024 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн хуралдаанаар хэлэлцүүлэн дэмжигдэж 2024 оны 12 дугаар сарын 27-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн. Түүнчлэн хуулийн төслийг Улсын Их Хурлын Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны 2025 оны 1 дүгээр сарын 8-ны өдрийн хуралдаанаар хэлэлцүүлэн дэмжигдсэн. Хуулийн төсөл нь нэг зүйлтэй бөгөөд Батлан хамгаалахын техник, тоног төхөөрөмж болон технологи шилжүүлэх тухай Монгол Улсын Засгийн газар, Япон Улсын Засгийн газар хоорондын хэлэлцээрийг Монгол Улсын Засгийн газрын өргөн мэдүүлснээр соёрхон батлахаар тусгасан.

Хуулийн төсөл нь Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улс нэгдэн орсон олон улсын гэрээнүүд болон бусад хууль, тогтоомжтой нийцэх бөгөөд хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлэх мөн батлагдсантай холбогдуулан шинээр боловсруулах болон нэмэлт, өөрчлөлт оруулах, хүчингүй болгох хууль, тогтоомж байхгүй болно. Хуулийн төсөл батлагдсанаар манай улсын нийгэм, эдийн засгийн хөгжилд аливаа сөрөг үр дагавар үзүүлэхгүй. Улсын төсвөөс нэмэлт зардал шаардагдахгүй.

Засгийн газар хоорондын энэхүү хэлэлцээрийг соёрхон баталснаар 2 улсын Энх тайван, хөгжил цэцэглэлтийн төлөөх стратегийн тусгай стратегийн түншлэлийн үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилт хангагдаж Япон Улстай хөгжүүлж буй батлан хамгаалах салбарын харилцаа, хамтын ажиллагаа өргөжих, бүс нутагт цэргийн итгэлцлийг бэхжүүлэх, цэрэг, техникийн хамтын ажиллагаатай орны тоо нэмэгдэж, Монгол, Япон Улсаас орчин үеийн батлан хамгаалахын зэвсэг техник, тоног төхөөрөмж болон технологи шилжүүлэн авах Монгол Улсын Зэвсэгт хүчний үүрэг гүйцэтгэх чадавхыг нэмэгдүүлэх боломж бүрдэх ач холбогдолтой юм аа.

Иймд батлан хамгаалахын техник тоног төхөөрөмж болон технологи шилжүүлэх тухай Монгол Улсын Засгийн газар, Япон Улсын Засгийн газар хоорондын хэлэлцээрийг соёрхон батлах тухай хуулийн төслийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг хүсье ээ.

Анхаарал тавьсанд баярлалаа.

Хуулийн төслийн талаарх Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Дашцэрэнгийн Энхтүвшин танилцуулна. Индэрт урьж байна.

Д.Энхтүвшин: Улсын Их Хурлын дэд дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газраас 2024 оны 12 сарын 27-ны өдөр Монгол Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн батлан хамгаалах техник, тоног төхөөрөмж болон технологи шилжүүлэх тухай Монгол Улсын Засгийн газар Япон Улсын Засгийн газар хоорондын хэлэлцээрийг соёрхон батлах тухай хуулийн төслийг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 78 дугаар зүйлд заасныг үндэслэн Аюулгүй байдал гадаад бодлогын байнгын хороо 2025 оны 1 сарын 8-ны өдрийн хуралдаанаараа хэлэлцлээ.

Хуулийн төслийг хэлэлцэх үед Улсын Их Хурлын гишүүн Д.Ганбат төслийг дэмжиж байгаагаа илэрхийлээд шинэ техник, тоног төхөөрөмж, технологи эзэмшсэн боловсон хүчний нөөц хэр байгаа талаар, Улсын Их Хурлын гишүүн Батбаатар батлан хамгаалах чиглэлээр гадаадын олон улстай хамтын ажиллагаагаа бэхжүүлэх хүрээнд хийгддэг хээрийн сургуулилт зэрэг үйл ажиллагааны талаар иргэдэд зөв мэдээлэл ойлголт өгөхөд хэрхэн анхаарч байгаа талаар асуулт асууж хариулт авлаа.

Хуулийн төсөлтэй холбогдуулан гишүүд үг хэлээгүй бөгөөд Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн олонх хуулийн төслийг дэмжсэн болно оо.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Батлан хамгаалахын техник, тоног төхөөрөмж болон технологи шилжүүлэх тухай Монгол Улсын Засгийн газар, Япон Улсын Засгийн газар хоорондын хэлэлцээрийг соёрхон батлах тухай хуулийн төслийг хэлэлцсэн талаарх Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж, хуулийн төслийг эцэслэн баталж өгөхийг та бүхнээс хүсье ээ.

Анхаарал тавьсанд баярлалаа.

Х.Булгантуяа: Ажлын хэсгийн нэрийг танилцуулъя. Сандагийн Бямбацогт Батлан хамгаалахын сайд, Дагвадоржийн Ганхуяг Батлан хамгаалах яамны ТНБД, Төрбатын Наранхүү БХЯ-ны Гадаад хамтын ажиллагааны газрын дарга, Гомбосүрэнгийн Энхболд БХЯ-ны Төрийн захиргаа, удирдлагын газрын Хуулийн хэлтсийн дарга, Цогтсайханы Сэргэлэнбаатар БХЯ-ны гадаад хамтын ажиллагааны газрын Олон улсын гэрээ эрх зүй ёслолын ажил хариуцсан ахлах мэргэжилтэн гэсэн ийм бүрэлдэхүүнтэй байна.

Хууль санаачлагчийн илтгэл болон байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан асуулт асууж, үг хэлэх Улсын Их Хурлын гишүүд нэрээ өгнө үү. С.Ганбаатар гишүүнээр. Сайнзориг гишүүнийх орж гараад байх юм. Сайнзориг гишүүнээр тасалъя. Улсын Их Хурлын гишүүн Сайнхүүгийн Ганбаатар.

С.Ганбаатар: Би маш товчхон л хэдэн асуулт асууя аа. Энэ буцалтгүй тусламж гэж орж ирж байна. Энэ буцалтгүй тусламжийн энэ зүйл бэлгийн морины шүдийг үздэггүй гэдэг шиг. Тэгэхдээ энэний үнэ цэн, зах зээлийн үнэ цэн нь хэд вэ, Ер нь бид хэдэн төгрөгийн ийм буцалтгүй тусламжаар аваад байгаа юм гэдэг асуудлыг би та нар тооцоо судалгаа тооцоо хийсэн юм байгаа юу? Тодруулах хэрэгтэй.

Хоёрдугаарт, энэ олон тоног төхөөрөмжүүдийг авлаа. Бүгдийг нь би ингээд харлаа л даа бүх жагсаалтуудыг нь үзлээ. Энэ зүйлүүд дээр буцалтгүй тусламж байна. Сайхан л юм. Дараад нь урсгал зардал засвар үйл ажиллагааны зардал дээр хэд гарах вэ гэдэг энэ тооцоо судалгааг хийсэн үү? Энэ талаар бидэнд дэлгэрэнгүй мэдээлэл өгөөч ээ.

Х.Булгантуяа: Батлан хамгаалахын сайд Сандагийн Бямбацогт.

С.Бямбацогт: Тэгээд Монгол Улс өнөөдөр дэлхийн 39 улстай батлан хамгаалах салбарт хамтын ажиллагааны хэлэлцээртэй ингэж ажиллаж байгаа. Үүнээс 5 улстай, ОХУ, Хятад улс, Турк улс, Беларус, Украин гээд энэ 5 улстай цэрэг техникийн хамтын ажиллагаатай. Япон улстай бид нар цэрэг техникийн хамтын ажиллагаатай болох хэлэлцээр хийж байгаа. Энэ хүрээндээ бид нар техник тоног төхөөрөмж, технологи шилжүүлэн авах хэлэлцээр байгуулж байгаа. Энэ хүрээндээ бол тодорхой үнийн дүн бүхий тодорхой зориулалт бүхий тоног төхөөрөмжийг бид буцалтгүй тусламжаар авах гэж байгаа. Буцалтгүй тусламжаар. Тэгээд яг тийм зориулалтаар тийм үнийн дүнтэй гээд хэлэх нь улсын нууцад ордог юм байна лээ. Тийм болохоор танд шаардлагатай бол албан бичгээр өгч болно.

Хуралдааныг хаалттай болгох юм бол чөлөөтэй дэлгэрэнгүй мэдээлэл өгч болно. Мөн одоо энэ авч байгаа тоног төхөөрөмж маань манай зэвсэгт хүчинд хэрэгтэй юу, батлан хамгаалах салбарт хэрэгтэй юу гэдэг дээр л нэн чухал хэрэгтэй

байгаа. Энэ бол үндсэндээ Монгол Улсын батлан хамгаалах салбарыг бэхжүүлэх Зэвсэгт хүчний чадавхыг нэмэгдүүлэх энэ зорилгоор юу гэдэг юм ашиглагдана.

Хоёр улсын хооронд байгуулсан гэрээ ч гэсэн энх тайван хөгжил цэцэглэлтийн төлөөх гэсэн ийм зорилготой түншлэлийн гэрээ байгуулсан Япон улс, Монгол Улс яг энэ зорилгын хүрээнд энх тайван 2 улсын хөгжил цэцэглэлийн төлөөх гэсэн энэ зорилгод энхийг сахиулах ажиллагаа энэ бүхэнд шаардлагатай асуудлууд шийдэгдэх ийм зорилготой тоног төхөөрөмж. Өнөөдөр тэртээ тэргүй батлан хамгаалах салбар, зэвсэгт хүчинд үйл ажиллагаа явуулж байгаа орон тоо, бүтэц, зохион байгуулалт яг энэ чиг үүргийн тоног төхөөрөмжүүд байж байгаа. Үүнийг шинэчилж сайжруулж байгаа учраас нэмэлт зардал гарахгүй. Нэмэлт зардлууд. Өөрөөр хэлэх юм бол байж байгаа бүтэц орон тоо, энэ дээрээ энэ тоног төхөөрөмжүүд суурилуулаад бид нар цаашдаа ашиглаад явна аа.

Х.Булгантуяа: Улсын Их Хурлын гишүүн Дүгэрийн Рэгдэл.

Д.Рэгдэл: Баярлалаа. Энэ манай батлан хамгаалахын салбарт өндөр хөгжилтэй орноос техник, тоног төхөөрөмж технологитойгоо хамт шилжүүлэх ийм хэлэлцээр санаачилж байгаад их баяртай байна. Ер нь бол улс орны нийгэм эдийн засгийн аль ч салбар ч гэсэн технологи дээр суурилж л ингэж л цаашаа хөгжвөл сая энэнийг тогтвортой хөгжлийнхөө шаардлагыг хангаж байна гэж дэлхий даяар үзээд байх шиг байгаа юм. Тэгэхээр мэдээж хэрэг энэ хамтарсан хороо байгуулаад тийм ээ. Энэ хамтарсан хороо нь бол ямар техник технологи тоног төхөөрөмжөө шийдээд явах юм байна. Тэгээд энэтэй холбогдуулаад нэг санал, нэг асуулт байгаа юм. Энэ манай талаас энэ хамтарсан хорооны бүрэлдэхүүнд Эдийн засаг, хөгжлийн яамнаас төлөөлөл байвал зүгээр санагдаж байгаа. Яагаад гэвэл одоо энэ шинэ Засгийн газрын мөрийн хөтөлбөрийн дагуу бүтэц, бүрэлдэхүүний тухай хуулиараа Монгол Улсын шинжлэх ухаан технологийн нэгдсэн бодлого төлөвлөлтийн асуудал бол энэ Эдийн засаг, хөгжлийн яаманд шилжээд оччихсон ийм юм.

Тийм учраас тэр санал бол тэндээс оролцвол зүгээр. Японы тал бол яах аргагүй 2, 3 яамныхаа нэрийг биччихсэн байна. Манайх бол мэдээж хэрэг БХЯ байж таарна. Тэгээд энэ яамнаас томилсон гэдгийнхээ оронд Эдийн засаг, хөгжлийн яам гээд 3 дугаарт нь яамнаас томилсон гэдгээ оруулчихвал зүгээр юм уу гэсэн саналтай байгаа. Асуулт юу байна вэ гэхтэй зэрэг энэ бол техник технологид техник тоног төхөөрөмжөөр дамжаад технологи орж ирнэ гэдэг нь угаасаа Монгол Улсад Технологи дамжуулах тухай хууль гэж нэг хууль байдаг юм. Тэгээд энэ хуулийг бол манай Бямбацогт сайд бол их сайн мэдэж байгаа. Энэ хуулийг бүүр анхнаас нь л анхдагч хуулиас нь эхлээд их идэвхтэй оролцож явсан. Тэгээд энэ гэрээ хэлэлцээр маань энэ технологи дамжуулах хуулийн шаардлагуудтай аль хэр нийцэж байгаа юм бол? Энэ талаар манай яамны мэргэжлийн хүмүүсийн саналыг сонсмоор байгаа юм. Баярлалаа.

Х.Булгантуяа: Бямбацогт сайд хариулах уу?

С.Бямбацогт: Рэгдэл гишүүний асуултад хариулъя. Тэгээд энэ удаагийн хэлэлцээрээр бид нар техник, тоног төхөөрөмж технологи дамжуулах гэж байгаа. Энэ хэлэлцээрээр бид нар бол техник тоног төхөөрөмж авах гэж байгаа. Технологи биш. Тийм учраас тэгээд нэг талаас тоног төхөөрөмж хүлээж авч байгаа учраас үндсэндээ бид бүхэн бол Монголын талаас БХЯ ашиглагч байгууллага гэдэг үүднээсээ хариуцахаар орж ирж байгаа. Холбогдох энэ хэлэлцээр байгуулагдсаны

дараа тоног төхөөрөмжийг шилжүүлж аваад хүлээлцэх үед мөн суурилуулах үед 2 талаас ажлын хэсэг гарна. Энэ ажлын хэсэг гарч ажиллах үед үндсэндээ бусад яамдын холбогдох албан тушаалтнуудыг оролцуулаад явах бүрэн бололцоотой. Таны хэлж байгаа Эдийн засгийн хөгжлийн яам, Гадаад харилцааны яам зэрэг байгууллагуудын төлөөллийг оролцуулах бүрэн боломжтой.

Японы талаас нөгөө гадагшаа өгч байгаа тодорхой хөрөнгөө Улсын төсөвт суусан хөрөнгөөсөө зарцуулж байгаа учраас Эдийн засгийн хөгжлийн яам, Гадаад харилцааны яам, Батлан хамгаалах яамнаас хамтарч оролцож шийдвэр гаргаж байгаа. Бид хүлээн авагч тал учраас батлан хамгаалахыг дангаараа авч байгаа юм аа.

Харин цаашдаа бид нар бол энэ батлан хамгаалах салбарт техник технологийг шинэчлэх технологи дамжуулах энэ тал дээр тодорхой бодлого барьж ажиллаж байгаа. 2025 оныг Монгол Улсын Батлан хамгаалахын яам эх оронч Монгол Их сэргэлтийн жил болгож зарласан байгаа. Энэ хүрээндээ бид нар батлан хамгаалах аж үйлдвэрийг сэргээх хөгжүүлэх энэ бодлого барьж байгаа. Үүнд бид нар дроны үйлдвэрлэл явуулах, аль болох олон улсын шилдэг техник тоног төхөөрөмж оруулж ирэх, радио станц өөрсдөө үйлдвэрлэдэг болох. Гаднаас радио богино долгионы радио станцыг худалдаж авдаггүй байх. Валютыг гадагшаа урсгадаггүй байх. Энэ тал дээр тодорхой ажлыг хийж хэрэгжүүлэх. Мөн хуягт тээвэрлэгч машинуудыг өөрсдөө дотооддоо үйлдвэрлэх гэх мэтийн дотооддоо бид нар батлан хамгаалах аж үйлдвэрийг сэргээж сайжруулах энэ хүрээнд техник технологийн дэвшлийг гадаадын одоо өндөр хөгжилтэй орнуудтай тухайлах юм бол Япон улс, тэгээд Солонгос, Хятад цаашлаад Оросын холбооноос ч зэвсэг техник бид нар авдаг. Турк, Вьетнам гээд улсуудтай хамтын ажиллагаа хөгжүүлж энэ тал дээр илүү анхаарч ажиллах ийм бодлого барьж байгаа.

Технологи дамжуулахдаа хуультай аль хэр зэрэг нийцэж байна вэ гэдэг дээр одоо бид бүхэн та бид хамтраад ажлын хэсэг болоод Инновацийн тухай хууль баталж байсан. Тэгээд энэ хуультай нэг их тийм зөрчилдөж байгаа зүйл байхгүй байх гэж ойлгож байгаа. Энэ дээр манай ажлын хэсгээс нэмээд хариулчих уу? 19 Ганхуяг дарга хариулъя.

Х.Булгантуяа: Төрийн нарийн бичгийн дарга Ганхуяг дарга нэмж хариулъя. Ажлын хэсгийн микрофон тоогоо өргөөдхөөрэй хэдэн номер байна. 19 номер асчихсан байна микрофон нь.

Д.Ганхуяг: Байна уу? Рэгдэл гишүүний асуултад БХЯ-ны Төрийн нарийн бичгийн дарга бригадын генерал Ганхуяг хариулъя. Ээнэ соёрхон батлахтай холбоотойгоор ямар нэгэн хуульд өөрчлөлт орохгүй. Мөн Технологи шилжүүлэх тухай тэр хуультай зөрчилдөж байгаа бол асуудал байхгүй. Сая сайд хэлчихлээ. Хоёр талын хамтарсан хороо юу авахаа тодорхойлно. Тэр ажлын хэсэгт бол бусад яамдаас төлөөлөл оролцох нь нээлттэй байгаа.

Х.Булгантуяа: Рэгдэл гишүүн тодруулъя.

Д.Рэгдэл: Би сая буруу сонсчихсон юм уу? Сайн ч мэдэхгүй л байна. Ер нь Бямбацогт сайд маань техник тоног төхөөрөмж орж ирнэ ээ. Технологи орж ирэхгүй гэсэн юм хэлчих шиг болох юм. Тэгэхээр хэлэлцээрийн нэр дээр технологи гээд

байж байгаа болохоор тэр яагаад хэлтсийн нэр нь нэрэн дээр технологи шилжүүлэх гээд орчихсон юм бол гэж гайхаад байна 1 дүгээрт.

Хоёрдугаарт ер нь өндөр хөгжилтэй газрын техник, тоног төхөөрөмж орж ирнэ гэдэг бол угаасаа технологийн шинэчлэл хийгддэг технологитойгоо аяндаа л ороод ирдэг. Техникийг ашиглахаас өгсүүлээд л шинэ технологи орж ирнэ л дээ. Тэгэхээр тэр технологи шилжүүлэх гэдэг үгнээс ер нь зугтмааргүй л энэ яг энэ нэрээр нь оруулаад технологи аяндаа агуулгаар орж ирж байгаа гэдэг тайлбартай явбал Их Хурлаас гарах тогтоолын төслийг дэмжихэд бэлэн байна аа.

Х.Булгантуяа: Бямбацогт сайд хариулъя.

С.Бямбацогт: Ер нь таны хэлж байгаатай санал нэг байгаа. Энэ хэлэлцээр 5 жилийн хугацаатай байгуулагдана. Тэгээд 2 талаас санал гаргахгүй бол автоматаар жил жилээр сунгагдаад явна. Энэ хүрээндээ үндсэндээ бол Япон Улсаас бид нар техник тоног төхөөрөмж технологи авах асуудал ингээд үе шаттай явагдана. Хамгийн анхны техник тоног төхөөрөмж бид нар авах гэж байгаа.

Цаашлаад юу гэдэг юм, шинэ дэвшилтэт технологи, түүнийг дагаад техник тоног төхөөрөмжийг Монгол Улсад үйлдвэрлэх бололцоо боломжийг бий болгох ийм асуудал цаашдаа нээлттэй байгаа.

Тийм болохоор үндсэндээ таны хэлж байгаа тэр технологи нэвтрүүлэх тал дээр бид нар цаашдаа тэр технологийг дагуулаад өөрсдөө бүтээгдэхүүн дэвшилтэт техник, тоног төхөөрөмж үйлдвэрлэх тал дээр илүү анхаарч ажиллана аа. Тэгээд энэ нэг удаагийн хэлэлцээр биш 5 жилийн хугацаатай байгуулагдаад цаашдаа олон тоног төхөөрөмж, олон техник, олон технологи орж ирэх бололцоотой гэдгийг хэлье ээ. Боломж бүрдэх юм гэдгийг.

Х.Булгантуяа: Улсын Их Хурлын гишүүн Сайнзориг.

П.Сайнзориг: Баярлалаа. Би асуултууд давхцаж байгаа. Тэгэхдээ агуулга асуултыг давхцуулахгүйгээр 2 зүйлийг тодруулж асууя гэж бодож байна. Ер нь бол энэ хэлэлцээр соёрхон батлах хуулийн төслийг зарчмын хувьд дэмжиж байна аа. Үеийн үед батлан хамгаалах салбарын идэвхтэй, зөв, үр дүнтэй энэ гадаад харилцааны бодлогоор үр дүнд Монгол Улсын хүн ам тодорхой салбарууд их хожиж ирсэн байдаг юм аа. Ялангуяа энхийг дэмжих ажиллагаанд оролцож байсан батлан хамгаалах салбарын идэвхтэй үйл ажиллагааны үр дүнд энэ Улаанбаатар хотын өнөөдөр гэхэд л ундны усны асуудлыг бид нар АНУ-ын ард түмний хөрөнгөөр ингээд шийдүүлэх энэ зүйл шийдэгдсэн байх жишээтэй. Тэгэхээр бид нар энэ батлан хамгаалах салбарын зарим энэ харилцааг өргөжүүлэх олон талт болгох энэ чиглэлийг зайлшгүй дэмжээд бас энэ дээрээ зөв нюанстай гаргалгаа гаргаад явах нь зөв байгаа юм аа.

Тэгээд энэ хэлэлцээрийн соёрхон батлах хүрээнд Монголд мэдлэг одоо ноу хау орж ирэх энэ үүд хаалга нээгдэж байна. Тэгэхээр миний зүгээр асуух гэж байгаа зүйл бол энэ цаашдаа батлан хамгаалах салбарын хүний нөөцийг бэлтгэх энэ бодлогын хүрээнд илүү тэр хуучин цагийн гэхээсээ илүүтэй орчин цагийн энэ техниктэй ажиллаж чадах энэ боловсон хүчнийг бэлтгэх ажлыг бодлогын хүрээнд салбарын яам маань яг ямар төсөөлөлтэй байгаа вэ? Ер нь зүгээр Бямбацогт

сайдын зарим мэдээллийг сонсож байсан. Тэгэхээр энийг бас иргэдэд илүү хүргэх шаардлагатай байгаа юм аа.

Залуучууд өнөөдөр яг цэрэгт очоод ямар давуу талтай болоод халагдах байдалтай байх вэ? Тэгэхээр энэ бүх зүйлүүд л энэ Гадаад харилцааны бодлоготой уялдаж байгаа байх. Энэ техник технологийг дагаад энэ дээр ажиллаж байгаа залуучууд хүртэл суралцаад гарна л гэж ойлгож байгаа. Тэгэхээр Монгол Улсын хөдөлмөрийн зах зээл дээр дутагдалтай энэ ажиллах хүчнийг ялангуяа ур чадвартай туслах ажилтнуудыг бэлдэх энэ ажил дээр БХЯ, Нийгэм хамгаалал, хөдөлмөрийн яам, Боловсролын яамтай хэрхэн яаж уялдаатай байгаа вэ? Ялангуяа энэ чиглэлдээ цэрэгт одоо цэргийн албаа хаангаа тодорхой ямар ямар салбаруудаар мэргэшэх бололцоонуудыг бүрдүүлж байгаа вэ? Цаашдаа энэ өндөр технологийн салбарууд руу энэ бодлого үргэлжлэх үү? Ялангуяа одоо дроны асуудал дээр бол жишээ нь дроны жолоочгүй нисгэгч гэж ярьдаг. Яах вэ бид дроныг сонирхогчийн түвшинд ойлгоод байх шиг байгаа юм. Цаашдаа энэ ачаа тээвэр ч гэдэг юм уу, энэ бол нэлээн овор хэмжээний хувьд томоохон дронуудыг нисгэгчид жолооддог. Энэ ч гэсэн батлан хамгаалах салбар гэлтгүй ХАА-н салбар дээр хүртэл ингээд бордоо цацахад хүртэл маш сайн энэ дронтой ажиллаж чаддаг залуучууд дутагдалтай байх жишээтэй. Эргээд энэ хот доторх бас одоо цус тээвэр эд эрхтэн шилжүүлэх юун дээр хүртэл дроныг ашиглаж байсан практик манайд байна.

Тэгэхээр ер нь зүгээр энэ чиглэлийн мэргэшсэн ур чадвартай боловсон хүчин бэлтгэх энэ ажил дээр цаашдаа бас гадаад харилцааны хувьд ер нь ямар зүйлүүд хийгдэхээр байгаа вэ? Энэ талын мэдээллүүдийг боломжтой бол.

Х.Булгантуяа: Бямбацогт сайд хариулъя.

С.Бямбацогт: Сайнзориг гишүүн маш чухал асуудал хөндөж байна аа. Тэгээд Монгол Улсын гадаад улс орон дахь дэлхий дэх нэр хүндийг өргөхөд батлан хамгаалах салбар манай Зэвсэгт хүчний энхийг сахиулагч нар маш үр дүнтэй маш өндөр тийм үүрэг оролцоотой байгаа. 2002 оноос хойш 20 гаруй жилийн хугацаанд энхийг сахиулах ажиллагаанд бид оролцож эхэлсэн. Иракаас авхуулаад өнөөдөр Өмнөд Судан улсын Серлион, Өмнөд Судан улсад 850 гаруй албан хаагч энхийг сахиулах үйл ажиллагаанд оролцож байгаа. Энэ очсон газар бүрдээ энхийг сахиулах ажиллагаанд оролцсон улс орон бүрдээ Монгол Улсын Зэвсэгт хүчний албан хаагч нар улс орныхоо нэрийг өндөрт өргөдөг үнэхээр хариуцлагатай Чингисийн цэрэг дэлхийн Монгол цэргийн байна гэж үнэлэгддэг. Үүнийх нь үр дүнд ч гэсэн Монгол Улсын гадаад дахь нэр хүнд өсөх саяын өөрийн чинь хэлж байгаа АНУ-ын Мянганы сорилтын сангаас хэдэн 100 сая долларын Улаанбаатар ундны усны асуудлыг шийдэх гэх мэтийн үр өгөөжийг Монголчууд бид хүртэж байгаа.

Тийм ч учраас бид нар энхийг сахих үйл ажиллагаанд оролцох оролцоогоо 3 дахин нэмэгдүүлье гэсэн зорилгыг Засгийн газрын үйл ажиллагааны мөрийн хөтөлбөрт тусгасан. Энэ хүрээндээ бид нар Зэвсэгт хүчний хөгжлийн санд тодорхой орлого ордог. Манай Зэвсэгт хүчний албан хаагч нар бас хэлний гадагшаа дотогшоо яваад мэдлэг чадвар амьдрах чадвар нэмэгддэг. Мөн санхүүгийн хувьд орон байрны хувьд асуудлаа шийддэг. Хамгийн гол нь гадаад улс дахь Монгол Улсын нэр хүндийг өндөрт өргөдөг. Ийм учраас илүү бид анхаарсан бодлогоо цаашид улам эрчимжүүлнэ.

Хоёрдугаарт нь энэ сүүлийн дэвшилт техник технологи энэ ноу хауд энийг ашиглах тийм орчин цагийн дайн байлдаан хүртэл ямархуу болсныг бид нар харж байгаа. Уламжлалт дайн биш тийм хосолмол ийм хэсэг бүлгийн дайн байлдаан явдаг болчихсон байна. Үүнд таарсан ажиллагааг бид явуулах ёстой. Энэ хүрээндээ бид нар үндсэндээ одоо бас энэ зэвсэг техникээ шинэчлэх энэ хүрээндээ ингээд орчин цагийн энэ нөхцөл байдалтай уялдуулж ажиллах тал дээр илүү анхаарч ажиллаж байгаа. Энийг бид нар хугацаат цэргийн албан хаагч нараасаа эхэлж байгаа.

Хугацаат цэргийн албан хаагч нар маань л цэргийн эрдэмд суралцаад цэргийн алба хаагаад бие сэтгэлийн хувьд тийм хатуужихаас гадна энэ эргээд амьдрал дээр гараад амьдралаа авч явах чадвартай амьдрахуйн, ажиллахуйн, нийгэмшихүйн гээд олон чадавхтай болох ёстой. Энэ талд нь бид нар англи хэлний сургалт явуулж, англи хэлний анхан шатын мэдлэгтэй болгох асуудал ярьж энэ жилээс ч хичээллэж эхэлнэ. Мөн одоо бас мэдээллийн технологи, компьютерын анхан шатын мэдлэгтэй болж таны хэлж байгаа цаашлаад энэ дрон ашиглах дроны жолооч болох ийм чадвартай болох, мөн одоо бас жолооч болох ийм шийдлүүдийг бид нар давхар хийж өгч байгаа.

Энэний цаад талд нь эндээсээ бид нар гэрээт цэргийн албан хаагч энэнээсээ цааш нь офицеруудаа бэлдэх энэ чиглэл рүү үндсэндээ нэн ач холбогдолтой, нэн тэргүүний гэдгээ ач холбогдлоор нь эрэмбэлээд энэ чиглэлийн боловсон хүчнийг орчин цагтай нийцүүлж гадаадын улс оронд бэлтгэе. Мөн одоо бас зэвсэг техникээ шинэчлэхдээ хамгийн нэн шаардлагатай орчин үеийн техник тоног төхөөрөмжийг бэлтгэх талдаа илүү бас анхаарч ажиллая гэсэн ийм бодлого зорилтыг тавьж ажиллаж байгаа. Тэгээд түүнээс гадна бас энэ улс ардын аж ахуйн салбарт манайд боловсон хүчний хомсдолтой, ажиллах хүчин дутагдалтай болсон үед энэ томоохон улс орны мега төслүүдийн бүтээн байгуулалтад оролцох, мөн Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачилсан тэрбум модны хөтөлбөрт оролцож ойжуулах ажлыг хийж хэрэгжүүлэх, Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачилсан эх оронч Монгол хөтөлбөрийг хэрэгжүүлж энэ иргэдээ эх оронч болгох өнөөдөр юу гэдэг юм жагссан болгон эх оронч биш, бид өнөөдөр иргэнийхээ үүргийг биелүүлж байгаа хүмүүсийг эх оронч гэж үзье. Эх оронч байж байж энэ Монгол Улсын үндэсний сөрөн тэсвэрлэх чадавх, тусгаар тогтнол, бүрэн эрхт байдал хадгалагдана аа. Энэ рүү чиглэсэн томоохон бодлого үйл ажиллагаа хийж хэрэгжүүлэх ийм ажлуудыг төлөвлөөд энэ хүрээндээ бид нар 2025 оныг Монгол Улсын БХЯ-аас эх оронч Монгол Их сэргэлтийн жил болгож зарлаад энэ хүрээнд томоохон бодлогын зорилтуудыг тавьж ажиллаж байгаа гэдгийг танд хэлье.

Х.Булгантуяа: Улсын Их Хурлын гишүүн Буланы Бейсен.

Б.Бейсен: Энэ Монгол Улсын Засгийн газар, Япон улсын Засгийн газар хоорондын хэлэлцээрээр батлан хамгаалахын техник тоног төхөөрөмж болон технологид шилжүүлэн тухай хуулийн төслийг дэмжиж байгаа юм аа. Гэхдээ бодууштай асуудлууд байна. Дэлхийн геополитикийн байдал ер нь хүнд дайны байдалд шилжсэн. Дайн ч явагдаж байна. Энэ үед энэ зэвсэг техник шилжүүлж авч байгаа нь зөв гэж бодож байна. Гэхдээ манайх чинь хуурай замын цэргийн тоног төхөөрөмж, буу, сум, нөгөө талаар агаарын цэргийн тоног төхөөрөмж гэж хэлж өгч авах боломжтой л доо. Усан цэрэг гээд боломжгүй юм чинь. Ус юу байхгүй.

Тэгэхээр энэ асуудал дээр нэлээн анхаарах асуудлууд байгаа юм аа. Технологи гэдэг дээр чинь заавал үйлдвэрлэл явагдана гэсэн үг. Тэгэхээр чинь энэ сум, бууны асуудал байж байна. Сая энэ зарим хуягт машин бусад асуудлууд байж байна. Дроны асуудал байгаа. Тэгэхээр энд шилжүүлж авч байгаа тоног төхөөрөмж, хамгийн сүүлийнх үү, аль эсвэл технологи нь хоцрогдсон хуучавтар юмнууд байна уу? Манай урд ба хойд хөрш бол хамгийн байлдааны батлан хамгаалах зэвсэг техникийн хувьд нэлээн хөгжсөөр байна шүү дээ.

Тэгэхээр энэ дээр яаж анхаарч авч байна. Нөгөө талаар тэр шилжүүлж ирж байгаа тоног төхөөрөмж дээр ажиллах боловсон хүчин мэргэжилтнийг бэлдсэн үү, Дараа сургах юм уу? Ялангуяа энэ агаарын цэргийн дрон дотоодын их дээд сургуулиуд байж байна? Тэрэн дээр бэлдэх талын асуудал дээр бас нэлээн анхаарах уу? Энэ тал дээр ямар бодлого байна? Мөн дрон үйлдвэрлэлийн асуудал бид нар түрүүн энэ жилийн юун дээр юуны асуудал оруулсан. Тэгэхээр энэ байдал дээр ямар бодлого барьж байна гэдгийг асууя.

Х.Булгантуяа: Батлан хамгаалахын сайд Бямбацогт хариулъя.

С.Бямбацогт: Бейсен гишүүн маш чухал асуудал хөндөж байна аа. Ер нь бол дэлхийн гео стратеги, геополитикийн нөхцөл байдал маш амаргүй байгаа, маш ээдрээтэй байгаа. Хаа сайгүй л ерөөсөө дайн байлдаантай, улам энэ өргөжих тийм эрсдэлтэй. Үүнээсээ болоод дэлхийн бүх улс орнууд батлан хамгаалах салбарт зарцуулдаг зарлалаа нэмэгдүүлж байгаа. НАТО-ийн орнууд жишээ нь ДНБ-ий 2 хувийг батлан хамгаалах зардалдаа зарцууллаа гээд 2 хувьд хүрсэн бол цаашдаа 5 хувьд хүргэх зорилго тавьж байна. ОХУ одоо Украйны хийж байгаа энэ дайндаа нийт төсвийнхөө үндсэндээ 30 хувийг зарцуулж байна. Израиль улсад 15 хувь гэх мэтээр. Тийм үе энэ цаг үед батлан хамгаалах салбараа бэхжүүлэх энэ улс орныхоо тусгаар тогтнол, бүрэн эрхт байдал, аюулгүй байдлаа хангахад бид бүхэн онцгой анхаарах ёстой, онцгой анхаарах ёстой.

Өнөөдөр АНУ-ын Ерөнхийлөгч Трамп гээд хүн сонгогдох гэж байна. Энэ хүн гарч ирээд үндсэндээ Канад Улсыг манай 51 дэх муж болоо. Грийнланд арлыг бид авна аа. Панамын сувгийг бид байгуулсан юм чинь бид буцааж авна өгөхгүй гэвэл бид зэвсэг хүч хэрэглэнэ гэх мэтчилэн ингээд асуудалтай болж байгаа. Өнөөдөр өнөөдөр Орос, Украйны дайн ч гэсэн ингээд өнөөдөр хиллэж байгаа фронт эзэлсэн фронтоороо ингээд дайн байлдааныг зогсооё гэх юм бол одоо хүлээн зөвшөөрөхөөс өөр аргагүй байдалд Украйн орох байх. Иймэрхүү байдлаар үндсэндээ нэг том гүрнүүдийн нэг жоохон тийм давамгайлах хандлагууд цаашдаа бий болох эрсдэл байна.

Энэ цаг үед Монгол Улс өөрсдийнхөө аюулгүй байдлыг хангах энэ үндэсний сөрөн тэсвэрлэх чадавхыг бий болгох энэ зорилгоор бид нар үндсэндээ эх оронч Монгол хөтөлбөр санаачилж байгаа. Энэ ондоо иргэн болгон эх орныхоо төлөө гэсэн сэтгэлтэй, иргэн болгон эх орныхоо өмнө үүрэг хариуцлага хүлээдэг ухамсартай, иргэн болгон миний хийж байгаа бүтээж байгаа, миний үр хүүхдээ өсгөж хүмүүжүүлж байгаа багш болгон хүүхдийг сургаж хүмүүжүүлж байгаа эх орныхоо төлөө юм шүү гэдэг үзэл хандлагыг бий болгохгүй дэлхий нийтээр амаргүй болж байгаа. Тийм болохоор энэ рүү чиглэсэн энэ Монгол Улсын аюулгүй байдал, бүрэн эрхт байдал, халдашгүй байдал энэ болгонд зөвхөн БХЯ биш Монгол Улсын Их Хурал бүгд л иргэн болгон онцгой анхаарах ийм шаардлагатай байгаа, шаардлагатай байгаа.

Тийм болохоор таны хэлж байгаа асуудал дээр Монгол Улсын БХЯ илүү онцгой анхаарч ажиллаж байгаа. Бодлого зорилгоо ч үүн рүү чиглүүлж тавьж байгаа гэдгийг хэлье ээ. Япон Улсаас оруулж ирж байгаа тоног төхөөрөмжийн тухайд шинэ тоног төхөөрөмж, шинэ тоног төхөөрөмж. Мөн удахгүй бид нар Турк Улсаас Монгол Улсад сум үйлдвэрлэдэг үйлдвэр оруулж ирэх гэж байгаа. Тэгээд галт зэвсэг Галт сумаа бид нар өөрсдөө гаднаас импортоор өндөр үнэтэй валютаар худалдаж авахгүй дотооддоо үйлдвэрлэдэг болно. Энэ иргэний болон цэргийн зориулалттай. сумыг бид Монгол Улсад үйлдвэрлэдэг болох гэж байгаа гэдгийг танд хэлье ээ. Энэ орж ирж байгаа тоног төхөөрөмжийг ашиглах тал дээр бол боловсон хүчин бэлэн байгаа. Үндсэндээ энэ орж ирж байгаа тоног төхөөрөмжийг ашиглах боловсон хүчин бэлтгэгдсэн чадавхтай боловсон хүчнүүд байгаа гэдгийг танд хэлье ээ.

Х.Булгантуяа: Буланы Бейсен гишүүн тодруулъя.

Б.Бейсен: Энэ орж ирж байгаа батлан хамгаалахын тоног төхөөрөмж чинь хэчнээн хувийг сургалтын чиглэлээр хуваарилсан юм бол? Сургалт хийхгүй бол бас болохгүй л дээ энэ чинь. БХИС байна. Хил хамгаалахын сургуулиуд байж байна. Тэгэхээр чинь энд хэчнээн хувийг яаж байна. Нөгөө талаар агаарын довтолгоо, пуужингийн юм уу, дроны довтолгооноос хамгаалах тоног төхөөрөмж оруулж ирэх үү? Ер нь энэ талын асуудлыг бодохгүй бол сая энэ Украин Оросын дайныг бодоход ер нь тийм асуудал гарч байна шүү дээ. Цаашдаа энэ талаар бодож байгаа бодлого байна уу гээд асууя.

Х.Булгантуяа: Бямбацогт сайд Бейсен гишүүний асуултад, тодруулгад.

С.Бямбацогт: Энэ оруулж ирэх тоног төхөөрөмж бүх л тоног төхөөрөмж байгаа. Зүгээр яг энэтэй холбоотой бас зайлшгүй сургах, дадлагажуулах шаардлагатай хүмүүсийг Япон улсдаа бэлдэнэ ээ. Япон улсын техник, технологи тоног төхөөрөмж учраас.

Агаарын довтолгооноос эсэргүүцэн хамгаалах систем гээд та ярьж байх шиг байна. Энэ бол үндсэндээ Монгол Улсад маань үүнийг худалдаж авах тийм чадавх төсөв санхүүгийн бололцоо тун бага байна аа. Маш өндөр үнэтэй байдаг. Бид нар яах вэ 2 том хөрштэй. 2 том хөрштэйгөө маш сайн харилцаатай байж цэрэг улс төр дипломатын аргаар үндсэндээ батлан хамгаалах салбар хамгаалах энэ харилцан тийм бие биетэйгээ хамтарч ажиллах ийм хүрээнд үйл ажиллагаа явж байгаа.

Тийм болохоор нэг талаасаа 2 хөршдөө найддаг. Гэхдээ нөгөө талдаа бид нар бэлтгэл юмыг болзошгүй тийм аюулгүй байдал, болзошгүй эрсдэл бол тодорхой хэмжээгээр хамгаалалттай байх ёстой. Энийгээ бид нар бол үндсэндээ түрүүн хэлсэн иргэн болгоноо эх оронч үзэлтэй болгох иргэн болгоноо эх орныхоо төлөө цохилох зүрхтэй болгох.

Х.Булгантуяа: Би нэг зүйл тодруулъя. Учрал сайд ороод ирлээ. Учрал сайдаас тодруулчихъя тэгэх үү?

Зээл тусламжаар дээрээс нь нэмээд улсын төсвийн худалдан авалтаар ер нь хийж байгаа, төрийн өмчүүдийн бүртгэл мэдээлэл хэр сайн явагдаж байгаа вэ? Бид нар ингээд Улсын Их Хурлаас төсөв дээр, дээрээс нь нэмээд зээл тусламжаар ч гэсэн авч байгаа энэ техник тоног төхөөрөмжүүдийн бүртгэл дутуу дулимаг дээрээс

нь нэмээд ийм байснаас ер нь шамшигдуулж байгаа зарж борлуулж байгаа гэсэн ийм асуудлууд ер нь байна уу үгүй юу? Компьютер гэхэд жишээлбэл нягтлан бодох бүртгэлээр 2 жилийн дотор элэгдэл хорогдол хийчхэж байгаа юм. Ингээд л манайх элэгдээд дуусчихсан шүү дээ. Бүртгэлд бараг байхгүй шүү дээ. Шинээр худалдан авахаас өөр аргагүй шүү дээ гэдэг ийм асуудлууд яригдаад байгаа юм биш биз дээ? Энэ төрийн өмчийн энэ ингээд л төрийн өмчид бүртгэгдэнэ гэсэн үг шүү дээ. Тэгэхээр төрийн өмчүүдийн бүртгэл техник тоног төхөөрөмжийн бүртгэл мэдээлэл хэр сайн явж байгаа вэ? Улсын Их Хурлаас энэ зээлийг ч энүүнийг гэрээг батлаад явахад гэдэг ийм асуултыг асуух гэсэн юм.

Н.Учрал: Энэ мэдээж энэ зээл тусламжтай холбоотой гол мэдээлэл бол Сангийн яаман дээр байгаа. Тэгээд энэ мэдээллүүдийг бол нэгтгээд танд тухайлан өгье. Мэдээж нөгөө төрийн өмчтэй холбоотой ер нь өмч үнэгүйдэж байгаа асуудал бол яригдаж байгаа. Тийм учраас бид нар бол энэ Төрийн өмчийн хороо одоо бол нөгөө Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар гэдэг байгууллага дээрээ төрийн болон орон нутгийн өмчийн нэгдсэн бүртгэлийг нэгтгээд Засгийн газар бол мэдээж энэ өмчүүдийг хооронд нь шилжүүлэх, олон нийтэд худалдаалах эсвэл бусад зохих арга хэмжээнүүдийг авах ийм эрх нь байгаа учраас бид нар Засгийн газар дээр шийдвэрлээд явдаг. Тэрнээс биш мэдээж өмчийг хэн нэгэн агентлаг байгууллага бол дураараа шилжүүлэх ийм эрх байхгүй. Энэ ч утгаараа бол бид удахгүй Их Хурлаар хэлэлцэх энэ төрийн өмчийн компанийн хуулийн дараа төрийн болон орон нутгийн өмчийн хуулийн шинэчлэлийг оруулж ирнэ. Энэ үеэрээ ер нь бол Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар бол төрийн болон орон нутгийн өмчийн нийт бүртгэлээ хариуцдаг, түүнийгээ бусад тэр төрийн өмчийнхөө компаниуд дээр хяналтаа тавьдаг.

Ингээд одоо үр ашигтай, үр ашиггүй байдлаар нь захиран зарцуулах гэж байгаа дээр нь хяналт тавьдаг. Цаашлаад Засгийн газрын тохируулагч агентлагийн хуваарь Зөрчлийн хуулийг хэрэгжүүлэх ийм эрх бүхий субъект улсын ерөнхий байцаагчийн эрхтэй, ийм агентлагийн статустайгаар үйл ажиллагааг нь салгаж өгөхгүй бол нэг талаасаа харахаар өмч хянаад байгаа юм шиг, нөгөө талаас нь харахаар ТӨК-удын ашигт ажиллагааг сайжруулах гээд менежмент хийгээд байгаа компани шиг харагдаад байгаа учраас бид нар энийг 2 салгаад хуулийн хүрээнд зохицуулж байгаа юм.

Тийм учраас энэ төрийн өмчийн компанийн хуулийн дараа төрийн өмчийн болон орон нутгийн өмчийн хууль ч батлагдана. Тэнд бол ерөөсөө ТӨБЗГ-ын эрх үүрэг маш тодорхой болж байгаа. Үйл ажиллагааны ашигт ажиллагааг нэмэгдүүлэх ажил бол нөгөө нийт одоо төрийн өмчийнхөө компаниудад байгаа үйл ажиллагааг нь зөвхөн оперешин төслийг нь хариуцах төрийн өмчийн корпорацийн засаглал руу шилжинэ. Ингэснээрээ чиг үүргийн давхардал арилна. Үүний үр дүнд Төрийн өмчийн хороо тэр Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар бол яг өмчийн хяналтаа тавьдаг, хяналтаа хэрэгжүүлдэг бие даасан Засгийн газрын тохируулагч агентлаг болно оо гэдгийг хэлье ээ.

Д.Амарбаясгалан: Гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа.

Санал хураалтыг асуудлуудаа хэлэлцэж дуусаад нэгдсэн байдлаар санал хураалтаа явуулъя.

Дараагийн асуудалд оръё. Стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордын төрийн эзэмшлийн хувь хэмжээг орлуулах тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийн эцсийн хэлэлцүүлгийг явуулна аа.

Төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх Эдийн засгийн байнгын хорооны танилцуулгыг Улсын Их Хурлын гишүүн, Улсын Их Хурлын дэд дарга Бөхчулууны Пүрэвдорж байна танилцуулна. Индэрт урьж байна.

Б.Пүрэвдорж: Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газраас 2024 оны 12 дугаар сарын 25-ны өдөр Улсын Их Хуралд яаралтай хэлэлцүүлэхээр өргөн мэдүүлсэн Стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордын төрийн эзэмшлийн хувь хэмжээг орлуулах тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийн анхны хэлэлцүүлгийг Улсын Их Хурлын чуулганы 2025 оны 1 дүгээр сарын 9-ний өдрийн нэгдсэн хуралдаанаар явуулж нэгдсэн хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Эдийн засгийн байнгын хороонд шилжүүлсэн.

Эдийн засгийн байнгын хороо 2025 оны 1 дүгээр сарын 9-ний өдрийн хуралдаанаараа тогтоолын эцсийн хэлэлцүүлгийг явуулж чуулганы нэгдсэн хуралдааны анхны хэлэлцүүлгээр санал хурааж, олонхын дэмжлэг авсан саналуудыг тогтоолын төсөлд нэмж тусган төслийн агуулга зарчмыг алдагдуулахгүйгээр үг хэллэг, дэс дарааллыг жигдлэх хууль зүйн техникийн засваруудыг хийж тогтоолын төслийн эцсийн хувилбарыг та бүхэнд хүргүүлсэн болно.

Эдийн засгийн байнгын хороо тогтоолын төслийн эцсийн хэлэлцүүлгийг явуулах үед ажлын хэсгийн ахлагч, Улсын Их Хурлын гишүүн Б.Пүрэвдорж Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.2.3 дахь заалтыг үндэслэн тогтоолын төслийн 3 дахь заалт буюу стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордын АМНАТ-ийн 30-аас доошгүй хувийг олборлолтын сөрөг нөлөөлөлд өртөж байгаа аймаг сумдын орон нутгийн хөгжлийн санд хуваарилах эрх зүйн үндсийг бий болгох чиглэлээр холбогдох арга хэмжээ авахыг Монгол Улсын Засгийн газар Оюун-Эрдэнэд даалгасугай гэснийг тогтоолын төслөөс хасах горимын санал гаргасныг хуралдаанд оролцсон гишүүдийн 3-ны 2-оос буюу 80 хувиар саналаар дэмжлээ.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ

Стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордын төрийн эзэмшлийн хувь хэмжээг орлуулах тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх Эдийн засгийн байнгын хорооны танилцуулга, саналын томьёолол, эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн төслийг хэлэлцэн шийдвэрлэж, тогтоолын төслийг баталж өгөхийг та бүхнээс хүсье ээ.

Анхаарал тавьсанд баярлалаа.

Д.Амарбаясгалан: Ажлын хэсгийг танилцуулъя.

Ням-Осорын Учрал Монгол Улсын сайд ЗГХЭГ-ын дарга, Дорждэрэмийн Цолмон ЗГХЭГ-ын дэд дарга, Лхагвабаярын Энх-Амгалан Эдийн засаг, хөгжлийн

яамны Макро эдийн засгийн бодлогын газрын дарга, Бямбарагчаагийн Тэлмүүн Сангийн яамны Татварын бодлогын газрын дарга, Нармандахын Жамъянхүү ХЗДХЯ-ны Хууль зүйн бодлогын газрын дарга, Гүнчинсүрэнгийн Намчинсүрэн Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны Эрдэс баялгийн бодлогын газрын дарга, Туулхангайн Ганбаатар Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны Хуулийн хэлтсийн дарга, Цэрэндоржийн Уранчимэг Байгаль орчин уур амьсгалтын өөрчлөлтийн яамны Байгалийн нөөцийн бодлогын хэрэгжилтийн газрын дарга, Цагааны Өнөрнасан Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны Геологи уул уурхайн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын ахлах шинжээч, Шаравдоржийн Ганхуяг АМГТГ-ын дарга, Зэнээмядарын Батбаяр Усны газрын дарга, Сэрээнэндоржийн Төгсжаргал Татварын Ерөнхий газрын Том татвар төлөгчийн газрын дарга, Гунаажавын Манлайжав Цөмийн энергийн комиссын ажлын албаны дарга, Мавогийн Чадраабал Цөмийн энергийн комиссын Ажлын албаны Цөмийн технологийн бодлогын газрын дарга, Энхгэрэлийн Нямдаваа Цөмийн энергийн комиссын ажлын албаны Цөмийн аюулгүй байдлын бодлогын газрын дарга, Сэр-Одын Ган-Очир АМГТГ-ын Хайгуул ашиглалтын газрын дарга, Санжаагийн Наранцогт Эрдэнэс Монгол компанийн гүйцэтгэх захирал, Балжиннямын Гэрлээ Эрдэнэс Монгол Компанийн Хууль, эрх зүйн зөвлөлийн дарга, Лувсаншаравын Наранчимэг Эрдэнэс Монгол компанийн Дотоод хяналт эрсдэлийн удирдлагын газрын дарга, Цэдэнбалжирын Төгсбуян Эрдэнэс Монгол компанийн Геологи, үйлдвэрлэлийн бодлогын газрын дарга, Түмэнжаргалын Төрбадрах Эрдэнэс Монгол компанийн хамтын ажиллагааны хэлтсийн менежер, Бат-Эрдэнийн Хулан ЗГХЭГ-ын даргын зөвлөх, Алтангэрэлийн Мандуул ЗГХЭГ-ын даргын зөвлөх, Лхагвасүрэнгийн Жаргалсайхан ШУА-ийн Хими, хими технологийн хүрээлэнгийн захирал, Доржбалын Далайжаргал Мон-Атом компанийн захирал, Дашдаваагийн Сугарсүрэн Мон-Атом компанийн Захиргааны албаны дарга, Амарсанаагийн Алтанхундага Мон-Атом компанийн ахлах геологич, Дашдоржийн Баярхүү олон улсын харилцааны судлаач профессор, Яндагийн Ганболд Монголын мал эмнэлгүүдийн дундын хоршооны зөвлөх, Монгол Улсын шинжлэх ухааны гавьяат зүтгэлтэн, академич, профессор, Норовын Тэгшбаяр Физикийн ухааны доктор, Ганбатын Мөнхболд Дотоодын хуулийн зөвлөх, Баярбатын Батмандах Дотоодын хуулийн зөвлөх, Зуунайн Шагдарсүрэн Дотоодын хуулийн зөвлөх, Сүхдоржийн Батхүлэг Дотоодын хуулийн зөвлөх.

Улсын Их Хурлын гишүүд Байнгын хорооны танилцуулгатай холбогдуулан намын бүлэгт болон бүлэгт харьяалагдаагүй гишүүдээс урьдчилан ирүүлсэн нэрсийн дагуу асуулт асууна аа. Нийт 5 гишүүн байна.

Нанзадын Наранбаатар гишүүн асуулт асууя.

Н.Наранбаатар: Та бүхэнд өдрийн мэнд хүргэе.

Энэ төсөл дээр бол орон нутгийн харилцаатай холбоотой заалт тусгаж өгсөнд талархалтай байгаа. Тэгээд Байнгын хорооны хурал дээр орон нутагтай холбоотой заалт оруулъя гээд Бадамсүрэн гишүүн зарчмын зөрүүтэй санал гаргаад дэмжигдээгүй. Яг энэ асуудалтай холбоотой биш гэдэг утгаараа тэгээд цаашдаа анхааръя гэдэг байдлаар явж байх шиг байна. Тэгээд уул уурхайтай аймгаас сонгогдсон гишүүний хувьд энэ хөдөө орон нутагт аймаг суманд том төсөл ялангуяа уул уурхайн чиглэлийн ийм төсөл хэрэгжихэд тулгараад байдаг нэг бэрхшээл зовлон бол энэ байгаль орчны асуудал, тэнд байгаа иргэдийн ажил хөдөлмөр эрхлэлттэй холбоотой асуудал суурин газрын тоос шороо агаарын бохирдолтой холбоотой асуудал, усны асуудал гээд л олон асуудлууд тулгарч байдаг юм аа.

Тэгэхээр энэ төсөл дээр орон нутагтай холбоотой заалтууд гэрээ нь тусгагдахаар орж ирж байгаад талархалтай байгаа.

Тэгэхээр хамгийн их уул уурхайн төсөл хэрэгжиж байгаа. Өмнөговь аймгийн хувьд л гэхэд Цогтцэций суманд Тавантолгойн стратегийн орд дээр 3 компани олборлолтын үйл ажиллагаа явуулж байгаа. Тэгээд өнөөдрийн байдлаар тэр харьяа сумынх нь иргэд нь ажилгүй. Мөн байгаль орчин сүйдсэн, олон салаа зам гарсан. Мөн суманд амьдарч байгаа хүмүүсийн эрүүл аюулгүй орчинд ажиллаж амьдрах Үндсэн хуулиар олгогдсон эрх нь зөрчигдсөн. Мөн жилээс жилд энэ уул уурхайд ашиглаж байгаа гүний усыг их хэмжээгээр ашиглаж байгаатай холбогдоод энэ усны хомсдолын асуудал гээд ийм олон асуудлууд байгаа. Мөн тухайн харьяа суманд нь, багт нь иргэдэд, аймагт нь энэ уул уурхайн төслийн үр өгөөж их муу очиж байгаа гэсэн ийм олон асуудлууд бол тулгарч байдаг учраас энэ дээр цаашдаа дараа дараагийн төслүүд хэрэгжүүлэхэд онцгой анхаарах ёстой. Энэ уул уурхай энэ олборлолт хийгдэж байгаа, баялгаа ухуулж байгаа энэ аймаг, сум, тэнд ажиллаж амьдарч байгаа иргэдэд аль болохоор энэ үр өгөөж нь илүү очдог байх зайлшгүй шаардлага байгаа.

Өнөөгийн хуулиар бол ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр, мөн ААНОАТ, хүн амын орлогын албан татварын хувь орон нутагт үлдэж байгаа гэж ярьж байгаа боловч яг одоо хэрэг дээрээ тийм биш ээ. Аймгуудын суурь зардал, сумдуудын суурь зардал орлогыг хасаад л зөрүүг нь шууд татаад авч байх жишээтэй. Тухайлбал Өмнөговь аймаг дээр яаж байна вэ гэхээр зэрэг 1.7 их наяд төгрөгийг нь шууд аймгаас нь улсын төсөвт татаад авчаж байгаа юм. Тэгээд цаана нь одоо нөгөө үлдэж байгаа тэр орон нутаг бүтээн байгуулалтад зарцуулах хөрөнгө мөнгө байхгүй. Жишээ нь Цогтцэций сум гэхэд сургуульгүй, цэцэрлэг хүрэлцээ байхгүй. Одоо ажиллаж байгаа сургуулийн дээвэр нь нураад хүүхдүүд дарж байх жишээтэй. Тэгээд ийм байгаа нөхцөлд цаашдаа бусад аймаг суманд энэ том төслүүд явна гэхэд бол хэцүү шүү.

Өнөөдөр Цогтцэций сум Гурвантэс суман дээр очиж үзээд л энэ уул уурхайг дэмжмээргүй юм байна том төслүүдийг дэмжмээргүй юм байна гэдэг ойлголтыг шууд ард иргэд авахаар ийм байдалтай байгаа.

Тэгэхээр зэрэг би тодруулаад асууя. Энэ уул уурхай цаашдаа төслүүдэд шаардагдах энэ усны асуудлыг 14 мега төсөлд тусгасан. Тэгэхээр энэ ажил одоо энэ зунаас хойш мөрийн хөтөлбөр батлагдсанаас хойш энэ дээр ямар ахицтай ажил хийгдэж байна вэ гэж асуумаар байна аа.

Д.Амарбаясгалан: Ажлын хэсгийн дарга Бөхчулууны Пүрэвдорж гишүүн хариулт өгье.

Б.Пүрэвдорж: Бадамсүрэн гишүүн яг энэ АМНАТ-өөс стратегийн орд бүхий ач холбогдол бүхий уул уурхайн ордоос АМНАТ-ийн 30 хувийг тухайн орон нутаг өгөх тухай санал гаргасан. Тэгэх дээр энэ санал бол маш зөв зүйтэй санал. Тэгэхээр яг энэ зөвхөн стратегийн орд Бадамсүрэн гишүүний хэлээд байгаа зүйл нь бүх уул уурхайн ордоос. Гэтэл энэ зөвхөн стратегийн орд дээр авахаар жоохон өрөөсгөл болоод байна аа.

Тийм учраас энэ асуудал дээр ямар зүйлийг ярьсан бэ гэхээр Наранбаатар гишүүний таны нөгөө ахлаад байгаа уул уурхайн, нөгөө Ашигт малтмалын тухай

хууль байгаа. Тэр хууль дээр хэрвээ хурдан Их Хурлаар орох юм бол тэрэн дээр яг энэ заалтыг оруулж өгье. Аль эсвэл юу гэдэг юм. Төсөв төсвийн тодотгол хийхэд энэ асуудлыг оруулж болно. 2026 оны төсвийн хуулиар бас шийдэж болно.

Учрал сайдын хувьд бол Засгийн газраас энэ Байнгын хорооноос яг энэний дагуу чиглэл аваад тэгээд Засгийн газраас энэ хавар өргөн барих татвар, НДШ-тэй холбоотой энэ хуулиудын төслүүдийг оруулж ирэхдээ яг энэ АМНАТ-өөс 30 хувийг нь орон нутагт олгох энэ асуудлыг зөвшилцөж энүүний хүрээнд шийдэгдэж байгаа, шийдэгдэнэ. Тэгэх дээр ер нь яг одоо энэ төслийн хувьд бол орон нутагтайгаа маш их хамтарч ажиллаж байгаа. Зөвхөн Улаанбадрах суманд гэхэд энэ жил өнгөрсөн жил бол 630 орчим сая төгрөг, хажуу талын Зүүнбаян 300 орчим сая төгрөг энэ тэр гээд хөрөнгө оруулалтууд хий хийгдэж байгаа.

Дээрээс нь энэ төсөл амжилттай явах юм бол зөвхөн Улаанбадрах суманд гэхэд 1 сая долларын орон нутгийн хөгжлийн санд хөрөнгө орох замаар энэ сумын хөгжил дэвшилд бас тодорхой хувь нэмэр оруулна гэсэн ийм зорилттой байгаа. Тэгэхээр таныг яг тэр Ашигт малтмалын тухай хуулийг ажлын хэсгийг ахлаад оруулах үед тодорхой саналуудыг хамтарч энэ орон нутагт хэрэгтэй тухайн сумд болон аймагт хөрөнгө оруулалтыг илүү үр өгөөжийг нь авдаг ийм эрх зүйн орчныг бүрдүүлэх талаар цөмөөрөө хамтдаа ажиллая аа. Баярлалаа.

Д.Амарбаясгалан: Одонтуяа сайд, Усны газрын дарга Батбаяр. Ажлын хэсгийн 14 дүгээр микрофон.

3.Батбаяр: Гишүүний асуултад хариулъя. Усны тал дээр Монгол Улсын хэмжээнд усны нөөцийн жигд хуваарилалтыг бий болгох зорилгоор төсөл хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэх зайлшгүй шаардлагатай байгаа. Энэ хүрээнд Ховд аймгийн Эрдэнэбүрэн суманд усан сан барих ажил эхлэхээр боллоо. Энэ нь эрчим хүчний үйлдвэрлэлээс гадна уур амьсгалын өөрчлөлт буюу мөнх цасны хайлалтыг тогтоон барих цаашлаад Их нууруудын хотгор, Ховд голын байгалийн тэнцвэрт байдлыг хадгалахад маш чухал үүрэгтэй байгаа. Эгийн голын асуудлыг та бүхэн мэдэж байгаа учраас асуудлууд яригдаж байгаа. Энэ нь мөн адилхан Сэлэнгэ мөрөн, Байгаль нуурын байгалийн урсцыг хамгаалах хэвийн байдлыг хангахад чухал байгаа. Яг юунаас хойш 14 мега төсөлтэй холбоотойгоор одоо Хэрлэн тооно, Орхон, Онги төслүүдийг хэрэгжүүлэх замын зургийг зурж Гантөмөр сайдаар ахлуулсан Шадар сайдаар ахлуулсан ажлын хэсэг дээр танилцуулагдахаар бэлтгэж байна. Энэ дээр нарийн танилцуулгыг та бүхэнд хийх болно. Мөн энэ уур амьсгалын.

Д.Амарбаясгалан: Гүйцээж хариулъя. Ажлын хэсгийн 21 дүгээр микрофон.

3.Батбаяр: Мөн уур амьсгалын өөрчлөлтөөс бий болж байгаа мөн уур уул уурхайн үйл ажиллагаанаас бий болж байгаа орон нутгийн иргэдийн усны хангамжтай холбоотой асуудлуудыг шийдвэрлэх зорилгоор 333 нуур санаачилгыг хэрэгжүүлж ажиллахаар энэ дээр уурхайн компаниудтайгаа хамтарч гадаргын усны хэрэглээг нэмэгдүүлэх нийт Монгол Улсын хэмжээнд газрын доорх усны хэрэглээг 90 орчим хувиас 50 хувь руу бууруулах, гадаргын усны хэрэглээг 25 хувьд хүргэх, үлдсэн 25 хувийг саарал усны хэрэглээгээр дэмжихээр ийм төлөвлөгөөтэй ажиллаж байна. Гишүүн болоод мөн ажлын хэсэгт бичгээр төлөвлөлтүүдээ нарийн хүргэж болно оо. Баярлалаа.

Д.Амарбаясгалан: Амгаланбаатарын Ганбаатар гишүүн асуулт асууя.

А.Ганбаатар: Үндэсний баялгийн сангийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулахад дагалдаж оруулсан Ашигт малтмалын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн 1 дүгээр зүйлд 47.2.2, энэ хуулийн 5.3, 5.4, 5.5-д заасан стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордыг энэ хуулийн 47.2.1-д заасан ашигт малтмалын нөөц ашигласны тусгай төлбөрийн хувь хэмжээг тухайн ордын онцлогоос хамаарч Засгийн газар өргөн мэдүүлж Их Хурал тогтооно гэсэн ийм заалтаар өөрчилж оруулж ирж байгаа. Тэгэхээр энэ тухайн ордын онцлогоос хамаарч гэдэг нь өөр өөр ордныхыг 1, 1 удаа тогтоогоод цаашаа бариад явах юм уу. Эсвэл одоо энэ дэлхийн зах зээл дээр байж байгаа үнэ ханш гэдэг юм уу. Нөхцөл байдал өөрчлөгдөх бүрд Засгийн газар маань Их Хуралдаа өргөн мэдүүлээд энэ тусгай төлбөрийн хувь хэмжээ өөрчлөгдөөд явах юм уу? Нэг ийм асуудал байж байгаа юм.

Дараачийнх нь болохоор энэ баялгийн санг төсвийн нөөц төсөв болгож болохгүй гэсэн нэг ийм зарчмын санал байгаа. Өөрөөр хэлбэл энэ сангийн удирдлага төрөөс ангид мэргэжлийн гадаад, дотоодын менежментийн баг оролцсон ийм байвал зүйтэй байна гэсэн санаа байгаад байна. Учир нь юу вэ гэвэл улс төрчид засаг удирдсан сангууд ЖДҮ, ХАА-г дэмжих сан гэх мэтээр асуудалд орооцолдож байсан бас өөдлөхгүй байгаа. Бид нар бүгд мэднэ. Норвегийн баялгийн сангийн тухай. Тэгэхээр Норвегийн баялгийн сан болохоор Сангийн яамныхаа дэргэдэх тусгай банк нь менежментийг нь авч явж байдаг. Тэгээд энэ олон улсын төсөл ашигтай төслүүдэд хөрөнгө оруулалт хийгээд энэ сангийнхаа хөрөнгийг өсгөж явж байдаг.

Тэгэхээр энэ менежментийг хийх ёстой биш үү, хийх байх гэж найдаж байгаа. Уг нь бол зориулалтын банк нь Хөгжлийн банк гэж ойлгож байгаа. Гэтэл Хөгжлийн банк бол ийм чадваргүй гэж харагдаж байгаа. Тэгэхээр энэ дээр ямар бодлого барих вэ?

Сангийн менежментийг ямар менежментийн баг хийх вэ? Ийм 2 асуулт байгаа.

А.Ганбаатар: ЗГХЭГ-ын дарга Учрал сайд хариулт өгье.

Н.Учрал: Энэ хөрөнгө оруулалтын гэрээг хийхэд өөрсдөө бид санхүүгийн схемээ хийх гэж зорьсон. Энэ хүрээндээ энэ санхүүгийн схем дээрээ бол бид яг одоо энэ дэлхийн зах зээлийн тэр спорт ханш фунт тутамд яг хэд байх юм, дотоод өгөөжийн норм нь үнэ фунт тутамд ямар байх вэ гээд ийм тооцооллуудыг гаргасан.

Тэгэхээр энэ ажилласан санхүүгийн баг бол яг л энэ олон улсын санхүүгийн зах зээл дээр ажиллаж байгаа байгууллагуудын жишигтэй нийцүүлээд ийм урт хугацааны үнийн төсөөллүүдийг авсан. Тэгэхээр мэдээж энэ төслийн санхүүгийн моделийг бол яг л нөгөө хувийн хэвшил хөрөнгө оруулалт хийх гэж байгаа бол ямар загвараар явдаг юм бэ гэдэгтэй ижилхэн ийм түвшинд хийсэн. Тэгэхээр мэдээж ийм урт хугацааны гэрээ, хөрөнгө оруулалтын гэрээ бол өөрөө тийм динамик шинж чанартай байна. Энэ ийм урт хугацааны төслийн хувьд бол өнөөдөр л бид нар мэдэгдэж байгаа зах зээлийн үнэ, ТЭЗҮ, эрэлт, нийлүүлэлтийн гол трендүүдийг авч байгаа л өнөөдөр бид яг өнөөдрийн энэ санхүүгийн моделийг барьж байгаа болохоос энэ динамик шинжтэй. Цаашдаа зах зээл дээр ураны үнэ өсөх, буурахад

ямар хөдөлгөөнүүд хийгдэх вэ, тооцоолж болшгүй осол аваар одоо энэ ковид шиг ийм нөхцөл байдал үүсвэл яах вэ гэдгийг эргэж харах ийм зохицуулалтуудыг тусгаж өгсөн.

Гэхдээ яг авч байгаа мэдээллээр бол цаашдаа энэ ураны урт хугацааны үнэ бол тийм өсөх хандлагатай. Харьцангуй бол тогтвортой байх юм гэдгийг олон улсын энэ санхүүгийн байгууллагуудаас авч байгаа мэдээлэл дээр харагдаж байгаа. Тийм учраас бид анх удаа энэ өсөн нэмэгдэх АМНАТ гэдэг ойлголтыг энд оруулж ирснээрээ өсөн нэмэгдэх АМНАТ бол яг ураны зах зээлийн үнэ дээрээ шууд хэлбэлзээд явахаар зах зээлийн ханштайгаа дүйцэж иргэдэд үр өгөөж нь шууд очно оо.

Энэ ч утгаараа түрүүн гишүүдийн яриад байгаа нөгөө орон нутгийн хөгжлийн сан руу суурь АМНАТ-ын 5 хувь, өсөн нэмэгдэх АМНАТ дахиад нэмэгдээд эхлэхээр тэр 65 хувиас үлдэж байгаа АМНАТ бол орон нутгийн санд илүү төвлөрөх нь дамжиггүй. Ингээд бид нар Үндэсний баялгийн сан дээр хэрхэн орлогыг төвлөрүүлэх вэ, хуримтлуулах вэ гэдэг дээр нэгэнт Баялгийн сангийн хуулийг хийчихсэн. Ирээдүй өв сан 2030 он хүртэл ажиллаад, 30 оноос өөрөө са санхүүгийн хэрэгсэл рүү оруулах ийм нөхцөлүүдийг нь бүрдүүлэх ийм хуультай.

Тэгэхээр өнөөдөр Үндэсний баялгийн сан дотроо байгаа ирээдүй өв сан ирээдүй хойчдоо өвлүүлэх тэр ассет менежмент хийх боломжтой сан. Хуримтлалын санг хэрхэн удирдах вэ гэвэл бид нар нэгэнт хуулиараа Монгол банкн дээр байршуулаад ингээд бодлогын хүүтэй тооцоод явж байгаа. Түүнтэй адилхан бол бид нар баялгийн сангийн менежментийг 2030 он хүртэл бэлтгэл ажлыг хангуулах зорилгоор энэ баялгийн сангийн орлогыг төвлөрүүлж байгаа Эрдэнэс Монгол компанийн дэргэд бид нар энэ менежментийг зохион байгуулах олон улсын менежмент оруулах чиглэл рүү ажлуудыг хийгээд явж байна. Үүн дээр Олон улсын тэр сангуудын.

Д.Амарбаясгалан: Мягмарсүрэнгийн Бадамсүрэн гишүүн асуулт асууя.

М.Бадамсүрэн: Уул уурхайн сөрөг нөлөөлөлд өртөж байгаа бүс орон нутагт АМНАТ-ийн төлбөрийн 30-аас доошгүй хувь хуваарилах гэдэг энэ үзэл санааг дэмжиж байгаа Их Хурлын гишүүддээ их баярлалаа.

Ер нь яах вэ энэний утга нь бол тухайн бүс нутгийн иргэд бол энэ олборлолтын сөрөг нөлөөлөлд заавал өртөнө. Байгаль орчин талаасаа, сэтгэл зүй талаасаа. Бусад тэгээд л шороо тоосжилт гээд. Тийм учраас энэ олон улсын хувьд энэ 30-аас доошгүй хувийг нь тухайн бүс нутагт хөрөнгийг нь орон нутгийн хөгжлийн санд нь хуваарилдаг ийм тогтолцоотой. Тэгээд Канадад ийм, Австралид ийм. Тэгэхээр миний хэлээд байгаа зүйл нь энэ бусад Казахстанд гэдэг юм уу ингээд ам АМНАТ-ийн тэдэн хувийг нь авдаг юм байна ингээд. Мөн технологийн хувьд газар доогуур уусган баяжуулах аргаар олборлодог сайн жишгийг бид нар авлаа гэж манай хууль санаачлагчид тайлбарлаж байгаа. Яг үүнтэй адилхан сайн жишгийг бид нар авах нь зүйтэй.

Тэгээд энэ дээр бол ер нь цаашдаа зарчмын хувьд бол Их Хурал бүхэлдээ холбогдох сайд нар энэ агуулгыг дэмжиж, ойлгож, дотоод итгэл үнэмшлийн хувьд ийм 30 хувиас доошгүй хувийг хуваарилах нь зөв юм байна гэдэгт санал нэгдэж байгаад би 1 дүгээрт энэ орон нутгийн ажил амьдралыг иргэдийг нь төлөөлж

байгаагийн хувьд энэ дээр баяртай байгаагаа илэрхийлье. Тэгээд надад 2, 3 асуулт байна.

Байнгын хорооны хуралдаан дээр бас энэ саналаа татаж аваач гэдэг зүйлийг ажлын хэсгийн ахлагчийн зүгээс Пүрэвдорж гишүүний зүгээс санал тавьсан. Энийг татаж авч болдог уу? Энэ хэлэлцүүлэг дээр. Энийг би Их Хурлын Тамгын газраас асууя. Яагаад гэхээр холбогдох сайд нар болон энэ ажлын хэсгийн ахлагчийн зүгээс Их Хурлын гишүүдийн зүгээс ер нь энэ зарчмыг дэмжье ээ. Гэхдээ энэ удаа бол хөрөнгө оруулалтын гэрээнд Францын талтай байгуулах гэрээнд нөлөөлөх гээд байна гэдэг зүйлийг тайлбарлаж энэ дээр нэлээд хэлэлцүүлэг өрнүүлж байгаа учраас энийг бол мэдээж гэж ойлгож байна. Гэхдээ цаашдаа бол энэ зарчмаа дэмжинэ гэдэг ийм зүйлийг ярилцаж Эдийн засгийн байнгын хороон дээр ирэх 7 хоногийн Эдийн засгийн байнгын хорооны хуралдаанаар энэ дээр холбогдох шийдвэрийн төслийг боловсруулж танилцуулахыг Засгийн газарт даалгасан ийм тогтоолын төсөл гаргая гэдэг дээр зарчим дээр тогтсон.

Тэгэхээр энд болох уу гэдгийг би 1 дүгээрт асууя.

2 дугаарт нь энэ суурь АМНАТ гээд 5 хувь байгаа. Энэ 5 хувийн чинь 30 хувь буюу 1.5 хувь нь суурь АМНАТ-ийн 1.5 хувийг л орон нутгийн хөгжлийн санд хуваарилах ёстой хуваарилах асуудлыг л энэ дээр яригдаж байгаа гэдгийг тайлбарлаж хэлэх нь зүйтэй. Өсөн нэмэгдэх АМНАТ болон тусгай АМНАТ-ийн хувьд бол энэ хуулийн үйлчлэл орох уу үгүй юу гэдэг нь тусдаа асуудал байгаа. Тэгэхээр жишээлбэл Дорнод аймагт газрын тосны нэг л талбай дээр бүтээх роялти тооцдог 7,5 хувиар 21 дүгээр талбай дээр. Эндээс жилд 60 тэрбум төгрөг ороход энэний 30 хувийг нь буюу 18 тэрбум төгрөг нь тэр сөрөг нөлөөл өртж байгаа Дорнод аймгийн Матад, Халх гол суманд хуваарилах ёстой хөрөнгө нь 21 аймагт 500, 500 саяар хуваарилагдчихаад байгаа байхгүй юу.

Тэгэхээр сөрөг нөлөөлөлд өртөөгүй бүс нутаг өртсөн бүс нутаг 2-т яг адилхан хэмжээний ийм хөрөнгө оруулалт очихоор тэнд байгаа нутгийн иргэдийн хувьд бол энийг ерөөсөө дэмжихгүй байгаад байгаа нэг гол шалтгаан маань энд оршиж байгаа юм. Түүнээс энийг ерөөсөө орон нутагт заавал илүү мөнгө авах гээд байгаа юм байхгүй. 70 хувийг нь улсын хэмжээндээ хуваарилаад болж байна. 30 хувийг л тухайн орон нутагт нь сөрөг нөлөөлөлд өртөж байгаагийн хувьд байгаль орчныг нөхөн сэргээх, зам харгуй тавих, малчид иргэдийн амьжиргааг дэмжих бэлчээр усанд нь дэмжлэг үзүүлэх хүүхдүүдийнх нь ирээдүйд нь зориулсан ийм зүйл дээр хуваарилъя гээд энэ олон улсын л жишгийг явж байгаа гэдгийг би зориуд энэ дээр хэлэх нь зүйтэй байх гэж бодож байна.

Тэгээд дараагийнх нь асуулт энэ Үндэсний баялгийн сангийн тухай хууль бол ингээд АМНАТ-ийн төлбөрөөс ирээдүй хойч үедээ хадгална. Одоогийн иргэддээ хуримтлалын сандаа төрийн эзэмшлийн 34 хувийг хадгална гэдэг ийм л зохицуулалттай байгаа. Тэгэхээр энэ 2-ын хооронд буюу төрийн эзэмшлийн.

Д.Амарбаясгалан: Энэ 1 дүгээрт нөгөө эцсийн хэлэлцүүлэг дээр орж ирсэн Байнгын хорооны санал байхгүй юу Бадамсүрэн гишүүн. Хувь гишүүний гаргасан санал энэний өмнөх хэлэлцүүлэг дээр татаж авах боломжтой байсан. Одоо Байнгын хороо санал гаргаад ороод ирж байгаа. Хэрвээ татаад авчихвал энэ заалт чинь үлдэнэ л гэсэн үг болчихож байгаа юм. Тамгын газраас энэ дээр тайлбар хийх үү? Байнгын хороо татаад авчихвал тэр 3 дахь заалт чинь хэвээр үлдээд гишүүний

гаргасан санал өмнөх хэлэлцүүлэг дээр босож ирсэн тэр байдлаараа явах болчихож байна л гэсэн үг болж байна шүү дээ.

Хоёр дахь нь ер нь тийм Ашигт малтмалын тухай хуулиараа энэ өөрөө зохицуулагдах ер нь бол энэ манай дотоод татвар. АМНАТ-тай холбоотой дотоодын асуудал гэдэг талаас нь илүү сайн харах ёстой байх.

Тамгын газар Дондогмаа дарга. 12 дугаар микрофон өгье.

Ч.Дондогмаа: Бадамсүрэн гишүүний асуусан асуулттай холбогдуулаад Дэгийн хуулийн холбогдох заалтыг уншиж танилцуулъя аа. Дэгийн хуулийн 41 дүгээр зүйлийн 7 дахь хэсэгт гишүүн, нам, эвслийн бүлэг гаргасан зарчмын зөрүүтэй саналаа нэгдсэн хуралдааны анхны хэлэлцүүлгийн явцад татаж авч болно гэсэн зохицуулалттай.

Одоо бол Их Хурлын тогтоолын төслийн эцсийн хэлэлцүүлгийг хийж байгаа учраас гишүүн саналаа татан авах боломжгүй байгаад байгаа.

Д.Амарбаясгалан: Тэгэхээр Эдийн засгийн байнгын хороо татаж авах эрхтэй гэсэн үг тийм ээ. Санал гаргаснаараа. Гэхдээ татчихсан тохиолдолд энэ заалт хасагдахгүй гэсэн үг байхгүй юу. Тэгэхээр энийг Улсын Их Хурлын гишүүд сая Байнгын хорооны 3-ны 2-ын саналаар хасах нь зүйтэй гэсэн санал орж ирж байгаа. Хасъя гэвэл дэмжинэ гэсэн үг болчихож байгаа юм. Санал хураалт дээр.

Мягмарсүрэнгийн Бадамсүрэн гишүүн тодруулж асууя.

М.Бадамсүрэн: Би энэ ЗГХЭГ-ын дарга Учрал сайдаас болон Уул уурхайн сайдаас хоёулангаас нь хариулт авмаар байна, Сангийн сайдаас. Ер нь энэ хаврын чуулганд багтаагаад энэ Төсвийн тухай хууль, Ашигт малтмалын тухай хууль холбогдох хуулиудад өөрчлөлт оруулж энэ АМНАТ-ийн 30-аас доошгүй хувийг орон нутагт хуваарилах энэ зүйл дээрээ яг одоо нэгдсэн байр суурьтай байж энийг цаашид ер нь хэрэгжүүлбэ гэсэн ийм хүсэл эрмэлзэл байгаа юу энэ. Энэ яагаад гэвэл уул уурхайн төслүүд цаашид Монгол Улсад үр өгөөжөө өгөхөд орон нутгийн сөрөг нөлөөллийг бууруулах энэ олон улсын жишиг юм. Олон улсын сайн жишгийг бид нар авч явахад яг нэг ийм санал, хүсэл зоригийн хувьд нэг байгаа юу. Засгийн газар болоод Уул уурхайн сайд болоод Сангийн сайд. Тэгээд энийг хариулт авъя гэж бодож байна.

Д.Амарбаясгалан: Сангийн сайд Болдын Жавхлан хариулт өгье.

Б.Жавхлан: Бадамсүрэн гишүүний асуултад хариулъя аа. Бид нар нэлээн ярилцсан. Би ойлголцсон л гэж ойлгож байгаа. Одоо бид энэ олон улсын хэлэлцээр тусгайлан хэлэлцээр ярьж байна. Ингээд 2 тал гадна талынхантайгаа хэлэлцээр яриад ингээд нөхцөлүүдээ Их Хурал дээрээ оруулж ирээд дэлхий нийтийн өмнө ил тод хэлэлцэж байгаа ийм үед АМНАТ тойрсон дотоодын асуудал, дотоод хуваарилалтынхаа асуудлыг хэлэлцээр хийж байгаа нөгөө талын барьцаанд аваачиж ингэж хаяад, тэгээд дотоод асуудлаа шийдэх гэж байгаа ийм хэлбэр рүү явж орох аягүй буруу жишиг шүү энэ. Одоо ингээд сайд нараасаа ам мөчгийг нь авна. Тэгээд хавар энэ асуудлыг шийднэ гэдэг бол нэг талаараа техникийн хувьд энэ аягүй буруу жишиг гэж харагдаж байна.

Таны ярьж байгаа зарчим агуулгын хувьд бид нар бүрэн дэмжиж байгаа шүү дээ. Ялангуяа сүүлийн жилүүдэд бид энэ АМНАТ-өөс орон нутгийн хөгжлийн сангаар дамжиж орон нутагт очиж байгаа энэ хуваарилалтыг байнга нэмж байгаа. Хаана илүү орон нутагт энэ уул уурхайн эргэлтэд орж байна тэр хэмжээгээр орон нутагт АМНАТ-ийн болон бусад хуваарилалтууд илүү очиж байдаг. Энэ зарчим руугаа бид нар алхам алхмаараа л явж байгаа. Энэ зарчмыг энэ удаа шийддэг энэнтэй холбож шийддэг асуудал биш. Төсвийн тухай хууль, Ашигт малтмалын тухай хууль гээд өөр энэ чинь тусдаа бие даасан органик хуулиудаар асуудлуудаа шийдээд явна. Харин шийдлүүдээ хэдүүлээ цуг сууж байгаад ярилцъя. Энэ асуудлуудыг ороод ирэхээр нь Бадамсүрэн гишүүн өөрөө бас орон нутагт энэ зовлон жаргалыг сайн мэдэх хүн өөрөө ахлаад энд улс төрийн манлайлал үзүүлээд ингээд явахад бүрэн боломжтой.

Бүгдээрээ энэ дээрээ сууцгаагаад ингээд ажиллая. Харин энэ удаагийн энэ олон улсын гэрээ хэлэлцээр ярьж байгаа энэ юмтай битгий хутгаач гэж хүсэх байна. Тэгээд ч өөрөө Бадамсүрэн гишүүн ойлгосон байна. Хэрвээ татаж болдог бол одоо бас татахад бэлэн болсон байна гэж би ингэж харж байгаа юм. Харин татаж болохгүй юм байна харамсалтай. Тэгэхдээ гишүүд маань энийг ойлгож байгаа учраас одоо энэ санал хураалт дээрээ бүгдээрээ сая Байнгын хороон дээрээ гаргасан. Байнгын хороон дээр дэмжсэнийг нь дэмжээд явчихвал их зөв байна.

Д.Амарбаясгалан: Цэвэгдоржийн Туваан сайд хариулт өгье.

Ц.Туваан: Бадамсүрэн гишүүний асуултад хариулъя аа. Бадамсүрэн гишүүн, Сүхбаатарын Эрдэнэболд гишүүн гээд нэлээн олон гишүүдээс энэ орон нутгаас сонгогдсон гишүүдээс энэ асуудлыг ярьж байгаа. Тэр нь юу вэ гэхлээр сүүлийн үед энэ уул уурхайн салбартай холбоотой ялангуяа энэ орд газрын ашиглалттай холбоотой асуудал бол орон нутаг дээр нэлээн эсэргүүцэлтэй тулгараад явж байгаа. Тэгэхээр энийг шийдэх гарц нь бол ганцхан Монгол Улсад ч биш дэлхий дахинд ер нь энэ тухайн уул уурхай ашиглаж байгаа орон нутгийн удирдлага иргэддээ учраа олох энэ асуудлууд байгаа. Тэгэхээр энэ асуудал дээр бол таны саналыг бүрэн дэмжиж байгаа. Өмнө нь Цөмийн энергийн тухай хууль хэлэлцэх үед Бадамсүрэн гишүүн бусад гишүүд энэ асуудлыг хөндсөн. Өмнөговь аймгаас сонгогдсон Байнгын хорооны дарга Сэддорж, энэ Ашигт малтмалын тухай хуулийн ажлын хэсгийн дарга Наранбаатар нарын гишүүд ингээд энэ асуудлыг хэлэлцээд явж.

Д.Амарбаясгалан: Гүйцээж хариулъя. Туваан сайд.

Ц.Туваан: Салбарын яамны зүгээс энэ асуудлыг 100 хувь дэмжиж байгаа. Тэгэхээр ирэх 7 хоногт манай яаман дээр Наранбаатар гишүүний ахалсан ажлын хэсэг бусад Их Хурлын гишүүд ажиллаж бид нар энэ хуулийн ажлын хэсгийн асуудлаа ярилцана. Энэ үеэр таныг боломж байвал хүрч ирээд манай яаман дээр энэ асуудлыг ярилцаач гэж. Тэгэхээр энэ асуудал дээр тодорхой заалт болгоод оруулахыг яамны хувьд бүрэн дэмжиж байгаа. Ер нь бол манай орны хувьд энэ өмнөх жишгээр алтыг нь аваад авдрыг нь хаядаг гэдэг. Энэ байдал буюу орон нутагт нь энэ уул уурхай ашиглуулсны нөгөө талд нь шууд ашиг нь очихгүй байгаагаас болж эсэргүүцэл нэлээн гарч ирж байгаа. Тэгэхээр ойрд Монгол Улсын Засгийн газар ч тэр энэ асуудал дээр дэмжиж шийдвэрлэх байр суурьтай байгаа гэдгийг албан ёсоор хэлье.

Д.Амарбаясгалан: Агваанлуvsсангийн Ундраа гишүүн алга байна. Батын Батбаатар гишүүн асуулт асууя.

Асуулт давхардсан байна.

Ингээд Улсын Их Хурлын гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа.

Байнгын хорооноос гаргасан зарчмын зөрүүтэй саналын томьёоллоор санал хураалт явуулахаар байгаа. Ирцийн бүртгэлийн нэг санал хураалт явуулаадахъя. Танхимд хэчнээн гишүүд байна. Бусад гишүүдийг танхимд орж ирэхийг урьж байна. Зарчмын зөрүүтэй саналаа хураачихъя гэж бодож байна.

Бүртгэлийн санал хураалт явуулъя.

51 гишүүн танхимд байгаа юм байна. Санал хураах боломжтой ирц байна. Тэгвэл зарчмын зөрүүтэй нэг санал байгаа.

Зарчмын зөрүүтэй, саналыг дэмжсэн, эсрэг байр суурьтай намын бүлгийг төлөөлж мөн аль нэг нам эвслийн бүлэгт харьяалагдаагүй тус бүр 2 хүр хүртэл гишүүн үг хэлж болохоор байгаа. Үг хэлэх гишүүний нэр ирсэн үү? Урьдчилж нэр ирээгүй байна. Үг хэлэх гишүүн алга байна. Тэгвэл зарчмын зөрүүтэй саналын томьёоллыг уншиж танилцуулъя.

Стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордын төрийн эзэмшлийн хувь хэмжээг орлуулах тухай Монгол Улсын Их Хурлын тогтоолын төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томьёолол.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.2.3-д заасны дагуу хураалгасан санал.

Эдийн засгийн байнгын хороо дэмжсэн санал.

Төслийн 3 дахь заалтыг хасах. Санал гаргасан. Эдийн засгийн байнгын хороо.

Эдийн засгийн байнгын хорооны дэмжсэн саналыг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя аа.

Санал хураалт

61 гишүүн буюу 64.9 хувиар Байнгын хорооны санал дэмжигдлээ.

Зарчмын зөрүүтэй саналын томьёоллоор санал хурааж дууслаа.

“Стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордын төрийн эзэмшлийн хувь, хэмжээг орлуулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн эцсийн хэлэлцүүлгийг явуулж дууслаа. Энхцэцэг гишүүн санал хураалт явах гэж байна.

Эцэслэн батална. 64 гишүүнээр санал хураалт шийдэгдэнэ.

“Стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордын төрийн эзэмшлийн хувь, хэмжээг орлуулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг батлах санал хураалт явуулна.

Батлуулах тогтоолын төслийн хувилбарыг Эдийн засгийн байнгын хороо бэлтгэн гишүүдэд тараасан байна аа.

Санал хураалт.

Байнгын хорооны саналаар “Стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордын төрийн эзэмшлийн хувь хэмжээг орлуулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг баталъя гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулна аа.

Санал хураалт.

Эцэслэн баталж байгаа юм. Тэгэхдээ тогтоол учраас танхимд байгаа гишүүдийн олонхоор батлагдана. Гишүүд хариуцлагатай оролцож байна. Баяр хүргэе.

Тогтоолын төсөл батлагдлаа.

Улсын Их Хурлын гишүүд ажлын хэсэгт талархал дэвшүүлье ээ.

Эдийн засгийн байнгын хорооны дарга Сэддорж санал гаргаж байна.

Р.Сэддорж: Дарга энэ тогтоолын эцсийн найруулгыг сонсьё гэсэн саналтай байна.

Байнгын хорооны даргын саналаар Байнгын хорооноос гаргасан саналын дагуу батлагдсан Улсын Их Хурлын тогтоолын эцсийн найруулгыг сонсьё.

“Стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордын төрийн эзэмшлийн хувь хэмжээг орлуулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын эцсийн найруулга дээр саналтай гишүүд байна уу? Алга байна. Эцсийн найруулгыг сонссонд тооцлоо.

Өмнөх санал хураалтууд явагдахаар байгаа.

5 дахь асуудал буюу “Жамсрангийн Самбуугийн алдар гавьяаг мөнхжүүлэх түүний мэндэлсний 130 жилийн ойг тэмдэглэн өнгөрүүлэх талаар авах зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн зарчмын зөрүүтэй саналуудаар санал хураалт явуулна.

Нийт 4 санал байна. ТББХ-ны дэмжсэн санал.

1.Төслийн гарчгийн Жамсрангийн Самбуугийн алдар гавьяаг мөнхжүүлэх түүний мэндэлсний 130 жилийн ойг тэмдэглэн өнгөрүүлэх талаар авах зарим арга хэмжээний тухай гэснийг Засгийн газарт чиглэл өгөх тухай гэж өөрчлөх.

Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Сүхбаатарын Эрдэнэболд. ТББХ-ны дэмжсэн саналыг дэмжье гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя аа.

Санал хураалт.

65 гишүүн буюу 69.1 хувиар санал дэмжигдлээ.

Сангийн сайд Болдын Жавхлан дэмжсэнээр протоколд тэмдэглүүлэх хүсэлт гаргаж байна.

2.Төслийн тэмдэглэх хэсгийн Бүгд Найрамдах Монгол Ард Улсын АИХ-ын Тэргүүлэгчдийн дарга асан Бүрэн эрхт Элчин сайд 20 дугаар зууны төр нийгмийн нэрт зүтгэлтэн Жамсрангийн Самбуугийн мэндэлсний 130 жилийн ой тохиож байгаатай холбогдуулан түүний алдар гавьяаг мөнхжүүлэх зорилгоор гэснийг хасах.

Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Сүхбаатарын Эрдэнэболд ТББХ-ны дэмжсэн саналыг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулна аа.

Санал хураалт.

67 гишүүн буюу 71.3 хувиар санал дэмжигдлээ.

Батбаярын Жаргалан гишүүнийг дэмжсэнээр протоколд тэмдэглэе.

3.Төслийн 1 дүгээр заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“1.БНМАУ-ын Ардын Их Хурлын тэргүүлэгчдийн дарга асан, хөдөлмөрийн баатар, Онц бөгөөд Бүрэн эрхт элчин сайд, төр, нийгмийн нэрт зүтгэлтэн Жамсрангийн Самбуугийн мэндэлсний 130 жилийн ой 2025 онд тохиож байгаатай холбогдуулан түүний алдар гавьяаг мөнхжүүлэх зорилгоор дараах арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг Монгол Улсын Засгийн газар /Л.Оюун-Эрдэнэ/-т даалгасугай:

1/Нийтээр тэмдэглэх баярын болон тэмдэглэлт өдрүүдийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.2-т заасны дагуу Жамсрангийн Самбуугийн мэндэлсний 130 жилийн ойг тэмдэглэх өдрийн товыг тогтоож, ойг тэмдэглэн өнгөрүүлэх бэлтгэл ажлын төлөвлөгөө, үйл ажиллагааны хөтөлбөр баталж, зохион байгуулах үүрэг бүхий ажлын хэсэг байгуулан ажиллуулах;

2/Жамсрангийн Самбуугийн Монгол Улсын нийгэм, эдийн засгийг хөгжүүлэх, олон улсын харилцааг бэхжүүлэх, энх тайвныг сахин хамгаалах, төрийн албыг төлөвшүүлэхэд гүйцэтгэсэн үүрэг, түүний амьдрал, үйл ажиллагааг олон нийтэд сурталчлан таниулах ажлыг зохион байгуулах;

3/ойг тэмдэглэн өнгөрүүлэх арга хэмжээнд шаардагдах зардлыг санхүүжүүлэх арга хэмжээг хууль тогтоомжид заасан эрх хэмжээний хүрээнд шийдвэрлэх.” Төрийн байгуулалтын байнгын хорооны дэмжсэн саналыг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя.

Санал хураалт.

64 гишүүн буюу 68.1 хувиар санал дэмжигдлээ.

4.Төслийн 2 дугаар заалтын үүрэг болгосугай гэснийг даалгасугай гэж өөрчлөх санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Сүхбаатарын Эрдэнэболд. ТББХ-ны дэмжсэн саналыг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя аа.

Санал хураалт

67 гишүүн буюу 71.3 хувиар санал дэмжигдлээ.

Зарчмын зөрүүтэй саналын томьёоллоор санал хурааж дууслаа.

“Жамсрангийн Самбуугийн алдар гавьяаг мөнхжүүлж түүний мэндэлсний 130 жилийн ойг тэмдэглэн өнгөрүүлэх талаар авах зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр ТББХ-нд шилжүүллээ.

15.30 цагт

Дараагийн санал хураалтыг явуулъя.

Зургаа дахь асуудал. Байнгын хорооны саналаар “Батлан хамгаалахын техник тоног төхөөрөмж болон технологи шилжүүлэх тухай Монгол Улсын Засгийн газар, Япон улсын Засгийн газар хоорондын хэлэлцээр”-ийг соёрхон баталъя гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулна аа.

Нийт гишүүдийн олонх 64-өөр.

Санал хураалт.

Санал хураалтыг цуцалъя. Соёрхон баталъя гэж саналын томьёоллоор санал хураалт явуулъя аа.

Санал хураалт.

71 гишүүн буюу 75.5 хувиар санал дэмжигдлээ.

Улсын Их Хурлын нийт гишүүний олонх дэмжсэн тул Батлан хамгаалахын техник, тоног төхөөрөмж болон технологи шилжүүлэх тухай хэлэлцээр соёрхон батлах тухай хуулийн төслийг эцэслэн баталсанд тооцлоо.

Улсын Их Хурлын гишүүд, ажлын хэсэгт талархал дэвшүүлье ээ.

15.32 цагт

Дараагийн асуудалд оръё.

8 дахь асуудал. Үндэсний баялгийн сангийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг явуулна аа.

Төслүүдийн анхны хэлэлцүүлгийг явуулсан талаарх Эдийн засгийн байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн, Улсын Их Хурлын дэд дарга Бөхчулууны Пүрэвдорж танилцуулна.

Индэрт урьж байна.

Б.Пүрэвдорж: Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газраас 2024 оны 12 дугаар сарын 25-ны өдөр Улсын Их Хуралд яаралтай хэлэлцүүлэхээр өргөн мэдүүлсэн Үндэсний баялгийн сангийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслийн хэлэлцэх эсэх асуудлыг Улсын Их Хурлын чуулганы 2024 оны 12 дугаар сарын 26-ны өдрийн нэгдсэн хуралдаанаараа хэлэлцэн шийдвэрлэж төслийг анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Эдийн засгийн байнгын хороо болон холбогдох бусад Байнгын хороонд шилжүүлсэн. Монгол Улсын Их Хурлын 2024 оны 338 дугаар захирамжаар хуулийн төслүүдийг Байнгын хорооны болон чуулганы нэгдсэн хуралдаанд хэлэлцүүлэгт бэлтгэх, санал, дүгнэлтийн төсөл боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгийг байгуулж ажлын хэсгийн ахлагчаар Улсын Их Хурлын гишүүн, Улсын Их Хурлын дэд дарга Б.Пүрэвдорж, бүрэлдэхүүнд Улсын Их Хурлын гишүүн Б.Баярбаатар, Г.Тэмүүлэн, А.Ариунзаяа, Б.Батбаатар, О.Батнайрамдал, Ж.Баярмаа, Ш.Бямбасүрэн, Г.Ганбаатар, Х.Ганхуяг, Б.Найдалаа, У.Отгонбаяр, Д.Пүрэвдаваа, П.Сайнзориг, Х.Тэмүүжин, Б.Уянга, Г.Уянгахишиг, Да.Цогтбаатар, С.Цэнгүүн, Ө.Шижир, Б.Энхбаяр, С.Эрдэнэбат нар ажиллалаа.

Эдийн засгийн байнгын хороо 2025 оны 1 дүгээр сарын 27-ны өдрийн хуралдаанаараа дээрх хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлгийг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39 дүгээр зүйлд заасныг баримтлан явуулж, дараах санал, дүгнэлтийг гарган та бүхэнд танилцуулж байна аа.

Байнгын хорооны хуралдаанаар хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг явуулах үед Улсын Их Хурлын гишүүн М.Бадамсүрэн орон нутгийн хөгжлийн санд хуримтлагдсан мөнгөн хөрөнгөөс эрчим хүчний төсөл хөтөлбөрүүдийг санхүүжүүлэх мөн уур уурхайн салбараас төвлөрүүлсэн орлогоос ХАА-н салбарт хөрөнгө оруулалт хийхэд чиглэсэн бодлогуудыг Монгол Улсын Засгийн газар хэрэгжүүлэхээр төлөвлөсөн эсэх, стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын нөөц ашигласны тусгай төлбөрийн үндсэн хувь хэмжээг хэвээр үлдээх талаар асуулт асууж хариулт авлаа.

Байнгын хорооны хуралдаанаар хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлгийг явуулах үед Улсын Их Хурлын гишүүн Г.Уянгахишиг Ашигт малтмалын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 1, 2, 3 дугаар зүйлүүдийг нэгтгэж өөрчлөн найруулах гэсэн зарчмын зөрүүтэй санал гаргасныг хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Үндэсний баялгийн сангийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг

явуулсан талаарх Эдийн засгийн байнгын хорооны санал дүгнэлт, зарчмын зөрүүтэй саналын томьёоллын хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг та бүхнээс хүсье ээ.

Анхаарал тавьсанд баярлалаа.

Д.Амарбаясгалан: Ажлын хэсгийг танилцуулъя. Ням-Оосорын Учрал Монгол Улсын сайд, ЗГХЭГ-ын дарга Дорждэрэмийн Цолмон ЗГХЭГ-ын дэд дарга, Лхагвабаярын Энх-Амгалан Эдийн засаг, хөгжлийн яамны Макро эдийн засгийн бодлогын газрын дарга, Бямбарагчаагийн Тэлмүүн Сангийн яамны Татварын бодлогын газрын дарга, Нармандахын Жамъянхүү ХЗДХЯ-ны Хууль зүйн бодлогын газрын дарга, Гүнчинсүрэнгийн Намчинсүрэн Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны Эрдэс баялгийн бодлогын газрын дарга, Туулхангайн Ганбаатар Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны Хуулийн хэлтсийн дарга, Санжаагийн Наранцогт Эрдэнэс Монгол компанийн гүйцэтгэх захирал, Балжиннямын Гэрлээ Эрдэнэс Монгол компанийн Хууль эрх зүйн зөвлөлийн дарга.

Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан намын бүлэг болон бүлэгт харьяалагдаагүй гишүүдээс урьдчилан ирүүлсэн нэрсийн дагуу асуулт асууна аа.

Нийт 10 гишүүн байна. Аюушийн Ариунзаяа гишүүн асуулт асууна.

А.Ариунзаяа: Үндэсний баялгийн сан, хуримтлалын сан байгуулах, мөн түүнчлэн олон улсын туршлагыг судлах ажил бол маш удаан хугацааны явцад байсан. Одоо жишээлбэл Монголын төр засгийн зүгээс төлөөлөгчид Сингапур Норвегт маш олон танилцах айлчлалуудыг зохион байгуулсан байдаг аа. Ерөнхий сайд Оюун-Эрдэнэ түүний кабинет яг энэ түүхэндээ бол яг энэ баялгийн сан хуримтлалын санг байгуулсан гэдэг автор болоод яг энийг байгуулж чадсан ийм кабинет болж байгаа. Ерөнхий сайд Оюун-Эрдэнэ Хэрэг эрхлэхийн сайд байхдаа Сингапур болон Норвегт яг энэ танилцах айлчлалыг хийгээд дээрээс нь яг Ерөнхий сайдаар ажиллаж байхдаа 2021, 2022 онд Сингапурт айлчлал хийхэд би Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд байхдаа хамт явж байсан. Тэгээд ингэхдээ яг энэ хуримтлалын нэгдсэн санг байгуулах ажлыг Сингапуртай хамтран ажиллах гэрээ хэлэлцээрийг байгуулж байсан. Энэ хуримтлалын нэгдсэн санг байгуулах урьдчилсан ажлуудыг ч гэсэн Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яаман дээр хийгдээд яг хэрэгжиж байгаа хуулийнхаа дагуу тэтгэврийн даатгалын 17 хувийн шимтгэлээс 2 хувийг нь яг бодитой мөнгөн хэлбэрээр нь хуримтлуулж бодит энэ хуримтлалын сангийн тогтолцоог нь хагас хуримтлалын сан тогтолцоог нэвтрүүлээд явж байгаа.

Бидний энэ баялгийн сан болоод энэ хуримтлалын сан Норвег болон Сингапурын нэг холимог тогтолцоонд орчхоод яг аль нэг улсынхаа классик тэр зарчмаараа батлагдаагүй хэдий ч эхлэл нь ингээд ямар ч байсан зөв тавигдаад явж байгаа юм аа.

Цаашид зүгээр яг энэ хуримтлалын сан, баялгийн сангаа яг тэр классик загвараар нь хөгжүүлэх хэрэгтэй шүү гэдэг саналыг хэлэх гэсэн юм. Тэгээд энэ нь бол тухайн үедээ Учрал сайд Сингапур руу явахад хамт яг энэ провид энд фандын туршлагыг хамтдаа яг харж байсан. Сингапур улсын хувьд 1955 онд энэ хуримтлалын санг байгуулаад, тэгээд 13 жил хуримтлуулж байгаад орон сууц эрүүл мэнд боловсрол, мөн түүнчлэн дээрээс нь тэтгэвэрт зарцуулах энэ боломжийг нь нэмэгдүүлж байсан. Манай баялгийн сан болон хуримтлалын сан, хуримтлалын сан

тусдаа тэтгэврийн даатгалын 2 хувийг тусад нь нэг байгаад тусдаа менежменттэй байх гээд байна. Баялгийн сан нь бол орон сууц боловсрол, эрүүл мэндэд зарцуулагдаад ингээд тусдаа байх гээд байна. Гэтэл баялгийн сангаасаа жишээлбэл орон сууц, эрүүл мэнд, орон сууц, боловсрол, эрүүл мэнддээ зарцуулахгүй хүн өндөр настны тэтгэвэртээ гарахдаа хуримтлалын сан баялгийн сангаа нийлүүлээд өндөр насны тэтгэвэр дээрээ энэ авдаг байх зарчмыг хэрэгжүүлэх боломжтой юу?

Цаашдын энэ классик загвар руу нь оруулах тал дээр ямар төлөвлөгөөтэй байгаа вэ? Та энийг дараа дараагийн өөрчлөлтүүдээрээ оруул. ЗГХЭГ-ын дарга Ням-Осорын Учрал сайд хариулт өгье.

Н.Учрал: Энэ 4 дүгээр сард батлагдсан Үндэсний баялгийн сангийн хууль яг амилж байна л даа. 4 дүгээр сард батлагдаад 12 сарын сүүл гэхэд 480 тэрбум төгрөг хуримтлагдаад яг иргэн болгонд хадгаламж хэлбэрээр харагдаж байна гэдэг бол маш том дэвшил. Ингээд Ирээдүйн өв санг бол бид нар нөгөө Үндэсний баялгийн сангийн хуулиар 2030 он хүртэл ирээдүй үр хойчдоо өвлүүлэх байдлаар хадгалаад түүнийг бол цаашдаа яг одоо энэ санхүүгийн хэрэгсэлд оруулах цаашлаад яг тэр Сингапурын тэр сорернити фандын жишгээр бол хуримтлал үүсгээд түүний өгөөжийг нэмэгдүүлэх ийм үйл ажиллагаануудыг зохион байгуулах шаардлагатай. Үүнийг бол олон улсын жишгээр мэдээж цалинтай нь уяж байна. Жишээ нь одоо нийгмийн даатгалын шинэчлэлийн хүрээнд бид нар тэтгэврийн шинэчлэлийг эхлүүлэхдээ 2 хувийг хуримтлал шилжүүлэх ийм эхлэл тавьсан. 2 хувь хуримтлал шилжээд эхэлнэ гэдэг бол нөгөө төлсөн нийгмийн даатгалынхаа шимтгэлээр эргээд тэр тэтгэвэрт гардаг тогтолцоо руу шилжихгүй бол өнөөдрийн яг одоо идэвхтэй ажиллаж байгаа ажилтан албан хаагчдын залуучуудынх нь тэр цалингаас төлж байгаа даатгалаар тэтгэвэрт гарагчдыг шууд төлөөд байх юм бол 3 хүний тэтгэврийг нэг хүн барагдуулна гэх юм бол энэ чинь нийгмийн даатгалыг төлөх сонирхолтой иргэд гэж байхгүй болно шүү дээ.

Тийм учраас бол яг олон улсын жишгийн дагуу бид нар бол 2030 оноос хойш бол энэ баялгийн сан бол яг ийм тэтгэврийн сан хэлбэр рүү ажиллаж байж л яг иргэний карман руу орох юм билээ. Тэрнээс биш бол бид цаашдаа нийгмийн даатгал чинь өөрөө татвар шиг дарамт хэлбэрээр иргэдэд хүрээд байх юм бол өөрчлөлт гаргахгүй. Тэгэхдээ энэний эхлэлийг тавьсан. Тэгэхээр Үндэсний баялгийн санг бол цаашдаа ирээдүйн өв сан ч бай, хуримтлалын сан ч бай ер нь цаашдаа санхүүгийн хэрэгсэл рүү оруулдаг. Цаашлаад бол яг олон улсын бирж дээр гарсан шаардлагатай хувьцааг авдаг, үнэт цаас авдаг, ингээд хөрөнгө мөнгө босгодог чиглэл рүү явж байж иргэн өөрөө төлсөн шимтгэл нь яг тэр байгалийн баялгаас олж байгаа хуримтлалтай нь хамтдаа өгөөж нь өөрт нь ирдэг байдал руу шилжинэ. Үүнийг олон улсад тэр эрүүл мэндтэй боловсролтой уясан, орон сууцтай нь уясан. Тэгэхээр ажил хийж байвал сайхан амьдарч болдог, ажил хийж байвал эрүүл мэндийн үйлчилгээ авдаг, ажил хийж л байх юм бол боловсролын үйлчилгээ авдаг энэ системийг бий болгох гэж л энэ баялгийн сангийн хууль батлагдсан. Эхлэл тавигдаад юутай ч хуримтлал бий болж байна. Цаашдаа энэ өгөөжийг нэмэгдүүлэхийн төлөө л Засгийн газар ажиллах болно.

Д.Амарбаясгалан: Аюушийн Ариунзаяа гишүүн тодруулж асууя.

А.Ариунзаяа: Бид хагас хуримтлалын тогтолцоо руугаа шилжих эхлэлийг нь нийгмийн даатгалын багц хуулиудаараа тавьчихсан. Яг одоо 17 хувийн тэтгэврийн

шимтгэлийн 2 хувь нь бодитоор хуримтлагдаад тухайн шимтгэл төлж байгаа хүний нэр дээр нь бодит мөнгөөрөө нэгдсэн нэг дансанд явж байгаа. Энэ жилийн хувьд 219 орчим тэрбум төгрөг төвлөрөөд байгаа гэсэн ийм мэдээлэл байгаа. Тэгэхээр энэ жил болгон нэмэгдээд явна гэсэн үг. Тэгэхээр баялгийн сан болон энэ хуримтлалын сангийнхаа менежментийг уг нь хамтад нь нэгдсэн төрийн биш мэргэжлийн кастадион байгууллагаар явуулах нь их чухал юм гэдгийг онцолж хэлмээр байна аа. Бид нар бол бас төрдөө итгэх итгэл нь яг энэ хөрөнгө оруулалтын менежмент дээр бол бас их нэлээд унасан учраас кастадион нэгдсэн 1 удирдлагатай байвал уг нь их илүү зөв зохистой юм гэдгийг хэлье. Мөн түүнчлэн гадаад улсын дэд бүтэцтэй эхлээд нь хөрөнгө оруулдаг түүнийхээ хувийг Засгийн газрын бондоороо дамжуулдаг энэ хөрөнгө.

Д.Амарбаясгалан: Учрал сайд нэмж хариулъя.

Н.Учрал: Ариунзаяа сайд сайд байхдаа энэ 2 хувийн хуримтлалыг шилжүүлэх хуулийн хэрэгжилтийг нь хангуулж эхэлсэн. Энэ том дэвшил. Гэхдээ яг үнэндээ бас Ариунзаяа сайдаа энэ Монголбанкн дээр энэ хуримтлалын сангийн хөрөнгө мөнгийг төвлөрүүлээд иргэд хүсэлт гарвал Монголбанкнаас шийдээд явахгүй бол яг үнэндээ айгаад байх юм аа. Энэ нөгөө манай хэдэн нөхдүүд чинь нөгөө нийгмийн даатгалын санг самардаг шиг, дахиад одоо самарчихвал нөгөө баялгийн сан ч үгүй, юу ч үгүй болчих эрсдэлтэй учраас энийг бол тэр хуулийнх нь дагуу 30 хувь хүртэл хатуу бариад Монголбанкны дэргэд нь байлгаад явахгүй бол нэг өглөө сэрсэн чинь нөгөө Нийгмийн даатгалын сан дээр найрладаг шиг найрлачих нөхдүүд их олон байна аа.

Тийм учраас ер нь хэдүүлээ жоохон хариуцлагатай тэгээд л ил тод болгоод л ингээд л хянаад л явж байсан нь одоохондоо бол зөв байх л гэж бодож байгаа.

Д.Амарбаясгалан: Аюушийн Ариунзаяа гишүүн дахин тодруулга авъя.

А.Ариунзаяа: Яах вэ бид нар өмнө нь гаргасан алдаа энэ хөрөнгийн зах зээл хөгжөөгүй болон банкнуудын эрсдэлээс болж яг нийгмийн даатгалын сангийн нэр хүнд нэлээд унасан нь ойлгомжтой. Гагцхүү бид бол яг энэ хөрөнгийн менежментээ бас хуулийнхаа дагуу зөв зохистой хийж арвижуулах чиг үүргээ хэрэгжүүлэхгүй л бол яг одоо зүгээр тэр хуримтлалын сангаасаа гадна зүгээр нийт нийгмийн даатгалын сангийн энэ чөлөөт үлдэгдэл нь өөрөө хаана байна вэ гэхээр төрийн сан дээр байгаад байгаа юм. Төрийн сан бол өөрөө ядаж л бодлогын хүүнээсээ давсан тухайн жилийн инфляцтайгаа уялдуулж нэмэгдүүлж байж иргэдийн төлж байгаа энэ шимтгэлийг үнэ цэнийг нь алдагдуулахгүй байх ийм үүргийг хүлээж байгаа юм аа.

Тэгэхээр өнөөдөр биш юм гэхэд алсдаа нэгдсэн нэг бодлоготой байгаасай. Олон улсын биш юм гэхэд ядаж мэргэжлийн кастодион байгууллагууд өөрсдөө энэ асуудлыг хариуцдаг байгаасай, улс төрчид энэ шийдвэрт нь битгий ордог байгаасай гэдэг ийм саналыг хэлж байгаа юм аа.

Д.Амарбаясгалан: Санал хэллээ. Отгоншарын Батнайрамдал гишүүн асуулт асууна.

О.Батнайрамдал: Баярлалаа. Үндэсний баялгийн сангийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах талаар бид бүхэн ярилцаж байна.

Тэгэхээр Монгол Улс бол байгалийн баялаг арвинтай. Экспортын 95 хувиас ерөөсөө л гаднаас орж ирж байгаа долларын урсгалыг л тэр чигээрээ л бид нар уул уурхайгаас бүрдүүлж байгаа юм. Тэгэхээр өнөөдөр бид нар энэ баялгийн сан сая Ариунзаяа гишүүн ч ярьж байна. Хуримтлалын сан энэ бүхэн ерөөсөө бидний хийх гээд байгаа зорих гээд байгаа зүйл ерөөсөө энэ газрын доорх баялгийг Үндсэн хуулиар олгосон тэр эрхийн хүрээнд бид нар шударга хуваарилж чадах уу үгүй юу л гэсэн асуулт байгаа.

Баялгийн сангаар дамжуулж бид нар ард түмэндээ шударга хуваарилж чадах уу, энэ алхмыг хийж чадах уу? Эсвэл яг л урд өмнө нь давтагдсан нэг хэдэн эрх ашигт, хэдэн компанид хуваарилаад дуусга. Олон жишээ байгаа шүү дээ. Эрдэнэтийн 49 хувиас эхэлнэ. Эрдэнэс Тавантолгой энэ уул уурхайг дагасан томоохон төмөр замын дэд бүтцүүд байна. Яг одоо ч гэсэн бас нэлээн сэдэв болоод байгаа энэ Ачит ихтийн асуудал ч юу байгаа юм. Уул уурхайн салбарт дэд сайдын хувьд 3 жил ажилласан.

Тэгэхээр энэ салбарын өнцгөөс би зүгээр нэг та бүхэнд нэг жишээ өгье гэж байгаа юм. Эрдэнэт үйлдвэр сүүлийн 40 жил Монгол Улсыг тэжээж ирсэн бүгдээрээ саалийн үнээ ч гэж янз бүрээр хэлдэг. Энэ Эрдэнэт үйлдвэр тухайн үедээ сувилал эмчилгээнд орлоо ч гэж ярьж байсан бараг Ганбаатар гишүүний хэлдгээр дампуурлаа ч гэж ярьж байсан. Дахиад дараагийн 40 жилдээ Эрдэнэт үйлдвэр Монгол Улсыг тэжээнэ шүү. Хангалттай ордоо нөөцөө баталгаажуулаад авчихсан. Тэгэхээр ийм юм байгаа юм л даа. Эрдэнэт олборлолт хийхээр 2 төрлийн хүдэр гарч байгаа юм. Нэг төрлийн хүдэр нь энэ сульфитын хүдэр энэ баяжуулах фабрик руугаа яваад баяжуулагддаг хүдэр. Нөгөөдөх нь болохоороо үүсмэл орд гэж яриад байгаа юм. Энэ ерөөсөө исэлдсэн хүдэр байхгүй юу. Исэлдсэн хүдрийг ондоо технологи ашиглаж уусган баяжуулж бид нар авдаг. Гэхдээ зүгээр нэг өнцөг хэлье. Энд төрд төлж байгаа АМНАТ тэгвэл энэ нэг уурхайгаас гарч байгаа 2 хүдэр дээр ямар зөрүүтэй байдаг гээч. Эрдэнэт үйлдвэр энэ сульфидын хүдрийг баяжуулаад өнөөдөр 17-оос 18 хувийн АМНАТ төлж байгаа юм. Гэтэл энэ Ачит ихтийн ашиглаад байгаа үүсмэл орд дээр АМНАТ нь 2.5 хан хувь байхгүй юу. 2.5 шүү. Бас л тухайн үедээ улс төржиж бас энэ Улсын Их Хурлаар үүсмэл орд гэж концепц Ашигт малтмалын тухай хууль дээр оруулж ирээд АМНАТ-аа 2.5 хувиар тавиулж авсан. Өнөөдөр бид нар Ораногийн гэрээ ингээд амжилттай байгуулах болчихлоо. АМНАТ-ыг нь бид нар ямар ч байсан 5-аас 19 хувь хүргэж чадаж байгаа. Гэтэл Ачит эхэд зориулсан энэ үүсмэл ордын Ашигт малтмалын тухай хууль дээр оруулсан өөрчлөлт 2.5-хан хувь шүү. Өөр юу 2.5 хувь байдаг гээч. Зүгээр дотооддоо бид нар борлуулж байгаа Багануурын уурхайгаас Шивээ-Овоогийн уурхайгаас дотооддоо борлуулж байгаа хүрэн нүүрс дээр АМНАТ 2.5 хувь байдаг. Өөр гадагшаагаа экспортоор гарч байгаа ямар ч бүтээгдэхүүн дээр ийм бага АМНАТ байхгүй.

Тэгэхээр өөр Ачит ихээс өөр яах вэ урьд нь нэг Эрдмин гээд жижигхэн үйлдвэр анх бүр Ачит ихтээс өмнө байсан. Эндээс өөр үүсмэл орд яг энэ АМНАТ-аар тооцож байгаа өөр ямар ч компани байхгүй байхгүй юу. Тэгэхээр 1 компанид ч ингэж зориулж энэ том хуулиудад өөрчлөлт оруулаад ийм ялгавартай нэг талдаа адилхан нэг уурхайгаас гарч байгаа 2 төрлийн хүдэрт хоорондоо 7, 8 дахин зөрүүтэй ийм АМНАТ тооцдог ийм үйлдэл бид нар ямар ч байсан энэ шинэчлэгдсэн парламент дахиж хийх ёсгүй л гэж үзэж байгаа юм. Энэ нь өөрөө ард нь бол хэдэн зуун сая доллар яригдана. Алдагдсан боломжоор тооцох юм бол энэ чинь.

Д.Амарбаясгалан: Хариулт өгье ЗГХЭГ-ын дарга Ням-Осорын Учрал сайд хариулт өгье.

Н.Учрал: Тийм. Энэ үндэсний баялгийн сангийн хууль дээр болон Ашигт малтмалын тухай хуулийн 5.4, 5.5 стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын орд түүний үүсмэл ордыг ашиглаж байгаа хуулийн этгээдийн төрийн эзэмшлийн 34 хувийг хэрвээ тухайн тэр нөөцийг нь улсын төсвөөс санхүүжүүлж тогтоосон бол 50 хүртэлх хувийг нь төр үнэ төлбөргүйгээр авна гэж. Нэг ёсондоо түрүүн бас энэ гишүүд яриад байна шүү дээ. Байгалийн баялаг энэ бол. Хэн нэгэн бүтээгээгүй.

Тийм учраас байгалийн баялаг чинь үнэлгээтэй. Тэрнийг нь хэрэглээд бизнес хийж байгаа бол ард түмэнд энэ баялгийг хүртэх ёстой. Энэ бол суурь зарчим шүү дээ. Тийм учраас энэ баялгийн сангийн хуулийг хэрэгжүүлэхийн тулд энэ стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордын жагсаалтыг харж үз ээ. Энд бол 16 стратегийн орд байгаа юм байна лээ. Төрийн эзэмшилд 7 стратегийн орд л байгаа. Бусад нь хувийн эзэмшилд байгаа. Тэгээд нөөц нь тогтоогдчихсон. Тэгээд энд хэлэлцээр хийе гэж байгаа юм. Хэлэлцээр хийхэд юу саад болоод байна вэ гэвэл тусгай АМНАТ-аар эсвэл бүтээгдэхүүн хуваахаар орлуулаад явах гэхээр тусгай АМНАТ-ын босго нь 5 хувь. Энэнээс илүү нэмэгдүүлж болохгүй шүү гээд хуультайг бид өнөөдөр Баялгийн сангийн хууль энэ ашигт малтмалын дагасан хуулиар өөрчилж байна. Хэнд зориулаад энэ нэг 5 хувь гээд босго тавьчихдаг юм. Нөгөө талд тусгай АМНАТ-аа 10 хувь өгч болно гээд байхад манай хуулиар 5 илүү бид нар авахгүй гээд суучихдаг. Тэгээд энэ уул уурхайн салбар чинь эдийн засгийг бүрдүүлж байгаа гол салбар. Гэхдээ энэ бол арай юм байна лээ шүү ер нь бол. Миний хувьд бол нөгөө уул уурхай, уран байтугай хүрз, шуудуу машин тэрэг юу ч байхгүй учраас би чинь өөрөө нэг ийм нөгөө ахмад бөхийн хажууд нэг дүлий цэрэг болохоор дүлий л байна л даа.

Тийм учраас би тэр нөхдүүдтэй нэг хэл амаа ололцохдоо их муу.

Тийм учраас энэ дээр бол зүгээр их хамтдаа энэ баялгийн сангийн хуулиа амилуулаад авъя л гэж ингэж л зориод байгаа юм. Тийм учраас Засгийн газрын зүгээс стратегийн орд эзэмшиж байгаа компаниудтай хэлэлцээ хийнэ. Ачит эхтэй хийнэ. Ачит эхт бол стратегийн орд. Түүн дотроо үүсмэл орд шүү, хэлэлцээ хийнэ. Хэлэлцээ хийхдээ бид нар аль аль талдаа вин вин гэдэг зарчмыг барина. Бид санхүүгийн шинжээч нараа томилно, хуулийн багийг томилно, ингээд энэ баг бол санхүүгийн схемээ гаргана. Монголын ард түмэнд аль нь ашигтай вэ гэдэг санхүүгийн модель дээрээ суурилна. Манай энэ орчин цагийн залуучууд өөр болчихсон байна. Хэнтэй ч ямар ч түвшний хэлэлцээр хийнэ. Хэн ч тэгж 1 хулхидуулаад чадуулаад байхгүй юм байна лээ.

Тийм учраас мэргэжлийн хүмүүсийг өөдөөс нь хэлэлцээрт оруулна. Ингээд эргээд эцсийн үр дүнд та бүхний өөрчилсөн энэ хуулийн хүрээнд тусгай АМНАТ-аар орлуулсан бол иргэний хуримтлалын дансанд энэ хуримтлал шилжинэ. Ингэсэн цагт ард түмэн байгалийн баялагтаа жинхэнээсээ эзэн болох бололцоо бүрдэнэ ээ.

Д.Амарбаясгалан: Амгаланбаатарын Ганбаатар гишүүн асуулт асууя.

А.Ганбаатар: Би түрүүн асуусан асуултын 2 дугаар асуултад хариулт аваагүй. Ерөнхийдөө бол энэ баялгийн сангийн менежментийг хэн хийх юм бэ гэдгийг тодруулж өгөөч гээд байгаа юм л даа. Маш товчхондоо Ариунзаяа гишүүний

хэлээд байгаа тэр саналтай зарчмын санал нэг байгаа юм. Мэргэжлийн баг нь энийг удирдаад гол нь хуримтлуулахаас нөгөөтээгүүр нөгөө төсөл хөтөлбөрүүдэд хөрөнгө оруулалт хийж өсгөх талыг нь хэн хариуцах юм бэ. Тэгэхээр Монгол банк яах вэ. Хяналтаа тавьж болно. Нөгөө өсгөх талд нь бирж талд нь оролцоод том том төслүүдийг судлаад хөрөнгө оруулалт хийгээд буцаад энэ хөрөнгөө арвижуулах талд нь гадна дотнын мэргэжлийн багаа зоож өгөхгүй юм уу. Тэгээд дандаа нөгөө сайд, Монголбанк гээд харьяа байгууллагууд хариуцчихаар улс төрийн нөлөөлөл нь үүсээд энэ сан чинь өөрөө цаашдаа төсвийн нөөц төсөв болчихгүй байгаа л гэж бодоод байна л даа.

Тухайлбал тэр ирээдүй өв сангийн АМНАТ-ийн 65 хувийг төвлөрүүлнэ гэж байгаад 40 болгоод багасгачихсан байсан хүүхдийн мөнгө эд нар руу явчихсан шүү дээ. Тэгээд үнэхээр энэ баялгийн сан эхэлж байгаа бол ирээдүй одоо байгаа иргэд ирээдүйн иргэддээ ийм боломж олгох гэж байгаа бол энийг өсгөх ёстой шүү дээ. Тэгэхээр энэ өсгөдөг менежментийн тийм баг нь байх юм уу байвал ямар хүмүүс байх юм бэ гэж асууж байгаа юм аа. Баярлалаа.

Д.Амарбаясгалан: ЗГХЭГ-ын дарга Ням-Осорын Учрал хариулт өгье.

Н.Учрал: Үндэсний баялгийн сангийн хуулиар бол яг тэр одоо энэ хуримтлалын сангийн ч бай ирээдүй өв сангийн ч бай энэ зохицуулалтуудыг Монгол банкн дээр хяналтад байлгаж байна. Энэ И Монгол дээр харагдаад байгаа тэр 138 мянган төгрөг гээд одоо бага юм шиг мөртөө харагдаад байгаа мөнгө бол бид энэ жил стратегийн орд эзэмшиж байгаа нэг эхнэ 2-оос 3 компанитай бол хэлэлцээр хийнэ ээ. Аль аль талдаа ашигтайгаар ард түмэнд ашигтайгаар хийнэ.

Ингэснээр энд баялгийн сангийн орлого нэмэгдэнэ. Үүний дараа иргэн та энэ хадгаламжид байгаа хуримтлалын мөнгөө орон сууцад зарцуулах уу, эрүүл мэндэд зарцуулах уу, боловсролд зарцуулах уу гэдгийг сонголтоо хийнэ сонголтоо хийнэ. Эсвэл хадгалаад үлдээд банкны бодлогын хүүгээр үржүүлээд явах уу гэдгээ сонголтоо хийнэ. Ийм л хэлбэр лүү шилжинэ. Тэгээд одоо цаашдаа бол баялгийн сантай сая 5 компани орлого бүрдүүлэхэд 480 тэрбум болдог болсон бол жишээ нь хувийн хэвшил стратегийн орд эзэмшиж байгаа буруу биш шүү дээ. Гол нь тогтвортой үйл ажиллагаа явбал ард түмэнд тэр байгалийн баялгийн хувь хишгийг нь хүртээж байх ёстой. Тэгвэл тэр компаниудаас надад хэдэн төгрөгийн хуримтлал ирэв ээ? Жишээ нь Эрдэнэтийн үүсмэл орд тэр Ачит эхээс надад энэ жилийн 12 сард хэдэн төгрөгийн хуримтлал ирэв гэдгийг иргэн хардаг болох юм бол Ачит эхийн захирал хэн байхаас үл хамаараад хүндэтгэнэ шүү дээ. Энэ нөхөр чинь миний хуримтлалын санд мөнгө хийгээд ашигтай ажиллуулж байна шүү дээ гэж. Тэгээд энэ төрийн өмчит энэ хэдэн энэ уул уурхайн компаниудынхаа захирлуудын нэр хүндийг өсгөхгүй бол болохоо болилоо шүү дээ.

Цаашдаа ард түмний эрүүл мэндэд боловсролд, орон сууцад зарцуулах хуримтлалыг нэмэгдүүлж чадаж байгаа компанийн захирлыг гудамжаар алхаад явахад нь алга ташдаг болмоор байна шүү дээ. Тэгэхгүй бол бүгдээрээ харахаар энэ чинь хулгайч гэж хараад байна шүү дээ. Тэгэхээр цаашдаа төрийн өмчийн компаниудыг чадалтай, мэдлэгтэй, боловсролтой, хэлэлцээ хийж чаддаг, санхүүгийн өндөр мэдлэгтэй хүмүүс удирддаг цаг ирээд миний ард түмний баялагт энэ эзэн ингээд хуримтлалыг нэмэгдүүлж байна гэдгийг хүндэтгэж ийм хэлбэр рүү шилжинэ. Тэгэхээр үндэсний баялгийн сан бол цаашдаа бол хуримтлал нэмэгдээд эхлэхийн хэрээр бид энэ нөгөө ассет менежмент хийх шаардлага үүснэ. Одоо бол

хөрөнгө оруулалтын санг бол хөрөнгө оруулалтын хуулиараа хөрөнгө оруулалт менежментийн компани л удирддаг. Тэгэхээр хомкоор нь удирдуулах ёстой шүү дээ. Тэгээд хөрөнгө оруулалт менежментийн компани өөрөө төлөвлөгөөгөө гаргаад удирддаг ийм зөв жишиг рүү явахгүй бол нөгөө олон улсын жишгээс гажсан ийм гаж тогтолцоогоор хүн болгонд тохируулсан ингээд 2.5-аар АМНАТ аваад авъя. Тэндээс нь АМНАТ авъя. Угаасан нүүрсээ эцсийн бүтээгдэхүүн гэж үзчихье. Уран дээр бол шар нунтаг эцсийн бүтээгдэхүүн биш шүү гээд. Тэгээд тэрийг нь хөндчихье гэхээр тэнд нэг хэсэг бүлэг нөхдүүд байдаг. Наадхыг чинь дийлэх юм уу хэдүүлээ энэ тэр гээд. Нэг ийм л юм яриад байгаагаар л олон жил явчихсан юм байна шүү дээ. Тэгээд энийг л өөрчлөх л ёстой.

Д.Амарбаясгалан: Хүрэлбаатарын Булгантуяа гишүүн асуулт асууя.

Х.Булгантуяа: Баялгийн сан 3 сангаас бүрдэж байгаа юм. Ирээдүйн өв сан. Тэр нь ашигт малтмалаас. Өнөөдөр орж байгаа орлогоос тодорхой хувь нь. Бид нар ирээдүйдээ хадгална. Нөгөөдөх нь хуримтлалын сан, нөгөөдөх нь хөгжлийн сан байгаа юм. Хуримтлалын сан дээр өнгөрсөн оны сүүлээр 495.6 тэрбум төгрөг. Ирээдүйн өв сан дээр 789 тэрбум орчим төгрөг одоо байх шиг байна. Хөгжлийн сан дээр 500 орчим тэрбум төгрөг Хөгжлийн банкаар дамжуулж хөгжлийн чиглэлийн томоохон стратегийн төсөл хөтөлбөрүүдэд хөрөнгө оруулалт хийнэ гэж байгаа юм.

Тэгэхээр би нэг хэд хэдэн асуултууд асуух гэсэн юм.

Нэгдүгээрт, хуримтлалын сангийн И Монголиа дээр ингээд гардаг болчихсон нь аягүй сайхан байна аа. Би нийт хүмүүсийг ер нь ийшээ ороод нэг ямар ТӨК Эрдэнэс Монголын нэгдэл компани хэдэн төгрөг төвлөрүүлж бай гэдгийг би нэг хараасай гэж бодож байгаа юм. Нөгөө сайн муу хэлээд байгаа төрийн өмчит хэдэн компаниуд маань цагаа туулахаар хамгийн ихийг төвлөрүүлжээ. Хамгийн томыг Эрдэнэт үйлдвэр 273 тэрбум төгрөг, дараа нь Эрдэнэс Тавантолгой 200 тэрбум төгрөг тэгээд Монросцветмет гээд Дарханы төмөрлөгийн үйлдвэр хүртэл 13.6 тэрбум төгрөг. Эрдэнэс Оюу Толгой 342 сая төгрөг л төвлөрүүлсэн байна. Энийгээ ингээд нийт ард түмэнд хуваагаад ингээд нийт хуваарилсан дүн нь нэг би болон манай хүүхдүүдэд гэхэд хүн тус бүрд 138993 мянган төгрөг хүн болгонд хуваарилсан юм шиг байна. Нэг хүүхдийг минь орхичхож араас нь хөөцөлдөх ёстой юм шиг байна. Тэгээд ингээд харахаар уг нь бид нар бас баялгийн санг нийт ард түмэн яг ороод ирэх жил жишээлбэл Эрдэнэс үйлдвэрийн ТӨК-ийн захирал үүнээс багыг төвлөрүүлэх юм бол бид нар асуудал ярих ёстой. Ард түмэн яагаад энэ компанийн төвлөрүүлсэн мөнгө маань багасчхав бид нар дээр ирэх мөнгө багасчхав гэж араас нь хөөцөлддөг болно гэсэн үг. Нөгөө талдаа нөгөө хуримтлалын сангийн маань бид нар бас хууль дээрээ зарцуулах нэг хэдхэн зүйл заалтууд байгаа шүү дээ. Одоо Учрал сайд энэ өргөн барьж байгаа өөрчлөлт дээр яг хуримтлал хуримтлалын сан руу орох эх үүсвэрийг нь бид нар 2 төрлөөр нэмж байгаа тиймээ.

Тэгэхээр та бүгдийн тооцооллоор саяхан бид нар төсөв батлахад 507.1 тэрбум төгрөг хуримтлалын санд төвлөрнө гэсэн. Тэгэхээр одоо та бүгдийн тооцооллоор хэд болж 1 дүгээрт нэмэгдэх вэ?

Хоёрдугаарт хуримтлалын санд одоо би хуримтлалын сангийнхаа мөнгийг харахаар нөгөө талдаа тооцсон өгөөж харагдах ёстой. Энэ чинь байгуулагдаад нэлээн хэдэн сар болчихлоо. Энэ хооронд банкны хүү шиг дор хаяж бодлогын хүүгээр нэмэгдэх ёстой гэсэн. Энэ өгөөж нь яагаад нэмэгдэхгүй байна вэ? Одоо

ингээд аваачаад нөгөө хүүгээрээ нэмэгдэхгүй бол бас иргэдийн дунд ахиад л хардалт сэрдэлт төрөөд явчихна.

Дээрээс нь нэмээд оны сүүлээр энийг ОУБ-аар ер нь менежментийг нь хийлгэнэ гэсэн. Энэ хэзээ бий болох вэ? Ахиад дээрээс нь энэ хуримтлалын сангийн зарцуулах журам маань ер нь гарсан уу? Би одоо иргэн хүний хувьд би хүүхдийнхээ боловсролд, эрүүл мэндэд зарцуулмаар байгаа бол яг яаж зарцуулна гэсэн үг вэ? Энэ хууль чинь аль хэдийн хэрэгжээд эхэлчихсэн. Энэ оны 1 сарын 1-ээс миний зарцуулах эрх бас нээгдэх ёстой байхгүй юу? Тэгэхээр миний тэр зарцуулах эрх хаана нээгдэж байна вэ? Ямар журмаар би юу яах вэ? Тэгээд хүүхэд маань, жишээлбэл ханиад хүрээд байна гэхэд хүүхдээ аваад надад хүүхдийн амралт сувилалд амрах өвөл бидэнд 1 сарын эрх нээгдэх үү, үгүй юу? Би тэрүүнийг олж мэдмээр байна. Нөгөө талдаа бид нар уг нь үүнийгээ дагаад 2 хувиа мөнгөжүүлнэ гэсэн. Мөнгөжүүлэх яг албан ёсоор энийг нь төсөв дээр тавьж өгөөгүй юм шиг байна аа. Төсвийн тодотгол дээр ч. Сая 2025 оны төсөв дээр ч. Ингэхээр л нөгөө нэг том хуулиуд маань батлагдсан хуулиудын маань реформууд нэг талдаа нөгөө еэвэнгийн 2 тал шиг л юм харуулаад баймаар байгаад байна л даа. Тэгэхээр нөгөө талдаа бас тэгмээргүй байх юм. Бас нэг асуулт нь Хөгжлийн банкны 500 тэрбум төгрөгийг саяхан Хөгжлийн банкны шинэ захирал аймаар мэдэгдэл хийсэн шүү дээ. Ер нь манайд бараг ажиллах хүн олдохгүй юм шиг байна аа. Шийдвэр гарган хүн болгон шүүхийн шийдвэрээр шоронд орчих гээд байгаа болохоор гээд.

Тэгэхээр 500 тэрбум төгрөгөө та бүхэн маань Хөгжлийн банк маань үүнийгээ захиран зарцуулж чадах уу? Зоримгоор энэ шийдвэрийг чинь Хөгжлийн банкны хүмүүс чинь гаргаж чадах уу? Энэ нөгөө талдаа энэ шийдвэр гаргаж байгаа хүмүүсээ та бүхэн маань яая гэж бодож байгаа юм бэ? Хэрвээ ингэвэл нээрээ л энийг чинь зүгээр нэг төрийн албаны бараг цалингаар ямар амьтан тэнд очоод дараа нь.

Д.Амарбаясгалан: Учрал сайд хариулт өгье.

Н.Учрал: Ер нь энэ төрд ажиллаж байгаа хүмүүс бүгдээрээ болохоо бүтэхээ больчихсон гэдэг энэ ойлголтоос бид нар салах ёстой. Нэг үхрийн эвэр доргихоор мянган үхрийн эвэр доргино гэдэг шиг зарим нэг ийм бусармаг нөхдүүдийн үйлдлээс болж энэ төрийн албыг бүхэлд нь ингэж хулгайч дээрэмчин шиг харагдуулж болохгүй. ТӨК-удтай ч гэсэн ашигтай орлоготой компаниа аваад явж байгаа сайн менежерүүд зөндөө байна. Төрийн төлөө хоёргүй сэтгэлээр зүтгэж байгаа олон залуучууд байна. Энэ хүмүүсийг яаж ажиллах нөхцөлөөр хангах вэ л гэдэг бидний хамгийн чухал асуудал.

Тийм учраас төрд чадалтай мэргэжилтэй хүмүүсийг яаж авч үлдэх вэ гэдэг ийм л дээсэн дөрөөн дээр бид нар байна л даа. Нэг хүнийг ч гэсэн ажил хийж байгаа хүнийг ч гэсэн яаж авч үлдэх вэ алдчих гээд байна шүү дээ. Тийм ч учраас бол энэ Хөгжлийн банкны үүсээд байгаа асуудал яг үнэн. Тийм ч учраас энэ Хөгжлийн банкан дээр менежментийн хувьд цогц шинэчлэл хийгээд экспорт импортын банк болгож өөрчлөх энэ менежментийн шинэчлэл хийж байна. Тэгээд ер нь нэг балансаа юмаа цэвэрлээд ингээд нэг урагшаа хараад явъя. Тэгээд Эдийн засаг, хөгжлийн яамны дэргэд энэ Хөгжлийн банк одоо эдийн засгийн бодлогоо барьж байгаа яамны дэргэд ажиллаж байгаа.

Тийм ч учраас Хөгжлийн банкан дээр өөрчлөлт бас гарна гэж бодож байна.

Дээрээс нь Үндэсний баялгийн сангийн хуулийн энэ хөгжлийн сан хэрвээ нөгөө ашигтай гарах юм бол тийшээ хуримтлал хийнэ. Тэгэхээр энэ хөгжлийн санг ч гэсэн цаашдаа төсөл хөтөлбөрийг санхүүжүүлдэг Хөгжлийн банкныг зориулалтаар нь ажиллуулахын тулд бол цогц шинэчлэл хийх гээд Эксим банк болгох ийм менежмент хийгээд эхэлсэн гэдгийг бас хэлье. Тэр зарцуулах журам бол Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамнаас оруулж ирээд баталсан. Яг иргэний хуримтлалын дансыг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам хариуцах хуультай. Ингээд Сангийн яам бол Ирээдүйн өв сан дээр хяналт тавиад явдаг. Тэгээд ингээд эхлэхээр бид нар энэ баялгийн сан дээр салбар дундын зохицуулалтыг хангах үүднээс Ерөнхий сайдын захирамжаар энэ баялгийн сангийн хэрэгжилтийг хангах орлогыг төвлөрүүлж нэмэгдүүлэх чиглэлээр Хэрэг эрхлэх газрын даргаар ахлуулсан ийм ажлын хэсэг байгуулсан.

Эрдэнэс Монголын дэргэд бол Чингис хаан Үндэсний баялгийн сан менежментийн нэгж ажиллаж байна. Энэ менежментийн нэгж бол бэлтгэл хангаад цаашдаа одоо яг тэр хөрөнгө оруулалт менежментийн компаниар удирдлага шинэчлэлийг хийнэ. Уул уурхайн бус компаниудаа төрийн өмчийн корпорац гээд бусад компаниудыгаа нэгдэж нийлүүлээд давхардсан чиг үүргүүдийг арилгах сая шинэчлэлийг эхлүүлчихлээ. Энэ хавар одоо ингээд төрийн өмчийн компанийн хуулиа баталчихна. Засаглал нь ил тод болно. Энэ Үндэсний баялгийн сангийн хууль дээр, хууль хэрэгжсэний үр дүнд энэ 5 компанийн төвлөрүүлсэн хуримтлалаас иргэн болгонд яг энэ И Монгол дээр харагдаад байгаа 138 мянга бол Монгол банкны бодлогын хүү 10 хувиар тооцогдоод нэмэгдсэн дүн.

Тэгэхээр цаашдаа иргэн болгон сонголтоо хийнэ гэсэн үг. Би одоо.

Д.Амарбаясгалан: Учрал сайдад нэмж минут өгье.

Н.Учрал: Тэгэхээр энэ 138 мянга бол бодлогын хүүг тооцсон дүн. Тэгээд цаашдаа бол энэ бодлогын хүүгээ аваад ингээд үүнийгээ аль ч зүйлд зарцуулахгүйгээр ингээд хадгалаад явах сонголтыг нь иргэдээс И Монголоор авдаг болох бэлтгэлийг хангаж байна. Эсвэл эрүүл мэнддээ, боловсролдоо, орон сууцдаа ингээд сонголтоо хийнэ. Ирээдүйн өв сан дээр ч гэсэн одоо анх удаа энэ ураны гэрээн дээр өсөн нэмэгдэх АМНАТ орчхож байгаа учраас хүссэн хүсээгүй орон нутгийн сан ч нэмэгдэнэ, тэр ирээдүйн өв сангийн ч хуримтлал нэмэгдэнэ. Цаашлаад тогтворжуулалтын сангийн хуримтлал ч нэмэгдэнэ.

Ураны гэрээн дээр бол гэрээний дагуу бол нөгөө АМНАТ-өөс авах тэр орлого бол АМНАТ бол өөрөө 2028 оноос уурхай ашиглаж эхлэх үеэс яригдана. 2031 оноос 10 хувийн ноогдол ашиг яригдана гэсэн үг. Тэр хүртэл АМНАТ гэдэг ойлголт мэдээж байхгүй. 2028 оноос бид харин ашиг хүлээхгүйгээр шууд тусгай АМНАТ-ийг аваад суурь АМНАТ, өсөн нэмэгдэх АМНАТ-уудыг тооцоод явахаар тусгай АМНАТ.

Д.Амарбаясгалан: Булгантуяа гишүүн тодруулж асууя.

Х.Булгантуяа: Тэгвэл энэ хууль батлагдсанаар 2025 онд хуримтлалын сан бол улсын төсөв батлуулсан 507.1 тэрбум төгрөгөөс бол нэмж нэмэгдэхгүй юм байна гэж ойлголоо. Зөв үү 1 дүгээрт.

Хоёрдугаарт хуримтлалын сан 1 дүгээрт нэгэнт л ийм мөнгөтэй болчихсон юм бол энэ нөгөө И Монголиа дээр харагдах байдлаа нэг сайжруулаад эхний үлдэгдэл

нь бараг уг нь 138993 мянган төгрөг байх ёстой байх. Тэгээд өгөөжүүд нь тооцсон өгөөжүүд нь яг харагдах ёстой байх. Тэгэхгүй бол энэ чинь банкны аппликэйшн дээр ороход ядаж нэг хүү нь харагдаж байдаг шүү дээ. Одоо энэ дээр орохоор надад Монгол банк, хариуцаж байгаа мөртөө ядаж ямар ч хүү ямар ч хүү тооцоогүй юм шиг харагдаад байгаа байхгүй юу.

Дээрээс нь нэмээд энийгээ дагаад шууд хуримтлалын нэгдсэн данс дээр та ийм ийм юм зарцуулж болно гээд журмыг нь эс үгүй бол тавиад надад сонголтыг нь ингээд шууд харагдаж болдоггүй юм уу? Тэр журам нь Засгийн газраар батлагдсаныг жирийн иргэд битгий хэл Улсын Их Хурлын гишүүд бид нар нөгөө мэдээлэлд ойрхон байгаа гээд байгаа хүмүүс чинь хүртэл мэдэхгүй болохоор.

Д.Амарбаясгалан: Ням-Осорын Учрал сайд хариулт өгье.

Н.Учрал: Монгол Улсын Засгийн газрын тогтоол гарсан журам батлах тухай Баялгийн сангийн хуулийн 7.1.5-д заасан хуримтлалын дансыг нэрийн дансыг үүсгэх, хөтлөх, сангаас зарцуулалт хийх журмыг бол гаргасан. Энэ журмын хүрээнд бол хуримтлалын нэрийн дансыг яаж үүсгэх вэ? Тэгээд нэрийн дансаа яаж хөтлөх вэ, яаж зарцуулалт хийх вэ гэдгийг тодорхой тусгасан. Тэгэхээр яг таны хэлж байгаа саналын дагуу бид нар бол яг И Монгол дээр бодлогын хүүнд хэдээр тооцогдсон тэгээд хүсэлтүүдийг авдаг болох бэлтгэлийг хийж байгаа юм. Яг эрүүл мэнддээ юм уу, боловсролдоо юм уу, орон сууцанд юм уу эсвэл хадгалуулах уу гээд. Бид нар бол цаашдаа энэ хуримтлалын санг зарцуулах эрхийг нь олгоно. Тэрнээс биш энийг нөгөө ирээдүйн өв сан шиг ирээдүйдээ зарцуул гээд байлгахгүй. Энэ бол өнөөдрийн иргэдэд зориулсан. Тэгэхээр яг энэ хүсэлтүүдээ аваад ингээд зарцуулдаг болгохын тулд 138 мөнгөн төгрөгийн орлогыг нэмэгдүүлэх ажлыг энэ жил хийнэ. Энийг бас Их Хурлыг дэмжихийг бас хүсэж байна.

Д.Амарбаясгалан: Хүрэлбаатарын Булгантуяа гишүүн дахин тодруулж асууя.

Х.Булгантуяа: Иргэдээс бас нэг ийм санал байгаад байгаа юм аа. Бид нар одоо жишээлбэл бүгдээрээ 138 мянган төгрөгтэй байсан ч гэсэндээ Улаанбаатарын утаан дунд амьдарч байгаа даа. Дансандаа байсан ч гэсэндээ бараг 4 их наяд төгрөг өнгөрсөн 2024 оны сүүлээр баялгийн сан дээр байна аа гэсэн мөртөө бид нар цахилгаан станцынхаа мөнгийг энд тэндээс гуйгаад байгаадаа гутамшиг царайлаад байгаа байхгүй юу. Тэгэхээр хүсэх юм бол иргэд бид нар энэ мөнгөө байдаг юм уу? Ийм юманд бид нар хувьцаа эзэмшигч нэг бодлын болоод хөрөнгө оруулаад нийгмийн томоохон төсөл хөтөлбөрүүдийн нэг бодлын хувьцаа эзэмшигч хөрөнгө оруулагч байгаад энэ том асуудлуудаа шийдэхийн төлөө зарцуулж болох уу? Би өнөөдөр 138 мянган төгрөгөө үнэнийг хэлэхэд бараг нэг амралтын газар бүр нэг олигтойхон шиг амралтын газар нэг хонохгүй л юм билээ. Тэгэхээр тийм боломж бололцоо бид нарт үүд хаалгыг байж болох уу гэдэг асуултууд тавиад байгаа юм.

Д.Амарбаясгалан: Учрал сайд хариулт өгье.

Н.Учрал: Ер нь тусгай одоо энэ бид нар энэ баялгийн сангийн хуулиар бол нөгөө тусгай АМНАТ-ыг орлуулж байгаа. Тусгай АМНАТ-аар төрийн эзэмшлийн 34 хувийг. Тэгээд иргэд юу гэсэн бэ гэхээр хуримтлалын дансанд энэ АМНАТ-аар орлуулж байгаа хэсэг чинь орохгүй бол энэ болохгүй ээ.

Тийм учраас бид хуулийг нь өөрчилж байна шүү дээ. Тэгэхээр яг стратегийн ордууд гээд нэг ийм одоо нэг 11 компани дээр гэхдээ л тусгай АМНАТ-ыг хэрвээ 10 хувиар орлуулаад л тооцоолоод явчихвал 1.2 их наяд шууд жилийн дотор бүрдэх бололцоо байгаад л байгаа юм. Ийм тооцоолол гарсан юм. Тэгэхээр энэ 138 мянган төгрөгийг бол бид энэ жил нэмэгдүүлнэ. Нэмэгдвэл хэлэлцээр хийнэ. Тэгээд Их Хуралд оруулж ирээд, яг ингээд тогтоолоо гаргаад батлаад дараа нь шууд АМНАТ-аас нь нөгөө ашиг хүлээхгүйгээр авдаг ийм нөхцөлийг л бүрдүүлээд явчихъя.

Тэгээд 2028 оноос гэхэд л нөгөө уран дээрээс орж ирж байгаа тусгай АМНАТ-ийн төлбөр нь ингээд л гар утсанд нь ороод ирдэг. Ийм болоод эхэлбэл энэ чинь баялгийн сандаа ард түмэн итгэж эхэлнэ л гэж ингэж бодож байгаа.

Д.Амарбаясгалан: Бадамдоржийн Пунсалмаа гишүүн асуулт асууя.

Б.Пунсалмаа: Сайн байцгаана уу энэ өдрийн мэндийг хүргэе. Ашигт малтмалын цөмийн энергийн тухай хуулиар АМНАТ-ийг улсын төсөвт бүрдүүлдэг байсан. Одоо бол стратегийн ач холбогдолтой төрийн өмчийн оролцоотой энэ ордуудад ашигт малтмалын төлбөрийг баялгийн санд хуримтлуулдаг болж байна аа. Энэ бол Монгол Улсын Үндсэн хууль газрын баялаг бүх ард түмний өмч гэдэг энэ заалт зарчим биелж байгаагийн маш тод илрэл. Энэний одоо эхний жишээ нь бол Орано Майнингийн энэ одоо төсөл орж ирж байна гэж ойлгож байгаа. Орано майнинг Оюу Толгойгоос 5 дахин жижиг төсөл гэсэн хэдий ч баялгийн сан дээр шууд сан бүрдүүлж байгаа гэдэг утгаараа энэ маш жишиг уул уурхайн итгэлийг иргэдэд бий болгосон ийм төсөл болж байна аа.

Цаашлаад стратегийн ач холбогдолтой 16 орд байгаа. Эдгээр ордуудаас бол тус ашигт малтмалын тусгай төлбөрийг 7 компаниас нь авч байгаа. Цаад 9 компани энэ тусгай төлбөрийг хэрхэн баялгийн санд бүрдүүлэх вэ? Энэ ашигт малтмалын тусгай төлбөрийг бүрдүүлж байгаа юу гэдэг энэ асуулт байна. Энэ тусгай төлбөр маань цаашлаад бол баялгийн сангаар дамжигдаад хуримтлалын санд орж байгаа. Энэ хуримтлалын сан дээр орохдоо иргэн бүрийн нэрийн дансанд орж байгаа. Энэ нэрийн дансанд орсноороо энэ дансанд орсон энэ баялгийн санг иргэд ямар нөхцөлтэйгөөр, ямар журмаар энэ сангийн зарцуулалтыг иргэд хэрэгжүүлэх вэ гэдэг энэ асуулт. Цаашлаад бол ирээдүй өв санд энэ мөнгийг хуримтлуулаад заавал энэ хуримтлалын сангаар биш ирээдүй өв сандаа бөөгнүүлж байгаад ингээд гадаадын хөрөнгө оруулалтын сангуудаасаа өгөөж хүртээд эргээд хуримтлалын сандаа иргэддээ буцаагаад олгодог байвал зөвхөн уул уурхайн орлого биш энэ гадаадын хөрөнгөөс өгөөж хүртдэг ийм арга механизмаа нэмэгдүүлэх ямар боломж байна вэ гэдэг ийм 2 асуултыг асууя.

Д.Амарбаясгалан: Учрал сайд хариулт өгье.

Н.Учрал: Жишээ нь одоо Эрдэнэс Тавантолгой компани нөгөө БЭТ томилсон цаг үеэс хойш бол борлуулалтынх нь орлого маш их нэмэгдсэн. Тийм ч учраас сая 1072 хувьцааны ноогдол тараах дээр бол бараг энэ чинь ирэх жил бараг 400 мянга хүртэл хэмжээний ноогдол ашиг тараах бололцоо бараг бүрдэж байна уу гэж ингэж харагдаад байгаа юм.

Тэгэхээр ашигтай ажиллаад зөв менежменттэй байвал боломж бололцоо бүрддэг. Тийм ч учраас ер нь бол нөгөө энэ уул уурхайн компаниуддаа ч бай манай Монголчууд их цөөхөн учраас тэгээд яаж ийж явж байгаад л нэг нутаг ус, ах дүү

амраг садан, анги гээд л ингээд л явдаг юм шиг байна л даа. Тэгэхээр энэнээс ангид байхын тулд бол энэ хараат бус байх зарчмыг хангуулахгүй бол нөгөө хөрөнгийн хэрэгсэл, санхүүгийн хэрэгсэлд зарцуул, тэгээд менежментийг нь өөрчил гээд ингэчихээр бас дахиад юу болчихыг мэдэхгүй.

Тийм учраас бол зүгээр ер нь Эрдэнэс Тавантолгой компани дээр бол Засгийн газар шийдвэр гаргаад ирэх 7 хоногийн 3 дахид нөгөө яг тийм стракчерийнх нь хувьд нэлээд өөрчлөлт ороод нэг 6 албан тушаалыг багаар эсвэл хувь хүнээр гэдэг олон улсын ажлын байрны нээлттэй сонгон шалгаруулалт зарлах гэж байгаа. Ер нь олон улсын сайн менежерүүдээр удирдуулъя. Тэгээд гүйцэтгэлийн үнэлгээг нь жил болгон шалгаад явъя гэж. Тийм ч учраас ер нь Үндэсний баялгийн сан нь цаашдаа менежментийг бол олон улсын хөрөнгө оруулалт, менежментийн компаниар удирдуулна. Мэдээж төр лицензээ эзэмшинэ, газрын баялаг болоод төрийн энэ ард түмний өмч. Тийм учраас лицензээ эзэмшинэ. Гэхдээ зөвхөн оперэйшн түвшинд тэр үйл ажиллагааг нь бол өөрсдөө тэр гаднын менежмент аваад явуулах бололцоо байгаа байх аа.

Ингэж байж хараа хяналт нь илүү бодитой байна гэж ингэж үзэж байгаа. Тэгээд тэр эхний асуулт дээр бол тэгээд хуримтлал нэмэгдээд ингээд явж байгаа гэж хэлье ээ.

Д.Амарбаясгалан: Нэмж хариулт. Сангийн яамнаас Тэлмүүн хариулах уу? Энэ ажлын хэсгийн гишүүд чинь хааччихав? Зарим нь.

Эрдэнэс Монголын захирал Наранцогт ажлын хэсгийн 20 дугаар микрофон.

Х.Наранцогт: Энэ хуримтлалын сангийн хөрөнгийн менежмент зарцуулалтын талаар гишүүд маань нэлээд олон удаа асуучихлаа. Тэгэхээр энэ дээр ингээд нөгөө хууль хэлэлцэж байх үеэс авхуулаад бидэнд энийг нэлээн ярьсан юм аа. Тэгэхээр энэ дээр бол одоо ингээд үндэсний баялгийн санг дагалдуулаад гарсан Их Хурлын тогтоолоор Засгийн газарт 2029 онд багтааж энэ цаашдаа энэ хөрөнгийн менежментийг олон улсын энэ баялгийн сангийн жишгийн дагуу боловсруулах тэр эрх зүйн орчныг нь сайжруулж оруулж ирэх. Мөн Засгийн газарт бол энэ хөрөнгийн удирдлагын менежментийн компанийн чадавхыг сайжруулах гэсэн ийм 2 үүрэг даалгавар тогтоолоор өгөгдсөн. Энэ дээр ингээд Засгийн газар ажиллаад эхэлчихсэн. Манай Эрдэнэс Монголын хажууд сая Учрал сайдын хэлсэн Чингис Хаан менежментийн компани энэ бэлтгэл ажлыг хийж боловсон хүчнээ чадавхжуулах.

Д.Амарбаясгалан: Гүйцээж хариулъя.

Х.Наранцогт: Цаашдаа энэ хөрөнгийн менежментийн компани болох чиглэлээр ингээд ажиллаж эхлэхээр ингээд сая өнгөрсөн Засгийн газрын хуралдаан дээр оруулж шийдвэр гарсан байгаа. Зарцуулалтын хувьд бас Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн яамнаас ингээд журам ороод ирсэн бэлэн бусаар зарцуулах.

Тэгэхээр энэ бүх сангийн одоо хөрөнгийн менежмент ч тэр, зарцуулах ч тэр бас тодорхой хөрөнгө хуримтлагдаж байж нэг иргэнд одоо хуримтлагдаж байгаа хэмжээ маань бусад орон сууцынхаа урьдчилгааг төлөх хэмжээнд очих зэрэг гээд бид нарт тодорхой хугацаа шаардлагатай байгаа. Тийм учраас бид нар ер нь энэ 30 он гэсэн энэ онг хууль батлагдах үед энийг ярьсан юм. Хөрөнгийн менежмент ч тэр

нийт дүнгээрээ хуримтлалын сан маань нэг 500 тэрбум төгрөгтэй болж байна. Яг энэ тохиолдолд Монголбанкнаас хүү бодож байгаа нь бараг хамгийн сайн хөрөнгө арвижиж байгаа.

Өнөөдөр бодлогын хүү 10 хувьтай байгаа.

Хоёрдугаарт гишүүд нэг зүйлийг жоохон буруу ойлгоод байх шиг байна. Энэ яамдууд өдөр тутмын хөрөнгийн удирдлага, хөрөнгө оруулалтын чиглэлээр ямар ч шийдвэр гаргах ийм эрх энэ Үндэсний баялгийн хуульд энэ сан гэдэгт хууль дээр байхгүй. Яамдууд маань өдөр тутмын үйл ажиллагааг хариуцна гэдэг маань бүртгэлийг хөтлөх тайлагнах энэ холбогдох энэ журам гарах зэрэг иймэрхүү энэ иргэдийн хүсэлтийг авч гаргах энэ тэр гэсэн ийм өдөр тутмын үйл ажиллагаа хийж байгаа болохоос биш 2030 он хүртэл бол Засгийн газартай гэрээ байгуулаад Монгол банк энэ хөрөнгийн арвижуулах энэ менежментийг дангаараа хийх мандаттай ажиллаж байгаа. Хуримтлалын сангийн хувьд бол Монгол банкны энэ бодлогын хүүгээр бодож арвижуулж өгч байгаа нь бол эрсдэлгүй хамгийн сайн одоо бараг хөрөнгө нь арвижиж байгаа гэж үзэж хэлж болохоор байгаа юм.

Харин Ирээдүйн өв сангийн хувьд бол Монгол банкны тайлбарлаж байгаагаар бол гадаадад хуулиараа гадаад зах зээлд эрсдэлгүй менежмент хийх энэ менежментийг хийж байгаа. Ихэнх нь бол Америкийн Засгийн газрын үнэт цаасны хөрөнгө оруулалт холбооны банкны үнэт цаасны хөрөнгө оруулалтад орж байгаа гэж ингэж тайлбарлаж байна лээ. Энэ бол өөрөө эрсдэлгүй бөгөөд тэгэхдээ өгөөжийн хувьд бол маш бага өгөөжтэй ийм менежмент хийгдэж байгаа. Тэгэхээр энэ нөгөө Монгол банкны эрсдэлийн бодлогынхоо хүрээнд энэ хийгдэж байгаа гэж ингэж тайлбарладаг.

Тийм учраас энэ Үндэсний баялгийн сангийн хуулийг дагаж гарсан Их Хурлын тогтоолын хэрэгжилтийг хангаад 2030 он гэхэд бид энэ хөрөнгийн удирдлага тэр үед бас зарцуулалтын журам, зарцуулах боломжууд ч гэсэн нэлээн нэмэгдэнэ. Тэр хүртэл бид нар Үндэсний баялгийн сангийн орлогыг нэмэгдүүлэх.

Д.Амарбаясгалан: Агваанлуvsсангийн Ундраа гишүүн. Алга байна. Батын Батбаатар гишүүн алга байна. Цэндсүрэнгийн Мөнхтуяа гишүүн асуулт асууя.

Ц.Мөнхтуяа: Та бүхэнд энэ өдрийн мэнд хүргэе ээ. Үндэсний баялгийн сан гэж бидний өвөг дээдсийн халуун амь бүлээн цусаараа хамгаалж ирсэн тусгаар тогтносон Монгол Улсын одоо ба ирээдүйн иргэн бүрдээ байгалийн баялгаас үр өгөөжийг нь тэгш шударгаар хүртээх зорилготой ийм сан гэж ойлгож байгаа. Энэ сан маань 1 дүгээрт Ирээдүйн өв сан, 2 дугаарт Хуримтлалын сан, 3 дугаарт Хөгжлийн сан гээд ийм 3 төрөлжсөн сантай.

Эндээс Хөгжлийн сан сангийнх нь тухай асуулт асууж тодруулъя гэж бодож байна аа. Хөгжлийн сан нь газрын хэвлийн баялгийн үр өгөөжийг одоо ба ирээдүйн үеийн иргэн бүрд тэгш шударга хүртээх зорилгоор Монгол Улсын урт дунд хугацааны хөгжлийн бодлогын баримт бичигт туссан эдийн засаг нийгмийн үр өгөөж бүхий хөгжлийн төсөл хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх ийм зорилготой сан юм байна гэж ойлголоо.

Энэ санг бүрдүүлэх эх үүсвэр нь нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцэл ашигтай гарсан тохиолдолд гол нэр төрлийн эрдэс баялгийн үнэ тухайн жилийн

төсөвт тооцсон үнээс өндөр байснаар нэмэгдэж орох орлогын 50 хувиас бүрдэнэ гэж Үндэсний баялгийн сангийн тухай хуулийн 11.1.3-д заасан байна. Энэ бол одоогийн манай төсвийн бодлогын хүрээнд бол нэлээн чанга тоо. Бас л хатуу шалгуур харагдаж байна аа. Өөрөөр хэлбэл төсөв алдагдалгүй ашигтай гарч байж дээрээс нь зэс, нүүрс гээд манай гол нэр төрлийн эрдэс баялгийн үнэ дэлхийн зах зээл дээр өндөр байж байж энэ санд хэсэг мөнгө төвлөрөх нь гэж ойлголоо.

Тэгээд энэ 2024 онд энэ санд мөнгө төвлөрсөн үү? Энэ хөгжлийн санд.

Хоёрдугаарт 2025 оны төсвийг Их Хурал алдагдалгүй байхаар баталсан учраас нөгөө зэс, нүүрсний үнэ чинь гайгүй өндөр байгаад байвал нэг хэсэг мөнгө 2025 оны хөгжлийн санд төвлөрнө гэсэн ийм хэдэн төгрөг төвлөрнө гэсэн урьдчилсан тооцоо байгаа вэ? Хөгжлийн санд мөнгөн хөрөнгө төвлөрсөн тохиолдолд түүнийхээ яг хэдэн хувийг боловсролд хэдэн хувийг эрүүл мэндийн салбарт өөрөөр хэлбэл нийгмийн үр өгөөжтэй төсөл хөтөлбөртөө зарцуулна гэсэн тооцоо байгаа вэ гэдгийг асуумаар байна аа. Ер нь бол энэ сангийн мөнгийг орон сууц боловсрол эрүүл мэнддээ зарцуулна гээд байгаа хэдий ч түрүүн Булгантуяа гишүүн асууж байна шүү дээ. Нэг зуун гучин наймхан мянган төгрөгөөр ямар сувилалд явж амрах вэ хүүхдээ амрааа гэхэд гээд. Тэгэхээр энэ мөнгө чинь одоо 2028 онд л нэлээн өснө гэж сая Учрал сайд хариу өгч байсан. Тэгэхээр энэ дээр бас нэг ийм 3 асуулт асууж хариулт авъя аа. Учрал гишүүнээс.

Д.Амарбаясгалан: ЗГХЭГ-ын дарга Ням-Осорын Учрал сайд хариулт өгье.

Н.Учрал: Тийм. Энэ Үндэсний баялгийн сангийн хууль бол 4 дүгээр сард л батлагдсан хууль юм аа. Тийм Мөнхтуяа гишүүн ээ. Тэгээд энэ 6, 7 сарын хугацаанд л нэг 480 тэрбум төгрөг хуулийн дагуу бүрэлдлээ л дээ. Тэгэхээр энэ бол зүгээр дэвшил. Өмнө нь хэзээ ч ингээд хуримтлал бүрдээд иргэдийн тоогоор энийг ингээд севинг байдлаар ингээд хадгалж үзүүлж байгаагүй. Одоо үүнийг хуулийн дагуу хатуу эрүүл мэнд, боловсрол, орон сууцад зарцуулна гээд хуульчилчихсан. Тэрнээс биш түрүүн Булгаа сайд хэлж байна шүү дээ. Тэр өөр юм руу зарцуулж болохгүй хуультай.

Энэ хуулиар түгжихсэн. Тэгээд Ирээдүйн өв сангийн хөрөнгө мөнгө рүү хэн нэгэн орох тийм боломж байхгүй. Ингээд хуулиудаар түгжиж авахгүй бол аюултай юм байна лээ л дээ. Нөгөө зориулалтын бусаар ашигладаг. Тэгээд гоё гоё юм ярьж байгаад ингээд бужигнаан үүсгэдэг. Тэгээд ийм нэг нөхдүүд байна л даа.

Тэгэхээр ингээд хуулиар нь ингээд хатуу түгжээд явчихаар энэ 138 мянган төгрөг чинь бид нар зүгээр эхлэл болгож байгаа байхгүй юу. Та боддоо төрийн өмчийн 122 компани шүү дээ. Байсан байгаа шүү дээ. Тэгээд уул уурхайн нэг 30 орчим компаниас 5 компани нь л энд хуримтлал үүсгэх гээд байна шүү дээ. Гэтэл бүх уул уурхайн компани ашигтай ажиллаад хуримтлал үүсгээд ажиллах юм бол ямар үр дүн гарах вэ гэдэг нь ойлгомжтой байхгүй юу. Дээрээс нь стратегийн орд эзэмшиж байгаа компаниудтай буюу 16 стратегийн ордын 9 дээр нь бид нар хэлэлцээ хийх бололцоо байхгүй юу. 9-ийн зөвхөн 10 дээр нь хэлэлцээ хийхэд зөвхөн тусгай АМНАТ-ыг борлуулалтаас нь 10 хувийг авахад л 1.2 их наяд, 15 хувийг аваад 34-ийг орлуулах юм бол 1.8 их наяд хүрэхэд энэ ард түмний энэ хуримтлалын данс өөрөө өснө шүү дээ. Тэгээд цаашдаа бол бид нар төсөв тойрсон маргаан биш парламент дээр баялгийн сангийн хууль яагаад хэрэгжихгүй байна, яагаад тэр компани орлого бүрдүүлэхгүй байна, яагаад тэр компани менежментгүй байна,

яагаад наад уул уурхайн компани чинь хариуцлагатай байгаа юм бэ гэдэг дээр хяналт тавьдаг болно.

Тэгээд цаашдаа Норвеги шиг парламентын сонгуульд улс төрийн намууд орохдоо баялгийн сангийнхаа орлогыг нэмэгдүүлнэ ээ. Баялгийн сангийн орлогод гар хүрэхгүй, хэмнэлт өгнө, шинэ төслүүд хэрэгжүүлж таны энэ И Монгол дахь хуримтлалын дансыг нэмэгдүүлнэ гэдэг ийм сэдэв дор бид нар өрнөх юм байна лээ. Сэдвийн яриа тийм ч учраас энэ өөрөө хуулиар бид нар сайн манах хэрэгтэй. Тийм учраас 126 гишүүнтэй болсон бүгдээрээ энэ хуулийг манаж энэ хуулийн хэрэгжилтийг хангуулж шахаж шаардаж ингэж ажиллана. Тэгээд энэ ашиг сонирхлоос хол тэгвэл үр дүн гарна гэж бодож байна. Түрүүний нэмэлт асуултаар Сангийн яамнаас.

Д.Амарбаясгалан: Ажлын хэсгийн 18 дугаар микрофон.

Б.Тэлмүүн: Сангийн яам Тэлмүүн. 2024 оны төсвийн гүйцэтгэл хараахан эцэслэгдэж гараагүй байгаа төсвийн гүйцэтгэл ойрын хугацаанд гараад Үндэсний Аудитын газраар аудит хийлгээд Улсын Их Хуралд 2024 оны төсвийн гүйцэтгэл хаврын чуулганаар орж танилцуулагдана. Тийм учраас яг 2024 онд эцсийн байдлаар жилийн эцсээрээ хэд орох вэ гэдэг тоог гүйцэтгэл баталгаажсаны дараа хэлэх боломжтой байна аа. 2024 оны урьдчилсан байдлаар бол Үндэсний баялгийн санд нийт 4.4 орчим их наяд төгрөгийн хуримтлал бол үүсэхээр ийм төлөвтэй байгаа. Үүн дээр бол хамгийн том нь мэдээж Ирээдүй өв сан. 2024 оны урьдчилсан гүйцэтгэлээр сангийн хуримтлал Монгол банкны валютын дансанд 3.9 орчим их наядын хуримтлал үүсэхээр ийм тооцоо гарч байна. 2025 онд бол нэмж 1.7 сая ам.доллар бол төвлөрөх ийм төлөвлөгөөтэй байгаа. Хөгжлийн сангийн хувьд бол.

Д.Амарбаясгалан: Тэлмүүн нэмж хариулъя 18 дугаар микрофон.

Б.Тэлмүүн: Хөгжлийн сан бол төсөв ашигтай гарсан үед хуримтлагдана. 2024 оны урьдчилсан гүйцэтгэлээр төсөв алдагдалтай гарч байгаа. Тэгэхээр бол 2024 оны гүйцэтгэлээр хөгжлийн санд одоогоор мөнгө хуваарилагдахгүй. 2025 онд мөн төсөв алдагдалгүй, яг төсвийн өмнө тэнцэлтэйгээр орсон учраас одоогийн байдлаар мөнгө хуваарилагдах ийм төлөвлөгөөгүй байгаа. Хуримтлалын санд бол нийт 2024 оны гүйцэтгэлээр ноогдол ашиг болон хүүгийн орлогоор нэг 500 орчим тэрбум төгрөгийн урьдчилсан хуримтлал үүсэж байгаа. Энийг Учрал сайдын хэлснээр орон сууц, боловсрол, эрүүл мэндийн чиглэлээр зарцуулагдахаар энэ хууль батлагдсан байгаа. Энэ чиглэлийнх нь дагуу хуулийн дагуу зарцуулалтууд хийгдээд явна аа. Баярлалаа.

Д.Амарбаясгалан: Мөнхтуяа гишүүн тодруулж асууя.

Ц.Мөнхтуяа: Эрүүл мэнд, боловсрол, орон сууц авахад зарцуулна гээд байгаа шүү дээ. Тэгэхээр орон сууцанд зарцуулах тийм их хэмжээний мөнгө баялгийн санд хэзээнээс эхэлж төвлөрөх вэ? Энийг иргэд их сонирхож асууж байна аа. Яах вэ, эр эрүүл мэнд, орон сууц, боловсрол гээд тодорхой юунд заачихсан байгаа нь зөв л дөө. Тэгэхдээ яг хэзээнээс энэ орон сууц авахад дэмжлэг болохуйц тийм мөнгө төвлөрөх вэ гэдгийг л иргэд асуугаад байгаа юм аа. Энийг нэг хариулж өгөөч.

Д.Амарбаясгалан: Тэгээд энэ дээр маш тодорхой хариулчихмаар байх юм. Жилдээ ипотекийн зээлд зориулж 500-аас 600 тэрбум төгрөгийн эх үүсвэртэй байсан бол Баялгийн сангийн хууль батлагдсанаар хуримтлалын нэгдсэн сан орон сууцны ипотекийн зээлд зориулагдах эхний ээлжид зориулагдана гэж шийдэгдсэнээр энэ өнгөрсөн 2024 онд гэхэд 1.1 их наяд төгрөг зарцуулагдсан гэсэн үг ипотекийн зээлд. 100 сая төгрөгөөр бодоход үндсэндээ 5-аас 6 мянган айл жилдээ ипотекийн зээл авдаг байсан бол өнгөрсөн 2024 онд 10-аас 11 мянган өрх зээл авах боломж бүрдсэн гэж энэ дээр Наранцогт захирал маш тодорхой хариулаад өгчихье.

Х.Наранцогт: Тэгэхээр бид нар энэ дээр төсөөллүүд хийж ажиллаж байгаа. яг одоо бол сая бид нарын ярьж байгаа энэ Эрдэнэс Монголын харьяаны 5 компани л хуримтлалын санд ноогдол ашиг төвлөрүүлж байна. Тэгээд өнгөрсөн энэ 6 сарын хугацаанд 2024 онд бид нар ингээд 487 тэрбум төгрөг хуримтлуулсан. Монгол банкнаас 9.9 тэрбум төгрөгийн хүү бодогдсон. Тэгээд энэ дүнгээр нэг иргэнд Монгол Улсын амьд сэрүүн байгаа бүх иргэнд ингээд тэгш шударгаар хуваарилагдаж байгаа. 138 мянган төгрөгийн хуримтлал бий болсон байна аа. Бид нарын төсөөллөөр бол яг үндсэн энэ байгаа. Өнөөдөр стратегийн ордод нэмж орд авалгүйгээр одоо үйл ажиллагаа явуулж байгаа компаниудынхаа энэ тооцооллыг хийгээд энэ ноогдол ашгийн тооцоолол хийж үзэхэд нэг 2040 он хүрэхэд нэг 40 орчим их наяд төгрөг цугларахаар байгаа юм. Тэгэхээр энийг бол.

Д.Амарбаясгалан: Гүйцээж хариулъя. Наранцогт даргын микрофон өгье.

Х.Наранцогт: Тэгэхээр энийг нэмэгдүүлье гэдэг л ийм зорилгоор Үндэсний баялгийн сангийн орлогыг нэмэгдүүлэх реформыг Эрдэнэс Монгол дээр зарлаад Засгийн газраас энэ санаачилгыг гаргаад бид нар нэлээд хэд хэдэн шийдвэрийг гаргуулаад ингээд ажиллаж байгаа юм. Энэ өнөөдрийн бид нарын энэ баялгийн сангийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулж байгаа асуудал ч тэр Ашигт малтмалын хуульд өөрчлөлт оруулж байгаа асуудал нь ч тэр бүгд ерөөсөө энэ иргэдийн хуримтлалын сангийн орлогыг нэмэгдүүлэх чиглэлд ажиллаж байгаа гэсэн үг.

Тэгэхээр үлдсэн 9 стратегийн орд дээр хэлэлцээр хийгдэнэ. Дээр нь 2007 онд гарсан 29 стратегийн ордод орох боломжтой ордуудын жагсаалт байгаа. Үүнээс хойш 2007 оноос хойш ч гэсэн илэрсэн нэлээд олон ордын стратегийн ордын бүлэг ордын хил хязгаар тогтоох стратегийн ордод өөр оруулах энэ жагсаалт шинэчлэх ажил уурхайн яаман дээр хийгдэж байгаа. Ингээд ирэх юм бол энэ стратегийн ордууд нэмэгдээд, стратегийн ордууд дээр хийгдэх энэ төрийн эзэмшлийг тогтоох тусгай АМНАТ-өөр солих энэ хэлэлцээрүүд ингээд амжилттай явах юм энэ тооцоолол эрс нэмэгдэх бололцоо байна гэдэг ийм тооцоолол бас давхар хийгдэж байгаа.

Д.Амарбаясгалан: Гишүүд асуулт асууж хариулт авч дууслаа.

Байнгын хорооноос гаргасан зарчмын зөрүүтэй саналын томьёоллоор санал хураана.

Зарчмын зөрүүтэй нэг санал байгаа.

Зарчмын зөрүүтэй саналыг тайлбарлаж түүнийг дэмжсэн эсрэг байр суурьтай намын бүлгийг төлөөлж мөн аль нэг намын эвслийн бүлэгт харьяалагдаагүй тус бүр 2 хүртэл гишүүн үг хэлж болно.

Зарчмын зөрүүтэй саналыг саналын томъёоллын танилцуулъя.

1.Эдийн засгийн байнгын хороо дэмжсэн санал

1.Төслийн 1, 2, 3 дугаар зүйлийг нэгтгэн доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“1 дүгээр зүйл.Ашигт малтмалын тухай хуулийн 47² дугаар зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

“47² дугаар зүйл.Стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордын ашигт малтмалын нөөц ашигласны тусгай төлбөр

47².1.Энэ хуулийн 5.3, 5.4, 5.5-д заасан төрийн эзэмшлийн хувь, хэмжээг стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордын ашигт малтмалын нөөц ашигласны тусгай төлбөрөөр орлуулах тохиолдолд тусгай зөвшөөрөл эзэмшигч хуулийн этгээд нь тусгай төлбөрийг энэ хуулийн 47².2-т заасан хувь хэмжээгээр тооцож төлнө.

47².2.Энэ хуулийн 47².1-д заасан стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордын ашигт малтмалын нөөц ашигласны тусгай төлбөрийн хувь, хэмжээг тухайн ордын онцлогоос хамаарч Засгийн газрын өргөн мэдүүлснээр Улсын Их Хурал тогтооно.” Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Гончигдоржийн Уянгахишиг.

Саналтай холбоотой Сандагийн Бямбацогт гишүүн үг хэлье.

С.Бямбацогт: Энэ заалтыг дэмжиж байгаа. Бид нар 2019 онд Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлт хийсэн. Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтөөр бид Үндэсний баялгийн сан байгуулна аа. Байгалийн баялгийн өгөөжийн дийлэнх хэсэг нь Монголын ард түмэнд ноогдох ёстой өгөөжийг хүртэх ёстой гэсэн Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлт хийсэн. Энэ заалтыг бид нар амилуулж 2024 онд Үндэсний баялгийн сангийн тухай хуулийг баталсан. Баялгийн сангийн тухай хууль энэ Баялгийн сангийн хууль маань ирээдүйн өв сан, дээрээс нь Хөгжлийн сан, хуримтлалын сан гэсэн 3 сантай. Зөвхөн өнөөдөр амьдарч байгаа иргэддээ юм уу ноогдол ашиг аваад тэгээд хуваагаад дуусах биш, ирээдүй хойч үедээ тодорхой хэсэг хадгалж үлдээх зорилготой. Түүнийгээ өсгөж үржүүлж арвижуулах ийм зорилготой. Мөн бас хөгжлийн асуудлаа шийдэх энэ томоохон төслүүд хэрэгжүүлэх ард иргэд маань тулгамдсан асуудал шийдэх энд Хөгжлийн сан үйлчлэх ёстой. Ийм байдлаар бид нар баталсан. Сая хэлж хэлж байна. 2024 онд 4 их наяд төгрөг тийм үү стратегийн 5 ордын эзэмшигч ТӨК-удаас 34 хувь эзэмшээд 4 орчим их наяд төгрөг хуримтлагдсан гэж.

Цаашдаа энэ стратегийн ордууд улам нэмэгдээд эндээс тэр 34 хувиа эзэмших юм уу орлуулж АМНАТ авдаг болоод ингээд явах юм бол энэ сан улам л арвижна. Энэ арвижсан сангаасаа бид иргэдийнхээ эрүүл мэндийн асуудлыг шийдэхэд, өвдсөн зовсон үед нь хагалгаа хийхэд, сургуульд сурч байгаа үед нь сургалтын төлбөрийг шийдэхэд, орон байргүй иргэд нь орон байртай болоход

зарцуулагдана зориулагдана аа. Энэ санг л аль болох бид хурдан хугацаанд аль болох арвижуулах л ийм зорилготой.

1996 онд Норвегийн сан байгуулагдаж байсан юм байна лээ. Одоо энэ 30 орчим жилийн хугацаанд 1.7 их наяд доллар хуримтлагдсан байна тэнд хуримтлагдсан. Нэг иргэнд ноогдох нь 325 мянган доллар буюу 1 тэрбум 100 орчим сая төгрөгийг нэг иргэнд ноогдохоор ийм болчихсон байж байгаа. Түүнтэй адилхан бид нар ингээд хуримтлуулаад энэ баялгийн сангаасаа хуримтлуулах юм бол ийм хэмжээний асуудлыг шийдэх боломжтой болох юм аа. Тийм болохоор л аль болох стратегийн ордуудаа төр тодорхой хувь нь эзэмшье эс үгүй бол роялти авъя, аль болох стратегийн ордуудыг нэмэгдүүлье гэсэн бодлого барьж байгаа.

Энэ хүрээндээ ч гэсэн ингээд ойлгомжгүй байгаа гацчихсан байгаа тэр ордуудаа ойлголцоод, хувийн хэвшилтэйгээ ойлголцох, гадаадын хөрөнгө оруулагчтай ойлголцох энэ юмнуудаа явуулаад энэ баялгийн сангаа л нэмэгдүүлье. Өнгөрсөн хугацаанд бид нар баялгийн сангаас 2022 онд иргэн болгон 150 орчим мянган төгрөг хүртсэн. 2023 онд бид нар 256 мянга 2024 онд бид нар 350 орчим мянган төгрөгөөс ноогдол ашиг авах авах гэж байгаа. Энэ зөвхөн одоо Эрдэнэс Монголын харьяа Тавхан компаниас энэ 15 болох юм бол тэр стратегийн орд орох бололцоотой 27 компаниар нэмэгдэх юм бол дахиад жишээ нь шинэ шинэ томоохон ордууд нээгдээд үүнд бас төр эзэмшээд явах юм бол Монголын иргэдийн байгалийн баялгийн өгөөжийг хүртэх Үндсэн хуулийн заалт амилах юм. Тийм болохоор энэ чухал заалтыг бүгдээрээ ойлгоод бүгдээрээ дэмжээд энэ рүү чиглэсэн үйл ажиллагаагаа л энэ хамтарсан Засгийн газрын үед явуулъя гэж байгаа. Энийг тэгээд энэ талаас нь хараад дэмжиж байгаа гишүүдийг дэмжинэ байх гэдэгт итгэж байна аа.

Д.Амарбаясгалан: Гишүүд дүгнэлт дууслаа. Эдийн засгийн байнгын хорооны дэмжсэн саналыг дэмжье гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя аа.

Санал хураалт.

65 гишүүн буюу 69.1 хувиар санал дэмжигдлээ.

Үндэсний баялгийн сангийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Эдийн засгийн байнгын хороонд шилжүүллээ.

Өнөөдрийн нэгдсэн хуралдаанаар хэлэлцэх асуудал дууссан тул чуулганы хуралдаан өндөрлөснийг мэдэгдье.

ДУУНЫ БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ
БУУЛГАЖ, ХЯНАСАН: ШИНЖЭЭЧ П.МЯДАГМАА

